
Улсын бүртгэлийн
дугаар

Төсөл хэрэгжүүлэх гэрээний дугаар
ШуУд-2020/24

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН
НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР**

**“ЗАЛУУЧУУДЫН НИЙГЭМ, УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, НАС,
СЭТГЭХҮЙ, БИЕ БЯЛДАР, ТҮҮХ СОЁЛЫН ХӨГЖЛИЙГ
ТОДОРХОЙЛОХ НЬ”** захиалгат судалгааны төслийн тайлан
(2020-2022)

Төслийн удирдагч: Б.Болд-Эрдэнэ. доктор, профессор
МУИС-ийн ШУС-ийн НУС хариуцсан захирал

Захиалагч: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Санхүүжүүлэгч: Шинжлэх ухаан технолгойн сан

Тайлан өмчлөгч: МУИС-ийн ШУС-ийн Нийгмийн ухааны салбар

ГАРЧИГ

| | |
|---|-------------------------------------|
| Захиалгат судалгааны ажлыг гүйцэтгэгчдийн мэдээлэл | 4 |
| НЭГ. ҮНДСЭН ХЭСЭГ | Error! Bookmark not defined. |
| 1.1. Захиалгат судалгааны төслийн зорилго, хэрэгцээ, шаардлага | 5 |
| 1.2. Төслийн зорилго, зорилт | 8 |
| ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ | Error! Bookmark not defined. |
| 2.1 Судалгааны арга зүй, аргачлал | 9 |
| 2.2 Судалгааны түүвэр, объект | 11 |
| 2.3 Судалгааны мэдээлэл цуглуулах хүрээ | Error! Bookmark not defined. |
| 2.4 Судалгааны багийн зохион байгуулалт ба үйл ажиллагааны төлөвлөгөө | 14 |
| 2.5 Судалгааны багийн үйл ажиллагааны төлөвлөгөө | 17 |
| 2.6 Төслийн хүрээнд хийсэн судалгаанаас хүлээгдэж буй үр дүн, бүтээгдэхүүн ... | 18 |
| ГУРАВ. ЗАЛУУЧУУДЫН НИЙГЭМ, УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, НАС, СЭТГЭХҮЙ, БИЕ БЯЛДАР, ТҮҮХ СОЁЛЫН ХӨГЖЛИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН | 19 |
| 3.1 Судалгаанд хамрагдсан залуусын нийгэм, хүн ам зүйн үзүүлэлтүүд | 19 |
| 3.2 Залуучуудын нийгэм, улс төрийн оролцооны байдал | 27 |
| 3.3 Залуучуудын сэтгэхүй, бие бялдарын үзүүлэлтүүд | 36 |
| 3.4 Залуучуудын үнэт зүйл, түүх, соёлын хөгжлийг тодорхойлох нь | 44 |
| ДӨРӨВ. ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ | 58 |
| 4.1 Залуучуудад тулгамдаж буй асуудал ба хөтөлбөрийн хэрэгжилт, эрх зүйн орчин | 58 |
| 4.2 Залуучуудын ерөнхий мэдээлэл ба үйлчилгээ | 70 |
| 4.3 Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд үзүүлсэн үйлчилгээг шинжлэх нь | 74 |
| 4.4 Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээ | 79 |
| 4.5 Залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээг хөгжүүлэх нь | 85 |
| 4.5.1 Гадаадын зарим улс орнуудын туршлага | 85 |
| 4.5.2 Үндэсний туршлага | 92 |
| ТАВ. ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ | 97 |
| 5.1 Залуучуудын хэрэгцээ, шаардлагад тулгуурласан үйлчилгээг бий болгох нь | 97 |
| 5.2 Залуучуудын насны бүлэгт тохирсон үйлчилгээг бий болгох нь | 99 |
| 5.2.1 Залуучуудын насны бүлэгт тохирсон нийтлэг үйлчилгээ | 99 |
| 5.2.2 Зорилтот бүлэгт үзүүлэх үйлчилгээ | 100 |
| 5.3 Үйлчилгээний тодорхойлолт, арга зүй, үйлчилгээний дараалал | 101 |

| | |
|--|------------|
| <u>5.3.1 ЗХТ-ийн үйлчилгээний тодорхойлолт</u> | 101 |
| <u>5.3.2 Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээний арга зүй, дараалал</u> | 109 |
| ➤ <u>Залуучуудын хөгжлийн нийтлэг үйлчилгээ</u> | 109 |
| ➤ <u>Зорилтот бүлгийн залуучуудын хөгжлийн үйлчилгээ</u> | 110 |
| ➤ <u>Холбон зуучлах үйлчилгээний хүрээнд хүргэх нэмэлт үйлчилгээ</u> | 111 |
| <u>4.4 ЗХТ-ийн үйлчилгээг анхан шатны нэгжид зохион байгуулах нь</u> | 116 |
| <u>ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ</u> | 123 |
| <u>НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ</u> | 128 |
| <u>ХАВСРАЛТ МАТЕРИАЛ</u> | 131 |

Төслийн багийн бүрэлдэхүүн

Багийн ахлагч:

Б.Болд-Эрдэнэ. МУИС-ийн ШУС-ийн НУС хариуцсан захирал, доктор, профессор

Гишүүд:

Б.Наранбаатар эрхлэгч МУИС, ШУС, НУС-ын Сэтгүүлзүй, олон нийтийн харилцааны тэнхмийн

О.Энхтуяа ХААИС, Нийгмийн ухааны тэнхмийн дэд профессор, доктор

Ц.Батболд МУИС, ШУС, НУС-ын Улс төр судлалын тэнхмийн дэд профессор, доктор

Д.Оюунгэрэл МУИС, ШУС, ХУС-ын философи шашин судлалын тэнхмийн дэд профессор, доктор

С.Бат-Эрдэнэ ШУТИС, НУС-ын багш доктор

НЭГ. ҮНДСЭН ХЭСЭГ

1.1. ЗАХИАЛГАТ ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Монгол Улсын ардчилсан өөрчлөлтийн он жилүүдийн нэгэн чухал ололт нь иргэний нийгмийн байгууллагуудын хөгжил, төлөвшил юм. Иргэний нийгмийн оролцоогүйгээр ардчилсан нийгмийг төсөөлөх аргагүй. Төрийн зүгээс иргэнийхээ үгийг сонсдог, тэдэнд шуурхай үйлчилдэг, ажлаа ил тод, нээлттэй явуулдаг байлгахын төлөө ажиллаж байна. Мөн иргэдийн үзэл бодол, санал санаачилгыг үйл ажиллагаа, шийдвэртээ тусгахыг илүүд үзэж, иргэний нийгмийг төлөвшүүлэхийн төлөө анхаарч ажиллаж байна.

Нэн ялангуяа залуучуудыг идэвхижүүлснээр тэднийг улс орны хөгжилд болон өөрсдийнх нь амьдралын аливаа шийдвэрт нөлөөлөх эрхээ эдэлж, үүргээ хэрэгжүүлэх боломжийг олгоно. Залуу нас бол хувь хүний өөрийн гэсэн үзэл бодол нь төлөвшиж, хариуцлагатай сонголт хийх, нийгэмд танигдаж харилцаанд орох, улс төрийн үйл ажиллагаанд оролцох, таалагдсан үзэл санаагаа дэмжих, хамт олон бүрдүүлэх, иргэний нийгмийн байгууллага, бүлэгт гишүүнээр элсэх, хүсэл шаардлагаа илэрхийлэх, өөрийн үйлдэлдээ хяналт тавьж сурах чухал үе юм.

Өнөө үед дэлхийн аль ч улс оронд залуучуудын хөгжлийн асуудалд төрийн байгууллагаас эхлээд олон нийт, иргэний нийгэм судлаачид онцгой анхаарах болжээ. Монголын ардчиллын хөгжлийн тулгамдсан сорилтуудын нэг болсон залуучуудын оролцооны тухай асуудал өнөөдөр бодлого, эрх зүйн талаасаа ч, судалгаа боловсруулалтынхаа хувьд ч, нийгмийн улс төрийн амьдралын хэрэгцээ шаардлага талаасаа ч анхаарал татсан чухал сэдвийн нэг юм.

Энэхүү судалгаа нь залуучуудын нийгэм, улс төрийн оролцооны асуудлыг бие хүний болон нийгмийн хүчин зүйл болох нас сэтгэхүй, бие бялдар, түүх, соёлын үүднээс илүү нарийвчлан судлах, ингэхдээ энэ талаарх төрийн бодлого, эрх зүйн орчин, залуус буюу шинэ үеийнхэний улс төрийн идэвхи, хандлага, байр суурийг тодруулах зорилго тавьсан болно. Энэ зорилгоо хэрэгжүүлэх хүрээнд дор дурьдсан чиглэлээр мэдээллийн сан бүрдүүлж дүн шинжилгээ хийнэ. Үүнд нэгд, улс төрийн оролцооны онол, үзэл баримтлал болон Монголын залуучуудын улс төрийн оролцоо, тэдний зан үйлийн өнөөгийн байдалд шинжилгээ хийх хоёрт, залуучуудын асуудлаар төрөөс баримталж буй бодлого, хөтөлбөрүүд болон эрх зүйн орчны өнөөгийн нөхцөл байдалд ерөнхий дүн шинжилгээ хийх, гуравт, залуучуудын улс төрийн оролцоо ба нас сэтгэлзүй, нийгэмч байр суурийнх нь талаарх санаа бодлыг тандан судлах, судалгааны үр дүнд шинжилгээ хийж ерөнхий дүр зураг гарахыг оролдоно.

Улс төр, сонгуулийн оролцоо, залуучуудын зан үйлийн судалгаа нь хууль эрх зүй, ёс суртахуун, сэтгэл зүй, социологийн үлэмж нарийн үзэгдлүүдтэй холбоотой байдаг учраас олон шинжлэх ухааны уулзварт оршиж, олон салбарын мэргэжлийн судлаачдын хамтын хөдөлмөрөөр хийгдэх том ажил юм. Манай орны хувьд залуучуудын улс төрийн идэвхи, оролцоог тухайлан судлах ажил эхлэлийн төдий байгаа билээ.

Түүнчлэн залуучуудын улс төрийн ухамсрын тулгамдсан асуудлыг тодруулах, цаашид мэргэжлийн судлаачид, судалгааны байгууллагын анхаарлыг зүй ёсоор татаж байна. Энэ удаагийн захиалгат судалгаа нь залуучуудын улс төрийн оролцооны асуудлыг бие хүн болон нийгэмч зан сэтгэхүйтэй холбон төрийн бодлого, эрх зүйн орчин, залуучууд түүний дотор шинэ сонгогчийн зан үйлийг олон нийтийн санаа бодолд тулгуурлан нарийвчлан судлахыг зорилго болгож байна. Судалгааны ажил нь хүн амын гуравны нэгийг хамарсан “залуучууд” хэмээх нийгмийн томоохон бүлгийн улс төр, нийгмийн идэвхи, оролцоо, зан үйлийн асуудлыг хөндсөнөөрөө онцлог юм. Энэхүү сэдвийг судлах хэрэгцээ шаардлагыг төсөл боловсруулагчид дараах хэдэн шалгуур үзүүлэлт дээр үндэслэн тайлбарласан болно. Үүнд:

- Төр засгийн бодлого, үйл ажиллагааны хэрэгцээ шаардлага: хэмжих үзүүлэлт-төрийн бодлогын барим бичигт сэдвийн агуулга тусгагдсан байдал, нийгмийн өмнө тулгарч буй асуудлыг шийдэхэд энэ чиглэлийн судалгаа шинжилгээг ашиглах хэрэгцээ
- Шинжлэх ухааны онол арга зүйг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага: хэмжих үзүүлэлт- залуучуудын сэтгэхүй, соёл, ухамсрыг тодорхойлох онол үзэл баримтлал, шалгуур замаар шинжлэх ухааны мэдлэг, парадигмын хөгжилд хувь нэмэр оруулах хэрэгцээ
- Эмпирик хэрэглээ, мэдлэгийг эргэлтэнд оруулах хэрэгцээ: хэмжих үзүүлэлт-онолын арга зүйн мэдлэгийг хэрэглээнд оруулах аргачлал, зөвлөмж, бодлогын хувилбар боловсруулах, хэрэгжүүлэх төлөвлөгөө стратеги

Дээр дурдсан хэрэгцээ шаардлагыг тус бүрээр нь товч тодорхойлон авч үзье.

Төр засгийн бодлого, үйл ажиллагааны хэрэгцээ шаардлага:

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын тогтвортой өсөлтийг хангах, иргэдийн урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих, таатай орчинг бүрдүүлэх, хувь хүн болон гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино хэмээн бодлогын баримт бичигт тусгасан (МУЗГ, Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, 2016) байна. Хүн ам зүйн бодлогын асуудал нь нийгэм-эдийн засгийн хөгжлийн явцад хүн амын өсөлт, хүн амын газар зүйн болоод насны бүлгийн тархалт, хөгжлийн үйл явцын харилцан нөлөөллөөр урган гарч байдаг. Хүн амын үндсэн хүчин зүйлст хүн амын өсөлтийн хурд, хүн амын газар зүйн болоод насны бүлгийн тархалт зэрэг ордог ба эдгээр үзүүлэлт нь тухайн улсын нийгэм-эдийн засгийн хөгжил, амьдралын чанарыг дээшлүүлэхэд түлхэц болох, эсвэл хойш ухраах хүчин зүйл болж байдаг.

Монгол Улсын Засгийн газар Залуучуудын хөгжлийг дэмжихэд анхаарч ирсэн бөгөөд Монголын залуучуудын үндэсний хөтөлбөрийг 1998-2005 онуудад 2 үе шаттайгаар хэрэгжүүлсний зэрэгцээ Гэр бүлийн хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого, Хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого зэрэг бусад бодлого, чиглэлд залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээг тусган хэрэгжүүлж ирсэн. Мөн 1998 оныг “Залуучуудын жил”, 2002 оныг “Оюутны жил” болгон зарлаж залуучуудын санаачлагыг өрнүүлэхэд анхаарч ажилласан.

Засгийн газрын 2006 оны 282 дугаар тогтоолоор баталсан Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр нь 2007-2008, 2009-2012, 2013-2015 онд 3 үе шаттайгаар, залуучуудын өөрийнхөө төлөө болон нийгмийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, хөгжих, эрх ашгаа хамгаалах, нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд оролцох оролцоог өргөжүүлэх ээлтэй орчинг бүрдүүлэх замаар чадварлаг, бүтээлч, ёс суртахуунтай, боловсролтой, соёлтой иргэн болж төлөвших, тэдний улс орныхоо хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлсэн.

Өнөө үед залуучуудын эрүүл мэндийн байдал, ялангуяа сэтгэцийн эрүүл мэндийн байдалд анхаарах, эзэмшсэн мэргэжил, мэдлэгээ ажилдаа хэрэглэх боломж нөхцлийг сайжруулах, залуучуудын нийгмийн болон эдийн засаг, улс төр дэх оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна. Эдгээр асуудлаас үүдэх үр дагавар, уршигт байдалтай тэмцэх бус нөлөөлж буй хүчин зүйлс, нөхцөл байдлыг цогцоор шийдвэрлэхийг чухалчилж Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг 2017 онд Улсын Их хурлаар баталж, 2018 оноос хүчин төгөлдөр мөрдөж байна.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд хувь хүний хөгжил; боловсрол, соёл, урлаг, спорт, шинжлэх ухаан; эрүүл мэнд; хөдөлмөр эрхлэлт; аюулгүй амьдрах, хөгжих орчныг дэмжих гэсэн үндсэн 5 чиглэлээр залуучуудын эрх, хөгжил, хамгаалал, оролцоог дэмжихээр томъёолсон. Эдгээр чиглэлтэй уялдуулан 2019-2022 онд хэрэгжүүлэх Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд залуучууд идэвхтэй оролцож, хөгжилд бодитой хувь нэмэр оруулах таатай орчинг бүрдүүлэх замаар өөрийн, гэр бүлийн болон нийгмийн өмнө хүлээх хариуцлага, хуулиар олгогдсон эрх, үүргээ ухамсарладаг, өрсөлдөх чадвартай иргэн болоход дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулсан.

Шинжлэх ухааны онол арга зүйг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага:

Нийгмийн тогтолцооны өмнө тулгарч буй аливаа асуудлыг судлах, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг боловсруулахад залуучуудын талаарх судалгаа шинжилгээ тулгуур нөхцөл болдог.

Эмпирик хэрэглээ, мэдлэгийг эргэлтэнд оруулах хэрэгцээ:

Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад шинжлэх ухааны ололт амжилт, судалгаа шинжилгээг ашиглахад онолын арга зүйн мэдлэгийг хэрэглээний эргэлтэнд оруулах хэрэгцээ шаардлага тулгардаг. Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцын аюулгүй, найдвартай байдлыг хангахад шинжлэх ухаан, судалгаа шинжилгээны үр дүнг ашиглахыг хууль эрх зүйн хэм хэмжээгээр албажуулах нь улс оруудад түгээмэл байдаг.

Чухамхүү төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад шинжлэх ухааны онолын суурь мэдлэг, хэрэглээний судалгааны үр дүнг ашиглах замаар нийгмийн өмнө тулгарч буй асуудлыг судлан мэдэх, тэдгээрийг шийдвэрлэх шийдлийн хувилбар боловсруулж эргэлтэнд оруулахад энэ төслийн бас нэгэн эрэлт хэрэгцээ тодорхойлогдоно.

1.2 ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү төслийн үндсэн зорилго нь монголын залуучуудын нийгэм улс төрийн оролцоо, идэвхи, бие хүний (нас, сэтгэхүй, бие бялдар) болон нийгмийн (түүх, соёлын) хүчин зүйл зэргийг холбон хөгжлийн өнөөгийн байдлыг нэгтгэн, дүн шинжилгээ хийхэд чиглэсэн болно. Өнөөгийн залуучуудын талаарх судалгааны үр дүнд тулгуурлан цаашид авч хэрэгжүүлэх сургалт нөлөөлөл, бодлогын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилт, үр нөлөөг сайжруулахад чиглэсэн санал зөвлөмжийг боловсруулахад оршино.

Дээрх зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг шийдвэрлэх болно. Үүнд:

Багц зорилт 1: Судалгааны арга зүй аргачлал боловсруулах

- Монголын залуучуудын улс төр, нийгмийн оролцоо, нас сэтгэхүй, түүх соёлын хөгжлийг тодорхойлох арга зүй, аргачлал боловсруулах, олон улсын сайн туршлага болон үндэсний хэмжээнд ашиглаж буй арга зүй, аргачлалыг харьцуулах судлах

Багц зорилт 2: Боловсруулсан арга зүй, аргачлалыг ашиглан эмпирик судалгаа хийх

- Залуучуудын үзэл бодол, хандлага, санаа бодлыг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан дэлгэрэнгүй судлах;
- Залуучуудын төлөвшилд нөлөөлөх хүчин зүйлсийг судлах;
- Залуучуудын нийгэм, соёл, улс төрийн ухамсрын өсөлтийг бий болгох нөөц, нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа;

Багц зорилт 3: Төслийн үр дүнг хэрэглээний эргэлтэнд оруулах нь


- Залуучуудын талаарх төрийн болон олон нийтийн байгууллагын хэрэгжүүлэх бодлого шийдвэр, зөвлөмж боловсруулах
- Төслийн үр дүнг сонирхогч талуудад хүргэх, шаардлагатай нөлөөллийн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх санал боловсруулах
- Төслийн үр дүнгээр эрдэм шинжилгээ, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах
- Төслийн үр дүнг хэвлэх нийтлэх

ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

2.1 Судалгааны арга зүй, аргачлал

Залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас, сэтгэхүй, бие бялдар, түүх соёлын хөгжлийг тодорхойлох суурь судалгааны мэдээллийг цуглуулахдаа тоон ба чанарын судалгааны арга зүйг хослуулан явуулсан болно. Үүнд тоон ба чанарын судалгааг явуулахдаа анхдагч ба хоёрдогч мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийсэн.

Зураг-1.1. Судалгааг хэрэгжүүлэх аргачлал, үйл ажиллагааны тойм



Залуучуудаас мэдээлэл цуглуулахад асуумж, бүлгийн ярилцлагыг үндсэн арга болгосны зэрэгцээ баримт бичгийн судалгааны аргыг ашиглан мэдээлэл цуглуулсан. Анкетын аргаар цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийх орчин үеийн багц программ “SPSS-25.0”-ыг хэрэглэн боловсруулсан юм. Цуглуулсан мэдээлэлд анхдагч үр дүн болох нэг хэмжээст тархалтыг тооцохын зэрэгцээ, шинээр хувьсагч үүсгэх, логик ангилал гаргах,

харьцуулалт болоод статистик шинжилгээ зэрэг мэдээлэл боловсруулалтыг хийж нэгтгэн дүгнэсэн болно.

- **Зорилт, арга, судлах зүйл**

Хүснэгт-1.1. Зорилт, арга, судлах зүйл

| | Зорилт | Судалгааны арга | Сонгох баримт, судлах зүйл |
|---|---|------------------------------------|---|
| 1 | Холбогдох бодлогын баримт бичиг, мэдээлэлд дүн шинжилгээ хийх | Баримт бичгийн судалгаа | Үндэсний хэмжээнд хэрэгжиж буй хууль, эрх зүйн орчин, залуучуудын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагаа, сургалт, судалгааны тайлан, материал, баримт бичиг г.м |
| 2 | Залуучуудаас асуумжийн аргаар судалгаа авах | Асуумж судалгаа | Судалгааны зорилго, зорилттой уялдуулан нийт оюутан залуучуудыг судалгаанд хамруулах |
| 3 | Хөтөлбөрийн үр шимийг хүртэгч болон хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлж буй залуучуудаас нийслэл, аймгийн төв, сумдад ганцаарчилсан ба бүлгийн ярилцлага хийх | Ганцаарчилсан ба бүлгийн ярилцлага | Нийслэл, аймаг, сумдын түвшинд хөтөлбөрийн хүрээнд сургалт, үйл ажиллагаа, арга хэмжээнд хамрагдсан залуучуудаас чанарын мэдээлэл цуглуулах |

Судалгаанд оролцогчдоос мэдээлэл цуглуулахад асуулга, бүлгийн ярилцлагыг үндсэн арга болгохын зэрэгцээ аймаг, орон нутгийн залуучуудын хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан оюутан, залуучуудаас ганцаарчилсан сурвалжлагын аргыг ашиглан мэдээлэл цуглуулсан болно.

Анкетын аргаар цуглуулсан мэдээллийг боловсруулалт хийх орчин үеийн багц программ “SPSS-25.0”-ыг ашиглан боловсрууллаа. Цуглуулсан мэдээлэлд анхдагч үр дүн болох нэг хэмжээст тархалтыг тооцохын зэрэгцээ, шинээр хувьсагч үүсгэх, логик ангилал гаргах, харьцуулалт болоод статистик шинжилгээ зэрэг мэдээлэл боловсруулалтыг хийж нэгтгэн дүгнэсэн.

Мэдээлэл цуглуулах бүхий л хэрэглэгдэхүүн нь(асуумж, ярилцлагын болон баримт бичгийн шинжилгээ гм) чанарын баталгаа хангасан судалгааны зорилго, зорилтыг хэрэгжүүлэхүйц аргууд байлаа.

- **Баримт бичгийн шинжилгээ**

Үндэсний хэмжээнд хэрэгжсэн бодлого, хууль эрх зүй болон залуучуудын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, аймаг, дүүрэг орон нутагт зохион байгуулсан үйл ажиллагаа, сургалтын гарын авлага, судалгааны тайлан, материал, баримт бичигт дүн шинжилгээ хийсэн.

- **Анкет-асуумжийн арга**

Судалгааны зорилго, зорилттой уялдуулан өсвөр үе залуучууд, их дээд сургуулийн оюутнуудыг хамруулж, залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас, сэтгэхүй, бие бялдар, түүх соёлын онцлогийг тодорхойлох стандарт асуумжийн маягт ашиглан мэдээлэл цуглуулсан.

- **Ганцаарчилсан ба бүлгийн сурвалжлага хийх**

Нийслэл, аймгийн түвшинд үйл ажиллагаа явуулж буй залуучуудын хөгжлийн төв хариуцсан мэргэжилтэн, зорилтот бүлгүүдээс нэмэлт мэдээлэл олж авах зорилгоор ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийлээ. Залууст тулгамдаж буй нийгэм, эдийн засаг, улс төрийн асуудал, өнөөгийн нөхцөлд байдалд тулгуурлаж, аймгийн төв, дүүргээс бүлгийн ярилцлагад сонгон хамруулсан болно.

1.1. Судалгааны түүвэр, объект

Түүврийн тоо хэмжээг тоон болон чанарын аргын хувьд харилцан адилгүй тогтоов. Судалгаа хийх талбар болон түүврийн тоо хэмжээг Схем зураг 1.1-ээс үзнэ үү. Түүврийн хэмжээг тогтоохдоо дараах томъёоллоор тооцсон болно. Үүнд:

$$n = \frac{Z^2 * (P_0) * (1 - P_0)}{e^2}$$

- Z^2 = хүсэж буюу ач холбогдлыг тодорхойлсон статистик утга
- P_0 = түлхүүр үзүүлэлтийн тооцоо (хувийн жин)
- e = алдааны хязгаар

Жич: Ач холбогдлын түвшин 95%, алдах магадлалыг 5% байхаар тооцоо. $P = 0.05$ гэсэн стандарт утгаар авч тооцсон болно.

Эх олонлогийн хэмжээ 100 мянгаас дээш байгаа тохиолдолд тухайн аргачлалаар тооцож үзэхэд түүвэр олонлогийн нийт хэмжээ $n \approx 800$ байгаа бөгөөд бид санал асуулгын

судалгааны түүврийн зохист хэмжээг зорилтот бүлгийн эх олонлогийн тоо хэмжээнд тулгуурлан тооцоолсон болно.

Анкетийн аргаар мэдээлэл цуглуулах судалгаанд 16-40 хүртэлх насны 2000 залуучуудыг хамруулсан ба олон шатат зорилтот болон санамсаргүй түүвэрлэлт хийсэн. Монголын нийт залуучуудыг төлөөлөхүйц түүвэрийн бүтэц бүрдүүлэх үүднээс хоёр шатлал бүхий зорилтот түүвэрлэлт хийсэн ба түүврийн гурав дахь шатанд судалгаанд оролцох респондент /судалгаанд оролцогч/-ийг санамсаргүй байдлаар сонгосон болно.

Түүврийн I шат. Монгол Улсын 16-40 хүртэлх насны нийт залуучуудыг төлөөлөхүйц түүвэрлэлт хийхийн тулд Монголын нийгэм, эдийн засгийн бүсүүдийн төлөөлөх аймгууд болон нийслэлийг зориудаар түүвэрт оруулсан болно.

- Баруун бүсийг төлөөлүүлэн олон ястаны өлгий нутаг, баруун бүсийн хөгжлийн тулгуур төв болох Ховд аймгийг,
- Хангайн бүсээс хамгийн олон хүн амтай, аялал жуулчлалын бүс нутаг болох онцлогтой Хөвсгөл аймгийг,
- Төвийн бүсээс газар тариалангийн гол бүс нутаг болох Сэлэнгэ аймаг, харьцангуйгаар хотын соёл нэвтэрсэн Орхон аймаг буюу Эрдэнэт хотыг,
- Говийн бүсээс уул уурхайн үйлдвэрлэлээрээ Монголын эдийн засгийн өсөлтийг хангах, залуучууд олноороо очиж ажиллаж буй ашигт малтмалын өлгий нутаг Өмнөговь аймгийг тус тус,
- Зүүн бүсээс зүүн бүсийн хөгжлийн тулгуур төв, хүн амын суурьшил нягтрал ихтэй Дорнод аймгийг,
- Дээрх аймгуудаас гадна Монголын хүн амын бараг 2/3 нь суурьшсан, соёл боловсрол, үйлдвэрлэл үйлчилгээний хамгийн том төв болсон нийслэл Улаанбаатар хотыг түүвэрт хамруулсан.

Түүврийн II шат. Дээр сонгогдсон аймаг, хотуудаас судалгаанд хамрагдах 2-3 сумыг хүн амын тоо, байршил зэргийг нь харгалзан сонгоно. (Судалгаанд хамрагдах сумуудын нэрсийг хүснэгт.1-ээс харна уу.) Харин нийслэлийн төвийн 6 дүүрэг болон алслагдсан Налайх, Багануур дүүргүүдийг тус тус судалгаанд хамруулахаар сонгосон болно.

Түүврийн III шат. Түүврийн I, II шатанд зориудаар сонгосон судалгааны нэгжүүдээс судалгаанд шууд хамрагдах респондентуудыг судалгааны явцад санамсаргүй түүврийн аргаар сонгосон болно. Судалгааны түүврийн хэмжээг 16-40 насны 2000 хүн байхаар тогтоосон. Үүнийг сүүлийн 15 жилийн судалгааны практикт үндэслэн тогтоосон бөгөөд

энэ нь түүврийн алдаа хамгийн бага байх түүврийн зохист хэмжээ гэж үзэж байна. Харин хот, дүүрэг, аймаг, сумдаас судалгаанд хамрагдах респондентын тоог тухайн нэгжийн /хот, дүүрэг, аймаг, сум/ 16-40 насны нийт залуучуудын эзлэх хувийн жинд харгалзуулан тогтоосон болно. Судалгааны түүвэрлэлтийн тоо хэмжээг Хүснэгт 2-оос үзнэ үү.


Хүснэгт-1.2. Тоон судалгааны түүврийн тоо хэмжээ

| | Судалгааны талбар | Төлөвлөсөн | Бодит | Хүчинтэй |
|---|---|-------------|-------------|-------------|
| 1 | Ховд аймаг: ✓ Жаргалант сум /аймгийн төв/ ✓ Буянт сум | 150 | 161 | 161 |
| 2 | Хөвсгөл аймаг: ✓ Мөрөн сум /аймгийн төв/ ✓ Хатгал сум | 150 | 169 | 169 |
| 3 | Сэлэнгэ аймаг: ✓ Сүхбаатар сум /аймгийн төв/ ✓ Баянгол сум | 150 | 150 | 150 |
| 4 | Орхон аймаг: ✓ Баян-Өндөр сум | 150 | 182 | 182 |
| 5 | Өмнөговь аймаг: ✓ Даланзадгад сум /аймгийн төв/ ✓ Ханбогд сум | 150 | 170 | 170 |
| 6 | Дорнод аймаг: ✓ Хэрлэн сум /аймгийн төв/ ✓ Дашбалбар | 150 | 176 | 176 |
| 7 | Улаанбаатар хот: ✓ Багануур дүүрэг ✓ Баянгол дүүрэг ✓ Баянзүрх дүүрэг ✓ Налайх дүүрэг ✓ Сүхбаатар дүүрэг ✓ Сонгинохайрхан дүүрэг ✓ Хан-Уул дүүрэг ✓ Чингэлтэй дүүрэг | 1000 | 1032 | 1016 |
| | Нийт: | 1900 | 2040 | 2024 |

Судалгаанд нийт 9 дүүрэг, зургаан аймгийн оюутан суралцагч, өсвөр үе, залуучуудыг хамруулсан байна. Түүвэрлэлт хийх аргачлал нь олон шатат, мужилсан байлаа. Судалгаа хийх талбараас Асуумж судалгааны мэдээллийг 2000 гаруй иргэд, олон нийтээс авахаар төлөвлөсөн ба нийт 2040 асуумж авч, 2024 асуумж чанарын шаардлага хангасан тул үр дүнд шинжилгээ хийсэн. Санал асуулгын судалгаанд хамрагдсан залуучуудын тоо хэмжээг тухайн орон нутгийн хүн амын тоо хэмжээнд тулгуурлан, хувь тэнцүүлсэн түүвэрлэлтийн аргыг ашиглаж түүврийн хэмжээг тогтоосон.

Мэдээллийн түүврийн тооцоолол, тоо хэмжээнд нийцүүлэн дараах оролцогчдоос түүвэрлэлтийг мужилсан хэлбэрээр хийсэн болно. Судалгаанд баримт бичгийн судалгаа, санал асуулга, фокус бүлгийн болон ганцаарчилан ярилцлагын аргыг тус тус ашигласан болно.

Зураг-1.2. Судалгааны ажлын хамрах хүрээ



Санал асуулгын аргаар оюутан залуучуудаас мэдээлэл авсан. Үүний зэрэгцээ хөтөлбөрийг хэрэгжүүлэгч, оролцогч талуудаас ганцаарчилсан ярилцлага, иргэд, оюутан залуус, сурагчдын дунд бүлгийн ярилцлага, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй үйлчилгээ, арга хэмжээний талаар баримт бичгийн шинжилгээг тус тус хийсэн болно.


2.2 Судалгааны багийн зохион байгуулалт ба үйл ажиллагааны төлөвлөгөө

Аймаг, дүүргийн хэмжээнд тоон ба чанарын судалгаа хийх, тайлан, санал дүгнэлт боловсруулах ажлыг зохион байгуулахад МУИС-ийн төслийн багийн багш, судлаачид оролцож, түүвэр судалгааг орон нутагт явуулсан болно.

1. Судалгааны аргачлал, хүрээг танилцуулах: Судалгааны баг судалгааны сэдэв, аргачлалаа танилцуулж, санал авна.
2. Ажлын зорилго, аргачлалыг танилцуулах уулзалт зохион байгуулах: Ажлын хэсгийн уулзалтыг захиалагч талтай хамтран зохион байгуулах ба уулзалтад дараах бүрэлдэхүүнийг багтаасан болно.
 - Залуучуудын асуудлаар мэргэшсэн мэргэжилтэн
 - Залуучуудын хөгжлийн төв, түүнийг төлөөлөх албан тушаалтан;
 - Судалгааны багийн гишүүд
3. Үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах: Судалгааг гүйцэтгэх баг нь нарийн зохион байгуулалттай, шуурхай ажиллахын тулд цаг хугацааны нарийвчилсан төлөвлөгөө гаргана.
4. Туршилтын судалгаа зохион байгуулах: Дүүрэг, аймгийн залуучуудаас хамруулан явуулна.
5. Орон нутгийн судалгааны багийг чадваржуулах сургалт явуулах, хамтарч ажиллах
6. Судалгааны багийг тухайн орон нутагт ажиллах, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх
7. Судалгааны баг судалгааны нэгдсэн тайланг ажлын хэсэгт танилцуулж, санал, шүүмжлэлийг авах.

Судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд оролцогч байгууллагуудын хамтын ажиллагаа, судалгааны багийг зохион байгуулж ажил, үүргийг хуваарилна.

Зураг-1.3. Судалгааны ажлын зохион байгуулалт



Орон нутгийн залуучуудын салбар зөвлөл, Залуучуудын хөгжлийн төвийн мэргэжилтнүүд судалгаа, шинжилгээнд шаардлагатай мэдээллийг гаргаж өгөх чиглэлд хамтарч ажилласан.

Судалгааны багийн ажил үүргийн хуваарь

- Судалгааны багийн ахлагч нь судалгааны стандарт асуулгын хуудас, сургалт, туршилтын судалгаа удирдан зохион байгуулах;
- Талбарын ахлагч нар судалгааны ажлыг удирдаж, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах;
- Хянагч нар мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа, мэдээллийн чанарт хяналт тавьж ажиллах;
- Мэдээллийн сан хариуцсан судлаач мэдээллийг компьютерт үнэн зөв оруулж байгаад хяналт тавьж мэдээллийн сангийн чанарыг хариуцна;
- Мэдээлэл цуглуулалтад ажиллах судлаач нь судалгааны асуулгын хуудсыг ашиглан үнэн зөв нөхүүлж мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэнэ;
- Тайлан боловсруулах баг нь судалгааны мэдээллийн баазад хяналт хийж, тайлангийн боловсруулалтын ажлыг гүйцэтгэнэ.

Судалгааны баг нь бэлтгэл ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэх болно.
Үүнд:


1. Судалгааг хэвлэмэл асуулгаар авах ба цахим хэлбэрт шилжүүлж, шивэлтийн программд боловсруулна;
2. Түүвэрлэлтийн дагуу судалгаанд хамрагдах иргэд, хүмүүстэй холбогдож, судалгааны зорилго, ач холбогдлыг танилцуулан, судалгаа авах цаг хугацааг товлох;
3. Мэдээлэл цуглуулалтын багийг бүрдүүлэх: Мэдээлэл цуглуулалтын багийг бүрдүүлэхдээ өмнө нь судалгаанд ажиллаж байсан дадлага, туршлагатай судлаачдыг сонгон ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажилласан.
4. Мэдээлэл цуглуулалтад ажиллах судлаачдын сургалтын бэлтгэл ажил, сургалт зохион байгуулах: Сургалтын хөтөлбөр боловсруулах, асуулга танилцуулах, мэдээлэл цуглуулалттай холбоотой сургалт зохион байгуулах, судлаачдад зориулсан мэдээлэл цуглуулалтын сургалтын зохион байгуулсан.
 - ✓ Судалгааны асуулга, ойлголт тодорхойлолтыг заах, эзэмшүүлэх
 - ✓ Асуулгыг зориулалтын Excel болон SPSS програмд оруулах зааварчилгаа өгөх
 - ✓ Багийн гишүүдийн үүрэг хариуцлага, зохион байгуулалтад чиглэл өгөх

Судалгааны тоон болон чанарын бусад хэрэглэгдэхүүнд захиалагчийн саналыг тусган боловсруулж, мэдээлэл цуглуулах, боловсруулах, нэгтгэн дүгнэх, тайлан зөвлөмж бичих бүхий л шатанд МУИС-ийн төслийн багийн багш, судлаачдын баг ажиллана.

2.3 Судалгааны багийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Судалгааны анкет болон бусад хэрэглэгдэхүүнд захиалагчийн саналыг тусган боловсруулж, мэдээлэл цуглуулах, боловсруулах, нэгтгэн дүгнэх, тайлан зөвлөмж бичих бүхий л шатанд МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхимийн багш судлаачдын багаас бүрдсэн мэргэжлийн судлаачдын баг ажилласан. Судалгааг захиалагч талаас тусгасан хугацаанд явуулахаар төлөвлөсөн боловч Ковид-19 цар тахлын улмаас мэдээлэл цуглуулалт хойшилсон ба мэдээлэл цуглуулалтыг хийсний дараагаар судалгааны мэдээллийн сан үүсгэж, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, тайлан бичих ажлууд хийгдсэн болно.

Зураг-1.4. Багийн бүрэлдэхүүний схем



2.4 Төслийн хүрээнд хийсэн судалгаанаас хүлээгдэж буй үр дүн, бүтээгдэхүүн

Энэхүү судалгаа нь өнөөгийн нийгэмд өрнөж буй олон талт (эдийн засаг, хууль эрхзүй, улс төр, боловсрол) хямралын үед залуучуудын идэвхи оролцоог дэмжих, нээлттэй, иргэний нийгмийг төгөлдөржүүлэх, залуучуудад чиглэсэн төр засгийн зохистой бодлогыг боловсруулах эрэлт шаардлагыг тодорхойлоход үйлчилж байгаагаараа ач холбогдолтой юм. Мөн Монголын залуучуудын нийгэм, улс төрийн оролцоог хангах боломж, эрсдэлийг тогтоож, эерэг хүчин зүйлийг бодит болгон хэрэгжүүлэх арга зам, хөтөлбөр бодлогыг боловсруулахад шийдвэр гаргагчдад чухал судалгааны эх хэрэглэгдэхүүн болно. Захиалгат төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэхээр төлөвлөсөн болно. Үүнд:


- ✚ Залуучуудын үзэл бодол, үнэт зүйл, хандлага, санал бодлыг тодорхойлох судалгааны аргачлал боловсруулсан.
- ✚ Монголын нийгэм дэх залуучуудын хөгжилд тулгамдаж буй асуудал, өөрчлөлтийн хэлбэр, шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс, түвшин, үр дагаварын зураглал гаргасан.
- ✚ Залуучуудын хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагааны талаарх төрийн болон олон нийтийн байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, бодлогын санал зөвлөмж боловсруулсан.

ГУРАВ. ЗАЛУУЧУУДЫН НИЙГЭМ, УЛС ТӨРИЙН ОРОЛЦОО, НАС, СЭТГЭХҮЙ, БИЕ БЯЛДАР, ТҮҮХ СОЁЛЫН ХӨГЖЛИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

3.1 Судалгаанд хамрагдсан залуусын нийгэм, хүн ам зүйн үзүүлэлтүүд


Энэ хэсэгт судалгаанд оролцсон залуусын нас, хүйс, боловсрол болон ажил эрхлэлийн үзүүлэлтийг авч үзлээ. Эдгээр үзүүлэлт бол залуучуудын нийгэмд эзлэх байр байдлыг тодорхойлохын зэрэгцээ нийгэм, улс төрийн оролцоо, тулгамдаж буй асуудал, сэтгэхүй болон үнэт зүйл, соёлын хөгжлийг тодорхойлох чухал үзүүлэлт болно.

Судалгаанд хамрагдсан залуучуудын насны ангилалыг 20 хүртэлх насны, 21-25 хүртэлх, 26-30 хүртэлх, 31-35 хүртэлх, 36-40 хүртэлх дөрвөн бүлэгт хувааж үзсэн. Судалгаанд хамрагдсан залуучуудын 8.1% нь 20 хүртэлх насны өсвөр залуус, 30.2% нь 21-25 хүртэлх насны орь залуус, 25.4% нь 26-30 хүртэлх насны идэр залуус байсан юм. Харин 31-35 хүртэлх насны төгс залуус 19.1%-ийг эзэлж байгаа бол, 36-40 хүртэлх насны залуучууд 17.2%-ийг бүрдүүлж байлаа.



Дүрс-2.1 Судалгаанд хамрагдсан залуучуудын насны бүлэг


Залуучуудын насны эдгээр үзүүлэлтэд тулгуурлан тухайн нийгмийн бүлэгт чухам ямар асуудал тулгамдсан шинжтэй байгааг судалж болно. Судалгаанд хамрагдсан залуучуудын хүйсийн байдлыг харьцуулан авч үзэхэд залуучуудын 37.7% буюу 764 нь эрэгтэй, 62.3% буюу 1260 нь эмэгтэй байв.



Дүрс-2.2 Залуучуудын хүйсийн байдал

Хүйсийн байдал нь бидний хувьд залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас, сэтгэхүй, соёл, үнэт зүйлийн хөгжлийг тодорхойлоход нэн чухал үзүүлэлт юм.

Судалгаанд хамрагдсан залуусын боловсролын нөхцөл байдлыг энд мөн авч үзсэн. Судалгааны үр дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан залуусын 56.7 хувь нь дээд боловсролтой, 7.1 хувь нь тусгай дунд боловсролтой, 31.2 хувь нь бүрэн дунд боловсролтой хүмүүс байв. Харин суурь боловсролтой залуус 4.3 хувийг эзэлж байсан бол бага буюу боловсрол эзэмшээгүй залуус 0.6 хувийг эзэлж байсан болно.




Дүрс-2.3 Залуучуудын боловсролын байдал

Залуучуудын эзэмшсэн мэргэжлийн чиглэлийг салбараар авч үзэхэд дараах онцлог харагдаж байна. Тухайлбал, өнөөгийн залуучуудын 22.8 хувь нь нийгэм, эдийн засгийн мэргэжилтэй байгаа бол 15.6 хувь нь техник инженерийн мэргэжил эзэмшсэн байна. Мөн

улс төр хууль эрхийн чиглэлээр 5.2%, байгаль шинжлэлийн чиглэлээр 5.7%, эрүүл мэндийн чиглэлээр 6.2% нь мэргэжил эзэмшсэн бол 37.3% нь бусад чиглэлийн мэргэжилтэй буюу суралцаж байгаа гэсэн хариулт өгсөн юм.

Залуучуудын боловсрол мэргэжил нь цаашид ажил эрхлэх, амьжиргаагаа залгуулах үндэс болж өгдөг. Иймд залуучуудын нийгэмд эзлэх байр сууриа тодорхойлох чухал үзүүлэлтийн нэг бол ажил эрхлэлтийн байдал юм. Судалгаанд оролцогчдын хариултаас үзэхэд залуу өрхөд хоёулаа ажил эрхэлдэг- 53.9%, ганцаараа ажил эрхэлдэг өрх 33.2%-тай байна. Судалгаанаас үзэхэд өрхөд ямар нэг байдлаар ажил эрхэлдэггүй хүн тохиолдох байдал-73.8 хувьтай байгаа нь ихээхэн өндөр үзүүлэлт болно.

Танай гэр бүлийн хүн(эхнэр, нөхөр) ажил эрхэлдэг үү? гэсэн асуултад залуучуудын 56.9% нь тийм, 20.8% нь үгүй гэсэн хариулт өгчээ. Харин судалгаанд оролцсон таван залуу тутмын нэг нь(22.3%) энэ асуултад хариулт өгсөнгүй.



Дүрс-2.4 Залуучуудын ажил эрхлэлтийн байдал

Залуучууд ямар нэг байдлаар ажил эрхлэлтийн үр дүнд нийгмийн баялгаас хувь хүртэх буюу чухамдаа өрхийн цалин орлогоо бүрдүүлж, амьжиргаагаа залгуулдаг билээ.

Залуучуудын хувьд зарим нь өрх тусгаарлаж, гэрлэсэн бол зарим нь эцэг эхийн хамт амьдрадаг тухайгаа дурдсан байна. Судалгаанд хамрагдсан залуучуудаас өрхийн сарын дундаж орлогыг тэдний оролцоотойгоор тооцоход ойролцоогоор 720.0 мянган төгрөгийн орлоготой гэсэн хариулт өгсөн юм. Энэ нь улсын хэмжээнд авч үзэхэд нэг өрхөд ноогдох өрхийн сарын дундаж орлогоос 500.0 мянга орчмоор бага байна. Харин нэг залуу өрхөд дунджаар 3.8 ам хүн ам ногдож байгаа бөгөөд үүнд тулгуурлан нэг залуу

хүнд оногдож буй сарын дундаж орлогыг тооцож үзвэл 226.2 мянган төгрөг оногдож байна.

Хүснэгт-2.1 Залуу өрхийн сарын дундаж орлого, ба нэг хүнд ноогдох орлого

| | N | Дундаж | Улсын дундаж | Зөрүү |
|--|------|-------------|--------------|-----------|
| Танай өрхийн сарын дундаж орлого хэд вэ? | 1384 | 718988.29 | 1621454 | 902465.71 |
| Танай өрхийн ам бүлийн тоо хэд вэ?/ | 2024 | 3.5 | 4 | 0.5 |
| Нэг хүнд ноогдох орлого | 1384 | 226279.7588 | 405363,5 | 179083.74 |

Залуу өрхийн орлого бага байгаа боловч өөрсдийн амьжиргааны түвшинг үнэлэхдээ дундаж болон сайн гэсэн үнэлгээг өгсөн байна. Түүнчлэн залуус олж буй орлого, амьжиргааны түвшингээс үл хамаарч өөрсдийгөө нийгмийн дунд давхаргад оруулж үзэх явдал нийтлэг байна. Энэ нь судлаачдын тэмдэглэснээр алтан дунджийг баримталдаг зарчим, одоогийн нөхцөл байдлаар ирээдүйд сайжирна гэсэн өөдрөг төсөөлөл, мэдрэмж хүлээлтэй холбоотой байна. Тогтвортой хэрэглээг дэмждэг, хэрэгцээг бий болгодог, нийгэм эдийн засгийн гол тулгуур болох нийгмийн дунд анги, давхаргын тухай яригдаж буй өнөө үед дунд ангийн амьдралын чанарын үзүүлэлт төр засгийн, бодлого гаргагчдын, эрх мэдэлтнүүдийн аль алиных нь анхаарлын төвд байх ёстой.

Монголын залуу өрхийн орлогын эх үүсвэрийг зонхилон цалин бүрдүүлж байна. Өрхийн орлогод цалин зонхилсон энэхүү “цул” байдлыг задалж, аль болох олон эх үүсвэрээс орлого олдог болгох нь тухайн өрхийн санхүүгийн эмзэг байдлыг багасгах арга зам болно. Түүнчлэн өрхөд эзлэх тэжээгчийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Өнөөгийн байдлаар залуу өрхийн нэг тэжээгчид гурван хүн оногдож байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм.


Түүнчлэн хүн ам зүйн бүлгүүд дэх хөдөлмөрийн үнэлгээ ялгавартай, цалин орлого харьцангуй бага байна. Суурь судалгааны дүнгээс үзэхэд өнөөгийн ажил хөдөлмөр эрхэлж буй залуу насны бүлгийн бараг тал хувь(49.9%) нь 500 мянга хүртэлх төгрөгийн орлоготой, залуу өрхийн аль нэг гишүүн ажил эрхлэн(74.5%) амьдарч байна. Гэтэл улсын дундаж болон бодит орлогын хэмжээ залуучуудын цалин, орлогоос 1.5-2 дахин өндөр байгаа юм. 1990 оноос хойшхи хугацаанд хөдөлмөр эрхлэлтэд хөдөө аж ахуй, төр хувийн хэвшил, нийгмийн үйлчилгээний салбар зонхилох шинжтэй байгаагийн зэрэгцээ 2010 оноос хойш уул уурхай, үйлчилгээний салбарт ажиллаж буй хөдөлмөрийн насны

тоо хэмжээ өсөн нэмэгдэж байна. Залуучуудын өрхийн орлогын эх үүсвэрийг авч үзэхэд судалгаанд оролцогчдын 47.9% нь зөвхөн цалингаас, 14.2% нь бизнес наймааны орлогоос, 10.8% нь хүүхдийн тэтгэмжээс тус тус үндсэн орлогоо бүрдүүлж байгаа нь харагдаж байна. Үүний зэрэгцээ залуу өрхийн орлогод эцэг эхчүүдийн тэтгэвэр тэтгэмж-8.4%, өрхийн аж ахуй-6.2%, хамаатан садны дэмжлэг туслалцааг-4.8% ихээхэн нэмэртэй байдаг талаар дурдсан.

Хүснэгт-2.2 Залуу өрхийн орлогын эх үүсвэрийн байдал

| | Хариулт | | Тохиолдлын тоо |
|--|---------|--------|----------------|
| | Тоо | Хувь | |
| Цалин | 1552 | 47.9% | 80.3% |
| Түрээсийн ашиг | 98 | 3.0% | 5.1% |
| Бизнес, наймааны орлого | 460 | 14.2% | 23.8% |
| Өрхийн аж ахуй/мал, ногоо, туслах аж ахуй/ Зээлдүүлсэн болон хадгаламжийн хүүгийн орлого | 201 | 6.2% | 10.4% |
| Мөнгөн тусламж/гадаадаас гуйвуулсан мөнгө/ Тэтгэвэр тэтгэмж | 76 | 2.3% | 3.9% |
| Хамаатан садны дэмжлэг туслалцаа | 32 | 1.0% | 1.7% |
| Хүүхдийн тэтгэмж | 272 | 8.4% | 14.1% |
| Бусад хариултууд | 155 | 4.8% | 8.0% |
| НИЙТ | 349 | 10.8% | 18.1% |
| | 46 | 1.4% | 2.4% |
| | 3241 | 100.0% | 167.7% |

Төслийн хүрээнд хийсэн суурь судалгааны дүнгээс үзэхэд залуу өрхийн орлогын хүрэлцээ тааруу байгаа нь анхаарал татаж байна. Нийт залуу өрхийн талаас илүү хувь нь өдөр тутмын хооллох, хувцаслах хэрэгцээгээ хангах төдийгөөр “тарчигхан” байдалтай амьдарч байгаа юм. Залуус суралцах, гэрлэж өрх тусгаарлах, хүүхэд өсгөхөд олон төрлийн зайлшгүй зардал үүсэх, улмаар хүүхэд төрж өрхийн гишүүн ажилгүй болох, цалин орлогогүй болох үед залуусын амьжиргааны түвшин мэдэгдэхүйц дорддог байна. Өрхийн орлогын энэхүү нөхцөл байдал нь залуучуудын хэрэгцээг хэрхэн хангаж буй талаар асуухад дараах хариултыг өгсөн юм. Судалгаанд хамрагдсан залуучууд өрхийн орлогын хүрэлцээг тааруухан гэж 54.0% нь үнэлсэн байна. Тухайлбал, өдөр тутмын ойр зуурын хэрэгцээнд ч хүрэлцдэггүй гэж 13.5% нь, өдөр тутмын хэрэгцээгээ л хангадаг гэж 40.5% нь үзжээ. Өнөөгийн хүн амын хувьд мөнгөн орлого хомс, хэрэгцээгээ хангах байдал хязгаарлагдмал байгаа нь тэдгээрийн нийгмийн амьдралд эзлэх байр суурь, анги давхаргын байдал, харилцааг тодорхойлох гол хүчин зүйл болж байна.



Дүрс-2.5 Өрхийн орлогын хүрэлцээний байдал


Тэрчлэн судалгаанд хамрагдсан гурван өрх тутмын нэг нь буюу 33.6% нь ямар нэг байдлаар өдөр тутмын хэрэгцээгээ хангаж, дээр нь хэрэгцээтэй зүйлээ авчихдаг гэсэн хариултыг өгсөн байна. Орлогын хувьд боломжийн буюу үндсэн хэрэгцээгээ хангахаас гадна, хүссэн зүйлсээ авч чаддаг чинээлэг өрх 9.5 хувийг эзэлж байна. Дурдсан хүн ам зүйн бүлгийн боловсрол, мэдлэгийн түвшин өсөхийн хэрээр хөдөө аж ахуй, газар тариалан, ан агнуурын салбарт хөдөлмөр эрхлэхээс илүүтэй, үйлдвэр үйлчилгээний байгууллагад ажиллах хандлага харагдаж байна. Залуус олноороо суралцаж, дээд боловсролтой хүмүүсийн хувь хэмжээ байнга өсөн нэмэгдэж байгаа энэ үед орлого өндөртэй, тав тухтай орчинд ажиллах хөдөлмөрийн зах зээлийн өрсөлдөөнийг бий болгох нь дамжиггүй. Гэсэн хэдий ч залуу хүмүүст тулгамдаж буй асуудлууд болох цалин бага учир амьдралд нь хүрэлцэхгүй байх(21.3%), боловсрол ахиулсан ч цалинд өөрчлөлт ордоггүй(12.3%), мэргэжилдээ дадлагажаагүй(5.6%), боловсрол мэдлэг дутах(5.5%) явдал хөдөлмөрийн үнэлгээнд сөргөөр нөлөөлж, тэднийг ажлаа хэвийн явуулахад саад болсоор байгаа юм. Тэрчлэн хангалтай цалин орлогогүй, ажлын ачаалал их зэрэг хүчин зүйлс нь хөдөлмөрийн насны хүн амыг ажлаа солих, түр хугацаанд ажилгүй байх, улмаар урт хугацаанд ажил орлогогүй болох, цаашилбал эдийн засгийн хувьд эмзэг байдалд ороход голлох нөлөө үзүүлдэг. Хот хөдөөгөөр харьцуулан залуусын ажилгүйдлийн шалтгааныг авч үзэхэд хөдөөд ажлын байрны хүрэлцээ муу, хотод мэргэжлээрээ ажиллах боломж хомс, хөдөлмөрийн цалин урамшуулал бага, хөдөлмөрийн нөхцөл муу байгаагаас ажилгүйдэлд өртөх нь их байна.

Залуучуудын хувьд ажил албан тушаалын ахиц дэвшлээс гадна амьдралын хувьд гэр бүл зохиох, гэр бүлээ авч явах чухал сонголттой нүүр тулгардаг. Судалгааны үр дүнгээс үзэхэд залуучуудын 51.0% нь гэрлэсэн, бүртгэлтэй хамтдаа амьдардаг, 27.7% нь гэрлээгүй, 7.4% нь нөхөр, эхнэрт гарсан боловч албан ёсоор батлуулаагүй, 4.8% нь гэрлээгүй, хамтдаа амьдардаг хүнтэй, 4.5% нь гэрлээд салсан байна.

Хүснэгт-2.3 Залуучуудын гэрлэлтийн байдал

| | Давтамж | Хувь | Бодит хувь |
|--|---------|------|------------|
| Гэрлээгүй | 540 | 26.7 | 27.7 |
| Гэрлээд салсан | 88 | 4.3 | 4.5 |
| Бэлэвсэрсэн | 44 | 2.2 | 2.3 |
| Гэрлээгүй, хамтдаа амьдардаг хүнтэй | 94 | 4.6 | 4.8 |
| Гэрлэсэн, хамтдаа амьдардаггүй | 44 | 2.2 | 2.3 |
| Нөхөр/эхнэртэй, албан ёсоор батлуулаагүй | 144 | 7.1 | 7.4 |
| Гэрлэсэн, бүртгэлтэй, хамтдаа амьдардаг | 993 | 49.1 | 51.0 |
| Нийт | 1947 | 96.2 | 100.0 |

Гэрлэсэн боловч хамтдаа амьдардаггүй 2.3%-ийг мөн эзэлж байна. Гэрлээгүй залуучуудаас Хэрэв та гэрлээгүй бол хэдэн насандаа гэрлэх бодолтой байгаа талаар асуухад хамгийн бага нь 13, хамгийн их нь 43 насандаа гэрлэх төлөвлөгөөтэй байгаагаа дурдсан юм. Гэрлээгүй залуучуудын хувьд дунджаар 26-27 насандаа гэрлэх төлөвлөгөөтэй байдаг ажээ. Тэрчлэн өнөөгийн залуусыг амьдралд хэр зэрэг бэлтгэгдсэн талаар залуучуудаас лавлахад дараах байдлаар хариулжээ.



Дүрс-2.6 Өнөөгийн залуусын амьдралд бэлтгэгдсэн байдал

Та гэр бүлтэй холбоотой дараах бодомжуудын талаар өөрийн санал бодлоо хуваалцана уу? гэсэн асуултад залуус дараах хариулт өгсөн байна.

Хүснэгт-2.4 Залуусын гэр бүл, амьдралын талаарх бодомж


| | Тийм | Үгүй | Мэдэхгүй |
|--|------|------|----------|
| Хүн орон байр, санхүүгийн асуудлаа шийдэж байж гэрлэх ёстой. | 79.3 | 14.7 | 5.9 |
| Гэрлэх хүний боловсрол, мэдлэг зэргийг харах нь чухал. | 54.6 | 33.6 | 11.8 |
| Гэрлэлтээ батлуулах албагүй, хамтран амьдрагчид бол гэр бүл мөн. | 20.7 | 61.1 | 18.2 |
| Залуучууд гэрлэсэн бол эцэг эхээс тусдаа амьдрах нь зөв. | 87.8 | 6.2 | 6.0 |
| Гэр бүлээс гадуур бэлгийн харилцаа байдаг л зүйл. | 10.8 | 68.8 | 20.3 |
| Гэрлэхдээ нөхөр, эхнэрийн удам судар, жил мэнгийг нь харах хэрэгтэй. | 53.2 | 26.3 | 20.5 |
| Гэрлэхэд хайр сэтгэлээс гадна гэрлэгч талын бэл хөрөнгө чухал. | 15.6 | 66.6 | 17.8 |
| Хожуу гэрлэлт эрт гэрлэлтээс баг бөх байдаг. | 26.5 | 22.2 | 51.3 |
| Хүүхэд боловсролоос гадна зөв хүмүүжил, ёс суртахуунтай байх нь чухал. | 93.1 | 3.4 | 3.5 |
| Өрхийн тэргүүн гэр бүлээ тэжээн тэтгэж, амьдралаа авч явах ёстой. | 76.4 | 16.5 | 7.1 |
| Хүүхэд хүмүүжилтэй байх нь чухал биш, амьдралаа авч явах чадвартай байх | 44.7 | 41.4 | 14.0 |
| Хүүхдийн мэргэжил сонголтод эцэг эхчүүд нөлөөлөх ёстой. | 62.3 | 28.2 | 9.6 |

Судалгааны үр дүнгээс үзэхэд Хүүхэд боловсролоос гадна зөв хүмүүжил, ёс суртахуунтай байх нь чухал-93.1% гэдгийг залуучууд онцолж дурдсан байна. Мөн залуучуудын хувьд гэрлэсэн бол эцэг эхээсээ тусдаа амьдрах нь зөв гэдэгтэй 87.8% нь санал нийлжээ. Судалгаанд хамрагдсан залуучуудын ихэнх нь буюу 79.3% нь орон байр, санхүүгийн асуудлаа шийдэж байж гэрлэх ёстой гэсэн хариултыг өгсөн байна.

Эдгээр эерэг зан төлөв, хариултаас гадна хүүхэд хүмүүжилтэй байх нь чухал биш, амьдралаа авч явах чадвартай байх нь чухал-44.7%, Гэрлэх хүний боловсрол, мэдлэг зэргийг харах нь чухал-54.6%, Гэрлэлтээ батлуулах албагүй, хамтран амьдрагчид бол гэр бүл мөн-20.7%, Гэрлэхэд хайр сэтгэлээс гадна гэрлэгч талын бэл хөрөнгө чухал-15.6%, Гэр бүлээс гадуур бэлгийн харилцаа байдаг л зүйл-10.6% нь сөрөг зан үйл, амьдралын хэв маягийг дэмжсэн байна.

Түүнчлэн хүүхдийн мэргэжилт сонголтод эцэг эхчүүд нөлөөлөх ёстой гэсэн уламжлалт хандлага өндөр-63.2 хувьтай байгаа нь анхаарал татаж байсан юм. Учир нь өнөөгийн мэргэжил сонголт хийх үйл явц хэн нэгний зааварчилгаа, дутуу дулимаг мэдээлэл, сэтгэл хөдлөлөөр бус хөдөлмөрийн зах зээл, мэргэжлийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан, өөрийн авъяас ур чадварт нийцсэн байхаар шинжлэх ухааны үндэстэй, судалгаа

шинжилгээтэй, ул суурьтай сонгодог үйл явц болсон билээ. Энэхүү судалгаанд нийслэлийн 9 дүүрэг, бүс бүрийн төлөөллөөс зургаан аймаг хамрагдсан.



Дүрс-2.7 Судалгаанд хамрагдсан аймаг, нийслэлээр

Судалгаанд хамрагдсан 2000 гаруй залуучуудыг оршин суугаа аймаг, дүүргээр нь авч үзвэл 50.2 хувь нь нийслэл Улаанбаатар хотын 9 дүүргээс, 8.3% нь Хөвсгөл аймгаас, 8.0% нь Ховд аймгаас, 9.0 хувь нь Орхон аймгаас, 7.4% нь Сэлэнгэ аймгаас, 8.7% нь Дорнод аймгаас тус тус хамрагдсан байна.

3.2 Залуучуудын нийгэм, улс төрийн оролцооны байдал


Өнөөдөр дэлхийн аль ч улс оронд залуучуудын хөгжлийн асуудалд төрийн байгууллагаас эхлээд олон нийт, иргэний нийгэм онцгой анхаарах болсон. Хүн амын суурь бүлэг болох залуучуудын нийгэм, улс төрийн оролцооны асуудал бодлого, эрх зүйн талаасаа ч, нийгэм улс төрийн амьдралын хэрэгцээ шаардлага талаасаа ч анхаарал татсан чухал сэдвийн нэг юм.

Нэг талаар нийгэм, улс төрийн оролцоо нь ардчиллын суурь үзүүлэлт болох иргэний нийгмийн оролцоо, сонгуулийн оролцоо, шууд ардчилал, орон нутгийн ардчилалтай уялдаатай. Юуны өмнө ардчиллын мөн чанар болсон хувь хүний болон хамтын эрхийн тэнцвэрт байдлыг эрэлхийлэх, шударга ёс, иргэний эрх чөлөө болон нийгмийн эрх тэгш байдал зэрэг үндсэн эрхээ эдлэх нь залуучуудын хувьд нэн чухал юм.

Нийт хүн амын 38.5 хувийг 15-34 насныхан эзэлдэг бөгөөд хүн амын бусад бүлгүүдээс залуучуудын бүлэг бол суурь шинжтэй бүлэг юм. Чухамдаа Монголын залуучуудын үзэл бодол, сонголт, үйлдлээр манай орны ирээдүй цогцлон бүтнэ. Гэвч өнөөдөр манай

нийгэмд тулгамдаад буй нэгэн чухал асуудал нь залуучуудын улс төрийн оролцоо болоод байна. Өнгөрсөн хугацаанд явагдсан сонгуульд 18-25 насны залуучууд хамгийн бага хувьтай оролцсон байна. Мөн Удирдлагын академиас явуулсан залуучуудын улс төрийн оролцоог тодорхойлох судалгаагаар гурван залуу хүн тутмын нэг нь сонгуульд огт оролцдоггүй гэсэн дүн гарсан (Удирдлагын Академи, 2018) юм.

Судалгаанд хамрагдсан залуучуудын улс төрийн идэвх, сонирхол чухам ямар байгааг судлахад улс төрийг маш их сонирхдог гэж 5.2%, сонирхдог гэж 20.0%, сонирхдоггүй гэж 32.0%, огт сонирхдоггүй гэж 10.3% нь тус тус хариулжээ.



Дүрс-2.8 Залуучуудын улс төр сонирхох байдал

Дээрх үр дүнгээс үзэхэд дөрвөн залуу тутмын нэг нь буюу 25.2% нь улс төрийг сонирхдог бол гурван залуу хүн тутмын нэг нь сонирхдоггүй, 10 залуу тутмын нэг нь огт сонирхдоггүй гэж хариулсан байна.


Сүүлийн жилүүдийн залуучуудын улс төрийн оролцоо буурч, улс төрд итгэх итгэл итгэлээ алдаж байгаа нь эргээд олон сөрөг үр дагаварт хүргэж байгаа тэмдэглэх хэрэгтэй. Залуучуудын улс төрийн сонирхлыг насны бүлгээр харьцуулж үзэхэд тэдний нас багасахын хэрээр улс төрийг сонирхдоггүй гэсэн хувь хэмжээ ажиглагдаж байна. Тухайлбал, 20 хүртэлх насны бүлгийн улс төр сонирхох байдлыг авч үзэхэд их сонирхдог 20.1%, сонирхдоггүй 46.0% байна. Гэтэл энэ тоог 36-40 хүртэлх насны бүлгийн хувьд авч үзэхэд сонирхдог 27.4%, сонирхдоггүй хувь 36.8 байна. Үүнээс үзэхэд улс төрийг сонирхох байдлын үзүүлэлт залуучуудын насны бүлгүүдэд зөрүүтэй (сонирхохгүй-7.3%, сонирхдог-9.2%) байна. Хүснэгт 2.5-аас дэлгэрэнгүйг үзнэ үү?

Хүснэгт-2.5 Залуучуудын улс төрийн сонирхол(насны бүлгээр)

| | | Их сонирхдог | Сонирхдог | Дунд зэрэг | Сонирхдоггүй | Огт сонирхдоггүй | НИЙТ |
|--|--|--------------|-----------|------------|--------------|------------------|------|
| | | | | | | | |

| | | | | | | | |
|--------------------------|------|------|-------|-------|-------|-------|--------|
| 20 хүртэлх настай | тоо | 15 | 27 | 45 | 57 | 17 | 161 |
| | хувь | 9.3% | 16.8% | 28.0% | 35.4% | 10.6% | 100.0% |
| 21-25 хүртэлх | тоо | 36 | 124 | 189 | 187 | 70 | 606 |
| | хувь | 5.9% | 20.5% | 31.2% | 30.9% | 11.6% | 100.0% |
| 26-30 хүртэлх | тоо | 23 | 100 | 157 | 169 | 56 | 505 |
| | хувь | 4.6% | 19.8% | 31.1% | 33.5% | 11.1% | 100.0% |
| 31-35 хүртэлх | тоо | 14 | 69 | 137 | 127 | 36 | 383 |
| | хувь | 3.7% | 18.0% | 35.8% | 33.2% | 9.4% | 100.0% |
| 36-40 хүртэлх | тоо | 15 | 79 | 123 | 100 | 26 | 343 |
| | хувь | 4.4% | 23.0% | 35.9% | 29.2% | 7.6% | 100.0% |
| НИЙТ | тоо | 103 | 399 | 651 | 640 | 205 | 1998 |
| | хувь | 5.2% | 20.0% | 32.6% | 32.0% | 10.3% | 100.0% |

Хүйсийн хувьд харьцуулж үзэхэд эрэгтэй, эмэгтэй залуучуудын улс төрийн оролцооны түвшин ялгаатай байна. Тухайлбал, эрэгтэйчүүдийн 31.0% нь ямар нэг байдлаар улс төр сонирхдог бол, эмэгтэйчүүдийн 21.6% нь улс төр сонирхдог байна. Эсрэг тохиолдолд улс төрийг сонирхдоггүй эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 5.6%-иар илүү байгаа юм. Үүнээс үзэхэд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс улс төрийг илүү сонирхдог болох нь Дүрс 2.9-өөс харагдаж байна.



Дүрс-2.9 Улс төрийг сонирхох байдал(хүйсээр)


Монголын залуучуудын улс төрийг сонирхох байдлыг судалгааны талбараар авч үзэхэд дараах онцлог харагдаж байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд Өмнөговь аймгийн улс төр сонирхох байдал хамгийн өндөр буюу 37.1%, Дорнод, Ховд аймгийн залуучуудын 30 гаруй хувь нь, Сэлэнгэ аймгийн 25.5%, Улаанбаатар хотын 24.1%, Орхон аймгийн

залуучуудын 22.8%, Хөвсгөл аймгийн залуучуудын 11.4 хувь нь улс төр сонирхдог гэжээ.

Хүснэгт-2.6 Улс төрийг сонирхох байдал(орон нутгаар)

| | | Их сонирхдог | Сонирхдог | Дунд зэрэг | Сонирхдоггүй | Огт сонирхдоггүй | НИЙТ |
|-------------|------|--------------|-----------|------------|--------------|------------------|--------|
| Дорнод | тоо | 12 | 40 | 51 | 64 | 6 | 173 |
| | хувь | 6.9% | 23.1% | 29.5% | 37.0% | 3.5% | 100.0% |
| Ховд | тоо | 8 | 41 | 55 | 45 | 12 | 161 |
| | хувь | 5.0% | 25.5% | 34.2% | 28.0% | 7.5% | 100.0% |
| Хөвсгөл | тоо | 3 | 16 | 52 | 49 | 47 | 167 |
| | хувь | 1.8% | 9.6% | 31.1% | 29.3% | 28.1% | 100.0% |
| Өмнөговь | тоо | 12 | 51 | 51 | 46 | 10 | 170 |
| | хувь | 7.1% | 30.0% | 30.0% | 27.1% | 5.9% | 100.0% |
| Сэлэнгэ | тоо | 11 | 26 | 63 | 33 | 12 | 145 |
| | хувь | 7.6% | 17.9% | 43.4% | 22.8% | 8.3% | 100.0% |
| Орхон | тоо | 4 | 37 | 80 | 51 | 8 | 180 |
| | хувь | 2.2% | 20.6% | 44.4% | 28.3% | 4.4% | 100.0% |
| Улаанбаатар | тоо | 53 | 188 | 299 | 352 | 110 | 1002 |
| | хувь | 5.3% | 18.8% | 29.8% | 35.1% | 11.0% | 100.0% |
| НИЙТ | тоо | 103 | 399 | 651 | 640 | 205 | 1998 |
| | хувь | 5.2% | 20.0% | 32.6% | 32.0% | 10.3% | 100.0% |


Улс төрийн оролцоо бага байгаа шалтгааныг залуусын саналд үндэслэн энэхүү судалгаагаар тодорхойлсон юм.Судалгааны үр дүнгээс үзэхэд өнөөгийн залуучуудын 59.3% нь улс төрчдөд итгэдэггүй, 22.5% нь улс төрийг ойлгодоггүй, 10.5% нь улс төр надаас хамаарахгүй, 7.6% нь улс төр надад хамаагүй гэсэн байр суурь илэрхийлжээ.



Дүрс-2.10 Улс төрийг сонирхдоггүй шалтгаан

Ялангуяа улс орны ирээдүй болох залуучуудын нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлж, эрчимтэй өөрчлөгдөж байдаг эрэлт хэрэгцээг нь хангахад төрөөс дэмжлэг үзүүлэх, залуучуудын улс төрийн оролцоог өсгөх чиглэлээр оновчтой бодлого, хөтөлбөр

хэрэгжүүлэх шаардлагатай байна. Залуучуудын оролцоо нь залуучуудыг тэдний бодит хэрэгцээг хангахуйц, чадвар сорьсон шийдвэр гаргах, төлөвлөх түвшний үйл ажиллагаанд татан оролцуулснаар тэдэнд болон нийгмийн бусад хэсэгт нөлөөлөх явдал юм. Залуучуудын оролцоо нь залуучуудад санал бодлоо илэрхийлэх нөхцлийг бүрдүүлж өгөхөөс гадна тэднийг нэг зорилгын төлөө ажиллах боломжийг бүрдүүлж өгдөг билээ. Таны бодлоор өнөөгийн залуучууд чухам юуны төлөө улс төрд оролцож байгаа талаар байр суурийг нь тодруулахад дараах хариултыг өгсөн юм.



Дүрс-2.11 Залуучуудын улс төрд оролцох шалтгаан

Дээрх үр дүнгээс үзэхэд өнөөгийн залуучуудын цөөнгүй хувь(46.3%) нь улс орноо хөгжүүлэх-17.7%, эрх ашгаа хамгаалах-14.4%, төр засагт дуу хоолойгоо хүргэх-14.2% зэрэг нь улс төрд оролцох үндсэн шалтгаан болдог гэж дурджээ. Санал асуулгын зэрэгцээ чанарын судалгааны үр дүнгээс үзэхэд улс төрийн оролцооны идэвхээс үл хамааран оролцооны хэлбэрийн хувьд сонгуульд саналаа өгөх, нийгмийн сүлжээгээр дамжуулан санал бодлоо илэрхийлэх хандлага түлхүү ажиглагдсан юм.

Үүний хамт албан тушаал дэвших-12.9%, нэр алдар олох-12.8%, байр сууриа бэхжүүлэх-10.1%, мөнгө олох зувчуулах-9.7% зэрэг зорилгоор улс төрд оролцож байна гэсэн шүүмжлэлт байр суурь мөн илэрч байна. Судалгаанд хамрагдсан залуучуудын улс төрийн намын гишүүнчлэлийн байдлыг судлахад тэдгээрийн 80.3% нь ямар нэг улс төрийн намын гишүүн бус, 4.5% нь ямар нэгэн гишүүнчлэлтэй гэж хариулсан ба 8.1% нь ямар нэгэн хариулт өгөөгүй ба үлдсэн хувь нь АН, МАН, ХҮН, ИЗН зэрэг улс төрийн намуудад гишүүнчлэлтэй байна.

Залуучуудын оролцоо нь залуучуудад хувь хүнд болон нийгмийн хэмжээнд нөлөөлж чадах шийдвэр гаргах үйл явцад оролцох боломж олгох замаар тэдний хүсэл сонирхол, давуу тал, чадваруудыг таньж мэдэх явдал юм. Тухайлбал, Пэрси Смит, Томс (2010) нар

тэмдэглэхдээ жинхэнэ оролцоог бий болгохын тулд тодорхой хэмжээний шаардлагуудыг хангасан байх хэрэгтэй ба хууль, эрх зүйн орчин, мэдээллийн хүртээмжтэй байдал, шийдвэр гаргагч болон залуучуудын дунд явагдаж буй соёлын хандлагын өөрчлөлт, санал гомдлоо илэрхийлэх боломж, улс төрд оролцох арга зам, төрийн байгууллагуудын үйлчилгээ зэргийг харгалзаж үзэх хэрэгтэй ажээ. Залуучуудын хувьд төр засгийн ба оюутан залуучуудын байгууллагын үнэлгээг авсан юм. Тухайн үнэлгээнээс харахад ерөнхийдөө сайн гэсэн үнэлгээнээс илүүтэй муу гэсэн үнэлгээ давамгайлж байгааг харж болно.

Хүснэгт-2.7 Төр засгийн ба оюутан залуучуудын байгууллагын үнэлгээ

| | Сайн | Дунд | Гааруу | Муу |
|--|------|------|--------|------|
| Улсын Их Хурал | 6.9 | 44.6 | 31.2 | 17.3 |
| Ерөнхийлөгч, түүний институт | 10.3 | 45.2 | 23.8 | 20.8 |
| Засгийн газар | 8.4 | 45.3 | 27.3 | 18.9 |
| Орон нутгийн засаг даргын тамгын газар | 8.0 | 40.6 | 30.3 | 21.1 |
| Монголын залуучуудын холбоо | 9.6 | 36.8 | 20.4 | 33.2 |
| "Нийгмийн ардчилал Монголын залуучуудын холбоо" | 8.1 | 31.7 | 19.5 | 40.6 |
| Ардчилсан залуучуудын холбоо | 7.8 | 31.0 | 19.7 | 41.5 |
| Монголын оюутны холбоо | 12.2 | 34.7 | 19.1 | 34.0 |

Судалгааны үр дүнгээс харахад төр засгийн институт болон оюутан, залуучуудын байгууллагын үнэлгээ харьцангуй доогуур үнэлгээтэй гарсан нь анхаарал татаж байна. Судлаачдын тэмдэглэснээр, залуу үеийнхэн улс төр, худалдаа, арилжаа болон нийгмийн үйл ажиллагааг сонирхож эхэлснээр нийгэмд оролцох, дуу хоолойгоо илэрхийлэх идэвхтэй оролцоо эхэлдэг аж. Тухайн судалгааг явуулах үед залуусын оролцоо цахимаар идэвхжиж, төр засгийн байгууллагуудын талаар ихээхэн шүүмж өрнүүлээд байсан үе юм.

Нийгмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, оролцоо өндөртэй байх нь залуучуудад хувь хүнийхээ хувьд төлөвших, нийгэмд байр сууриа илэрхийлэхэд чухал нөлөө үзүүлдэг байна. Нөгөө талаар оролцооны олон нийтийн, нийгмийн, хувь хүний гэсэн гурван хэлбэрийг тодорхойлох нь бий.

Хүснэгт-2.8 Оролцооны хэлбэрүүд

| Цар хүрээ | Тайлбар | Жишээ |
|---------------------|---|---|
| Олон нийтийн | Дээд түвшинд шийдвэр гаргалтанд хамаарна. | Залуучуудын зөвлөл, зөвлөгөөн, парламент гм |

| | | |
|-------------------|--|--|
| Нийгмийн | Улс төрийн нам, бүлэглэлүүдээс гадна явагддаг албан ба албан бус хэв маягууд | Нийгмийн болон соёлын нэгдэл, орон нутгийн үйлчилгээ, олон нийтийн ажил, сонирхлын бүлгүүд |
| Хувь хүний | Бие хүний гаргаж буй шийдвэр, хариу үйлдэл | Өдөр тутам гаргадаг шийдвэр, сонголтууд |

Нийгэмд оролцоотой байх нь тухайн хүний зан төлөвт эерэгээр нөлөөлдөг болохыг олон судлаачид тогтоосон байдаг. Тухайлбал, залуучууд оролцоо өндөр байхын хэр хэмжээгээр нийгэмд тухайн насны бүлгийн үнэ цэнэ нь өсч, сайн үлгэр дууриалал болдог (Юунисс, Яэйтс 1997) онцлогтой. Мөн идэвхтэй оролцоо нь залуучуудын хүсэл, шаардлагад ч мөн адил нөлөөлдөг. Тухайлбал үр бүтээлтэй байх хүсэл (Шэрод, Фланаган, Юунисс 2002), өөрийгөө үнэлэх үнэлэмж, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ ухамсарлах байдал зэрэгт сайнаар нөлөө үзүүлдэг. Нөгөө талаар нийгэмд үнэлэгдэж танигдах тусам өөрийгөө үнэ цэнэтэй гэж үзэх хандлага төлөвшиж бий болдог аж.

Хүснэгт-2.9 Төр засгийн шийдвэрт нөлөө үзүүлэх бүлгийн талаарх байр суурь

| | | Нөлөөлж чадна. | Нөлөөлж чадахгүй. | Хэлж мэдэхгүй. |
|----|--------------------------------------|-----------------------|--------------------------|-----------------------|
| 1 | Хүүхэд, хүүхдийн байгууллага | 39.6 | 30.4 | 30.1 |
| 2 | Залуучууд, залуучуудын холбоо | 51.9 | 22.8 | 25.3 |
| 3 | Ахмадууд, ахмадын холбоо | 44.4 | 27.1 | 28.4 |
| 4 | Эмэгтэйчүүд | 41.1 | 28.0 | 30.9 |
| 5 | Банкны эзэд | 45.9 | 21.8 | 32.3 |
| 6 | Малчид, тариаланчид | 31.4 | 36.6 | 32.0 |
| 7 | Бизнесмен, хөрөнгөтэй хүмүүс | 55.1 | 18.0 | 26.9 |
| 8 | Ядуу, эмзэг хүмүүс | 20.7 | 49.7 | 29.6 |
| 9 | Нийгмийн зүтгэлтнүүд | 42.8 | 22.4 | 34.7 |
| 10 | Урлаг соёл, спортын одод | 40.0 | 24.8 | 35.2 |
| 11 | Төрийн бус, олон нийтийн байгууллага | 43.7 | 22.2 | 34.2 |
| 12 | Ажилгүйчүүд | 20.1 | 46.9 | 33.0 |
| 13 | Мэргэжилтнүүд | 35.8 | 26.8 | 37.4 |

Юуны өмнө залуучуудын хувьд өөрсдөдөө итгэх итгэл бусад бүлгээс харьцангуй өндөр буюу 51.9%-тай байна. Нийгмийн бусад бүлгүүдээс бизнесмен, хөрөнгөтэй хүмүүсийг төр засгийн шийдвэрт илүүтэй нөлөөлж чадна(55.1%) гэсэн байр суурь нийтлэг харагдаж байна. Харин ядуу эмзэг хүмүүс(49.7%) болон ажилгүйчүүд(46.9%) төр засгийн шийдвэрт нөлөөлж чадахгүй гэсэн байр суурьтай байв. Чухамдаа эндээс өнөөгийн залуучуудын нийгмийн бүлгүүдийн талаарх үнэлэмж, хандлага төлөвшил харагдаж байна.

Онолын хувьд залуучуудын оролцооны дараах найман үе шат байдаг бөгөөд эдгээр үе шат тус бүрийн онцлог, агуулгыг авч үзье.

1) Оролдлого.Насанд хүрэгчид залуучуудыг урамшуулж, үйл ажиллагаандаа татан оролцуулахыг зорино.

2) Туслах үе шат.Энэ үед залуучууд үйл ажиллагаанд шууд бусаар замаар дэмжих, тэтгэх байдлаар оролцоно. Насанд хүрэгчид ч залуучуудын оролцоог шагшиж магтахгүй.

3) Хэлбэрдэх.Залуучууд аливаа ажилд оролцож, дуу хоолойгоо хүргэх боловч яг үнэндээ юу хийх, яах нь тодорхойгүй байна. Энэ шатанд томоожих үйл явц явагдана.

4) Ажил хуваарилагдах.Энэ үед залуучууд тодорхой үүрэг хуваарилж авах бөгөөд хэрхэн яаж оролцох тухайгаа хэлэлцэнэ. Энэ шатанд залуучуудын холбоо чухал үүрэг гүйцэтгэнэ.

5) Зөвлөх, хэлэлцэх. Томчуудын санаачилж буй үйл ажиллагаанд залуучууд санал бодлоо илэрхийлнэ. Залуучууд шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл цуглуулж үр дүнгийн талаар хэлэлцэнэ. Залуучуудын зөвөлгөө өгөх зөвлөл энэ шатанд чухал үүрэг гүйцэтгэнэ.

6) Насан хүрэгчдийн санаачлага зонхилно.Төсөл хөтөлбөрүүдийг томчууд санаачилж зохион байгуулах ба, залуучууд шийдвэр гаргалтанд оролцох эрхтэй. Энэ шатанд оролцогчдын судалгаа чухал.

7) Залуучууд түлхүү оролцоно.Энэ шатанд залуучууд төсөл хөтөлбөрүүдийг санаачилж удирдан зохион байгуулна. Томчууд зөвхөн дэмжигчийн үүргийг гүйцэтгэнэ. Энэ шатны үйл ажиллагаа нь залуучуудын идэвх оролцоогоор тодоройлогдоно.

8) Залуучууд болон насанд хүрэгчид хамтран шийдвэр гаргана.Залуучууд төсөл хөтөлбөрийг санаачилж шийдвэр гаргалтыг хамтран гүйцэтгэнэ. Эдгээр төсөл хөтөлбөрүүд нь залуучуудыг дээд үеийнхнийхээ туршлагаас хуваалцах боломжийг олгоно. Оролцооны энэ шатанд залуучууд болон дээд үеийн хамтын ажиллагаа илүү нягт болно.

Залуучуудын оролцооны эдгээр үе шатуудын эхний гурван үе шат бол идэвхгүй, дараагийн таван шат бол залуучуудын оролцоо санаачилга дээр суурилсан идэвхтэй үе шатууд болно. Залуучуудын оролцооны идэвхийг харуулсан дээрх үе шатанд тулгуурлан

авч үзэхэд өнөөгийн залуучуудын оролцоо хэлбэрдэх буюу идэвхгүй(3 дахь шат) байдлаас зөвлөх хэлэлцэх идэвхтэй(5 дахь шат) үе шат руу шилжиж байна.

Залуучуудын оролцооны өөр нэг чухал загвар нь залуу хүмүүс нийгэмд идэвхтэй байгаа эсэхийг гурван үндсэн хэмжигдэхүүнээр тодорхойлдог. Нэгдүгээрт нь тэдэнд олгогдсон өөрсдийн чадвараа солих боломж, хоёрдугаарт нь тэдний өөрчлөлт хийх чадавх, бололцоо, гуравдугаарт нь тэд асуудлыг шийдэхийн тулд бие биентэйгээ холбоо тогтоох чадвар байгаа эсэх зэрэг болно. Фокус бүлгийн ярилцлага болон чанарын мэдээллээс үзэхэд залуучуудын асуудлыг шийдвэрлэх, хөгжлийг дэмжих дараах ажлуудыг нэн тэргүүнд хийх шаардлагатай талаар залуучуудын санал бодлыг багцлан үзвэл дараах онцлог харагдаж байна. Үүнд:


- ✓ *0-18 хүртэлх насны бүх хүүдүүдэд эрүүл мэнд, ёс суртахууны боловсрол маш цэгцтэй дэс дараалалтай системтэйгээр сургалтын хөтөлбөрт суулгаж өгөх, эрдэм мэдлэг хэрэгтэй хэдий ч, хүн байх, хүнлэг байх чанар илүү хэрэгтэй байна.*
- ✓ *Ажилтай, орлоготой, боловсролтой залуу гэр бүлийг дэмжиж, тоог нэмэгдүүлэх*
- ✓ *Залуучуудад гэр бүл болох, гэр бүлээ төлөвлөх, сайн аав ээж болох талаар сургалтыг бүх сувгаар хүргэдэг байх*
- ✓ *Ажилгүйдлийн тоог багасгах, ажлын байрыг нэмэгдүүлэх, намын харъяаллаас болж ажлаас халах, ялгаварлан гадуурхах байдлыг халах*
- ✓ *Ар гэртээ санаа зоволгүй ажиллах таатай боломжийг бий болгох, цалин хангамжийг нэмэгдүүлэх*
- ✓ *Боловсролын чанарт төрөөс онцгой анхаарах, зөвхөн боловсрол олгоод зогсохгүй хүмүүжил, төлөвшил, хөгжилд онцгой анхаарах*
- ✓ *Залуучуудын нийгмийн идэвх оролцоог сайжруулах, мэдлэг мэдээллээ солилцдог болгох*

Залуучууд нийгэмд идэвхтэй байж нийгмийн нэг салшгүй хэсэг байхын тулд дээрх гурван хэмжигдэхүүн тэнцвэртэй байх хэрэгтэй. Эхний ээлжинд нийгмийн оролцоог идэвхжүүлж, тэдэнд сэдэл өгөх үйл ажиллагаа байх шаардлагатай. Хоёрдугаарт, залуус боломжийг алдалгүй шүүрч авах хэрэгтэй бөгөөд өөрсдийн хүчин чармайлтаар өөрчлөлтийг бий болгох чадвартай байх явдал юм. Залуучуудын өөрчлөлтийг бий болгох хүсэл эрмэлзлэл, тэдэнд байгаа нөөц бололцоо нь нийгмийн хувьд оролцоотой байлгах гол түлхэц болж өгдөг. Өөрийгөө сорих чадвар болон тэдэнд байгаа чадавх нь хоорондоо хэд хэдэн замаар холбогддог. Оролцоо нь нэг талаараа ямар нэг зүйлийг хийх,

өөрчлөх хэрэгцээ байгааг харуулдаг бол нөгөө талаараа энэ бүхэнд шаардлагатай чадвар мэдлэг ч чухал юм. Зохих мэдлэг, чадвар дутах юм бол урам хугарч, өөртөө итгэлгүй болох болно. Харин өөрийгөө сорих хүсэл байхгүй байгаа тохиолдолд тодорхой нэг хүрээнд хүлэгдэж, зорилгогүй байх хандлага нийтлэг байдаг. Аливаа ажлыг хийх санаачилга нь бүтэлгүйтвэл өөртөө итгэх итгэлээ алддаг. Тиймээс өмнө нь амжилттай байсан туршлага чухал. Өмнө нь амжилт гаргаж байсан бол энэ нь залуучуудад ажиллах маш сайн хөшүүрэг болж өгдөг. Дэлхий нийтээр залуучуудад өөрсдийгөө хөгжүүлэх боломж олгох, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд онцгой анхаарч төрөл бүрийн үйл ажиллагаануудыг зохион байгуулж байна. Манай улсын хувьд Залуучуудын хөгжлийн цогц хөтөлбөрийг 2006 онд батлан хэрэгжүүлсэн боловч сүүлийн жилүүдэд огцом буураад байгаа залуучуудын улс төрийн оролцоог дэмжих, тэднийг гар бие оролцуулсан бодит үйл ажиллагаа дутмаг хэвээр байна. Тиймээс дэлхийн бусад орнууд залуучуудын улс төрийн оролцоог дээшлүүлэхэд авч хэрэгжүүлж байсан онцгой төсөл, хөтөлбөрүүдийн талаар судалж, үлгэр жишээ авах хэрэгтэй байна.

3.3 Залуучуудын сэтгэхүй, бие бялдарын үзүүлэлтүүд

Судалгааны хүрээнд тодорхойлон авч үзсэн нэгэн сэдэв бол залуучуудын сэтгэхүй, бие бялдарын үзүүлэлт болно. Өнөөгийн залуучуудын сэтгэхүйн болон амьдралын наад захын хэрэгцээгээ хангах байдал, тулгамдаж буй асуудал, сэтгэл ханамжийн байдлыг энэхүү судалгааны хүрээнд тодорхойлон гаргалаа.

 Залуучуудын өмнө тулгамдаж буй асуудал


Залуучуудын үзсэнээр орон нутагт тулгамдаж буй асуудлын нэгт ажилгүйдэл-25.9%, архидалт-22.0%, үнийн өсөлт-20.6%-иар тэргүүлж байна.

Хүснэгт-2.10 Орон нутагт тулгамдаж буй асуудлуудын эрэмбэ

| | | ТОО | ХУВЬ |
|---|---------------------------------|------|-------|
| 1 | Ажилгүйдэл | 1452 | 25.9% |
| 2 | Архидалт | 1233 | 22.0% |
| 3 | Үнийн өсөлт | 1156 | 20.6% |
| 4 | Авилгал | 639 | 11.4% |
| 5 | Гэр бүл салалт | 311 | 5.5% |
| 6 | Ядуурал | 274 | 4.9% |
| 7 | Гэмт хэргийн өсөлт | 272 | 4.9% |
| 8 | Намаар ялгаварлаж, ажлаас халах | 150 | 2.7% |
| 9 | Татварын ачаалал | 56 | 1.0% |

| | | | |
|----|-------------------|----|------|
| 10 | Шилжилт хөдөлгөөн | 61 | 1.1% |
|----|-------------------|----|------|

Эдгээр асуудлын зэрэгцээ авилгал-11.4%, гэр бүл салалт-5.5%, ядуурал ба гэмт хэргийн өсөлт тус бүр 4.9%-тай өндөр байгааг тэмдэглэжээ. Орон нутагт мөн намаар ялгаварлаж, ажлаас халах тохиолдол байдаг гэж залуучуудын 2.7% нь хариулжээ.

 Залуучуудын суурь эрх ба ялгаварлан гадуурхалд өртөх байдал

Энэхүү судалгааны хувьд залуучууд суурь эрхээ эдэлж чадаж байна уу? гэдгийг тодруулах зорилгоор залуучуудын санал бодлыг сонссон юм. Ялангуяа орон нутагт нийгмийн байдлаас шалтгаалан ялгаварлан гадуурхах явдал байгаа эсэхийг залуучуудын санал бодолд тулгуурлан тодорхойлоход ялгаварлан гадуурхах байдал ажил албаны зэрэг зиндаа-25.1%, намын харьяалал-22.8% зэргээр ялгаварлан гадуурхах явдал байнга тохиолддог болохыг дурджээ. Энэ байдал дөрвөн залуу тутмын нэгд байнга тохиолддог болохыг тэмдэглэсэн байна.

Мөн хөрөнгө чинээ-37.9%, ажил албаны зиндаа-35.4%, хот хөдөөгийн ялгаа-30.7% тус тус ялгаварлан гадуурхахад нөлөөлж байгааг дурдсан байна.

Хүснэгт-2.11 Нийгмийн байдлаас хамааран ялгаварлан гадуурхах байдал

| | | Байнга | Хааяа | Үгүй | Мэдэхгүй |
|----|--------------------------------|-------------|-------------|------|----------|
| 1 | Яс үндэс | 3.7 | 18.5 | 49.3 | 28.5 |
| 2 | Хөрөнгө чинээ | 18.0 | 37.9 | 26.1 | 17.9 |
| 3 | Нийгмийн гарвал | 6.1 | 26.8 | 39.9 | 27.2 |
| 4 | Хот хөдөөгийн ялгаа | 10.3 | 30.7 | 38.7 | 20.3 |
| 5 | Хүйсийн ялгаа | 5.1 | 23.8 | 48.5 | 22.5 |
| 6 | Ажил албаны зиндаа | 25.1 | 35.4 | 21.9 | 17.7 |
| 7 | Намын харьяалал | 22.8 | 30.0 | 25.2 | 22.0 |
| 8 | Нутаг усны гарал | 5.6 | 25.9 | 43.1 | 25.4 |
| 9 | Насны байдал: залуу, хөгшин гм | 15.9 | 30.5 | 33.7 | 20.0 |
| 10 | Шашин, шүтлэгээр | 2.8 | 12.2 | 52.0 | 33.1 |

Судалгааны үр дүнгээс үзэхэд нийгмийн гарвалаар ялгаварлан гадуурхах байдал гурван залуу тутмын нэгд тохиолддог ажээ. Ялгаварлан гадуурхалд өртөх нь залуучуудыг өөртөө итгэх итгэлгүй болгож, нийгэм, ул төрд оролцох оролцоог бууруулдаг сөрөг хүчин зүйл болно.

Чанарын судалгааны үр дүнгээс үзэхэд мэргэжил эзэмшиж, их дээд сургууль төгссөний дараагаар сум, орон нутагтаа ажилладаггүй, ажиллахаас цааргалж, хот орон нутаг бараадаж ажиллаж амьдрах үндсэн шалтгаан бол орон нутагт хангалттай ажлын байр байдаггүй, нөгөө талаас цөөн хэдэн хүн төрийн албыг хашиж, өөрсдийн хамаатан садан, үр хүүхдэд шилжүүлж өгдөг талаар дурдсан байна.

Судалгааны хүрээнд залуу гэр бүл дэх шийдвэр гаргалтын байдлыг хүйсийн байдлаар авч үзэж, харьцуулсан юм.

Хүснэгт-2.12 Гэр бүл дэх шийдвэр гаргалтын байдал

| | | Нөхөр илүү | Эхнэр илүү | Адилхан |
|----|---|------------|------------|---------|
| 1 | Хувцас, эд хэрэглэл авах | 6.0 | 49.4 | 44.6 |
| 2 | Эрүүл мэндээ анхаарал тавих | 7.6 | 36.2 | 56.2 |
| 3 | Орон байр худалдан авах | 22.7 | 16.1 | 61.2 |
| 4 | Үзвэр үйлчилгээ үзэх | 10.8 | 28.6 | 60.6 |
| 5 | Боловсрол мэдлэгээ ахиулах | 11.8 | 29.4 | 58.8 |
| 6 | Хамт олон найз нөхөдтэйгээ уулзах санаачлага гаргах | 20.4 | 21.1 | 58.5 |
| 7 | Өрхийн төсөв, санхүүг зарцуулах | 15.4 | 39.9 | 44.7 |
| 8 | Үр хүүхэддээ анхаарал тавих, сурган хүмүүжүүлэх | 7.8 | 40.3 | 51.9 |
| 9 | Өрхийн орлого олох | 31.6 | 16.5 | 51.9 |
| 10 | Эцэг эх, өндөр настныг асарч тойлох | 6.2 | 38.7 | 55.1 |
| 11 | Хоол хүнс гм гэрийн ажлыг голлож хийдэг. | 7.0 | 60.8 | 32.2 |
| 12 | Баяр ёслол тэмдэглэх | 9.8 | 23.0 | 67.3 |

Судалгаанаас үзэхэд залуу гэр бүлд өрхийн орлого олоход 31.6% буюу гурван оролцогч тутмын нэг нь, орон байр худалдан авахад 22.7% буюу таван оролцогч тутмын нэг нь нөхөр илүү үүрэг гүйцэтгэдэг тухай дурдсан байна. Харин хоол хүнс гэх мэт гэрийн ажлыг голлож хийх-60.8%, хувцас эд хэрэглэл авах-49.4%, үр хүүхэддээ анхаарал тавих, сурган хүмүүжүүлэх-40.3, болон өрхийн төсөв, санхүүг зарцуулах-39.9% зэрэгт эхнэр илүү үүрэгтэй гэж үзжээ. Үүнээс үзэхэд өнөөгийн залуучуудын хувьд ч гэсэн өрх гэрийн ажлыг эмэгтэйчүүд хийх ёстой гэсэн уламжлалт хандлага байсаар байна.

Залуучуудын амьдралд тулгамдаж буй нэгэн чухал асуудал бол гэр бүлийн зөрчил маргаан болно. Судалгааны үр дүнгээс үзэхэд залуу гэр бүлийн хувьд байнга зөрчилддөг асуудал бол архидалт зэрэг зохисгүй хэрэглээ-29.7%, мөнгө төгрөгнөөс-22.7% нь тус тус хамаардаг байна. Үүний зэрэгцээ итгэл эвдэж хуурч мэхлэх-17.6%, хайр халамж дутагдсанаас-15.0%, хадам хамаатнуудын харилцаа, хандлагаас-13.8% нь тус тус байнга зөрчилддөг гэж хариулжээ.


Эдгээр хариулт нь өнөөгийн залуу гэр бүлийн зөрчилдөөний үндсэн эх сурвалж, шалтгааныг тодорхойлж байна.

Хүснэгт-2.13 Залуу гэр бүлийн зөрчилдөөн

| | | Байнга зөрчилддөг | Хааяа зөрчилддөг | Огт үгүй |
|---|------------------------------------|-------------------|------------------|----------|
| 1 | Хүүхэдтэй холбоотой асуудлаас | 8.9 | 65.6 | 25.6 |
| 2 | Архидалт гм. зохисгүй хэрэглээнээс | 29.7 | 50.2 | 20.1 |
| 3 | Мөнгө төгрөгнөөс | 22.7 | 60.6 | 16.7 |

| | | | | |
|----|---|------|-------------|------|
| 4 | Итгэл эвдэж, хууран мэхэлсэнээс | 17.6 | 47.8 | 34.7 |
| 5 | Үзэл бодлын зөрчил, харилцан үл ойлголцлоос | 13.7 | 66.0 | 20.3 |
| 6 | Өөрийн орон гэргүйгээс | 14.3 | 41.4 | 44.3 |
| 7 | Хайр халамж дутагдсанаас | 15.0 | 53.3 | 31.6 |
| 8 | Хардалт, өмнөх амьдралаас | 15.4 | 48.0 | 36.7 |
| 9 | Бэлгийн харилцаанаас | 7.8 | 40.9 | 51.3 |
| 10 | Хадам, хамаатнуудын харилцаа хандлагаас | 13.8 | 56.6 | 29.6 |
| 11 | Амьдралд бэлтгэгдэж чадаагүйгээс | 9.4 | 31.1 | 59.5 |

Хүснэгтээс үзэхэд залуучуудын дунд үзэл бодлын зөрчил, харилцан үл ойлголцох байдал-66.0, хүүхэдтэй холбоотой асуудлаас-65.6%, мөнгө төгрөг-60.6% тус тус гэр бүлийн зөрчлийг хааяа бий болгох хүчин зүйл болж байна. Дээрх хариултыг судалгаанд оролцсон таван гэр бүл тутмын гурав нь өгсөн байгаа нь өндөр хувь болно. Тэрчлэн залуу гэр бүлийн 56.6% буюу талаас илүү нь хадам, хамаатнуудын харилцаа хандлагаас болж зөрчилд хүрдэг гэсэн хариулт өгсөн нь анхаарал татаж байна. Ялангуяа хүн ам төвлөрсөн нийслэл хотын хувьд залуу хүмүүс өөрийн орон гэр байхгүй, тусдаа амьдрах боломжгүйгээс хадмын гэрт амьдрах явдал түгээмэл байгаа бөгөөд энэ нь гэр бүлийн зөрчилдөөний үндсэн хэв маягийн нэг болж байна. Судалгаанд хамрагдсан залуу хүмүүсээс гэр бүлийн харилцаанд дараах байдал хэр зэрэг гардаг талаар лавлахад дараах хариултыг өгсөн юм.



Дүрс-2.12 Залуу гэр бүл дэх харилцаа

Өнөөгийн залуу гэр бүлийн хувьд маргалдах(11.8% нь нэлээд их, 74.7% хааяа), хэрэлдэх(5.8% нэлээд их, 69.7% хааяа) тохиолдол цөөнгүй гардаг талаар залуус дурдсан байна. Гэхдээ гэр бүлийн зөрчлийн хурцадмал хэлбэр болох зодолдох, удаан хугацаагаар муудалцах, хөндийрөх, түр хугацаагаар салах зэрэг нь харьцангуй бага байгааг дурдсан байна.Залуучуудын хувьд гэр бүл салалтын талаар чухам ямар бодолтой явдаг болохыг

лавлахад үнэхээр таарамжгүй бол салсан нь дээр гэж 27.8%, үр хүүхдээ бодоод салахгүй байсан нь дээр-28.4%, салсан ч хүүхдийнхээ өмнө хүлээх хоёр талын хариуцлага хэвээр байх ёстой-43.8% гэж хариулжээ. Энэхүү хариултыг хүйсийн ялгаатай байдлаар харьцуулж харвал дараах онцлог харагдаж байна.

Хүснэгт-2.14 Гэр бүл салалтын талаарх санал бодол

| | | 2.Таны хүйс | | Нийт | |
|--|------|-------------|---------|--------|--------|
| | | Эрэгтэй | Эмэгтэй | | |
| Үнэхээр таарамжгүй бол салсан нь дээр | тоо | 221 | 325 | 546 | |
| | хувь | 29.9% | 26.5% | 27.8% | |
| Үр хүүхдээ бодоод салахгүй байсан нь дээр | тоо | 229 | 329 | 558 | |
| | хувь | 30.9% | 26.8% | 28.4% | |
| Салсан ч хүүхдийнхээ өмнө хүлээх хоёр талын хариуцлага хэвээр байх ёстой | тоо | 290 | 572 | 862 | |
| | хувь | 39.2% | 46.7% | 43.8% | |
| Нийт | | тоо | 740 | 1226 | 1966 |
| | | хувь | 100.0% | 100.0% | 100.0% |

Юуны өмнө гэр бүл салалтад хандах залуучуудын хандлагыг хүйсээр харьцуулж үзэхэд бага зэрэг ялгаатай байна. Залуу эрэгтэйчүүдийн хувьд үнэхээр таарамжгүй бол салсан нь дээр гэсэн хандлага эмэгтэйчүүдээс 3.4%-иар илүү байна. Харин эмэгтэйчүүдийн хувьд салсан ч хүүхдийнхээ өмнө хүлээх хоёр талын хариуцлага хэвээр байх ёстой гэсэн санал бодол эрэгтэйчүүдээс 6.5 хувиар өндөр байв.


Залуучуудын сэтгэл ханамжийн байдал

Судалгаанд хамрагдсан залуучуудын амьдралын сэтгэл ханамжийн байдлыг авч үзэхэд дараах онцлог харагдсан болно. Ерөнхийдөө залуучууд хувийн болон гэр бүлийн амьдралдаа сэтгэл ханамжтай байгаагаар дурдсан байна.

Хүснэгт-2.15 Залуучуудын сэтгэл ханамжийн байдал

| | | Маш ханамжтай | Ханамжтай | Дунд зэрэг | Ханамжгүй галдаа | Огт ханамжгүй |
|---|-------------------------|---------------|-------------|-------------|------------------|---------------|
| 1 | Хувийн амьдралдаа | 25.6 | 53.2 | 18.6 | 2.4 | 0.2 |
| 2 | Гэр бүлийн амьдралдаа | 30.8 | 49.1 | 14.1 | 2.2 | 3.8 |
| 3 | Найз нөхөд, хамаатандаа | 21.0 | 56.4 | 20.3 | 2.0 | 0.3 |
| 4 | Цаг үе, нийгэмдээ | 5.9 | 27.3 | 48.0 | 15.6 | 3.2 |
| 5 | Хүрээлэн буй орчиндоо | 7.5 | 29.1 | 43.1 | 15.7 | 4.7 |
| | Дундаж | 18.2 | 43.0 | 28.8 | 7.6 | 2.4 |

Харин цаг үе нийгэм болон хүрээлэн буй орчиндоо сэтгэл ханамж дунд зэрэг байгаа нь харагдсан болно. Судалгаанд оролцсон залуучуудын сэтгэл ханамжийн байдлыг хүйсээр харьцуулж, дундаж үзүүлэлтийг тооцож үзэхэд дараах үр дүн гарсан болно.



Дүрс-2.13 Сэтгэл ханамжийн түвшин/хүйсээр

Дундаж үзүүлэлтээс үзэхэд хувийн болон гэр бүлийн амьдрал, мөн найз нахад хамаатандаа сэтгэл ханамжтай байдал өндөр гарсан байна. Харин хүйсийн хувьд эрэгтэйчүүд бүх үзүүлэлт дээр эмэгтэйчүүдээс сэтгэл ханамж өндөр байгаа нь анхаарал татаж байна. Үүний хамт ирээдүйн амьдралаа хэрхэн төсөөлдөг талаар залуучуудын санал бодлыг сонирхоход дараах хариултыг өгсөн юм.



Дүрс-2.14 Ирээдүйн амьдралын талаарх залуучуудын төсөөлөл

Судалгаанд хамрагдсан залуучуудын 68.9% нь ирээдүйн амьдралаа өөдрөг сайхнаар төсөөлж байгаагийн дээр дөрвөн залуу тутмын нэг нь буюу 25.6% нь амьдрал сайжирна гэдэгт итгэж байна. Харин судалгаанд хамрагдсан залуусын 1.9% нь бараг өөрчлөгдөхгүй энэ хэвэндээ байна гэсэн бол 1.0 хувь нь амьдралдаа гутрах зүйл олон тохиолддог талаар дурджээ.

Дээр дурдсан бүгдээс үзэхэд өнөөгийн залуучууд орлого багатай, орлогын хүрэлцээ тааруу, амьдралын нөхцөл дунд зэрэг боловч сэтгэл ханамж өндөр, амьдрал сайжирна гэдэгт итгэж, ирээдүйгээ өөдрөгөөр төсөөлж амьдарч байна.

🚦 Залуучуудын бие бялдарын үзүүлэлт

Залуучуудын бие бялдарын онцлог бол энэхүү судалгааны нэгэн үндсэн сэдэв болно. Судалгаанд хамрагдсан залуучуудын биеийн өндөр ба жингийн хэмжээг судалсан. Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн жин болон биеийн өндрийн хэмжээ эмэгтэйчүүдээс илүү байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд өнөөгийн залуу эрэгтэйчүүдийн дундаж өндөр 177.3, биеийн жингийн дундаж 78.3кг байгаа бол залуу эмэгтэйчүүдийн дундаж өндөр 169.1, биеийн жин 67.7 кг байна.



Дүрс-2.15 Залуучуудын өндөр, биеийн жин

Энэ нь судалгаанд хамрагдсан залуучуудын өөрсдийн санал бодолд тулгуурласан гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Энэхүү хариултаас үзэхэд өнөөгийн залуучуудын биеийн өндөр харьцангуй нэмэгдэж байгаа бололтой. Нөгөө талаас Монгол Улсын хүн амын дундаж өндөр ба жингийн статистик үзүүлэлттэй харьцуулахад өнөөгийн залуучуудын дундаж өндөр ойролцоогоор 4 см-ээр өндөр, дундаж жингээс 4.6 кг-аар илүү үзүүлэлттэй гарсан байна.

Судалгааны чанарын ярилцлагын үр дүнгээс үзэхэд өнөөгийн залуучууд амьдралын хэв маягийн хувьд буруу хооллолт болон эрүүл зохистой хооллолт гэсэн хоёр үндсэн туйлд хуваагдаж байна. Оюутан залуучуудын хувьд хичээл сурлагадаа шамдах, ажил хөдөлмөр эрхлэх зэргээр өдөр тутмын хооллолтонд анхаарах завгүй тохиолдолд хоол хүнсэндээ ихэвчлэн хагас боловсруулсан бэлэн бүтээгдэхүүн хэрэглэх, буруу хооллох зэрэг нь залуучуудын дундах суурь өвчлөлийн шалтгаан(жишээ нь таргалалтаас үүдэлтэй зүрх судасны өвчин гм.) болж байгаа ажээ. Нөгөө талаас залуучуудын дунд дасгал хөдөлгөөн хийх, иогоор хичээллэх, эрүүл зохистой хооллоход анхаарч буй хэсэг ч байна.

Судалгаанд хамрагдсан залуучуудын биеийн өндөр ба жингийн дундаж үзүүлэлтийг хүйсийн ялгаатай байдлаар тооцон дараах хүснэгтэд харуулсан болно.

Хүснэгт-2.16 Биеийн өндөр ба жингийн дундаж үзүүлэлт

| | | N | Доод | Дээд | Дундаж | Std. Deviation |
|----------------|--------------|------|------|------|--------|----------------|
| Ерөнхий | Биеийн өндөр | 2024 | 165 | 192 | 172.2 | 6.277 |
| | Биеийн жин | 2024 | 52 | 99 | 71.69 | 10.303 |
| Эрэгтэй | Биеийн өндөр | 764 | 165 | 192 | 177.3 | 6.428 |
| | Биеийн жин | 764 | 65 | 99 | 78.29 | 8.970 |
| Эмэгтэй | Биеийн өндөр | 1260 | 165 | 179 | 169.1 | 3.565 |
| | Биеийн жин | 1260 | 52 | 92 | 67.69 | 8.909 |

Залуучуудыг хүйсийн байдлаар харьцуулж үзэхэд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 8 орчим см-ээр өндөр байгаа ба жингийн хувьд 4 кг орчмоор их байна. Хэдийгээр биеийн өндөр ба жингийн харьцааны үзүүлэлт боломжийн түвшинд байгаа боловч Ковид-19 цар тахлын дараах нөлөөлөл болох цус өтгөрөх, даралт ихсэх гэх мэт өвчлөлийн шинж тэмдгүүд тохиолдож байгаа талаар залуучууд тэмдэглэж байна.

Биеийн жингийн үзүүлэлтийг судалгааны талбар бүрээр харьцуулж, хүснэгт 2.17-д үзүүлэв.

Хүснэгт-2.17 Биеийн өндөр ба жин(хот, аймгаар)

| Судалгааны талбар/аймаг хотоор | | Биеийн өндөр | Биеийн жин |
|--------------------------------|--------|--------------|------------|
| Дорнод аймаг | Дундаж | 169.14 | 69.92 |
| | Нийт | 176 | 176 |
| Ховд аймаг | Дундаж | 171.20 | 68.14 |
| | Нийт | 161 | 161 |
| Хөвсгөл аймаг | Дундаж | 172.16 | 68.60 |
| | Нийт | 169 | 169 |
| Өмнөговь аймаг | Дундаж | 171.18 | 71.20 |
| | Нийт | 170 | 170 |
| Сэлэнгэ аймаг | Дундаж | 171.63 | 71.67 |
| | Нийт | 150 | 150 |
| Орхон аймаг | Дундаж | 171.76 | 70.76 |
| | Нийт | 182 | 182 |
| Улаанбаатар хот | Дундаж | 173.24 | 73.32 |
| | Нийт | 1016 | 1016 |
| Нийт | Дундаж | 172.20 | 71.69 |
| | Нийт | 2024 | 2024 |

Судалгааны үр дүнгээс үзэхэд нийслэл буюу төв рүү ойртох тусам залуучуудын дундаж өндөр нэмэгдэж байна. Тэрчлэн зүүн ба баруун аймгуудыг харьцуулахад баруун аймаг(Ховд)-ийн залуучуудын дундаж өндөр зүүн аймаг(Дорнод)-ийн залуучуудын


дундаж өндрөөс 2 см-ээр илүү байна. Судалгаанд хамрагдсан бусад талбаруудын хувьд ойролцоо байсан бөгөөд гойд ялгаа ажиглагдсангүй.

3.4 Залуучуудын үнэт зүйл, түүх, соёлын хөгжлийг тодорхойлох нь

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн сүүлийн 30-аад жилд Монголчуудын нийгмийн харилцаанд олон тооны өөрчлөлт, хувьсал гарсан юм. Энэ нь юун түрүүнд залуучуудын үнэт зүйл, соёлын хөгжил, харилцаанд ихээхэн нөлөөлсөн. Хүн амьдралдаа чиг баримтлал болгодог үнэт зүйлгүй бол нийгэм хэмээх томоохон системийг нийтлэг зорилгоор удирдан чиглүүлэх боломжгүй болж, хүн бүр дур зоргоороо авирласан эмх цэгцгүй байдал үүснэ. Соёлын онолд тусгаснаар нийгмийн систем нь субъектийн хэрэгцээ, нийгэм соёлын орчны үнэт зүйл гэсэн дэд системийн харилцан уялдаанд үндэслэн бий болдог. Социологич Т.Парсонсын тэмдэглэснээр, өмнө дурдсан дэд системийн хооронд нэг талаас үнэт зүйл-хэм хэмжээний тогтсон агуулга, мөн чанарыг институт болгож, нийгмийн гишүүдэд хэвшүүлэн мөрдүүлэх, нөгөө талаас нийгмээр дагаж мөрдөж байгаа үнэт зүйл-хэм хэмжээг бие хүн өөртөө төлөвшүүлж, нийгэмших урвалж шинжтэй үйлдэл тасралтгүй явагдаж байдаг ажээ. Үүнд тулгуурлан авч үзэхэд өнөөгийн залуучуудын амьдарч буй нийгмийн соёл, нийгмийн институт, хувь хүний амьдралын замнал туршлагаас үндэстэй. Хүмүүс, хүн төрөлхтний түгээмэл хийгээд нийгмийн бүлгийн үнэт зүйлсийг амьдралынхаа явцад харилцан адилгүйгээр итгэл үнэмшлээ болгодог учир нэг хүнд хамгаас чухалд тооцогдох үнэт зүйл нөгөөд нь чухал бус байж болно.

Дэлхий нийтийг хамарсан даяаршил, мэдээлэл харилцаа холбооны технологийн хөгжил дэвшлийн нөлөөгөөр өнөөгийн залуучуудын нийгмийн харилцаа бүхэлдээ хувьсан өөрчлөгдөж байна.

Өнөөгийн Монголын нийгэм дэх залуучуудын үнэт зүйлс бүрэлдэн төлөвшихөд нөлөөлж буй хүчин зүйлсийг макро түвшний буюу улс төрийн тогтолцоо, эдийн засгийн харилцаа, нийгмийн бүтэц ба өмч хөрөнгө, оюун санааны өөрчлөлт, даяаршил, гадаад ба дотоод шилжилт хөдөлгөөн, амьдралын хэв маяг, өв уламжлал зэрэгтэй, нөгөө талаас микро түвшний буюу хувь хүнээс өөрөөс хамаарах нас, хүйс боловсрол, орлого ба баялаг эзэмших байдал, гэр бүлийн харилцаа, шашин шүтлэг, оршин суугаа газар, хөдөлмөр эрхлэлт зэрэгтэй уялдуулан тайлбарлаж болох юм.



Дүрс-2.16 Залуучуудын үнэт зүйлст нөлөөлөх хүчин зүйлс

Социалист аж төрөх ёс, нийтийн өмч, хамтын хөдөлмөр, нийгмийн сахилга дэг журмыг эрхэмлэж ирсэн социалист тогтолцооноос ардчилалд шилжсэнээр ардчилал, олон ургальч үзэл, хувь хүний эрх чөлөө, зах зээл, хувийн өмчийг эрхэмлэн дээдлэх болсон. Залуу нас бол амжилт бүтээл, алдаа оноо хосолсон хүний насны оргил үе билээ. Тиймээс ч залуу насанд оргилуун хүсэл, өөдрөг үзэл, шинэ санаа, эрч хүч, эр зориг, эрмэлзэх тэмүүлэл, хурц тод мэдрэмж, авьяас билгийн асар их нөөц бийг нэрт судлаач Х.Гүндсамбуу агсан тэмдэглэсэн нь буй.(Х.Гүндсамбуу нар, 1998) Чухамхүү эл насанд хүн бие, сэтгэхүйн хөгжил болон нийгэмшилтийн хувьд бусдад хүлээн зөвшөөрөгдөж, аливаад бие даан оролцохын зэрэгцээ, эрх эдлэн үүрэг хүлээж нэг ёсондоо эрх зүйн чадамж бүрдэж эхэлдэг. Үүний хамтаар боловсрох, мэргэжил эзэмших, гэр бүлийн амьдрал шинээр зохиох, эцэг эхээс өрх тусгаарлах, ажил хөдөлмөр эрхлэх зэрэг олон асуудал тулгамдсан шинжтэй болж ирдэг. Залуучуудын хувьд онцлон тодорхойлвол зохих субъектив хийгээд объектив, түгээмэл хийгээд өвөрмөц суурь хүчин зүйл бол үнэт зүйл, соёлын хөгжлийн өнөөгийн үзүүлэлт болно. Өнөөгийн залуучуудаас юуг зөвшөөрч, юуг эсэргүүцдэг, чухам юуг эрхэмлэж, юунд итгэдэг талаар асуухад харилцан адилгүй хариулт өгсөн байна. Залуучуудын хариултаас үзэхэд цөөнгүй хувь нь гэр бүл(16.8%), эрүүл мэнд(16.1%), эцэг эх(10.4%), эрдэм боловсрол(9.9%) зэргийг үнэт зүйл гэж үзсэн байна.

Хүснэгт-2.18 Залуучуудын үнэт зүйлсийн эрэмбэ


| | | Хариулт | | Тохиолдлын хувь |
|-------------|-------------------------|---------|--------|-----------------|
| | | Тоо | Хувь | |
| zaluus a | Гэр бүл | 1568 | 16.8% | 80.1% |
| | Эрүүл мэнд | 1509 | 16.1% | 77.1% |
| | Эцэг эх | 969 | 10.4% | 49.5% |
| | Эрдэм боловсрол | 928 | 9.9% | 47.4% |
| | Эх орон | 749 | 8.0% | 38.3% |
| | Эрх чөлөө | 659 | 7.0% | 33.7% |
| | Мөнгө | 591 | 6.3% | 30.2% |
| | Хангалуун амьдрал | 543 | 5.8% | 27.7% |
| | Хүмүүжил, ёс суртахуун | 540 | 5.8% | 27.6% |
| | Шударга ёс | 396 | 4.2% | 20.2% |
| | Шударга хөдөлмөр | 358 | 3.8% | 18.3% |
| | Эд хөрөнгө | 279 | 3.0% | 14.3% |
| | Эрх мэдэл, албан тушаал | 270 | 2.9% | 13.8% |
| Нийт | | 9359 | 100.0% | 478.2% |

Үүний зэрэгцээ мөнгө(6.3%), эд хөрөнгө(3.0%), эрх мэдэл, албан тушаал(2.9%) зэрэг үнэтэй зүйлийг өөрсдийн үнэт зүйлээ болгосон байх нь ч таарч байна. Бидний анзаарснаар залуучуудын үнэт зүйлд хүмүүжил, ёс суртахуун болон шударга ёс, шударга хөдөлмөр гэх мэт үнэт зүйл мөнгөнөөс хойгуур эрэмбэлэгдэж байгаа нь анхаарал татаж байна.

Өрнөдийн судлаачдын үзсэнээр үндэстний үнэт зүйлд эрхэмлэж буй хүчин зүйлс, итгэл үнэмшлийн байдал шууд нөлөөлдөг ба тэдгээрийн дотроос түгээмэл хэрэглэгдэж буй аргууд нь Шварц, Хофштед, Инглехарт нарын боловсруулсан аргачлалууд бий. Дурдсан судлаачдын хувьд хувь хүний болон нийгмийн үнэт зүйлсийг нийгэм, эдийн засаг, түүх соёлын хүчин зүйлстэй холбон авч үзэж, тайлбарладаг болно.

🚩 Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс

Судалгаанд хамрагдсан залуучуудаас хөрөнгө чинээний хувьд өөрсдийгөө нийгмийн аль хэсэгт хамруулах талаар лавлахад дөрвөн залуу тутмын гурав нь өөрсдийгөө дундаж хэсэгт оруулж үзжээ. Харин ядуу хэсэгт 4.2%, баян чинээлэг хэсэгт дөнгөж 1.2% нь өөрсдийгөө тооцсон байна.



Дүрс-2.17 Хөрөнгө чинээний хувьд өөрсдийгөө нийгмийн аль хэсэгт хамруулах вэ? Тус дүрсээс үзэхэд таван залуу хүн тутмын нэг өөрсдийгөө аль ч хэсэгт оруулж мэдэхгүй байв. Залуучуудын орлогын хомсдол нь ихэнх тохиолдолд ажилгүйдлээс үүдэлтэй бөгөөд суралцаж буй оюутан залуусын хувьд цагаар ажиллаж өдөр тутмын санхүүгийн хэрэгцээгээ хангах боломж нөхцөл байдаггүйтэй шууд холбоотой. Одоогоос арав гаруй жилийн өмнө хийгдсэн судалгаанаас харахад Европ дахь амьдралын өндөр өртөг, орлогын хомсдол залуучуудын сэтгэл ханамж хийгээд амьдралын баяр баясгаланг үгүй хийж байгаа тухай дурдсан байдаг(European Social Survey, 2004). Монголын залуучуудыг оршин суугаа байрлалаар нь авч үзвэл насны бүлэг болоод орлогын хэмжээний хувьд томоохон ялгаа байгаа нь анхаарал татаж байна. Орлогын хомсдол нь залуучуудыг санхүүгийн хувьд бие даан амьдрах боломжгүй болгож, үүний улмаас эцэг эхтэй хамт урт хугацаанд амьдрах, гэр бүл төлөвлөлт хийгээд гэрлэх нас хойшлох, ганцаар амьдрахыг эрхэмлэх хандлага зонхилоход хүргэж байна.

Сэтгэл хангалуун, сайн сайхан амьдрахын нэгэн үндэс бол орлого олохуйц ажил, мэргэжилтэй байх явдал бөгөөд илүү сайн ажил эрхлэх, хөдөлмөрийн үнэлгээгээ нэмэгдүүлэх нэг гарц бол сурч боловсрох, мэргэжил эзэмших явдал хэмээн үзэж болно. Эдүгээ хөдөлмөр эрхлээгүй залуучуудын дийлэнх нь сургууль завсардсан бус сурч байгаа залуучууд байна. Хөдөлмөрийн зах зээлд шинээр орж буй залуучууд бэлэн орон тоон дээр шууд ажиллах, эсвэл өөрөө бизнес эхлүүлэх боловсрол, мэдлэг, ур чадвар дутмаг байдаг. Үүнийг одоогийн сургалтын байгууллагуудын олгож буй мэдлэг, чадвар болон ажлын байранд шаардагдаж буй чадварын хоорондох ялгаа эрс тэс байгаагаар тайлбарлаж болно. ОУХБ-аас 15-29 насны залуучуудын амьдралын гол зорилготой холбоотой хэд хэдэн асуудлыг хөндөн судлахад ажил албан тушаалд хүрэхийг \17.0

хувь), “мэргэшихийг” \19.8 хувь), “аз жаргалтай байхыг” \18.9 хувь\ хамгийн чухал хэмээн үзжээ. Сурч байгаа залуучуудын хэтийн төлөв, хүлээлтийг судлан үзвэл тэдгээрийн 60.7 хувь нь үргэлжлүүлэн суралцах төлөвлөгөөтэй гэжээ.

Залуучуудын нийгмийн амьдрал, харилцааг тодорхойлох дараагийн үндсэн хүчин зүйл бол ажил хөдөлмөр эрхлэлттэй холбоотой харилцаа, хандлага мөн. Залуучуудад олгож буй боловсролын чанар тааруу байгаа нь тэдгээрийг хүссэн ажилдаа орох, мэргэших, өндөр цалинтай ажил эрхлэх, хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөхөд сөргөөр нөлөөлж байна.

Ажил эрхлэлт бол хувь хүний санхүүгийн бие даасан байдал, нэр хүнд, нийгмийн оролцооны түвшинг тус тус илэрхийлдэг амьдралын чанарын үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм. Улс орнуудын хөгжлийн түвшнээс үл хамааран залуучуудын ажил эрхлэх боломж, ажлын үнэ хүнд, ажлын үнэлгээ доогуур төвшинд байсаар байна. Хөгжсөн орнуудад ч ялгаагүй ажилгүйдэл өсөж, орлого буурсан нь залуучуудын амьдралыг илүү бэрхшээлтэй болгож байгаа аж. 1990-ээд оны сүүл гэхэд Европын холбооны улсуудын хувьд залуучуудын ажилгүйдэл тулгамдсан шинжтэй асуудал болон гарч ирсэн. Эл нөхцөл байдал нь залуу хүмүүсийг бусдаас илүү анхаарахад зүй ёсоор хүргэж байгаагийн сацуу ажилгүйдлийн өндөр түвшин нь Европын улсуудын хувьд нийгмийн гадуурхал болоод маргиналь байдлыг илүүтэй бий болгож байгаа болно. (European Social Survey, 2004)

Өгүүлэн буй зүйлтэй адилхан үйл явц Монголын нийгэмд тохиож байна. Хөдөлмөр эрхлэх боломжгүй, эдийн засгийн баталгаагүй байдлаас болж олон тооны залуучуудын хүсэл мөрөөдөл, амьдралын зорилгоо алдаж, архидалт, мансуурал, гэмт хэрэгт холбогдох нь ихсэж байгааг статистик мэдээлэл, судалгаанаас харж болно. Монгол Улсын хүн амын дийлэнх нь залуучууд бөгөөд жил бүр хөдөлмөрийн идэвхитэй хүн амын эгнээнд олон тооны хүмүүс нэгдэн орж байгаатай холбогдуулан тухайн бүлгийн хөдөлмөр эрхлэлт өнөөгийн тулгамдсан, үндсэн асуудлын нэг болж байна. Жил бүрийн статистик мэдээг харьцуулан үзвэл Хөдөлмөр эрхлээгүй хүн амын 60-70 хувь нь залуучууд бөгөөд жил тутам 50-60 мянган залуус хөдөлмөрийн насанд шилждэг боловч тэдгээрийн багадаа 50 хүртэл, ихдээ 60 гаруй хувь нь эрхэлсэн ажил, сургуульгүй үлддэг байна. Түүнчлэн залуучуудын хувьд ажил хөдөлмөр эрхлэх асуудлаа танил талаараа дамжуулан шийдэрлэх явдал түгээмэл болсны зэрэгцээ шийдвэр гаргах түвшинд ажиллахад ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна. Хэдийгээр Монголын залуучуудын

хувьд ажил эрхлэх сонголт өргөжсөн боловч хөдөлмөрийн үнэлгээ тааруу, ажил албанд ороход тал тохой татах явдал их байдаг нь тэгш боломж, өрсөлдөөнийг үгүйсгэж энэ хэрээр гадаадад гарч ажиллах явдал түгээмэл шинжтэй үзэгдэл болсон. Гадаадад ажиллаж “мөнгө хийх” нь зөв зүйтэй зүйл боловч олон тооны нийгмийн асуудлуудыг үүсгэж байгааг дурдахгүй өнгөрөх аргагүй. Наанадаж улс орны хувьд ажиллах хүчээ алдах, цаашилбал гэрлэлт хойшлох, гэр бүл салалт ихсэх, хамаатан садны харилцаа холбоо сулрах, урт хугацаанд ажилласнаас үүдэн эргэн ирээд дасан зохицох чадваргүй болох зэрэг олон сөрөг зүйлс гарсаар байгаа юм. Түүнчлэн хөдөлмөрийн хөлсний үнэлгээ доогуур байгаа нь залуучууд урт хугацаанд суралцах чиглэлийг сонгоход хүргэж байна.

Монгол Улсын хүн амыг насны бүлгээр харьцуулан авч үзвэл залуучуудын дунд ажилгүйдэл нэлээд өндөр хувьтай байгаа юм. Ажилгүйдэл, орлогын хомсдол, чанаргүй боловсрол зэргээс үүдэн Монголын залуучуудын нийгмийн баталгаа алдагдаж байна. Залуучуудын эдийн засгийн болон нийгмийн баталгааг тэд өөрсдөө хариуцах биш, гэр бүл, эцэг эхчүүд зонхилон үүрч байгаа нь өрөөсгөл зүйл юм. Хүн ам зүйн бүлгүүд, ялангуяа залуучуудын ажилгүйдэл, одоогийн олж буй цалин орлого бага болон эрхэлж буй ажилдаа сэтгэл ханамжгүй байгаа явдал нь тэднийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эдийн засгийн эмзэг байдлаа даван туулах үндсэн шалтгаан болж байна. Хэдийгээр гадаадад хөдөлмөр эрхлэх нь цалин орлогоо нэмэгдүүлэх бодит боломж хэдий ч, хүн амын эрүүл мэнд, аюул осолгүй нөхцөлд ажил эрхлэх зэрэг эрхийг ноцтой зөрчиж байна. Энэхүү нөхцөл байдал дотоодын барилга болон уул уурхайн салбарт мөн тохиолдож байна. Залуу хүмүүсийн амьдралын хэв маягт давтагддаг глобаль шинжтэй гурван чухал зүйлийг онцолбол сургууль төгсөх нас, өссөн гэр бүлээ орхих нас, өөрийн гэр бүлийг цогцлоох нас болно. Нийгмийн хамгаалал, эдийн засгийн баталгаат байдлаас хамааран Европын улс орнуудад дээрх хүчин зүйлс ба мөчлөгийн хугацаа харилцан адилгүй байдаг байна. (Florian Pichler, 2006)

Хүснэгт-2.19 Европын залуучуудын амьдралын хэв маяг, мөчлөг

| | |
|--|---|
| Скандинавын орнууд: Швед, Норвеги, Финланд, Денмарк | Төрж өссөн гэрээ эрт орхино. |
| | Дундаж насандаа(22-24) сургууль төгсөнө. |
| | Гэрлэлт, гэр бүл төлөвлөлт оройтдог. |
| Баруун Европт: Герман, Франц, Австри | Төрж өссөн гэрээ эрт орхино. |
| | Сурч, боловсроход их хугацаа зарцуулна . |
| | Гэрлэлт, гэр бүл төлөвлөлт оройтдог. |
| Өмнөд Европт: Итали гм | Гэр бүлдээ урт хугацаанд (30 нас хүртэл) амьдардаг. |

| | |
|-------------------|---|
| | Сурч, боловсроход их хугацаа зарцуулдаг. Гэрлэхээс өмнө урт хугацаанд хамтран амьдардаг. |
| Зүүн Европ | Гэрлэлт, гэр бүл төлөвлөлт оройтдог. Гэрлэхийн өмнө урт хугацаанд хамтран амьдардаг. |

Эх сурвалж: Florian Pichler. Subjective Quality of life of young Europeans, 2006

Европын улс орнуудын хувьд залуучуудын туулж өнгөрүүлэх энэхүү амьдралын хэв маяг харилцан адилгүй байгаа бол Монголын залуучуудын хувьд дээрх хэв маягуудын аль алиныг нь шингээсэн өвөрмөц дүр зураг харагдаж байна. Тухайлбал, одоогийн Монгол залуусын гэрлэлт, гэр бүл төлөвлөлт эрс оройтож, ганцаар амьдрахыг эрхэмлэж буйн зэрэгцээ аль болох урт хугацаанд сурахыг эрмэлзэхийн хэрээр төрж өссөн эцэг эхтэйгээ удаан хугацаанд хамт амьдрах нь (Өмнөд Европ) нийтлэг тохиолдож байна. Одоогоос хорь гаруй жилийн өмнө хийгдсэн судалгааны дүнгээс харахад өсвөр үеийнхний 24.2 хувь нь ирээдүйн сайн сайхан байдал, амьдралынхаа баталгаат байдалд эргэлзэж, 17 хувь нь огт итгэлгүй байгаагаа дурдсан байна. (О.Сарантуяа, 2001) Тэгвэл энэ хандлага одоо ч гэсэн залуу үеийнхэнд хэвээр хадгалагдаж буйг бидний судалгааны дүн батлан харуулж буй нь залуучуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар дорвитой арга хэмжээ авахгүй, авч байгаа ч үр дүн тааруу байгааг илтгэн харуулах юм.

Монголын залуучуудад тулгамдаж буй нийгмийн асуудлууд бол ажилгүйдлээс улбаатай орлогын хомсдол, хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадварыг боомилж буй чанаргүй боловсрол, эдгээрээс үүдэлтэй нийгэм, эдийн засгийн баталгаагүй байдал мөн. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас эрхлэн явуулсан “Сургуулиас ажилд шилжигсдийн судалгаа”-ны үр дүнгээс харахад Залуучуудын ажилгүйдлийн түвшин нийт хүн амын ажилгүйдлийн түвшингээс 2 дахин илүү буюу 14 хувь байгааг уг судалгааны дүн харуулж байна. Тэрчлэн хүн амын бүлгүүд ажилгүй болох үндсэн шалтгаан бол боловсролын байгууллагууд хөдөлмөрийн зах зээл дэх эрэлт хэрэгцээг харгалзахгүй мэргэжил олгодог, залуучууд хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээгүй мэргэжлийг олноор эзэмших үйл явцтай холбоотой байна. Хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжлийн болон дээд боловсролын үнэлэмж хандлагын ялгаанаас хамааран эрхэлж буй ажлын нэр хүнд, хөдөлмөрийн үнэлгээний зааг ялгаа их байна. Техник мэргэжлийн сургалт нь хүний хөгжлийн хоёрдогч болон гуравдагч сонголт, харин дээд боловсролтой хүн илүү сайн хөдөлмөр эрхлэх боломжтой, нэр хүндтэй хэмээх алдаатай үзэл хандлага хүн амын дунд зонхилсон хэвээрээ байна. Ялангуяа боловсролын ялгаатай үнэлэмж бүхий эл хандлагыг төрөөс зохицуулж, урамшуулах зорилгоор техник мэргэжлийн боловсрол

эзэмшигчдэд тэтгэмж(сарын 45000) олгож байсан боловч дээд боловсрол эзэмшигч оюутнуудад мөн тэтгэмж(сарын 70000) олгох болсноор эл бодлого бүхэлдээ үгүйсгэгдсэн гэж болно. Эдүгээ дээрх алдаатай бодлогыг төрөөс эргэн харж мэргэжлийн сургалтын төвд суралцаж буй оюутнуудын тэтгэмжийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч байгаа ч дорвитой үр дүнд хүрээгүй юм.


Цаашид хөдөлмөрийн насны хүн амд мэргэжлийн чиг баримжаа олгох, дахин сургах сургалтын хэрэгцээ үгүйлэгдэж байна.Хөдөлмөрийн зах зээлд шинээр дэвшин орж буй хүмүүсийн хувьд бэлэн ажлын байранд шууд ажиллах, эсвэл өөрөө бизнес эхлүүлэх боловсрол мэдлэг, ур чадвар дутмаг байна. Дээд боловсролын чанар тааруу, мэргэжлийн мэдлэг ур чадвар дутмаг, онолын сургалт давамгайлж байгаагаас шалтгаалж, дөнгөж ажил хөдөлмөрийн гараанд гарч буй хүмүүсийн хувьд мэргэжлийн ур чадвар дутах, ажлын байранд гологдох, цалин үнэлэмж доогуур байх зэрэг бэрхшээл тулгарч байгаа болно.

Залуучуудын талаар баримтлах үндэсний бодлогод залуучуудын амьдралын чанарт нөлөөтэй нэн тулгамдсан нийгмийн асуудлуудыг тусгаагүй, харин ерөнхий бөгөөд хоёрдогч хэрэгцээнүүдийг тусгасан байна. Залуу хүн нийгмийн амьдралд оролцох, өөрийгөө илэрхийлэх нь зүйтэй боловч ийнхүү оролцохын тулд давын өмнө боловсрол мэдлэг эзэмшсэн, ажил мэргэжилтэй, эдийн засгийн баталгаагаа хангасан байх ёстой билээ. Өнөөгийн Монголын залуус ажилгүй, орлого багатай, эдийн засгийн баталгаагүй байдалд амьдарч байгаа боловч амьдралын хэв маягийн хувьд Европын зарим улс орнуудтай жишиж болохуйц өвөрмөц гэмээр дүр зураг харагдаж байна.

Өнөөгийн залуучуудын хэрэгцээг хангах бодлогын орчин хэр зэрэг бүрдсэн, залуучуудын хэрэгцээ бүрэн дүүрэн биелэгдэж чадаж байгаа эсэх, энэхүү нөхцөл байдал тэдгээрийн хувийн сайн сайхан байдал, амьдралын чанарт хэрхэн нөлөөлж байгаад дүн шинжилгээ хийх нь ач холбогдолтой байх болно. Учир нь залуучууд бол нийгмийн шинэчлэлийг хийж, уламжлалыг хадгалан өсвөр үеийнхэнд дамжуулах үүрэг бүхий өвөрмөц бүлэг болохын хувьд хүн амын бодлогын цөм байх учиртай.

Хэдийгээр залуучуудын хөгжлийн зарим асуудлуудыг хөтөлбөрийн хүрээнд цаасан дээр тунхагласан боловч бодит амьдралд залуучуудын нийгмийн асуудал шийдвэрлэгдээгүй, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж буй олон тооны хүчин зүйлс байсаар байна. Эдгээрийг загварчлан харуулвал,

Дүрс-2.18 Залуучуудын амьдралын чанарт нөлөөлж буй хүчин зүйлс



Хэдийгээр өнгөрсөн хугацаанд Залуучуудын талаар төрөөс баримтлах хөтөлбөр/1996, 2006/ батлагдан хэрэгжсэн боловч, төрийн зүгээс баримталж буй нийгмийн бодлогын хэрэгжилт уялдаа холбоогүй, залууст тулгамдаж буй орон байр, ажил хөдөлмөр, ахуй хангамж, хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд чиглээгүй, соёл төлөвшлийн бодлого байхгүй, орхигдмол шинжтэй явж ирсэн байна. Монгол Улсын засгийн газраас 1998 оныг Залуучуудын жил болгон зохион байгуулахаар шийдвэрлэж, улмаар тус ондоо багтаан Монголын залуучуудын үндэсний хөтөлбөрийг баталсан нь нийгмийн энэхүү бүлэгт төр засгаас анхаарч буйн нэгэн илрэл болж байв. Тухайн үеийн хөтөлбөрийн үнэлгээний тайлангаас үзэхэд 1998-2005 онд хэрэгжүүлсэн Монголын залуучуудын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлт 80 хувьтай байжээ.

Харин 2006 онд баталсан Өсвөр үе, залуучуудыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг Мянганы хөгжлийн зорилготой нягт уялдуулан гаргасан ба 2015 он хүртэл хэрэгжих юм. Үүнд залуучуудын өөрийнхөө төлөө болон нийгмийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, хөгжих, эрх ашгаа хамгаалах, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд оролцох оролцоог өргөжүүлэх, хорт зуршил өвчлөлөөс сэргийлэх, аюулгүй ээлтэй орчныг бүрдүүлэх замаар чадварлаг, бүтээлч, ёс суртахуунтай, боловсрол соёлтой иргэн болж төлөвших зэрэг анхаарал татсан чиглэлүүдийг тусгажээ.

Манай улсын хүн амыг бүрдүүлэгч үндсэн цөм бол залуучууд юм. Тэрчлэн хүн амын бүлгүүдээс хамгийн үр бүтээлтэй байж болох, мөнхүү хамгийн их эрсдлийг хүлээж буй бүлэг бол залуучууд болно. Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрөөс үзэхэд ядуу буюу орлого багатай хүн ам болох залуучууд, тухайлбал

чинээлэг амьдралтай бүлгийн хүмүүсийг бодвол ядуу болон дунд зэргийн амьдралтай хүмүүс эрүүл мэндийн салбарын үйлчилгээг харьцангуй бага хүртэж байна.

Судалгааны баримтаас үзэхэд өнөөгийн Монголын залуучууд “албан ёсоор гэрлэлтээ батлуулдаггүй, хамтран амьдардаг шалтгаанаа өөрийн гэсэн орон гэргүй байгаагаас үүдэлтэй” хэмээсэн нь төрийн зүгээс анхаарвал зохих бодлогын асуудал юм. Учир гэвэл орлого багатай залуу гэр бүлийг орон сууцтай болгох талаар төрөөс оновчтой бодлого өнөө хэр нь гаргаагүй. Монгол Улсын төр засгаас хүчин чармайлт гаргаж дөрвөн мянга, дөчин мянга, зуун мянган айлын орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн боловч бодит байдалд орон сууцны үнийг хөөргөдөхөд хүргэж, 2008-2010 оны хооронд орон сууцны үнэ 50-80 хувиар нэмэгдсэн байна. Ингэснээр ихэнх залуу гэр бүл орон сууц худалдан авах хүндрэлтэй тулгарч, орон сууц худалдан авсан нь банк санхүүгийн барьцаа, өр зээлийн дарамтад өртөх болжээ. Залуучуудын хувьд хуримтлал үүсгэх бус, өнөөдөр олж буй орлогоо орон сууцны зээл, банкны өр зээлэнд тушааж буй нь нууц биш юм. Гэтэл залуусын хувьд одоогийн эрхэлж буй ажил тийм ч баталгаатай бус байгаа нь цаашид тулгарах эрсдэл, ирээдүйн баталгаагүй байдлын эхлэл болж байна. Ажилгүйдэл, орлогын хомсдол, эрүүл мэндийн баталгаагүй байдал зэргээс үүдэн залуучуудын нийгмийн баталгаа алдагдаж байна. Ялангуяа залуусын эдийн засгийн болон нийгмийн баталгааг тэд өөрсдөө биш, төрөөс бус, харин гэр бүлийн гишүүд, эцэг эхчүүд зонхилон үүрч байна. Хөдөлмөр эрхэлж байгаа Залуучуудын дийлэнхи олонхи нь албан бус секторт ажиллаж байгаа нь цалин орлого тогтворгүй болох, улирлын чанартай ажил хөдөлмөр эрхлэх, ажлаас халагдах, ажилгүй болох, сэтгэл санаагаар унах, зэрэг олон тооны эрсдлийг дагуулж байна. Анх удаа гэрлэгсдийг төрөөс дэмжих 500 мянган төгрөгийн дэмжлэг залуусын гэрлэлтийн түр зуурын өсөлт болон салалт ихсэхэд ихээхэн нөлөө үзүүлжээ. Энэ хугацаанд төр засгийн зүгээс залуучуудын боловсролыг дэмжих бодлогод алдаа, ахиц дэвшлийн аль алин нь гарсан. Монгол Улсын төрөөс явуулж буй дээд боловсролын бодлогын алдааны улмаас олон тооны чанаргүй их дээд сургуулиуд үүсч, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэхгүй салбар, мэргэжлүүд, мөн чадавхи муутай, мэргэжлийн дадал байхгүй боловсон хүчин олноор бэлтгэгдэн гарсан. Ингэснээр ажилгүйдлийн өндөр түвшин, сул байгаа ажлын байрны өндөр түвшин зэрэгцэн оршиж байна. 2010 онд Үндэсний хөгжил, шинэчлэлийн хорооноос хийсэн судалгаанаас харахад мянган ажлын байр сул байхад, зуун мянган ажилгүйчүүд бүртгэлтэй байжээ. Энэ зөрүү нь их дээд сургуулийн дийлэнх нь уул уурхай, барилга, дэд бүтцэд эрэлттэй байгаа байгалийн шинжлэл, инженер техникийн чиглэлээр боловсон

хүчин бэлтгээгүйтэй зарим талаар холбоотой ажээ. Хөдөлмөрийн насны хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин өндөр болж буй нөхцөлд, хүн амд тэжээгдэгч насны бүлэг(0-15, 65-с дээш насныхан)-ийн эзлэх хувийн жин буурснаар тэжээгчийн ачаа хөнгөрч, өрхийн хуримтлал хадгаламж нэмэгдэх, улсын төсөв хийгээд боловсролын чанарт ахиц гарах боломжтой. Гэсэн хэдий ч залуучуудын түрэлтийн энэ хугацаанд ажил хөдөлмөр эрхлэхгүй, сурч боловсроход тэмүүлсэн, сонгуулийн амлалттай холбоотой тэтгэмжийн зардлыг өсгөснөөр нийгмийн хамгааллын тогтолцоонд дарамт учруулж, төсөвт бэрхшээл авчирсан байна.

Хүн ам, хөгжлийн бодлого (МУЗГ, Алсын хараа 2020-2050, 2019) бол хүн амын ирээдүйн хэв маяг, хандлагын энэхүү өөрчлөлтийн дүнд хүмүүсийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх, хүн амын амьдралын чанарыг сайжруулахыг зорьдог юм. Тэрчлэн хүн амын бодлого нь тухайн улсын хүн ам зүй, нийгэм, эдийн засагт тулгараад байгаа нөхцөл байдал, тэдгээрийн хоорондын харилцаа холбоонд тулгуурладаг. Нийгэм-эдийн засгийн хөгжлийн явцаас шалтгаалан 2004 оноос хойш манай улсын хүн амын амьдралын хэв маяг, хандлагад олон чухал өөрчлөлт явагдсан. Хүн амын төрөлт, шилжих хөдөлгөөн нийгэм-эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдал, амьдралын түвшин, хөдөлмөр эрхлэх боломж, үйлчилгээний хүртээмжтэй уялдан өөрчлөгдөж ирсэн юм. Төрөлтийн түвшин 2005 онд 17.4 болж, түүхэндээ хамгийн бага түвшиндээ очиж байсан бол төр засгаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд энэ үзүүлэлт өсч, 2013 оны байдлаар төрөлтийн түвшин 27.5% болж, 1990 оноос хойшхи хугацаанд хамгийн өндөр түвшиндээ хүрсэн нь Засгийн газраас авч хэрэгжүүлсэн зөв бодлого, арга хэмжээ нь төрөлтийг, цаашлаад хүн амын өсөлтийг дэмжих үр нөлөөтэй бодлого болохыг харуулсан юм.


НҮБ-ын Хүн Амын Сангийн дэмжлэгтэйгээр 2012 онд хийгдсэн “Монгол Улсын хүн ам зүйн өөрчлөлтийн нийгэм, эдийн засгийн хөгжил, нийгмийн бодлого дахь нөлөөлөл” судалгаанд тодорхойлсноор (НҮБХАС, 2012) Монгол Улсын хүн ам зүйд “цонх үе” тохиож байна. Өөрөөр хэлбэл, тэжээлгэгч насны хүн ам тогтвортой буурч байхад хөдөлмөрийн насны хүн ам өсч байгаа үе буюу хөдөлмөрийн насны бүлэг (15-64 нас) ойрын хэдэн арван жил 60 гаруй хувийг эзлэн тогтвортой байх төлөв байдлыг тухайн судалгаанд дурджээ. Үүнээс үзвэл, хүн амын насны бүтцийн бодит байдал нь нийгэм эдийн засгийн хөгжилд таатай нөхцөлийг бий болгохын зэрэгцээ төрөөс хүн ам зүйн бодлогод онцгой анхаарах шаардлага бий болсныг харуулж байгаа бөгөөд энэ асуудалд судалгаа хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт тайлбар хийх, санал боловсруулах нь онолын болоод практик хэрэгцээ шаардлагыг бий болгож байгаа болно.

✚ Түүх, соёлын хүчин зүйлс

Залуучуудын түүх-соёлын өнөөгийн хөгжлийг тодорхойлохын тулд Монголчуудын суурь үнэт зүйл болон үнэлэмжийг тусгайлан авч үзэх шаардлагатай. Учир нь судлаачдын тэмдэглэснээр, Монгол хүний амьдрах арга ухаан, тэдний бүтээсэн соёл, урлаг, зан заншил, мэдлэг, өвлүүлэн үлдээх бүхий л цогц хэлбэр бол монголчуудын үнэт зүйл юм. Нөгөө талаас эв нэгдэл, хайр хүндэтгэл, эх оронч үзэл, гэр бүл, төр улсынхаа өмнө хүлээх үүрэг хариуцлага, нэр төрөө хамгаалах, шударга шулуун байдлыг эрхэмлэх ёс суртахуун, эрхэм чанарыг үр хүүхдүүддээ өвлүүлж байсан нь монголчуудын уламжлалт маягийн үнэт зүйл болж байна. XIII-XIV зууны монголын ёс зүйн сэтгэлгээний түүхийн эх сурвалжуудад эцэг эхийн ач, үнэнч шударга ёс, нөхөрлөх ёс, нэр төрөө бодох, эв эеэ хичээх, хатуужил тэвчээртэй байх, зарлиг ёсыг дагах зэрэг эрхэмлэлийг дээдэлж байсан тухай өгүүлдэг болно. Үүний хамт ахчлах дүүчлэх, тахилга, анд бололцох, ураг барилдах, элчин солилцох, хаан өргөмжлөх, хууль дээдлэх зэрэг ёс заншлыг тусгасны зэрэгцээ хуримын, андгай тангараг өргөх, найр наадмын, мэндлэх, талархлын, угтах үдэх, хувцаслах, зооглох, ёс горим тогтосныг харуулна. Түүнчлэн эв эе, эрдэм, нигүүлсэхүй сэтгэл, өршөөлт сэтгэл, ачийг ачаар хариулах ёс, өглөг, төрийг эрдмээр болон хууль цаазаар засах ёс өндөр байр суурь эзэлдэг байна. Энэ бүхнээс үзэхэд өнөөгийн залуучуудын эрхэмнэл, итгэл үнэмшилд түүх, соёлын хүчин зүйл үлэмж нөлөөтэй байдаг ажээ.

Өнөөгийн залуучуудаас юуг зөвшөөрч, юуг эсэргүүцдэг, чухам юуг эрхэмлэж, юунд итгэдэг талаар асуухад харилцан адилгүй хариулт өгсөн байна. Залуучуудын хариултаас үзэхэд цөөнгүй хувь нь гэр бүл(20.6%), мэдлэг боловсрол(19.2%), эрүүл мэнд(15.8%), эцэг эх(8.5%), хөдөлмөр(6.3%) зэрэг таван зүйлийг эрхэмлэж явдаг суурь үнэт зүйлсээ гэж үзсэн байна. Үүнээс үзэхэд өнөөгийн залуучуудын хувьд гэр бүлийн үнэт зүйл(бүлгийн), дараа нь мэдлэг боловсрол(нийгмийн), тэгээд эрүүл мэнд(хувийн) зэрэг үнэт зүйлсийг илүүтэй эрхэмлэж явдаг ажээ.

Дүрс-2.19 Залуучуудын үнэт зүйлсэд эзлэх түүх, соёлын хүчин зүйлс



Дашрамд тэмдэглэхэд, гэр бүлийн үнэт зүйлсийн хувьд өнөөгийн залуучууд материаллаг хангамжаас илүүтэй хайр халамж, гэр бүлийн гишүүдийн найрсаг уур амьсгал, үр хүүхдийн сайн сайхан байдлыг онцолж байгааг чанарын судалгааны ярилцлагад дурдсан байна. Гэр бүл нь уламжлал, ёс заншил ба хуулийн хүрээнд баталгаажсан нийгмийн анхдагч нэгж юм. Гэрлэлт нь тэгш эрх, сайн дурын харилцаан дээр үндэслэх ба гэрлэгчид нь бие биедээ үнэнч байх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, тэжээн тэтгэх, туслах, гэр бүлд шаардагдах эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх, хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй байх, угийн бичиг хөтлөх үүргийг адил хүлээхээр хуулинд заасан ба залуучуудын эрхэмлэж явдаг үнэт зүйлийг тэргүүлжээ.

Үүний зэрэгцээ хүний эрх эрх чөлөө(6.0%), ардчилал(3.4%), хариуцлага(3.1%) зэрэг нийгмийн үнэт зүйлсийг эрхэмлэж явдаг залуус байна. Мөн эд хөрөнгө(2.3%), ажил мэргэжил(2.1%), нэр төр(2.0%) зэрэг хувийн зүйлийг өөрсдийн үнэт зүйлээ болгосон байх нь ч таарч байна. Эдгээр үнэт зүйлийн дараагаар тусгаар тогтнол(1.5%), үндэсний уламжлал(1.2%), хүнлэг ёс(1.1%), энх тайван(0.2%) зэргийг үнэт зүйлсээ болгодог гэж хариулжээ. Бидний анзаарснаар залуучуудын үнэт зүйлд байгаль орчин, тусгаар тогтнол, үндэсний уламжлал, хүнлэг ёс, энх тайван гэх мэт үнэт зүйл эд хөрөнгөнөөс хойгуур эрэмбэлэгдэж байгаа нь анхаарал татаж байна. Залуучууд чухам юуг эрхэмлэж, юуг эс

зөвшөөрч байгаагаар тухайн үндэстний түүх, соёлын хэв шинж, хөгжлийн онцлогоор тодорхойлж болно. Өрнөдийн судлаачдын үзсэнээр үндэстний үнэт зүйлд тухайн улс орон дахь хүмүүсийн эрхэмлэж буй хүчин зүйлс, итгэл үнэмшлийн байдал шууд нөлөөлдөг ажээ.

Үнэлэмж нь нийгмийн харилцаанд бие хүний амьдралын хүсэл зориг, зорилго, үүрэг хариуцлага, нэр төр эрхэмлэх зүйлсийн тогтолцоог бүрдүүлж үйлдэл, үйл ажиллагаанд чиглүүлэгч үндсэн чиг шугам болж өгдөгөөрөө залуучуудын соёл түүхийн харилцаанд ихээхэн ач холбогдолтой. Тухайлбал, ёс суртахууны үнэлэмж нь нийгмийн харилцааг зохицуулах эерэг эрхэмлэлийг төлөвшүүлэн “өөртөө болон бусдад үнэ цэнтэй” байхуйц үйлдлийг тодорхойлдог байна. Орчин үеийн эрдэмтэд энэ асуудлын талаар салбар дундын чиглэлээр судалгааг эрчимтэй хийх болсон. Цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай үндсэн асуудал бол залуучуудын түүхэн мэдлэг, түүхэн ой санамж, түүхэн ухамсарын уялдаа холбоог тодорхойлох явдал юм. Оросын социологич Ю.А.Левада түүхэн ухамсарын тухай дараахь тодорхойлолтыг өгсөн (Ю.А, Левада, 1965) нь буй. Тухайлбал, “энэ ойлголт нь аяндаа үүссэн эсвэл шинжлэх ухаанаар бий болсон, нийгэм өнгөрсөн үеэ мэддэг олон янзын хэлбэрийг хамардаг” ажээ. Эрдэмтдийн үзэж байгаагаар түүхэн ухамсарын тухай ойлголт нь түүхэн ой санамжаас илүү өргөн хүрээтэй байдаг. Хэрэв ой санамжийг үндсэндээ өнгөрсөн үеийн туршлага, түүхийн туршлага руу чиглүүлдэг бол түүх, нийгмийн ухамсар нь өнгөрсөн үеийн туршлагын биелэл мэт одоог төсөөлж, ирээдүй рүү чиглүүлэхийг зорьдог ажээ. Судалгаанд оролцсон залуус ёс суртахуун, хүмүүжил төлөвшил, соёл, шашин, түүх, гэр бүлийн хүрээний үнэт зүйлсийн утга агуулгыг тайлбарлаж, үнэ цэнтэй зүйлээ эрхэмлэх нь хувь хүний болон нийгмийн хөгжил дэвшлийг хангах суурь хүчин зүйл болно гэдгийг тэмдэглэсэн байна.

Энэ бүгдээс ерөнхийлөн дүгнэхэд өнөөгийн залуус бол уламжлалт өв соёл, түүхэн өвийг эцэг эх, өвгөд дээдсээс тээн хөгжүүлж, ирээдүй хойчдоо залгамжлуулан үлдээх чухал хариуцлагатай үүргийг хүлээж, басхүү эзэмшиж байна. Хэдийгээр залуучуудын түүхэн ухамсар, соёлын хөгжилд төлөвшилд нийгмийн анхдагч үүр болох гэр бүлийн хүмүүжил, оролцоо чухал боловч төрийн бодлого, шийдвэрт үнэт зүйлсийг шингээсэн үзэл баримтлалыг суулгах нь нэн чухал байна. Өнөөгийн залуусын түүх соёлын хөгжлийг хангахын тулд хүүхдийн хүмүүжил, төлөвшилд багаас нь анхаарч чадвал үнэт зүйлийн чиг баримжаа баттай тогтох үндэс суурь бүрдэх болно.

ДӨРӨВ. ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

4.1 Залуучуудад тулгамдаж буй асуудал ба хөтөлбөрийн хэрэгжилт, эрх зүйн орчин

Аль ч улс орны хувьд хөгжил дэвшил, бүтээн байгуулалтыг бий болгогч нийгмийн хүчирхэг бүлэг бол залуучууд байдаг (М.Батбаатар, 2016). Чухамдаа энэ бүлгийн нийгэм, улс төр, эдийн засаг, оюун санаа, соёлын амьдралд оролцож буй түвшин, тэдгээрийн хөгжилд оруулж буй хувь нэмрээс улс орны хувь заяа хамаарах учиртай. Судлаачдын тэмдэглэснээр, “Монгол Улс бол Залуучуудын орон” хэмээн нэрлэгдэж ирсэн нь дан ганц хүн ам зүйн утга бус, өмнөх тогтолцооны үед ч, өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцад ч, өнөөдрийн энэ өдрүүдэд ч улс орны хөгжлийн түүчээ нь залуучууд байж ирсэн, байсаар байгаатай нягт холбоотой. Иймд хүн ам зүйн талаар баримталж буй төрийн бодлогод хүн амын суурь бүлэг болох залуучуудын асуудал чухал байр суурь эзлэх учиртай. Бүхэлд нь авч үзэхэд залуу хүн амын талаар баримтлах төрийн бодлого нь тодорхой хугацаанд шийдвэл зохих хүн амын тулгамдсан асуудлуудыг янз бүрийн арга хэмжээний нөлөөгөөр өөрчлөх (шийдэх) оролдлого билээ. Олон улсын байгууллагуудын тодорхойлолт, стандартаар залуучуудын бүлэгт 16-29 насныхныг хамруулан авч үзэж байна.(НҮБ, 2003) Монгол Улсын хувьд Хөдөлмөр эрхлэх насыг 16 гэж тогтоосон учраас Үндэсний статистикийн газраас жил бүр гаргадаг хүн амын талаарх мэдээлэлд эдийн засгийн идэвхтэй хүн амын хэсгийг тооцохдоо хөдөлмөр эрхлэлтийг уг наснаас эхлүүлэн тооцсон нь бий. Монгол Улс бол залуучуудын орон бөгөөд нийгмийн хөгжлийн тулгуур болсон энэхүү бүлэг, нийтлэгийн хэрэгцээ, сонирхол, хөгжил, хандлага, асуудал бэрхшээлийн талаар “Залуучуудын хөгжлийн хэрэгцээ”-г тодорхойлох, нийгмийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх үндэсний хэмжээний суурь судалгаа хэд хэдэн удаа хийжээ. Өнгөрсөн хугацаанд залуучуудын талаар хэд хэдэн удаа Засгийн газраас хөтөлбөр хэрэгжүүлсэн бөгөөд хууль эрх зүйн орчин сайжирсаар байна. Эдүгээ залуучуудын талаар төрийн бодлого тодорхой болж, Монголын залуучууд ямар нөхцөлд, хэрхэн амьдарч, юуг хүсэн мөрөөдөж, үнэлж, хэрхэн төлөвшиж, хөгжиж байна, тэдэнд юу хэрэгтэй, хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар сонирхон судлах эхлэл тавигдаж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, бодлогод тусгах, үйлчилгээ үзүүлэх чиглэлд ахиц дэвшил гарсныг дурдах учиртай.

1997 онд “Төрөөс залуучуудын талаар баримтлах бодлого”, 2005 онд “Хүн амыг орон сууцаар хангах үндэсний хөтөлбөр”, “Итгэлийн мөнгө”, “Залуу гэр бүл, шинээр төрсөн хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж” 2006 онд “Өсвөр үе, залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”, 2017 онд “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль”, холбогдох хөтөлбөр, дэд хөтөлбөрийг төр засгаас сүүлийн 20 гаруй жилд батлан, хэрэгжүүлж байгаа нь тодорхой хүрээнд үр дүнгээ өгч байгаа нь сайшаалтай. Гэвч, нэгдүгээрт эдгээр бодлогын арга хэмжээнүүд нь тэр бүр хангалттай хэрэгжиж залуучуудын өмнө тулгарч байгаа олон асуудлыг туйлбартай шийдвэрлэж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл хүн амын суурь бүлэг болсон залуучуудад тусгайлан баримжаалсан оновчтой, үр өгөөжтэй бие даасан бодлого, үйлчилгээ илт үгүйлэгдэж байгаа юм. Хоёрдугаарт, дээрх бодлогын арга хэмжээнүүд нь нэг талаас хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлд ахиц авчирсан боловч, нөгөө талаас төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, залгамж чанар, үр ашигт байдал үгүй байна. Иймд залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээний талаар ул үндэстэй судалж, өнөөгийн нөхцөл байдлыг танин мэдэх нь залуучуудад чиглэсэн төрийн үйлчилгээг сайжруулах, цаашилбал оновчтой бие даасан бодлого боловсруулан, хэрэгжүүлэх үндэс гэж үзэж байна.

Өнгөрсөн хугацаанд Залуучуудын хөгжлийн төвөөс суурь судалгааны тайлан үр дүн, санал зөвлөмжид тулгуурлан сонирхогч талуудыг оролцуулсан хэлэлцүүлэг (форум, эрдэм шинжилгээний хурал, телевизийн нэвтрүүлэг, сонингийн нийтлэл гэх мэт) өрнүүлэх замаар залуучуудын талаарх бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад нөлөөлөх, бодлогод санал дэвшүүлэх, хамтран бодлого боловсруулах, залуучуудын эрх ашгийг хамгаалдаг, энэ чиглэлд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил, судлаачид, эрдэмтэдийн анхаарлыг татах замаар цогц арга хэмжээ авч хэрэгжүүлсээр иржээ. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль мөрдөж эхэлснээр төрөөс залуучуудад үзүүлэх үйлчилгээний бүтэц тодорхой болсон хэдий ч, цаашид “*Залуучуудын талаарх үндэсний тогтолцоог хөгжүүлж*”, нийгмийн сүлжээг бий болгон бэхжүүлэх, нөлөөллийн стратеги боловсруулан, хэрэгжүүлэх явдал нэн чухлаар тавигдаж байна. Нийгмийн тогтолцоонд залуучуудын хөгжлийг хангах нөхцөл бүрдүүлж, эргээд тэднийхээ хүчээр нийгэм нь хөгжиж байдаг зүй тогтлыг бүрдүүлэх шаардлагатай байгаа ч дараах асуудлууд өнөөгийн залуучуудад тулгамдсан хэвээр, зохих шийдэл, гарцаа хүлээж байна.

- Монголын нийгмийн хөгжилд саад тээж буй ажилгүйдэл, ядуурлын дарамтыг шилжилтийн үеийн хүүхдүүд болоод өнөөгийн залуучууд нуруундаа

үүрсэн юм. Хүн ам зүйн бүтцийн болон бусад онцлогоос хамааран Монгол Улсын ядуурал, ажилгүйдэл бол залуучуудын ядуурал, ажилгүйдэл мөн. Нийт ажилгүйчүүдийн 60 гаруй хувийг 15-35 хүртэлх насны залуучууд эзэлж байна¹.

- Залуучуудын нэг хэсэг амьдралд хөлөө олж, сайхан амьдрах нөхцөл бүрдсэн ч нийгмийн үйлчилгээ, хөгжил, дэвшлийн үр шим зонхилох хэсэгт нь хүртээлгүй хэвээрээ байж, зах зээлийн ширвэлтэнд өртсөн залууст хөлөө олоход *нь юугаар, хэр хэмжээгээр, хэрхэн тулахаа* мэдэхгүй явсаар байна.
- Орлогын баталгаагүй байдал нь залуу хүний, залуу гэр бүлийн ирээдүйдээ итгэх итгэлийг мөхөөх хүчин зүйл болсоор байна. Хамгийн ноцтой нь залуучууд ядуурлыг өвлөн авч, ядуурал архагшиж² байгаа явдал юм. Эдгээрт шинжлэх ухааны үндэслэл бүхий хариулт үгүйлэгдсээр байна.
- Улс орон даяар хүн амыг орон сууцжуулах амлалт эхэлснээс хойш нэлээд хугацаа өнгөрчээ. Хот байгуулалт өрнөж, энд тэндгүй сүрлэг, чамин байрууд баригдсаар атал дийлэнхи залуучуудын хувьд энэ нь хамааралгүй зүйл болох нь нэгэнт тодорхой болов. Гэвч өнөөдрийг хүртэл залуучууд орон байр бус оромж төдий хэрэгцээтэй амьдарч байгаа, хөгжил, цэцэглэлт бүтээн байгуулалт яагаад тэдэнд хүртээлгүй байгаа, хэрхэн хүртээмжтэй болгох талаар *оношлох* шаардлагатай.
- Амьдралын эрхээр олон мянган залуус эх орноо орхин, харийн нутагт хүнд хүчир хөдөлмөр эрхэлж буй нь нууц биш. Мөнхүү тодорхой ажил, мэргэжлийн хүрээний оюунлаг залуус өөр оронд эрч хүч, авъяас чадвараа үнэлүүлэн амьдарч байна. Залуучуудыг олон мянгаар нь хуаранжуулан гадаадад явуулах нэрээр бүртгэж, тодорхой хэсгийг нь эрүүл гэх шалтгаанаар үлдээн, ядарсан олныг бүртгэл, шинжилгээ гэх өдий төдий мөнгөөр хохироодог явдлыг гадаадад ажиллах хүчний бодлого гэх нь арай л учир дутагдалтай мэт. Гадагш чиглэсэн залуучуудын нүүдлийг зөв буруу гэж дүгнэхээс илүүтэй цаашид эх орон нь энэ их нөөц баялгийг хэрхэн ашиглах, залуучууд өөрсдийн гэр бүл, үр хүүхэдтэйгээ элэг бүтэн аж төрөх, эх хэлээрээ зөв ярьж, эх соёл, түүхээ бүтээлцэх, эх хэлээ дархалж амьдрах цаг үе хэзээ вэ? гэдгийг тодорхойлох *алсын хараа Монгол улсад байгаа юу* гэдэг нь хариулт нэхсэн асуулт мөн.
- Дэлхий нийтийн хөгжлийн хандлага мэдээлэл, технологийн эрин үед шилжиж боловсрол, мэргэжил залуу хүний нийгмийн байр суурийг тодорхойлж байхад

¹ МУЗГ. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратеги. УБ 2003 он.

² Архаг ядуурал буюу Chronic poverty хэмээх ойлголт байх бөгөөд энэ нь өсвөр үе, залуучууд ядуурлыг эцэг эхээс өвлөн авч, ирээдүйн ядуучуудын эгнээнд шилжих үйл явцыг тэмдэглэдэг.

Монголын залуучууд хэдэн мянгаараа мэргэжилтэй ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж байна. Чухамдаа энэ асуудал боловсролын системд байна уу, хөдөлмөрийн зах зээлийн багтаамжид байна уу, мэргэжил сонголт, хамтын зан үйлд байна уу, боловсролын харалган бодлогод байгаа юу зэрэг олон асуултад харулт өгч чадаагүй байна. Цаашид залуу хүнд үнэтэй, чанартай боловсрол олгодог, залуу хүний байр суурийг эцэг эхийн бэнчин, нэр нөлөө биш өөрийнх нь мэдлэг, боловсрол тодорхойлдог байхын тулд ажил мэргэжил, мэргэжлийн чиг баримжаа, ажил хөдөлмөрт зуучлах чухамхүү ямар үйлчилгээг хэрхэн үзүүлэх хэрэгтэйг тодорхойлох цаг болжээ.

- Залуучууд хууль ёс, ёс суртахууны наад захын жишиг хэм хэмжээг үгүйсгэн амьдрах явдал улам даамжирч, ужгирах шинжтэй байна. Архидан согтуурах, хулгай луйвар хийх, өмч завших, авлига хээл хахуульд өртөх, хулгай дээрэм хийх, биеэ үнэлэх, хар тамхинд мансуурах, хүний амь бүрэлгэх гээд гэмт хийгээд гаж үйлдлийн эзэд, хохирогчид нь үнэн хэрэгтээ залуучууд байна. Тэд задарсандаа бус өнөөгийн нийгэмд хүний дайтай явах боломжгүй болсондоо дасан зохицох янз бүрийн аргыг хэрэглэж байгаа нь харагдаж байна. Монголын залуучуудын цөөнгүй хэсэг нь гэмт хэрэгт өртөхөөс эхлээд садар самуун явдалд уруу татагдаж ДОХ/БЗХӨ тархаах, архи мансуурах бодисонд донтох, хүчирхийлэл үйлдэх, хүн худалдаалах гэх мэт муу муухай бүхэнд аль хэдийнээ хутгалдсаныг баримт нотолж байна. Энэ мэт үзэгдлийн учир шалтгаан, учгийг хөндөж ирээдүйн эх орны эздээ жинхэнэ соёлт, хүнлэг, иргэн байлгахад юу хийх хэрэгтэй вэ? Үүнийг шийдвэрлэх бүтэц, тогтолцоо Монголд чухамдаа бүрэлдэн бий болсон уу? гэдэг асуулт асуудал болоод удаж байна.
- Тухлан амьдрах орон гэргүй, орлогын баталгаагүй, боловсрол, мэргэжилгүй, үнэ хүндгүй зэрэг асуудлуудаас үүдэн залуус хүний ёсоор хайр сэтгэлээ илэрхийлж, гэр бүл зохиож чадахгүй байна. Залуу гэр бүлийн хувь заяа нь цөөнгүй тохиолдолд тусдаа амьдрах, зөрчил маргаанд туйлдах, салж сарних явдлаар төгсөх болжээ. Нэг үгээр хэлбэл баталгаагүй амьдралын урхинд орсон залуусын гэр бүл аз жаргалтай амьдралыг мөрөөдөх ч эрхгүй байна. Өнөөдөр ажилгүй ядуу байгаа, уул уурхайд ээлжийн ажилтнаар/роастер/ ажиллаж байгаа, аргагүйн эрхэнд гадаадад хөдөлмөрийн дүрвэлт хийн, ажиллаж амьдарч байгаа, чанаргүй боловсрол эзэмшсэний улмаас ажил хөдөлмөр эрхлэхгүй байгаа олон тооны залуучууд байгаа бөгөөд харин тэдгээрээс үүдэн залуучуудын, залуу гэр бүлийн

амьдралд нийгэм, сэтгэлзүй, эрүүл мэндийн далд үр дагавар, эмгэг “архагшиж” байгааг тодорхойлж, “нийгмийн хөдөлгөгч хүч” болсон залуучуудын бүлэгт чиглэсэн ээлтэй үйлчилгээг чадвал олон улсын стандартад нийцүүлж, ядвал дөхүүлж үзүүлэх шаардлагатай юм.

- Хөдөлмөрийн насны хүн амын хувьд гадаадад хөдөлмөр эрхлэх сэдэл, хандлага түгээмэл хэвээр байна. Албан бус тоогоор 150 мянга орчим Монгол Улсын иргэд хилийн чанадад, өөр улс орнуудад сурч, ажиллаж, амьдарч байгаа нь манай улсын нийт ажиллах хүчний 9.3-18.6 хувийг эзэлж байгаа ажээ. Гадаадад ажиллагсдын дийлэнх нь 20-35 насны бүлэгт хамаарагдаж байгаа ба тэдний дундаж нас 31 байгаа болно. Гадаадад ажиллагчдын ар гэрийнхэн болон тэднээс авсан судалгааны мэдээллээр гадаадад хөдөлмөр эрхлэх явдал тэдний амьдралын хэв маяг, нийгмийн харилцаан ихэвчлэн сөрөг нөлөө үзүүлж байна. Гадаадад хөдөлмөр эрхлэгчид, тэдгээрийн ар гэрийнхний хувьд тулгамдаж буй томоохон асуудлын нэг бол гэр бүл салалт болоод байна. Ялангуяа БНСУ-д гэрээгээр ажиллагчдын хувьд өндөр үнэтэй байр хөлслөх, түрээслэхдээ нутаг нэгтэй хүмүүстэй хамтран хөлслөх, “хуурамчаар” эхнэр нөхөр болон хамтран амьдрах явдал түгээмэл бөгөөд удаан хугацаанд хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн ихэнх нь дахин гэрлэсэн буюу гэрлэлтээ цуцлуулсан байв. Түүнчлэн эцэг эхийн халамж, анхаарлаас хол хөндий өсөж буй хүүхдүүдийн нийгмийн асуудал тулгамдсан бөгөөд анхаарвал зохих асуудлын нэг мөн. Гадаадад ажиллагч Залуучуудын хувьд ихэвчлэн оёдол, барилга, үйлдвэр, худалдаа, үйлчилгээний салбарт, голчлон үнэлгээ багатай “хар бор” гэгдэх тухайн улс орны иргэд голоод хийдэггүй туслах, цэвэрлэгээ, үйлчилгээ, хүн асрах, хүүхэд саатуулах, усан онгоц, загас агнуур гм баталгаагүй, эрүүл мэндэд хор хохиролтой нөхцөлд хөдөлмөр эрхэлж байна. Тухайлбал гадаад улс орон, ялангуяа солонгост ажиллаж байгаа хүмүүсийн хувьд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүй, хүнд хортой нөхцөлд ажилладагаас үүдэн олон тооны залуус хөдөлмөрийн чадвар, эрүүл мэнд, амь насаараа хохирсоор байна. Энэ талаар 2010 онд Солонгост буй Монгол Улсын элчин сайд “...Солонгост ажиллаж буй Залуучууын хувьд 7 хоног бүр 6-7 хүн гэмтэж, 30-40 хүн архидалтаас үүдэн зодоон цохион хийж, тодорхой тооны хүмүүс нас барж байна” хэмээн тэмдэглэсэн нь бий. Гадаадад(Ялангуяа Солонгост) ажил эрхлэгчдийн нас баралтын статистикийг авч үзвэл өнгөрсөн хугацаанд 370 орчим тохиолдол байна. Эл бүгдэд үндэслэн МУЗГ-аас гадаадад

хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн асуудлыг анхаарч эхэлсний илрэл бол гадаадад ажиллагчдын нийгмийн даатгалын асуудлыг шийдвэрлэсэн явдал байлаа. Түүнчлэн гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучилж буй байгууллагуудын үйл ажиллагаанд анхаарч эхэлсэн юм. Ер нь МУЗГ гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах зөвшөөрлийг тогтолцоот байдлаар, системтэйгээр олгоход шилжилтийн эхнээс дуусах үе хүртэл анхаарч байсангүй. Иймээс ч гадаадад зуучлах албан(Монгол Ньюс, Заг ХХК гм 20 гаруй) болон албан бус(ихэвчлэн хувь хүмүүс) тогтолцоо бий болж, 2004 онд НХХЯ-ны дэргэд “Хөдөлмөр зуучлалын товчоо” байгуулагдан ажиллаж, 15000 мянган ажилчдыг сонгон шалгаруулах кампанит ажил хийж, нас, бие, эрүүл мэндээр шилж сонгон үй олноор нь гадаадад илгээж байлаа. Тухайн үеийн НХХЯ-ны албан тушаалтнууд нутгийн залуусыг гадаадад олноор нь хөдөлмөр эрхлэхээр явуулж байсан мэдээ баримт ч цөөнгүй бий. Үүнээс улбаалан ганц биеэр амьдрагчид нэмэгдэж, залуу насны бүлгийн хувьд ихэвчлэн гэрлээгүй, сурах хүсэл эрмэлзэлтэй хүүхэдгүй бүсгүйчүүд, боловсролтой, ажил төвт , салсан хүмүүс зонхилох болсон юм. Өнөөгийн залуучууд ганц биеэр амьдрах болсны шалтгаан нь а) гэрлэлтийн насны эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс цөөрсөн(гадаадад хөдөлмөр эрхлэхээр явагсад ихэвчлэн хөдөлмөрийн ид насны хүмүүс байгаа болно), б)залуусын танилцах боломж болсон их дээд сургуульд суралцагчдын (эрэгтэй:30, эмэгтэй:70) хүйсийн харьцаа алдагдсан в) боловсрол хүмүүжлийн түвшингээр эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс хоцрогдсон байдал удаан арилж байгаа, г) гэр бүл болох, гэр бүлийн амьдралын бэлтгэл тааруугаас гэр бүл салалт залуу гэр бүлд их байгаа(гэр бүл цуцлалтын 38 хувь нь 6-7 жил болоод гэр бүлээ цуцлуулсан залуу гэр бүл байна) зэрэг болно. Эдгээр болон бусад шалтгааны улмаас “гадаадад бус эх орондоо ажиллаж, амьдрах” тухай иргэний нийгмийн дуу хоолой 2008 оноос өрнүүн хэлэлцэгдэх болж ингэснээр МУЗГ гадаадад залуу ажиллах хүч олноор гаргах асуудалд шүүмжлэлт байр сууринаас хандаж эхэлсэн. Гадаадад хөдөлмөр эрхэлж буй Залуучуудын дунд явуулсан судалгааны дүнгээс үзэхэд тэдний 32.5-47.1 хувь нь гадаад явахаасаа өмнө Монголд ажил эрхэлж байгаагүй нь эдгээр залуусын гадаад улс оронд хөдөлмөр эрхлэх гол шалтгаан бол ажилгүй байсных хэмээн дүгнэхэд хүргэж байна.

- МУЗГ-ын 2010 оны 09.28-ны өдрийн 250 тоот тогтоол, Зөгийн үүр хөтөлбөрт “...хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдийг эх орондоо ирж ажиллах,

амьдрахад шаардлагатай бодит мэдээллээр хангах, тэдний боловсрол, мэргэжлийн туршлага, ур чадварын талаар мэдээллийн сан үүсгэх, судалгаа хийх” тухай тусгасан боловч өнөө хэр нь ажил хэрэг болоогүй, бодит үр дүн гараагүй байгаа болно.

- Дотоодын шилжинги чанартай хөдөлмөр эрхлэлт залуу гэр бүлд хохирол учруулсаар байна. Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтэд гарч буй нэгэн өөрчлөлт бол гэрээс хол, тодорхой хугацаагаар тусгаарлагдсан нөхцөлд хөдөлмөр эрхлэх байдал нэмэгдсэн явдал болно. 2010-2015 онд хөдөлмөрийн зах зээл дээр нийт 40000 гаруй ажлын байр шинээр бий болохоос 6000 гаруй инженер техникийн ажилтан шаардлагатай байгаа ба өндөр технологийн аж үйлдвэрийн салбарт шинээр ажиллах хүчний эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэх төлөвтэй байна. Ялангуяа Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр зэрэг аймгуудад олборлох үйлдвэр, уул уурхайн компаниуд олноор бий болж, хөдөлмөрийн шилжих хөдөлгөөнийг үүсгэсэн. Ингэснээр Монголчууд 14, 28 хоногоор ажиллаж амрах болсноор гэр бүлээс хөндийрөх, тусдаа амьдрах, улмаар гэр бүл салах хүртэл сөрөг нөлөө үзүүлэх болсон.
- Нөгөөтэйгүүр дотоодод нас, мэргэжил, хүйсийн онцлогоос хамааран хөдөлмөрийн хөлсний ялгаа үлэмж их, хүнд, хортой нөхцлүүд байсаар байна. Ялангуяа барилга болон уул уурхайн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдлаас үүдэлтэй аваар осол ихээр гарах болж, хүн амын дунд золгүй, тохиолдлын шинжтэй нас баралт ихсэх болсон. Уул уурхай, барилга зэрэг ажлын байран дахь аюулгүй байдлын сургалт дадал, техник тоног төхөөрөмж, ажлын орчин хангалтгүйгээс хөдөлмөрийн осол гэмтэл зонхилон гарч байна. Өөрчлөгдөн буй өнөөгийн эрин цагт, Монгол хүн ажиллаж, хөдөлмөрлөж түүнийхээ амт шимтийг мэдрэх, нөгөөтэйгүүр эрүүл амьдралын хэв маягийг эрхэмлэж, урт удаан аз жаргалтай амьдрах хандлагыг эрхэмлэх болсон нь амьдралын чанарт гарч буй томоохон дэвшил мөн.

Шилжилтийн дунд хугацаанд эдийн засгийн өсөлт тогтворгүй, зарим жилүүдэд эргээд буурсан бол, урт хугацаанд авч үзэхэд Монгол Улсын эдийн засгийн нөхцөлд өсөлтийн ерөнхий чиг хандлага ажиглагдаж байна. Эдийн засгийн тууштай өсөлт сэргэлт 2004 оноос эхэлсэн ба 2006-2008 оны хооронд эдийн засаг бүхэлдээ тэлж, өссөн нь харагдаж байна. Гэсэн хэдий ч эдийн засгийн өсөлт нь хүн амын амьдралын чанарт тодорхой бөгөөд шийдвэрлэх нөлөөтэй байсангүй. Статистикийн мэдээллээс үзэхэд ядуурлын

түвшин 2014 оны байдлаар 21.4 хувьтай байгаа нь 20 жилийн өмнөхөөс 15 орчим хувиар, 2010 онтой харьцуулахад 11 хувиар, одоогоос хоёр жилийн өмнөхтэй харьцуулахад 5.4 хувиар тус тус буурсан нь хангалтгүй үзүүлэлт юм. Шилжилтийн хугацаанд Монгол Улсын төр, засгийн зүгээс авч хэрэгжүүлсэн эдийн засгийн арга хэмжээнүүдийг энд авч үзлээ. Анх 1991 онд өмч хувьчлах тогтоол гарсан. Үүнтэй холбоотойгоор малыг малчдад хэмээх уриаг амьдрал дээр хэрэгжүүлж, томоохон аж ахуй, хоршооллын өмчүүд хувьчлагдсан н шилжилтийн үеийн эдийн засгийн хямралыг бий болгож, өмчийн ялгааг үүсгэх эхлэл болсон. 1994 оны нөхцөл байдал, хүндрэл бэрхшээлээс үүдэн Монгол Улс анх удаа Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Юуны өмнө шилжилтийн эхэн үе болох 1990-1993 онд өрхийн амьжиргааны түвшин илт доройтож, ажилгүйдлээс үүдэлтэй орлогын хомсдол нүүрлэж, хуримтлал үүсгэж чадахгүй, орлогын ихэнх хэсгийг өдөр тутмын хүнсний хэрэглээнд зарцуулж, товчхондоо Монгол өрх, гэр эдийн засгийн хувьд ихээхэн хүнд дарамттай тулгарч байжээ. Энэ үед МУЗГ-аас өрхийн амьжиргааны түвшин, ядуурлын төрөл хэлбэрийг тодорхойлон, улмаар өрхийн үндсэн хэрэгцээг хангах бодлогыг авч хэрэгжүүлсэн байна.

Шилжилтийн дунд үе болох 1994-2004 онд өрхийн амьжиргаанд тулгамдаж буй олон асуудлууд шийдвэрлэгдэж, ядуу өрхийн амьжиргааг төр засгийн зүгээс системтэйгээр дэмжиж эхэлжээ. Тухайлбал, хандивлагч улс орнуудын дэмжлэгтэйгээр өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлал боловсруулан, хүн амын амьжиргааг дэмжих бодлогууд болох Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр(1994-2000), Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратеги(2003)-ийг баталж, хандивлагч орнуудын дэмжлэгтэйгээр өрхийн амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Энэ үед өнөөгийн Монгол өрхийн амьдралын чанарт мэдэгдэхүйц өөрчлөлт гарч, амьжиргааны түвшин дээшлэх, өөрчлөгдөн хөгжих суурь тавигдсан болно. Мөн хугацаанд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох болсон, төрийн албан хаагчдын хүүхдийн сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх, сургалтын төрийн сангаас оюутны төлбөрт төрөөс олгосон хөнгөлөлттэй зээлийг цуцлах замаар барьцаалсан дипломыг буцаан олгох шийдвэр гаргасан зэрэг нь төрөөс дээд боловсролын салбарт ажиллах, мэргэжилтэй боловсон хүчнийг дэмжсэн бодитой алхам байжээ.

2004 оны Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд ядуу болон нэн ядуу өрхийн хүүхэд, залуусыг мэргэжлийн чиг баримжаа олгох болон ажилд зуучлах үйл ажиллагааг эрчимжүүлэхээр төлөвлөсөн боловч үүний хэрэгжилтийн талаар бодитой үнэлгээ, мэдээлэл байхгүй.

Шилжилтийн дараах үе буюу 2005-2008 онд өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх бодлогод эрс өөрчлөлт гарсан. Улс төрийн намуудын сонгуулийн амлалт, мөрийн хөтөлбөр, улмаар хамтарсан засгийн газар байгуулсантай холбоотойгоор өрхөд үзүүлэх нийгмийн халамжийн тоог нэмэгдүүлэн, ажил эрхлэлтийг дэмжих замаар өрхийн амьжиргааг дэмжин, ядуурлыг бууруулах олон тооны бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн болно. Энэ хугацаанд ялангуяа залуусыг эдийн засгийн тусгайлсан арга хэмжээ байхгүй боловч төрийн бодлогын зарим хэсэгт тусгагдан шийдвэрлэгдэж байсан юм. Сонгуулийн зарим популист амлалттай холбоотойгоор хүүхэд болон залуучууд, насанд хүрэгчдэд олгох мөнгөн дэмжлэг өрхийн эдийн засгийг дэмжихэд зохих хэмжээгээр нөлөөлсөн.

2010 оноос хойш Монгол өрхийн амьжиргааны түвшин өмнөх үеэс эрс дээшилж, шинэ хэрэгцээ, шинэ боломжууд бий болох эхлэл тавигдсан. Юуны өмнө эдийн засгийн нөхцөл, ажил эрхлэлтийн байдал сайжирч, мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн томоохон хөрөнгө оруулалт бий болсноор өрхийн орлого нэмэгдэж, зарлагад эзлэх хүнсний хувь хэмжээ буурч, өрхийн амьжиргаанд хэрэглээний эерэг хандлагууд төлөвшин бий болж байна

Стратегийн ач холбогдол бүхий томоохон орд газраас олсон орлогоос иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх зорилт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан. Тус зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 4 сард баталсан 84 дүгээр тогтоолоор 2010-2012 онд Монгол Улсын иргэн бүрт 1.5 сая төгрөгийг тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх, боловсрол, эрүүл мэнд, орон сууцны төлбөрийн эрх болон бэлэн мөнгө гэсэн хэлбэрээр олгохоор тогтсон.

Ингэснээр хүн амын залуу хэсэгт хандсан боловсрол, нийгмийн хамгааллыг дэмжих, амьжиргааг сайжруулах нийгэм-эдийн засгийн дараах хөтөлбөр хэрэгжсэн юм.

– Орон сууц худалдан авах урьдчилгаа, зээл болон зээлийн хүүг төлөхөд зориулан орон сууцны төлбөрийн эрх олгох;

– Их, дээд сургууль, коллеж болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа суралцагчдын сургалтын төлбөр, ерөнхий боловсролын сургуулийн 1-12 дугаар ангийн сурагчдын сурах бичиг, хичээлийн хэрэгсэл, сургуулийн дүрэмт хувцасны төлбөр, ажилгүй иргэдийг мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд хурдавчилсан сургалтаар мэргэжил эзэмшүүлэхэд зориулан төлбөрийн эрх олгох зэрэг үйл ажиллагаанууд тусгагдсан бөгөөд үр шимийг нь багагүй хүртсэн залуучуудын дундах цөм бөгөөд өвөрмөц бүлэг бол оюутнууд юм.

“Хүний хөгжил сангийн тухай” хууль батлагдсантай холбоотойгоор “Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай” болон “Эх, хүүхдэд, тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай” хуулиуд 2009 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хүчингүй болж, шинээр төрсөн хүүхдийн тэтгэмж, шинээргэрлэгсдэд төрөөс нэг удаа олгох мөнгөн тусламж (Залуу гэр бүлд олгох 500.000 төгрөг), шинэ төрсөн хүүхдэд төрөөс нэг удаа олгох мөнгөн тусламж, “Монгол Улсын хөгжүүлэх сангийн тухай” хуулийн дагуу олгож байсан хүүхдийн мөнгө тус тус олгогдохгүй болсон ба оюутнуудад “Хүний хөгжил сан”-гаас 500 мянган төгрөг олгох болжээ.

Хүн амыг насны бүлгээр авч үзэхэд ялангуяа залуучууд амьжиргааны түвшин, эдийн засгийн байдлын хувьд хүн амын бүлгийн дотор нэлээд доогуур түвшинд орж байгаа нь тэднийг эмзэг байдалд түлхэн оруулах үндсэн хүчин зүйл болж байна. Өнөөгийн залуусын талаас илүү хувь нь өдөр тутмын хооллох, хувцаслах хэрэгцээнээс илүү гарч чадахгүй байгаа явдал бол тухайн бүлгийн амьжиргаа тааруу, хэрэгцээ хангалт “тарчигхан”, эдийн засгийн агуулгаар ядуурлын нөхцөлд байгаа хэрэг мөн.


Монгол Улсын Их хурлаас 2017 оны 05 сарын 18-ны өдөр Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг баталж, 2018 оны 1 дүгээр 01-ний өдрөөс тус хууль хэрэгжиж эхэлсэн. Тус хууль нь төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, нийгмийн хөгжил, оролцоог хангах чиглэлээр үндсэн таван чиглэл болох Хувь хүний хөгжил, Боловсрол, соёл, урлаг, спорт шинжлэх ухаан, Эрүүл мэнд, Хөдөлмөр эрхлэлт, Аюулгүй амьдрах, хөгжих орчны хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд юуны өмнө залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай болсноор Залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндэс суурь бий болж, нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх үүргийг тодорхойлохтой холбоотой дүрэм, журамтай болох ажил эрчимтэйгээр хэрэгжих үндэс суурь баттай тавигдсан юм.

Ингэснээр 21 аймаг, 8 дүүргийн нийт 32 Залуучууд хөгжлийн төв (ЗХТ)-өөр дамжуулан төрийн үйлчилгээг залуучуудад хүргэх тогтолцоо бий болсон ба өмнө нь олон нийт, төрийн бус байгууллагаар дамжуулан хүргэдэг байсан ажил үйлчилгээг төрөөс хариуцах боллоо. ЗХТ нь 15-34 насны бүх залуучуудад залуучуудын хөгжлийн үйлчилгээг хүргэх үүрэгтэй. Монгол Улсын 2018 оны статистикийн мэдээгээр 14-35 насны нийт 1.054 сая хүн ам, хүйсийн харьцаа нь ойролцоогоор 50:50 гэсэн харьцаатай байна. Байршлаар авч үзвэл аймагт 15-40 мянга, суманд 1-3 мянга, нийслэлд 435 мянга, төвийн дүүрэгт 70-80 мянга залуу хүн ам амьдарч байна. Өнгөрсөн хугацаанд ЗХТ-өөр хагас жилд 60 орчим мянга, жилдээ 100 гаруй мянган залуучууд үйлчлүүлж байна.

Залуучуудын хөгжлийн тухай хуулинд тусгаснаар ЗХТ-өөр дамжуулан 1/амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт явуулах, 2/залуучуудын оролцоог хангах, мэдээллээр хангах, 3/залуучуудын хүсэл сонирхолд нийцсэн клуб зөвлөлийг ажиллуулах, бүлгийн үйл ажиллагааг дэмжих, 4/хууль зүйн туслалцаа болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд холбон зуучлах, 5/ гэр бүлийн боловсрол олгох, тулгамдсан бэрхшээлээ хамтран даван туулахад сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт, ярилцлага зохион байгуулах, 6/зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ мэдээллээр хангах, ажилд зуучлах, 7/залуучуудын гарааны компани эрхлэхийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай хамтран ажиллах зэрэг долоон чиг үүргийн хүрээнд төрийн үйлчилгээг залууст хүргэхээр заасан. Хуулийг хэрэгжүүлж эхэлсэн эхний жилд залуучууд, олон нийтэд үйл ажиллагааны талаар таниулах, мэдээлэх үйл ажиллагааг голчлон явуулжээ. Харин өнгөрсөн 2019 онд нийгмийн тодорхой бүлгийн гишүүдийг амьдрах ухааны сургалтанд хамруулах, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд холбон зуучлах болон өдөрлөг аяныг зохион байгуулахад анхаарсан байна. Нэг талаас ЗХТ-ийн үйл ажиллагаа тогтвортой биш, хөрөнгө санхүүгийн хувьд бэхжээгүй, ажиллаж буй мэргэжилтнүүдийн цалин хангамж тааруу, төрөөс үзүүлж буй зарим үйлчилгээ давхардалтай, институт хоорондын уялдаагүй байдал үйлчилгээний чанарт таагүй нөлөө үзүүлж байгаа бол, нөгөө талаас төвийн байршил, үйлчлүүлэгчийн тоо зэрэг хүчин зүйлс үйлчилгээг хүртээмжтэй хүргэхэд сөргөөр нөлөөлж байна. Тэрчлэн төрийн байгууллага, институцийн үйл ажиллагаа, удирдлагын идэвхи, онцлогоос хамаарч дүүрэг, орон нутагт ЗХТ-ийн үйл ажиллагаа харилцан адилгүй, хуулийн хэрэгжилт хангалттай биш байгаа юм. ЗХТ-өөс үзүүлж буй үйлчилгээний нэр төрөл хэт олон, тодорхой биш, төрийн бусад үйлчилгээтэй давхцах явдал хааяагүй тохиолдож байна.

Иймд залуучуудыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд аймаг, дүүрэгт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгээс харахад үйлчилгээний нэр төрөл, чиглэл, арга зүй, аргачлалыг боловсронгуй болгох, төрийн үйлчилгээг залуучуудад давхардалгүй, чанартай, хүртээмжтэй үзүүлэх эрх зүйн орчинг хангах, институт хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Ингэснээр хүн амын олонх болсон өсвөр үе, залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас, сэтгэхүй, баяе бялдар, түүх соёлын хөгжил оролцоог дэмжихэд чиглэсэн хууль хэрэгжих үндэс суурь тавигдаж, нэг ёсондоо залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр биелэх нөхцөл бүрдэх юм.

Схем зураг 3.1 Залуучуудын бодлого, хууль эрх зүйн тогтолцоо



4.2 Залуучуудын ерөнхий мэдээлэл ба үйлчилгээ

Монгол Улсын хэмжээнд 2018 оны байдлаар 15-34 насны 1.072.071 хүн амьдарч байгаа нь нийт хүн амын 33.7%-ийг эзэлж байсан бол 2019 онд 32.8%, 2020 оны байдлаар 31.7%-тай болсон байна. Нийт залуу хүн амыг 5 жилийн интервалаар бүлэглэн, насны онцлогийг болзолт байдлаар ангилж үзэхэд³ 15-19 насны 233 мянга, 20-24 насны 244.9 мянга, 25-29 насны 310.7 мянга, 30-34 насны 283.4 мянган залуучууд тус тус байна.

Хүснэгт 3.1 Залуучуудын тоон мэдээлэл/2018, 2019 он/

| | Насны бүлэг | Нэр | 2018 оны дүн | | 2019 оны дүн | |
|------|-------------|--------------|--------------|------------|--------------|------------|
| | | | Нийт тоо | Эзлэх хувь | Нийт тоо | Эзлэх хувь |
| 1 | 15-19 | Өсвөр залуус | 233001 | 21.7% | 223078 | 21.4% |
| 2 | 20-24 | Орь залуус | 244980 | 22.9% | 239604 | 22.9% |
| 3 | 25-29 | Идэр залуус | 310730 | 29.0% | 277392 | 26.5% |
| 4 | 30-36 | Төгс залуус | 283360 | 26.4% | 304728 | 29.2% |
| Нийт | | | 1072071 | 100.0% | 1044802 | 100.0% |

Тухайн чиглэлээр хийсэн зөвлөх үйлчилгээний тайлангаас үзэхэд⁴ Монгол Улсын Засгийн Газрын 2016 - 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт залуучуудын хөгжлийн талаар залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг баталж, хэрэгжилтийг хангах, Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх, залуу гэр бүлийг орон сууцжуулах, орон сууцны түрээсээ урьдчилгаанд тооцуулах журам батлах, “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг үргэлжүүлэн хэрэгжүүлэх зэрэг олон тооны арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Харин зорилтот бүлгийн залуучуудыг авч үзэхэд 15-34 насны Хөгжлийн бэрхшээлтэй хүн 19387 байгаагаас аймаг, орон нутагт 14030, дүүргийн хэмжээнд авч үзэхэд 5357 хүн байна. Хорихоос суллагдсан 330 залуучууд байгаа бөгөөд аймагт 206, дүүрэгт 124 хүн байна.

Аймаг, дүүргийн ЗХТ-өөс ирүүлсэн тоон мэдээлэлд тулгуурлан авч үзэхэд Асрамж халамжийн төвд 2018 оны байдлаар 15-18 хүртэлх насны 188, 18-24 насны 54 залуучууд тус тус байгаа гэж мэдээлсэн.

³ www.1212.mn

⁴ Б.Батхүү. Залуучуудын хөгжлийн үйлчилгээний жишиг зардлын тооцоолол. Нэгдсэн тайлан. УБ, 2018

Монголын залуучуудын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлсон судалгаа, баримт бичгийн үр дүн, нотолгоонд тулгуурлан дараах нийтлэг дүгнэлтийг хийж болохоор байгаа юм. Аль ч улс орны хувьд хөгжил дэвшил, бүтээн байгуулалтыг бий болгогч нийгмийн хүчирхэг бүлэг бол залуучууд байдаг. Чухамдаа энэ бүлгийн нийгэм, улс төр, эдийн засаг, оюун санаа, соёлын амьдралд оролцож буй түвшин, тэдгээрийн хөгжилд оруулж буй хувь нэмрээс улс орны хувь заяа хамаарах учиртай. Судлаачдын тэмдэглэснээр Монгол Улс бол залуучуудын орон хэмээн нэрлэгдэж ирсэн нь дан ганц хүн ам зүйн утга бус, өмнөх тогтолцооны үед ч, өөрчлөлт шинэчлэлтийн үйл явцад ч, өнөөдрийн энэ өдрүүдэд ч улс орны хөгжлийн түүчээ нь залуучууд байж ирсэн, байсаар байгаатай холбоотой.

Монгол Улс социалист системийн бусад орнуудын нэгэн адил улс төрийн нэг намын тогтолцоо, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг, нийтийн өмчийн ноёрхолд байж ирсэн тэртээх он жилүүдэд залуучуудын бодлого, тогтолцоо энэ системийн мөн чанар, зорилготой яв цав нийцсэн байдлаар бүрэлдсэн байв. Залуучууд коммунист үзэл суртлаар хүмүүжиж, социалист нийгэм дэх ажилчин, малчин, сэхээтэн ангийн залгамж халаа, үйлдвэрлэх хүчний нөөцийн түүчээ, гол сэлбэх хүчин болж байжээ⁵.

Монгол Улс хэдийгээр дэлхийн хөгжсөн ертөнцийн нэг хүнд ноогдох ДНБ-ий утгаар хөгжиж буй улс байсан ч гэсэн, тухайн үеийн бүх нийтийн хөдөлмөр эрхлэлт болон эрүүл мэнд, боловсролын тогтолцоо, нийгэм хангамжийн систем нь хойч үеийнхний хувьд үгүйсгэж үл болох ололтууд байсан бөгөөд нийгэм эдийн засгийн ийм харьцангуй тэгш нөхцөлд залуучууд атар газрыг эзэмшиж, илгээлтийн эзэд болж, хот байгуулж, чухамхүү хөгжил цэцэглэлт, бүтээн байгуулалтын жинхэнэ эзэд болж байсан юм.

Ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн эхний он жилүүдэд үйлдвэрлэл уналтад орж, ажилгүйдэл, ядууралд нэрвэгдэн, хүн амын амьдралын чанар үлэмж доошилж, залуучууд нийгмийн бусад бүлгүүдийн нэгэн адил нийгэм болон эдийн засгийн хувьд хүндхэн сорилтуудтай тулгарсан юм. Шилжилтийн хүндрэл бэрхшээл, сорилт дүүрэн энэ он жилүүдэд төрөөс залуучуудын бодлогын орчныг бий болгож, түүнд хамаарах бодлогын баримт бичгүүд болон хөтөлбөрүүдийг батлан гаргаж, хэрэгжүүлж ирсэн байна. Шилжилтийн зааг үе болох 1991 онд “Төрөөс хүүхэд залуучуудын талаар баримтлах бодлого”-ыг батлан гаргасан бол шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш анх удаа 1998 онд МУЗГ-аас “Монголын залуучуудын үндэсний

⁵ Х.Гүндсамбуу. Малчин залуучуудын нийгмийн дүр төрх, УБ 1984, Х.Гүндсамбуу, Ш.Дашдаваа. Ажилчин залуучуудын нийгмийн дүр төрх, УБ 1990.

хөтөлбөр” буюу зургаан жилийн хугацаанд хэрэгжих бодлогын баримт бичгийг боловсруулан баталжээ. Эдгээр нь⁶ нэг талаас залуучуудын бодлогын залгамж чанарыг хадгалах, нөгөө талаас шилжилтийн хүндрэлийн үед залуучуудын амьдралд дэмжлэг үзүүлэх үүргээ тодорхой хэмжээнд гүйцэтгэж ирсэн байна.

XXI зуун гарснаас хойш тухайлбал, 2004 оны үеэс Монгол Улсын эдийн засагт мэдэгдэхүйц өсөлт ажиглагдсан бөгөөд энэ нь байгалийн баялгийн олборлолт, дэлхийн зах зээлийн үнийн өсөлт, ХАА-н хөгжилд гол төлөв тулгуурласан юм. Энэ үеэс Монгол Улсын төр, засгийн газараас хэрэгжүүлэх бодлогын орчин өөрчлөгдөж, улс төрийн намуудаас хүн амын бүлгүүдэд баримжаалсан нийгмийн бодлогыг түлхүү баримтлах болсон юм. Энэ үед УИХ-аас 2004 онд “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг батлан гаргаж, үүндээ залуучуудын хөгжил, боловсрол, орон сууц, эрүүл мэнд, соёл, оролцооны хүрээнд зорилтуудыг тодорхойлжээ. Мөн МУЗГ-аас 2006 онд “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг батлан гаргасан ба үүндээ залуучуудын үүрэг хариуцлагыг болон улс орны хөгжилд оруулах хувь нэмрийг дээшлүүлэх, нийгмийн амьдралд оролцох оролцоог нь дэмжих зорилтуудыг дэвшүүлсэн байна. 2008 оны УИХ-ын сонгуулийн дараа байгуулагдсан Эвслийн ЗГ-аас дэлхийн хэмжээний уул уурхайн гэрээ хэлцэлийг хийж, төслүүдийг эхлүүлсэн ба улмаар Монголын эдийн засаг дэлхийн хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн билээ. 2004 оны сонгуулиас хойших бүхий л сонгуулийн хугацаанд улс төрийн намууд залуучууд болон залуу гэр бүлд чиглэсэн нийгмийн хамгааллын бодлогоор өрсөлдөж, төрөөс мөнгөн тэтгэмж, шилжүүлгийн нэр бүхий арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирсэн юм.

НҮБ-ын Хүн амын сан, Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлсэн “Залуучуудын хөгжил 2013-2017” төслийн хүрээнд 11 аймаг, 3 дүүрэг, 2 суманд нийт 16 Залуучуудын хөгжлийн төвийг байгуулсан бол Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль хэрэгжиж эхэлснээр 10 аймаг, 6 дүүрэгт нийт 16 залуучуудын хөгжлийн төвийг шинээр байгуулж, улсын хэмжээнд нийт 32 залуучуудын хөгжлийн төв үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны 4 дүгээр тогтоолын 1-р хавсралтаар “Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрэм”, 2-р хавсралтаар “Орон нутгийн салбар зөвлөлийн дүрэм”-ийг тус тус

⁶ Төрөөс хүүхэд, залуучуудын талаар баримтлах чиглэл. 1.1.2015. <http://www.legalinfo.mn/law/>, Монголын залуучуудын үндэсний хөтөлбөр. 1.1.2015. <http://www.legalinfo.mn/law/>

баталснаар хууль эрх зүйн орчин төгөлдөржиж, бүтэц тогтолцоо бий болох эхлэл тавигдсан юм.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 22.3-д заасны дагуу Ерөнхий сайдын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны 04 тоот захирамжаар Ерөнхий сайдаар ахлуулсан 29 хүний бүрэлдэхүүнтэй Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийг байгуулжээ.

Тус хуулийн 22.1-д заасны дагуу залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг тухайн орон нутгийн Засаг дарга тэргүүлэх үүрэгтэй. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг байгуулан ажиллахыг 21 аймаг, 9 дүүргийн Засаг дарга нарт, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 01-ний 01/70 дугаартай албан тоотоор хүргүүлэн өнөөдрийн байдлаар 205 орон нутгийн салбар зөвлөлийг байгуулаад байгаа юм.

Гэсэн хэдий ч хөгжиж буй бусад орны залуучуудын нэгэн адил Монгол Улсын залуучуудад зохистой эрүүл мэнд, боловсрол, санхүүгийн үйлчилгээ хүртэх, хөдөлмөр эрхлэх боломжоор хангагдах, нийгмийн амьдралд оролцох бололцоог тэгш олгох зэрэг тулгамдсан асуудлууд оршсоор байна. Залуучуудын өмнө өнөөдөр тулгамдаж буй асуудлууд нь эргээд үндэсний түвшинд залуучуудын хууль, төрөөс үзүүлж буй үйлчилгээний хууль эрх зүйн орчин, бодлогоо эргэн харах шаардлагатай гэдгийг харуулж буй хэрэг. Өөрөөр хэлбэл бодлогын үр нөлөө сайтай сайн туршлага, өвүүдийг үргэлжлүүлэн хөгжүүлж, ач тусаа өгөөгүй саар нэгийг нь халж өөрчлөх ёстой. Мөн олон улсын түвшин дэх залуучуудын бодлогын дэмшилтэт хувилбаруудаас суралцахын дээр үндэсний сэтгэхүй, онцлогоо тусган хөгжүүлэх хэрэгтэй гэсэн утгатай юм. Өнөөдрийг хүртэлх залуучуудын бодлогод гарсан гол гол сургамжууд юу вэ?, бид залуучуудын төлөөх үндэсний тогтолцоогоо бүрдүүлж чадсан уу?, **шинэ үеийн залуучуудын хөгжлийн шаардлага, шинэ үеийн хэрэгцээнд нийцсэн бодлогын загвар** ямар байх ёстой вэ? зэрэг олон зүйлийг эргэцүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Өнгөрсөн хугацаанд Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан давхардсан тоогоор 210 орчим мянган залуучуудад хүснэгт 3.2-д дурдсан 9 төрлийн зөвлөгөө, зуучлал, нөлөөллийн үйлчилгээг хүргэсэн нь 2016 оны үйлчилгээ арга хэмжээнээс хоёр дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 3.2 Залуучуудад үзүүлсэн үйлчилгээ/2018 оны жилийн эцсийн мэдээ/

| | Үйлчилгээ | Хамрагдсан залуусын тоо |
|---|---|-------------------------|
| 1 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Бүлгийн зөвлөгөөнд | 2181 |
| 2 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Ганцаарчилсан зөвлөгөөнд | 116 |
| 3 | Тулгамдсан асуудлаар холбон зуучилсан | 4485 |
| 4 | Нийт 112 дэмжих бүлэгтэй ажилласан | 1687 |
| 5 | 231 сонирхлын клубт дэмжлэг үзүүлсэн | 10057 |
| 6 | Амьдрах ухааны чадвар олгох 12 модуль сургалт | 42519 |
| 7 | Нөлөөллийн үйл ажиллагаа | 12536 |
| 8 | Залуучуудын эрх ашгийг хөндсөн нөлөөллийн арга хэмжээ, гэр бүлийн үнэ цэнийг ойлгуулах нөлөөллийн үйл ажиллагаа | 101722 |
| 9 | Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг сурталчлах | 32526 |
| | Нийт | 207829 |

ЗХТ-өөр дамжуулан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр холбон зуучлах үйлчилгээнд 4500 орчим залуусыг хамруулсан ба үүнээс түр ажлын байранд 2684, байнгын ажлын байранд 843, сургалтад 919, хөнгөлттэй зээлд 6, төсөл хөтөлбөрт 25 залуучуудыг тус тус хамруулсан байна. Дээрх бүртгэл мэдээлэлд тулгуурлан авч үзэхэд залуучуудад зөвлөгөө, дэмжлэг, сургалт, нөлөөлөл үзүүлэх чиг үүрэгтэй” **ЗХТ-ийн үйлчилгээний хэрэгцээ**” нэгэнт бий болсон нь харагдаж байна. Хуулинд үндсэн долоон төрлийн үйлчилгээг үзүүлэх чиг үүргийг тусгасан бөгөөд дурдсан үйлчилгээнээс чухам алиныг нь залуучуудын ямар бүлэгт, хэрхэн хүргэх вэ? гэдэг асуудал энд яригдах болно. Залуучуудын онцлог, үйлчилгээний нөхцөл байдлыг тодорхойлох ярилцлагын үр дүнгээс үзэхэд ЗХТ-өөс чиг үүргийн дагуу үзүүлж буй үйлчилгээний хувьд Амьдрах ухааны болон ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг өсвөр үеийнхэн болон амьдралд хөл тавьж буй орь залууст, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилд холбон зуучлах үйлчилгээг 25-34 насны идэр болон төгс залуучуудад үзүүлэх нь илүү үр дүнтэй байна.

3.3 Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд үзүүлсэн үйлчилгээг шинжлэх нь

Залуучуудын асуудал эрхэлсэн анхны төрийн байгууллага/ГБХЗХГ/ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяанд байгуулагдсан бөгөөд залуучуудын хөгжилтэй холбоотой засгийн газрын тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлж, үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй бөгөөд залуучуудын талаар эрх зүй, бодлогын орчинг сайжруулж, залуучуудын хөгжлийг дэмжих сан байгуулж, салбар хоорондын зохицуулалтыг хангах үүрэг хүлээж байна. Энэхүү чиг үүрэг болон хуулийн хэрэгжилтийн хүрээнд Залуучуудын хөгжлийн төв дангаараа болон бусад төрийн байгууллагатай хамтарсан байдлаар дараах долоон төрлийн үйлчилгээг үзүүлэхээр холбогдох хуулинд тусгасан.

Хүснэгт 3.3 ЗХТ-ийн чиг үүрэг

| | | |
|---|--|--|
| 1 | Амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх | 20.5.1.залуучуудад амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт явуулах; |
| 2 | Залуучуудын оролцоог хангах | 20.5.2.залуучуудын эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд бүх түвшинд оролцож, саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллээр хангах; |
| 3 | Залуусын хүсэл сонирхолд нийцсэн клуб, зөвлөл, дэмжих бүлэг ажиллуулах | 20.5.3.залуучуудын хүсэл, сонирхол, эрэлт, хэрэгцээнд тулгуурласан сонирхлын клуб, зөвлөл, бүлгийн үйл ажиллагааг дэмжих; |
| 4 | Эрүүл мэндийн болон хууль зүйн тусламж үйлчилгээнд холбон зуучлах | 20.5.4.залуучуудыг хууль зүйн тусалцаа болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд холбон зуучлах; |
| 5 | Сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулах | 20.5.5.залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, залуу гэр бүл тулгамдсан бэрхшээлээ хамтран даван туулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүлгийн уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулах санал, санаачилгыг дэмжих; |
| 6 | Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээллээр хангах | 20.5.6.зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, мэдээллээр хангаж, ажилд зуучлах; |
| 7 | Гарааны бизнес эрхлэх, залуучуудад дэмжлэг үзүүлэх, холбон зуучлах | 20.5.7.залуучуудын гарааны компани эрхлэхийг дэмжих чиглэлээр орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай хамтран ажиллах. |

Эх сурвалж: Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль. 20.5.1-20.5.7

Хэдийгээр хуулинд дээрх долоон төрлийн чиг үүргийг гүйцэтгэхээр тусгасан боловч баримт бичгийн судалгаа болон ганцаарчилсан ярилцлагын үр дүнд тулгуурлан авч үзэхэд 21 аймаг, 8 дүүргийн 32 Залуучуудын хөгжлийн төв 15-34 хүртэлх насны залуучуудад дараах үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

ЗХТ-өөс үзүүлж буй үйлчилгээнүүд

- Амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх сургалт/12 модуль/
- Ажил мэргэжлийн зөвлөгөө
- Холбон зуучлах үйлчилгээ
- Сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах, лавлагаа гаргах
- Зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах
- Номын сангийн үйлчилгээ
- Залуучуудын хөдөлмөрлөх, ур чадварыг үнэлэх, хувийн төлөвлөгөө боловсруулах дэмжих
- Ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх
- Хөгжлийг дэмжих үйлчилгээ
- Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр үе залуучуудад амьдрах ухааны сургалт, урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах
- Сэтгэлзүйн дэмжлэг, зөвлөгөө үзүүлэх
- Уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах
- Кейс багт ажиллах
- Нөхцөл байдлын үнэлгээ хийх
- Зорилтот бүлгийн судалгаа хийх
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгаа хийх

- Залуу гэр бүлийн асуудлыг тодорхойлох

Дээрх үйлчилгээнээс харахад хуулинд тусгагдсан үйлчилгээнээс гадна нөхцөл байдлын үнэлгээ хийх, кейс багт ажиллах, зорилтот бүлгийн судалгаа хийх олон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, залуу гэр бүлийн асуудлыг тодорхойлох зэрэг хуулинд тусгагдаагүй үйлчилгээг давхар эрхлэн хэрэгжүүлж байгааг ЗХТ-ийн мэргэжилтнүүд дурдсан байна.

Тулгамдаж буй асуудал, бэрхшээлүүд

- Хүний нөөц, орон тоо бага
- Төсөв, цалин ихээхэн бага/ТҮ-6-аар цалинждаг/
- Хүмүүст ЗХТ-ийн чиглэлээр ойлголт байхгүй, суманд хариуцсан хүн хэрэгтэй
- Байр, орчны асуудал шийдвэрлэгдээгүй
- Үйлчилгээний давхцал байна
- Ажлын давхцал гардаг.
- Эрх мэдэл сул
- Бүтэц, зохион байгуулалт тааруу
- Байгууллага хоорондын хамтран ажиллах, хамтын ажиллагаа тааруу
- Үйлчилгээний орчин нөхцөл хангагдаагүй
- Тоон мэдээлэл зөрүүтэй, яг таг гаргахад хэцүү. Цэргийн насны залуучуудын тоог гаргах боломжгүй/нууц гээд өгдөггүй/
- Өргөн цар хүрээтэй маш олон сургалт явуулдаг, үр дүн нь мэдэгддэггүй
- Гэрээт ажилтан хэлбэрээр явах нь ЗХТ-ийн мэргэжилтэн болон цаашидын үйл ажиллагаанд ач холбогдолгүй
- Стартап-инкубатор төвийг ажиллуулах хэрэгцээ бий боловч мэдлэг, ур чадвар хангалтгүй
- Хорихоос суллагдсан хүмүүс/эрсдэл гаргасан тохиолдолд асуудлыг хэн хариуцах вэ?/
- Шатахуун, томилолт гм төсвийн асуудлууд байнга тулгамддаг
- Төрийн үйлчилгээ үзүүлж буй 6,7 байгууллага санамж бичиг байгуулсан. Хөдөлмөр халамж ойлгоцгохгүй байна. Архинд хамааралтай, архинаас гаргах чин сэтгэлтэй хүмүүст тусламж, дэмжлэг үзүүлэх шаардлагатай боловч мэдлэг чадвар дутагдаж байна.
- Ажил үүрэг нь Төрийн үйлчилгээ байх уу, төрийн захиргаа байх уу? гэдэг асуудал байна. Хэрэв ЗХТ гэсэн нэртэй байвал Төрийн захиргаа байх боломжгүй
- Орон тооны эсвэл гэрээт байх уу? гэдэг асуудал тулгамдсан хэвээр байна.
- Төсөв хөрөнгө байхгүй учраас/сайн дурын даатгалд хэдэн залуус хамрагдаж байна, ажил эрхэлж буй залуусын тоо бүртгэл зэргийг гаргах боломжгүй/, эрх мэдэл байхгүй байна.

Аймаг, дүүргийн ГБХЗХГ-ын дарга, ЗХТ-ийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас үзэхэд Залуучуудын хөгжлийн ордон, хөдөлмөр эрхлэлт, стартап, АМЧБО, эрүүл мэндийн нөхөн үржихүйн сургалт, боловсрол, шинжлэх ухаан, сайн дурын үйл ажиллагаа, сонирхлын клуб, хувь хүний хөгжил амьдрах ухааны ажлуудаа дагнаж хийдэг жишиг төвүүд байхад төрийн нэг байгууллагын хажууд дайвар маягтай оршиж, зөвхөн сургалт, нөлөөллийн ажил болон бусад хуулинд тусгагдаагүй ажлыг хийдэг мэргэжилтэн, төвүүд ч байна.

Залуучуудын хөгжлийн төвд ажиллаж буй аймаг, дүүргийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын үеэр мэргэжилтнүүд ЗХТ-ийн ажил үйлчилгээнд дараах бэрхшээл, сорилтууд тулгамдаж буйг дурдаж байсан юм.

Завхан аймаг. Залуучуудыг хөгжүүлэх чиг үүрэгтэй боловч гэр бүл, хүүхдийн үйлчилгээ рүү илүү чиглэдэг. Манайд орон тоо байхгүй учраас өөр ажил руу орохоос өөр арга байхгүй. Ийм нэг дутагдалтай тал бий. Мөн салбар дундын уялдаа асуудалтай. Манайх халамж дээр очоод ажил хайж буй залуучуудын мэдээллийг авч сургалт өгөх, холбон зуучлах гэхлээр өгдөггүй. Нууцлалтай, өгөх боломжгүй гэдэг. Хамтарч ажиллах талаар хуулиндаа байгаад байдаг. Мэдээлэл өгдөггүй. Халамж дээр мөн л 12 модуль сургалтыг, мөн CV, ажлын ярилцлагад хэрхэн бэлдэх талаар сургалтыг заагаад явж байна. Ийм давхцуудыг шийдвэрлэх ёстой байх. Хүний нөөцийн асуудал. Тухайн ажлыг хийж чадавхижиж байгаад л гараад явчихдаг. Цалин мөнгөний хэмжээнээс их хамаардаг, тогтоод ажиллах хэмжээний цалин өгдөггүйтэй энэ нь холбоотой. Халамж дээр 12 модуль сургалтыг явуулдаг. ХХҮЕГ-ын үйлчилгээний хувьд үйлчилгээ сул байдаг тул бид тухайн үйлчилгээг хандах хүрээний хувьд нэмэгдүүлж явуулдаг. Холбон зуучлах үйлчилгээг голлон хүргэж байна. Амьдрах ухааны сургалтыг мөн залуучуудад хүргэж байна. Ихэвчлэн өсвөр насны хүүхэд залууст амьдрах ухааны сургалтыг үзүүлж байна. Хамрах хүрээний хувьд явцуу. ЗХТ-ийн хувьд залуучуудын хөгжлийн сургалтын зөвхөн 12 модуль сургалтаар хязгаарлах ёсгүй, өөр сургалтууд нэмж явуулах ёстой гэж боддог. CV танилцуулга, ажлын ярилцлагад хэрхэн бэлтгэх вэ, тэтгэлэгт хөтөлбөрт хэрхэн хамрагдах вэ? зэрэг подкаст маягийн зүйлсийг их хийж байна. Сургалтыг системтэйгээр явуулах шаардлагатай байна.

Өвөрхангай аймаг. Залуучуудын хөгжлийг дэмжих бодлого, хөтөлбөрийн хүрээнд үндсэн 7 чиг үүргийг гүйцэтгэж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд холбон зуучилж байна. Шийдвэр гаргах үйл ажиллагаанд залуучуудыг оролцуулах шаардлагатай. Ийм үед төсвийн асуудал ихээхэн тулгамддаг. Төрийн бус байгууллагаар төсвөө гаргуулж шийдвэрлэж явж байна.

Булган аймаг. Гарааны бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад ХХҮЕГ-аас та нар манай ажлыг булаах гээд байгаа юм уу гэдэг. Салбар дундын уялдаа холбоо байхгүй. Үйл ажиллагаанд оролцуулдаггүй. Хуулинд тусгасан боловч төсөв байхгүй.

Орхон аймаг. Хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийн үйлчилгээ бол ЗХТ-өөс үзүүлэх ёстой үйлчилгээний нэг . Өнгөрсөн онд гэхэд 200 гаруй залуус гарааны бизнесийн төсөлд хамрагдсан. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалт, гарааны бизнесийг дэмжих сургалт явуулах нь илүү үр дүнтэй байсан.

Хэнтий аймаг. Үйлчилгээний давхцал гэвэл олон улсын байгууллагатай зарим талаар давхцдаг. Төрөөс гэр олгох, байшин төсөл дээр хөгжлийн бэрхшээлтэй, ядуу гэр бүлийг оруулдаг. Залуу гэр бүлийг ерөөсөө оруулдаггүй. Шалгаруулалтад хэдийгээр бидэнтэй хамтран ажилладаг боловч зөвхөн өөрсдөө шийддэг.

Дархан-Уул аймаг. Хэдийгээр хуулинд тусгасан долоон төрлийн үйлчилгээг үзүүлж байгаа боловч ГБХЗХГ-ын харьяа ЗХТ гэдэг утгаараа бүх аймаг дүүрэгт бичигдээгүй гурван төрлийн үйлчилгээ нэмэгдэж орж ирдэг. Зорилтот бүлгийн судалгаанд ЗХТ-ийн мэргэжилтнүүд явдаг. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн судалгаанд мөн явдаг. Залуу гэр бүлийн асуудал дээр бас л явна. 15-18 насны албадан хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн кейс дээр та нар явна гэдэг. Бүх асуудал дээр явуулах гэдэг. Ажлын гүйцэтгэл дээр ийм ажил хий гээгүй учраас тайлангийн үзүүлэлт дээр орж ирдэггүй. Мөн ажлын цагийн хувьд анхаарах зүйл бий. Залуучууд яг 8.30-аас ажил эхлэхэд үйлчилгээ авдаггүй. 12-оос эхлээд оройн 8.00 цаг хүртэл ирдэг. Тэгэхлээр яг ажлын цагаар үйлчилгээ авна гэсэн ойлголт байхгүй. Бид нар илүү цагаар ажиллаж байна.

Өмнөговь аймаг. Тайлан мэдээ гаргах гэсэн чинь мэдээллээ энд тэндээс авах шаардлагатай тулгарсан. Залуу гэр бүлийн, залууудын нарийвчилсан тоог хаанаас авах ёстой юм. Бид нар өөрсдөө гаргах ёстой юм уу?. Цэргийн насны залуучуудын тоог гарга гэдэг. Гэтэл энэ нь нууц тоо гээд холбогдох газар нь өгдөггүй. Төрийн үйлчилгээний салбар дундын давхцал хаа сайгүй байна. Үйлчилгээн дээр гэхэд бүгд л давхцаж байгаа.

Баян-Өлгий. Орон байрны асуудал байгаа. Манай газар түрээсийн байранд байдаг. Залуучуудад ээлтэй үйлчилгээ үзүүлэх орчин байхгүй. ЗХТ-ийн ажилтнууд дүйцүүлэхийн ТҮ-6 шатлалаар цалинждаг. Ялангуяа COVID-ийн үед бусад ажилтнуудыг орлож ажиллах үед гэрээт ажилтнууд нэмэлтээр болон хавсарч хийж байгаа ч ажлын цалин, урамшууллын нэмэгдэл гэж байдаггүй.

Сүхбаатар аймаг. Салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа ихээхэн тааруу. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл авах гэхлээр асуудалтай. Бусад асуудлууд давхцаж байна.

Дорноговь аймаг. ЗХТ-д ажиллаад гурван жил болж байна. ГБХЗХГ гээд нэршил болон үйлчилгээ маань шинэ байна. ЗХТ-ийн хувьд ч гэсэн төрийн үйлчилгээний бүтэц рүү орж ирж байгаа учраас мөн шинэ байна. Тэгэхлээр бид нар шинэ тутам байгаа үйлчилгээг хүн брт өөрсдөө очиж хүрч байж таниулах шаардлагатай юм. ХХҮЕГ,

Нийгмийн даатгал зэрэг газрын хувьд хүмүүс өөрсдөө шууд ирж үйлчилгээ авдаг. Тэгэхлээр ЗХТ-ийн үйлчилгээ яг ийм байх ёстой. Төсөв санхүүгийн хувьд гэхэд ихээхэн асуудалтай. Малчин залуучуудын төлөөлөл болгож 300 залуучуудыг цуглуулж уулзалт зохион байгуулахад 28 сая төгрөгийн зардал гарсан. Гэтэл манайд төсөвлөсөн мөнгө 8 сая төгрөг байх жишээтэй. Өсвөр үеийнхэнд 4 сая, 19-34 насныханд 4 сая төгрөг тус тус хуваарилж ажиллаж байна. Үндэсний хөтөлбөрт тусгасны дагуу нийт хүн амын 50 орчим хувьд нь хүрч ажилласан байх шаардлагатай.

Налайх дүүрэг. Залуучуудын хөгжлийн төв ямар нэгэн эрх мэдэлгүй байгаа нь санаа зовоож байна. Ямар нэгэн төлөвлөгөө хамтран гаргасан боловч орхичихдог. Бид нар хойноос нь ихэвчлэн хөөцөлддөг. Эрх мэдэлтэй байхын тулд төсвийн асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай. Олон нийтийн ажлыг хийхэд ЗХТ-ийн гуравхан хүн хүрэлцдэггүй. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн асуудал бас бий. Эрүүл мэндээр тэнцэх хүн ховор.

Чингэлтэй дүүрэг. Үйлчилгээг явуулахад санхүүгийн асуудал ихээхэн тулгамддаг. Одоогийн үйлчилгээний хувьд сургалт явуулна, боломжтой бол холбон зуучилна. Эрүүл мэндийн байгууллагаас гэхэд ногоон картаараа эрүүл мэндийн үйлчилгээг дараалалгүй авчихдаг. Ажилд орох шаардлагатай байгаа ХБ-тэй хүний хувьд тусламж үйлчилгээ үзүүлэхэд хүндрэлтэй байна. Нөхцөл байдлын үнэлгээ хийхээс цааш хэтрэхгүй байгаа. Боломж нь тийм. Уг нь тэргэнцэр, ажилд нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлэх хэрэгтэй.

Дээр дурдсан кейс ярилцлагаас үзэхэд аймаг, дүүрэг бүрт тулгамдаж буй асуудал орон нутгийн онцлогоос үл хамаарч бүтэц тогтолцоо, төсөв мөнгө, албан тушаалын зэрэглэл, цалингийн хэмжээ, нийгмийн баталгаа, чиг үүрэгт тусгаагүй бусад ажлуудыг хийх зэрэг асуудал нийтлэг тулгамдаж байна. Нэг талаар ЗХТ-өөс үзүүлэх үйлчилгээний нэр төрөл хэт олон, нөгөө талаас ЗХТ-өөс үзүүлж буй зарим үйлчилгээ төрөөс үзүүлж буй хөдөлмөр, халамжийн үйлчилгээтэй давхцаж байгаа болно.

4.4 Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээ

ЗХТ-ийн үйлчилгээний зураглал хийхийн тулд үйлчилгээний төрөл, хамрах хүрээ, оролцогч талуудыг судлан тогтоох нь чухал юм. Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээний хамрах хүрээг авч үзэхэд 15-34 насны залуучууд багтах ба үүнд өсвөр


үеийнхэн, оюутан, ажилгүй залуучууд, шинээр гэр бүл болж буй залуус, тусгай хэрэгцээт болон хорихоос суллагдсан залуучууд хамрагдана.

Хүснэгт 3.4 Үйлчилгээний хамрах хүрээ

| Үйлчилгээний төрөл | Хамрах хүрээ | Залуучуудын бүлэг | Оролцогч талууд |
|---|---------------------------------|--|---|
| <p>Хөгжил Оролцоо Холбон зуучлал Зөвлөгөө Сургалт Дэмжлэг Нөлөөлөл</p> | <p>15-34 насны залуу хүмүүс</p> | <ul style="list-style-type: none"> • Өсвөр үеийнхэн • Оюутан • Ажилгүй залуучууд • Өрх толгойлсон залуучууд • Шинээр гэр бүл бологсод • Тусгай хэрэгцээтэй залуучууд • Гэмт хэрэгт өртсөн болон хорихоос суллагдсан залуучууд • Донтох эмгэг, хамааралтай болсон залуучууд | <ul style="list-style-type: none"> • Өсвөр үе, залуучууд • Яамд • Агентлаг • ГБХЗХХ • ЗХТ • Засаг дарга • Төрийн холбогдох бусад байгууллагууд • ИНБ • ОУБ |

ЗХТ-ийн одоогийн үйлчилгээний хүрээг авч үзэхэд ихэвчлэн нэг удаагийн сургалт, зөвлөгөөнд чиглэсэн, тогтвортой биш үйлчилгээний төрлүүд, эсвэл зөвхөн мэргэжлийн биш холбон зуучлах, дамжуулах үйлчилгээ зонхилж байна. Хүснэгт 3.4-т дурдсан хамрах хүрээнд тулгуурлан Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээний зураглалыг дараах байдлаар гаргаж болно (М.Батбаатар, 2019).

Схем зураг 3.1 ЗХТ-ийн үйлчилгээний зураглал



Эх сурвалж: Залуучуудын хөгжлийн төвийн жишиг үйлчилгээний стандарт, 2018

Анх НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан Залуучуудын хөгжлийн 16 төв ГБХЗХГ-ын удирдлагад ажиллахдаа 15-34 насны залуучууд, ялангуяа эмзэг бүлгийн залуучуудад дэмжлэг үзүүлэх, амьдрах ухааны боловсрол, дэмжих бүлэг, сонирхлоор нэгдсэн клубын үйл ажиллагаагаар дамжуулан залуучуудын хөгжлийг дэмжиж, чөлөөт цагаа үр ашигтай өнгөрөөх боломжийг бүрдүүлж, залуучуудын манлайлал, санаачлагыг хэрэгжүүлж, шийдвэр гаргах үйл явцад туслалцаа үзүүлэх үйлчилгээг тус тус хүргэж байжээ.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль батлагдан 2018 оноос мөрдөгдөж эхэлснээр, хуулинд тусгасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд ЗХТ-д үйлчилгээний шинэ арга хэлбэр, шинэ стандарт тавигдаж байна. Иймд ЗХТ-ийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай болгохын тулд насны бүлгээр залуучуудын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох нь зүйтэй юм. ЗХТ-ийн үйлчилгээ ХХҮЕГ-аас үзүүлж буй сургалт, хөдөлмөр зуучлалын үйлчилгээтэй олон талаар, халамжийн үйлчилгээтэй зарим талаар давхцаж байна.

Ихэнх залуучуудын хувьд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсээс чухам ямар үйлчилгээ авах талаар сайн мэдэхгүй байна. Иймд ажил хөдөлмөр эрхлэхэд хүндрэлтэй, идэвхитэй ажил хайж буй залуучуудыг хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс ямар үйлчилгээ авах талаар урьдчилан мэдээлэх, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, чадавхижуулах нь сум, орон нутгийн Залуучуудын хөгжлийн төвийн нэгэн чухал үйлчилгээ байж болохоор байна.

Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлоход баримт бичгийн судалгаа, ярилцлагын мэдээлэлд үндэслэн давуу болон сул тал, боломж ба эрсдэлд дүн шинжилгээ хийсэн юм. Гадаад дотоод орчны хүчин зүйлсийг шинжлэх нь SWOT шинжилгээний үндсэн үүрэг бөгөөд тухайн байгууллага эсвэл сүлжээ цаашдын үйл ажиллагаагаа амжилттай үргэлжлүүлэх нэгэн нөхцөл болдог.



Схем зураг 3.2 SWOT ба TOWS шинжилгээний үндсэн бүтэц, онцлог

Тухайн байгууллагын хувьд өөрийн давуу болон сул тал, боломж, эрсдлээ судлан үзсэний үндсэн дээр сул талаа давуу тал болгох, тулгарч буй эрсдэл аюул заналыг боломж болгон хувиргах/TOWS/ аргачлал мөн бий. Энд ЗХТ-ийн үйлчилгээний нэгэн сул тал болох төсвийн хомсдол ба тулгамдаж буй хэрэгцээнд тулгуурлан товч авч үзье.

Төсвийн хомсдол ба дэмжлэг

ЗХТ-ийн үйлчилгээний жишиг зардлыг боловсруулсан зөвлөх үйлчилгээний тайлангаас үзэхэд Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль батлагдснаар 2018 онд улсын төсвөөс Залуучуудын хөгжлийн хөтөлбөрт 1.2 тэрбум төгрөг хуваарилсан ба үүний 769 сая төгрөгийг ЗХТ-ийг улсын хэмжээнд байгуулах, эдгээрийн урсгал зардалд, 421 сая төгрөгийг залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээнд хуваарилсан байдаг. Хэдийгээр энэхүү төсвийн хуваарилалт үйлчилгээг санхүүжүүлэх чухал шийдвэр боловч агентлагаас батлагдсан төсөвт тулгуурлан улиралд 2 сая, жилдээ 8 сая хүртэлх төгрөг төсөвлөж байгаа нь үйлчилгээ үзүүлэхэд хүрэлцэхгүй байдаг байна.

Кейс. Төсөв санхүүгийн хувьд гэхэд ихээхэн асуудалтай. Малчин залуучуудаас төлөөлөл болгож 300 залуучуудыг цуглуулж, тэдний амьдрал ахуй, тулгамдаж буй асуудлаар уулзалт зохион байгуулахад 28 сая төгрөгийн зардал гарсан. Гэтэл манайд төсөвлөсөн мөнгө 8 сая төгрөг байх жишээтэй. Өсвөр үеийнхэнд 4 сая, 19-34 насныханд 4 сая төгрөг тус тус хуваарилан ажиллаж байна. Шинээр батлагдсан үндэсний хөтөлбөрт тусгасны дагуу нийт хүн амын 50 орчим хувьд нь хүрч ажилласан байх шаардлагатай.

Дорноговь аймаг. ЗХТ-ийн мэргэжилтэнтэй хийсэн бүлгийн ярилцлагаас

Залуучуудын хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрийн тайлангаас үзэхэд⁷ орон нутгийн эрх баригчдын дунд залуучуудын хөгжилд хувь нэмэр оруулж тууштай дэмжих явдал нэмэгдсэн нь санхүүжилт бүхий залуучуудын бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулж баталсны үр нөлөө болохыг дурдсан байна. Тухайлбал, өнгөрсөн хугацаанд Завхан, Өмнөговь, Орхон аймаг, Улаанбаатар хотын зарим дүүрэгт/тухайлбал, Хан-Уул дүүрэгт/ 115 сая төгрөгийн санхүүжилттэй залуучуудын дэд хөтөлбөрүүд батлагдсан байна. Мөн тайланд залуучуудын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг боловсруулж, залуучуудын хөгжлийг цогцоор нь авч үзсэнээр Монгол Улсад анх удаа залуучуудын хөгжлийг дэмжих орчин бүрдүүлэхэд ихээхэн ахиц гарсныг тэмдэглэжээ. ЗХТ-ийн үйлчилгээний төсөв зардал олон улсын төсөл хөтөлбөрөөс(LEAD, BEST гм) санхүүжих боломжтой хэдий ч орон нутгийн ГБХЗХХ-ийн төсвийг харъяалах сайдын багцаас шууд орон нутагт шилжүүлэх шинэ төсвийн зохицуулалтын улмаас багассан, үйлчилгээг үзүүлэхэд төсөв, санхүүгийн хомсдолтой нөхцөлд үйл ажиллагаагаа явуулж байна. Нөхцөл байдалд тулгуурлан дүгнэж үзэхэд, залуучуудын хөгжлийн төвөөс үзүүлж буй өнөөгийн үйлчилгээний нэр төрөл хэт олон, үндсэн биш үйлчилгээ давамгайлсан, бусад төрийн үйлчилгээтэй давхцах явдал хааяагүй тохиолдож байна. Цаашид залуучуудын хөгжлийг дэмжих, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй томоохон төсөл хөтөлбөрүүдтэй уялдаатай ажиллах, санхүүжилт босгох боломжийг судлах, давуу талаа тодорхойлох шаардлагатай.

Мэргэжлийн үйлчилгээ ба дутагдаж буй хэрэгцээ


Өнөөгийн ЗХТ-ийн үйлчилгээний чанар, хүртээмжид дүн шинжилгээ хийж үзэхэд залуучуудад олон тооны үйлчилгээ үзүүлэх гэхээсээ хагас нарийн мэргэжлийн үйлчилгээ дутагдаж байна. ЗХТ-ийн мэргэжилтнүүдээс үзүүлж буй үйлчилгээнд дүн шинжилгээ хийж үзэхэд хагас мэргэжлийн болон үндсэн биш салбарын үйлчилгээнүүд давамгайлж, сэтгэлзүйн болон нийгмийн ажлын хагас мэргэжлийн үйлчилгээ бараг үзүүлээгүй. Энэ нь ЗХТ-д ажиллаж буй боловсон хүчний мэргэжил, үйлчилгээний стандартад тавигдах шаардлагыг эргэн харахад хүрч байна. Тухайлбал, ЗХТ-д ажиллаж буй мэргэжилтнүүд нийгмийн үйлчилгээг хүргэх наад захын мэдлэг чадваргүй, мэргэжлийн биш хүмүүс зонхилж байгаа нь залуучуудад үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжид сөргөөр нөлөөлөх болно.

⁷ НҮБХАС. Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн 2016 оны тайлан

Өнөөгийн Монголын залуучуудын хувьд ажил хөдөлмөр эрхлэхэд ажлын байрны бодитой бус шаардлага, ялгаварлан гадуурхалаас үүдэлтэй зарим нэг бэрхшээлүүд тохиолдож байна. Ер нь аливаа улс орны хөдөлмөрийн зах зээл дээр нийгмийн бүлэг болон хувь хүнийг ялгаварлан гадуурхах явдал тулгарч байдаг. Хөдөлмөрийн зах зээлийн нэг онцлог бол ажил олгогч эрхэлж буй үйл ажиллагаанаас хамаарсан бодит шаардлагын улмаас ажилтан авах, ажлын байрны зар гаргахдаа зарим нэг тодорхой хязгаарлалтууд тавих тохиолдол бий. Жишээ нь, шинэ ажлын байрны зар гаргахдаа насны бүлгийг заасан байдаг. Энэ тохиолдолд ажил хайгч нь ажил олгогчийн зүгээс тавьсан “шаардлагад нийцэх” сул тал бүхий хүмүүс болж хувирдаг. Хөгжингүй орнуудад шашин шүтлэг, үндэс угсаа, арьс өнгө цаашилбал бэлгийн чиг баримжаагаар ялгаварлахгүй байхад анхаарч буй бол, хөгжиж буй орнуудад нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй эсэх зэрэг асуудлууд илүү тулгамдсан шинжтэй байгаа юм. Монгол Улсад гэхэд хөдөлмөрийн зах зээл дээр ажил олгогчийн зүгээс нас, бие бялдар, царай зүс гэх мэт зүйлсээр хязгаарлалт тавих тохиолдол нийтлэг байгаа нь институцийн сул хөгжил, түүний чиг үүргийн тодорхойгүй байдалтай холбоотой. Нөгөө талаас ажил олгогчийн зүгээс хязгаарлалт тавих нь ажил олгогчийн дур зоргын асуудал хараахан биш, “бодит шаардлага” гэдгийн доор чухам юуг хамааруулж ойлгохыг хуулиар зохицуулах ёстой. Иймд залуучуудын хөгжлийн бодлогын тогтолцоонд хөдөлмөр эрхлэлтийн бодлого үндсэн хөтөлбөр байх бөгөөд зорилтот бүлгийн залуучууд болон их сургуулийн оюутнуудад түлхүү чиглэх учиртай. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого нь зөвхөн харьяа яамны асуудал биш, холбогдох яамд, хөдөлмөрийн бирж, ИДС, Төгсөгчдийн холбоо, Ажил олгогчид, Залуучуудын хөгжлийн төвүүд зэрэг олон талын байгууллага, институцийг хамарч хэрэгжих ёстой юм.

4.5 Залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээг хөгжүүлэх нь

Залуучуудад чиглэсэн жишиг үйлчилгээ гэж чухам юуг хэлэх вэ? гэвэл, товчхондоо өсвөр үе, залуучуудад чиглэсэн “ээлтэй” үйлчилгээг ойлгож байна. Нэгэнтээ эрдэмтэн Пифагор залуу насыг 20-40 насны хүрээнд тодорхойлон “амьдралын зун” гэж нэрлэж байснаас үзэхэд залуу нас хүний амьдралын оргил бөгөөд нэн чухал цаг үе юм.



Схем зураг 3.3 Хүн амын насны бүлэг ба нийгмийн үйлчилгээ

Хүн амыг залуу үе(35 хүртэлх), дунд үе(36-59), ахмад үе(60-с дээш) гэсэн насны гурван бүлэгт хуваан авч үзвэл насны онцлог бүрт тохирсон нийгмийн үйлчилгээг үзүүлэх шаардлагатай.

ЗХТ-ийн жишиг үйлчилгээг тодорхойлохын тулд Азийн улс орнуудаас Солонгос Улсын Залуучуудын талаар баримталж буй бодлого, үйл ажиллагаа, хууль эрхийн онцлогийг, Европын холбооны улсуудаас Герман улсын насанд хүрэгчид залуучуудад үйлчилгээ үзүүлж буй ажил мэргэжлийн төвийн тусламж, үйлчилгээний онцлогийг тус тус авч үзлээ.

4.5.1 Гадаадын зарим улс орнуудын туршлага

БНСУ-ын Залуучуудын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх томоохон байгууллага бол Сөүл хотын залуучуудын хөгжлийн бодлогын сүлжээ (Seoul Youth Policy Network) орон нутагт бие даасан байгууллагын бүтцээр дамжуулан үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Залуучуудад хамааралтай бодлогын асуудлыг хэлэлцэх, шийдвэр гаргах байгууллагуудын албан үүргийг хэрэгжүүлэх ялгаатай бүтэц байгаа боловч ерөнхийдөө удирдлага, хурал зөвлөгөөн, үйл ажиллагааг холбох, залуучуудын хөгжлийг дэмжих

бодлогын газар, ажлын байр бий болгох чиг үүрэг бүхий алба, хэлтсээс бүрдэж байна. Чиг үүргийн хувьд голлох байр суурьтай байгууллага бол Залуучуудын бодлогын хороо (Youth Policy Committee) юм. Энэ хороо “Залуучуудын хөгжлийн үндсэн төлөвлөгөө, арга хэмжээ”-г боловсруулахын сацуу түүний хэрэгжилтэд “үнэлгээ хяналт, шалгалт” хийх үүрэгтэй.

Хүснэгт 3.5 БНСУ-д залуучуудын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх бүтэц

| Хот, аймаг | Удирдлагын бүтэц | Захиргааны алба, баг |
|-------------------|---|---|
| Сөүл | Залуучуудын хөгжлийн газар | Залуучуудын хөгжлийн төлөвлөлтийн хэлтэс, хамтын ажиллагааны хэлтэс, залуучуудын хөдөлгөөнийг дэмжих хэлтэс, залуучуудын хөгжлийн орчныг хариуцсан хэлтэс, орчныг засан сайжруулах хэлтэс, залуучуудын хөгжлийн бодлогын хэлтэс гэх мэт |
| Бусан | Ажлын байр, эдийн засгийг өсгөх стратеги | Залуучуудын хөгжлийн бодлогын хэлтэс |
| Гёнги | Залуучуудын халамжийн бодлогын газар | Залуучуудыг хөгжлийн дэмжих хэлтэс ажлын байр, бодлогын хэлтэс |
| Чонбуг | Ажлын байр эдийн засгийн бодлогын газар | Залуучуудын хөгжлийн бодлогын хэлтэс |
| Гуанжу | Залуучуудын бодлогын газар | Залуучуудыг дэмжих хэлтэс, ажлын байрны, халамжийн асуудал хариуцсан хэлтэс |
| Гоян (Goyang) | Ажлын байрны бодлогын газар | Залуучуудын хөгжлийн бодлогын хэлтэс, Халамжийн хэлтэс |
| Соннам (Seongnam) | Нийгмийн халамжийн байгууллага | Залуучуудын халамжийн асуудал хариуцсан хэлтэс |
| Чонгжу (Cheongju) | Санхүү эдийн засаг, ажлын байрны дэмжлэгийн газар | Ажлын байрыг бий болгох хэлтэс |
| Жонжу (Jeonju) | Залуучуудын ажлын байрны бодлогын газар | Эдийн засгийн бодлогын хэлтэс, гарааны бизнес, компани байгуулах ажлын байр бий болгох хэлтэс, залуучуудын хамтын ажиллагааны хэлтэс, зах зээлийн хөгжлийн хэлтэс |

Залуучуудын бодлого тэр дундаа “залуучууд” гэсэн ойлголтыг олон янзаар тайлбарлах ба “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай тусгай хууль”-нд ажил хийхийг хүсэж байгаа 15-29 нас⁸, Ассамблейн хурлаар баталсан “Залуучуудын суурь хууль”-нд

⁸ Ерөнхийлөгчийн зарлигаар 15-29 насны ажил эрхлэхийг хүссэн хүн хэмээн насны хязгаар тогтоосон боловч “Орон нутгийн аж ахуй нэгжийн тухай хууль”, “Төрийн байгууллагуудын удирдлагын тухай хууль”-нд заасны дагуу 15-34 насны хүмүүсийг залуучуудын бүлэгт багтааж байна.

19-39 настай хүмүүсийг тус тус багтааж байна. Дараах хүснэгтэд БНСУ-ын хууль тогтоомжинд заасан залуучуудыг насны бүлгээр ангилсан байдлыг харуулав.

Хүснэгт 3.6 Залуучуудыг насны бүлгээр ангилсан байдал

| Ангилал | Залуучуудын насны ангилал |
|--|---------------------------|
| Залуучуудын хөгжлийн суурь хууль | 19-39 нас |
| Залуучуудын хөдөлмөр эрхлэлийн дэмжих тусгай хууль | 15-29 нас |
| Залуучуудын үйл ажиллагааг дэмжих тухай хууль | 19 хүртэлх |
| Залуучуудын хамгааллын тухай хууль | 19 хүртэлх |
| Төрийн байгууллагын удирдлагын тухай хууль | 15-34 нас |
| Сөүл хотын залуучуудын үндсэн дүрэм | 15-29 нас |

Эх сурвалж: <http://www.law.go.kr/>

БНСУ-ын хувьд залуучуудын хөгжлийн бодлогод тэдний залуу насны бүлэг, онцлогт чиглэсэн улс төр, эдийн засаг, нийгэм, соёл зэрэг нийгмийн салбараас хэрэгжүүлэх бодлогын үйл ажиллагаа хэмээн үзэж суурь хууль, дүрмээ боловсруулсан байна. Тухайлбал Сөүл хотын залуучуудын хөгжлийн үндсэн дүрэм, бусад хууль тогтоомжод Залуучуудын хөгжлийн бодлогыг “залуучуудын улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын зэрэг бүх салбарт оролцоог нэмэгдүүлэх, эрхийг хамгаалах, хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлдэг үйл ажиллагаа” хэмээн хуульчилжээ. Түүгээр зогсохгүй Засгийн газар жил бүр залуучуудын талаар томоохон бодлогыг чиглэлийг боловсруулж Ассемблейд өргөн мэдүүлэх үүрэг хүлээдэг байна.

Хүснэгт 3.7 Солонгос улсын залуучуудад чиглэсэн хуулийн зорилго, чиглэл

| Хууль | Зорилго | Үндсэн чиглэл | Батлагдсан, хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн хугацаа |
|----------------------------------|---|--|---|
| Залуучуудын хөгжлийн суурь хууль | Залуучуудын эрх, үүрэг хариуцлага, төр, орон нутгийн засаг захиргааны байгууллагаас залуучуудын өмнө хүлээх үүрэг хариуцлагыг хуульчилж, залуучуудын хөгжлийн бодлогыг цогцлоож, тэднийг дэмжихтэй холбоотой үндсэн асуудлыг шийдвэрлэх талаар тусгасан | Залуу хүн бүрийн өөрийгөө хүндэтгэх эрхэм чанарыг дэмжих, идэвхтэй хөдөлмөрийн амьдралыг баталгаажуулах;; Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л салбарт залуучуудын оролцоог хангах Боловсрол, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн сургалтанд залуучуудыг ижил тэгш оролцох боломж олгох; Залуучуудын өсөж хөгжих таатай нийгэм, эдийн засгийн орчныг бүрдүүлэх; | Тус хуулийг 2020 оны 2 сарын 4-ний өдөр баталсан бөгөөд 2020 оны 8 сарын 5-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчлэх юм. |

| | | | |
|--|--|---|--|
| Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль | Ажилгүй залуучуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эдийн засгийн цаашдын хөгжил, нийгмийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулах тухай | Залуучуудын үйл ажиллагааг дэмжих, оролцоог тэлэх Залуучуудын ур чадварыг хөгжүүлэх Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг тэлэх, ажлын байрны тоог нэмэгдүүлэх Залуучуудын амьдрах орчин нөхцлийн аюулгүй байдлыг хангах | Тус хууль 2009 оны 10.09-ны өдөр анх баталсан бөгөөд 2016.09.13-нд Ерөнхийлөгчийн зарлигаар нэмэлт өөрчлөлт орж, хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн яам |
| Залуучуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай хууль | Залуучуудын үйл ажиллагааг дэмжих, холбогдох байгууллага, институцийн хамтын ажиллагаа, залуучуудын удирдах хорооны бүтэц, чиг үүргийг тус тус зааж өгсөн | Залуусын үйл ажиллагаанд бие даан, сайн дураар оролцох замаар хүсэл эрмэлзэл, итгэл найдвараа хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | Тус хуулийг 2018 оны 03.13-нд баталж, 2018 оны 09.14-нөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн. Хүйсийн тэгш байдал, гэр бүлийн яам |

БНСУ-ын хувьд залуучуудын эрх ашгийн хамгаалах бодлого нь дараах чиглэлээр хэрэгжиж байна. Тухайлбал:

- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрны тоог нэмэх чиглэл нь төрийн болон орон нутгийн засаг захиргаанаас хамгийн их анхаарах;
- Төрийн болон орон нутгийн засаг захиргаа нь залуучуудын компани байгуулах, гарааны бизнесийг дэмжих, орчныг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх;
- Төр болон орон нутгийн засаг захиргаа нь залуучуудын орон байрны аюулгүй байдал, орон байрны нөхцлийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх;
- Залуучуудын бие махбодь-оюун санаа эрүүл мэндийг хамгаалах, амьдралын чанар, сайн сайхан байдлыг сайжруулах зэрэг халамж хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх;
- Залуучуудын эдийн засгийн бие даасан байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх;
- Залуучуудын соёлын олон талт, бүтээлч үйл ажиллагааг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх;
- Залуучуудын олон улсын энх тайвныг дэмжих хөдөлгөөн, олон улсын хамтын ажиллагааны үйл ажиллагаанд оролцох боломжийг хангах бодлогыг хэрэгжүүлэхээр тус тус хуульчлан үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Мөн тус улсын хэмжээнд Залуучуудын үйл ажиллагааг дэмжих хуулийн хүрээнд Залуучуудын үйл ажиллагааг хариуцах ажлын албыг “Солонгосын залуучуудын ажлын агентлаг” байх тухай зааж, үүнтэй ижил нэр ашиглахыг хуулиар хориглосон байна. Тэрчлэн хувь хүн, корпорац, байгууллагын зүгээс Залуучуудын ажлын албыг дэмжих

зорилгоор мөнгө эсвэл бусад эд хөрөнгийг хандив хэлбэрээр өгөх зохицуулалтыг хуульчилж өгсөн байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын урьдчилсан тооцоогоор дэлхий нийтийн хэмжээгээр хямралын улмаас 2010 он гэхэд дор хаяж 20 сая хүн барилга, санхүү, үл хөдлөх хөрөнгийн болон автомашин үйлдвэрлэлийн салбарт ажилгүй болж, ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж байв. Гэхдээ энэ үзэгдэл бүс нутгуудын хувьд харилцан адилгүй байсан ба тухайлбал хямралын эхэн үед АНУ-д ажилгүйдлийн түвшин 9.4 хувь, Канадад 8.0 хувь, Францад 8.8 хувь, Германд 6.9 хувь, Японд 5.5 хувь, Хятадад 5.2 хувь, Өмнөд Солонгост 3.3 хувь байгаа бол, Ирландад 11.9 хувь, Латвид 18.4 хувь, Испанид 17.9 хувь, Туркт 13.4 хувь болж эрс өссөн байна.

Дэлхийн хөдөлмөрийн зах зээл дээр гарч байгаа гол өөрчлөлтүүд сургууль төгсөөд шинээр хөдөлмөрийн зах зээл дээр гарч байгаа залуучууд, орон тооны бус түр ажилчид, эмэгтэйчүүдэд илүү хүндээр тусч байжээ. Тухайн үеийн хямралын сөрөг нөлөө хөгжингүй орнуудад ажилгүйдэл эрс нэмэгдэх, харин хөгжиж буй орнуудад ядуурлын түвшин огцом өсөх хандлагаар тус тус илэрч байв.

Хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтөөс үүдэн эрсдэлт байдал үүсч, эмзэг байдал нэмэгдэж, болох ба үйлчилгээ үзүүлэх зорилтот бүлгүүдийг бий болгодог. Эмзэг байдлыг бий болгох эрсдлийн хүчин зүйлд тулгуурлан дараах байдлаар ангилжээ.

- Эдийн засгийн нөхцөл байдлын улмаас ажилгүй болох, зах зээлээс алслагдмал орчинд аж төрөх, худалдааны таатай бус нөхцлийн улмаас алдагдалд орох, үнийн тогтворгүй байдлаас хамаарч өр тавих, цалин тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь төлөхгүй байгаагаас шалтгаалан бэлэн мөнгөний дутагдалд орж амьдралаа залгуулж чадахгүйд хүрэх, үндсэн хөрөнгөө алдах болон өрөнд орох зэрэг нь өмнө нь ядуу биш байсан ч ядуурах гэнэтийн нөхцөл болдог байна.
- Нийгмийн харилцаанаас тусгаарлагдах, ураг төрлийн холбоо сулрах, тасрах, итгэл алдрах, бусадтай хамтран ажиллаж чадахгүй байх, орчиндоо дасч өөрийн байр сууриа олж чадахгүй байх (шинэ ажилтан, малчдын туршлагагүй байдал гм) нь эмзэг байдалд нөлөөлдөг.
- Байгаль орчны зохисгүй нөлөөллийн улмаас үүсэх эмзэг байдалд дэлхийн цаг уурын дулаарах, зуд, ган, үер усны гамшиг, шороон болон элсэн, цасан шуурга, түймэр, хот суурин газрын агаарын бохирдол зэргийг оруулж тооцдог.

- Эрүүл мэндийн хувьд дэлхий нийтийг хамарсан цар тахал, халдварт өвчин, хувь хүн биеэ зохистой авч явж чадаагүйн улмаас үүсэх эрсдэл, чанар муутай ундны ус, хүнсний бараа, эм тариа, ариун цэвэр, эрүүл ахуй муудсанаас болон биеэ үнэлсэнээс эрүүл мэнд эрсдэлд орох зэргээс шалтгаалан эмзэг байдалд ордог.

Европын холбооны байгууллагуудаас үзүүлдэг боловсрол, сургалтын болон ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээний зорилго, зарчим⁹ нь иргэдэд илүү хүртээмжтэй байхад (improving access for citizens) чиглэдэг бөгөөд зорилтот бүлэгт үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойлжээ.

Тухайлбал:

- Зорилтот бүлэгт чиглэсэн үйлчилгээг нээлттэй, ил тод болгох
- Хэрэглэгчдэд мэдрэмжтэй үйлчлэх
- Үзүүлж буй зөвлөх үйлчилгээ нь тасралтгүй, тогтвортой байх
- Шаардлагатай хүн бүрт үйлчилгээг хүртээмжтэй хүргэх
- Хэрэглэгчдэд найрсаг хандах
- Үйлчилгээг зорилтот бүлгийн онцлогт тохируулан үзүүлэх

Монголд явуулсан судалгаанаас харахад олон хүүхэдтэй ганц бие өрх толгойлсон эмэгтэйчүүд, 100-аас доош малтай өрх, ажилгүйчүүд, суурь боловсролгүй хүмүүс, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гудамжны болон өнчин хүүхдүүд ядууралд өртөх, улмаар үйлчилгээ авах зорилтот бүлэг болох нь түгээмэл байна.

Европын холбооноос (Council of Europe) залуучуудын хөгжлийн бодлогын хүрээнд хөдөлмөр эрхлэлт, орон байр, боловсрол, эрүүл мэнд, халамж хамгаалал, соёл, хүний эрх, оролцоо гэсэн чиглэлийг багтаан бодлогоо хэрэгжүүлэх хэрэгтэй¹⁰ гэж үздэг.

Хүн ам болон залуучуудад үзүүлж буй тусламж, дэмжлэгийн үйлчилгээг төрийн үйлчилгээний байгууллага, албадууд, төрийн болон хувийн зуучлалын байгууллагууд болон ажил мэргэжлийн төвүүд хэрэгжүүлдэг байна.

Хүснэгт 3.8 Асуудал ба мэргэжлийн тусламж үйлчилгээний төрөл

| Асуудлууд | Санал болгох мэргэжлийн тусламж, үйлчилгээ |
|---|---|
| Орон сууц | Хэрэгцээ, шаардлагатай үндсэн үйлчилгээнүүд |
| Хувь хүний болон гэр бүлийн асуудлууд | Үндсэн биш салбарын үйлчилгээнүүд |
| Эрүүл мэндийн болон нийгэм, сэтгэлзүйн асуудлууд | Нарийн мэргэжлийн үйлчилгээ |

⁹ Европын Мэргэжлийн Боловсрол Сургалтын Хөгжлийн Төв, 2005


¹⁰ <https://www.coe.int/en/web/youth/youth-policy>

| | |
|--|--|
| Өр зээл ба хамааралт байдал, сайн дурын үйлчилгээ | Бусад үр нөлөө бүхий хагас мэргэжлийн үйлчилгээ(клуб, өөртөө туслах бүлгүүд) |
|--|--|

Эдгээр үйлчилгээг нийгмийн үйлчилгээний бусад байгууллагууд болон мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааны хүрээнд, эсвэл хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний зарим байгууллагууд нэг цэгийн үйлчилгээ хэлбэрээр бусад үйлчилгээтэй хамт хүргэх нь бий. Ерөнхийдөө мэргэжлийн зөвлөх болон зуучлалын үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтнүүд чухам ямар байгууллагад ажиллаж байгаагаас хамааран нийгмийн үйлчилгээг хэрхэн зохицуулж, уялдуулах нь харилцан адилгүй байдаг.

Энд жишээ болгож ажил мэргэжлийн төвүүд нийгмийн үйлчилгээний сүлжээг хэрхэн удирдаж, зохион байгуулдаг талаар Европын зарим орнуудын туршлагыг энд авч үзье. Тухайлбал, ХБНГУ-ын ажил мэргэжлийн төвүүд нь холбооны нийгмийн үйлчилгээний хүрээнд үйлчлүүлэгчдэд төрөл бүрийн үйлчилгээг санал болгодог бөгөөд төвүүдийн ажил мэргэжлийн зөвлөхүүд өөрсдөө үйлчилгээг удирдан зохион байгуулдаг байна.

Схем зураг 3. ХБНГУ-ын Маннхайм хотын хөдөлмөр эрхлэлтийн нийгэмлэгийн бүтэц



Эх сурвалж: ARGE Mannheim, Маннхайм хотын ажил мэргэжлийн төв, SGB III-Нийгмийн хамгааллын багц хуулийн 3-р дэвтэр, SGB II-Нийгмийн хамгааллын багц хуулийн 2-р дэвтэр, SGB XII-Нийгмийн хамгааллын багц хуулийн 12-р дэвтэр

Зургаас үзэхэд нийгэм сэтгэл зүйн, эрүүл мэндийн, халамжийн, гэр бүлийн, санхүүгийн, орон сууцны суурь үйлчилгээнүүдээс гадна донтолын эсрэг зэрэг нарийн мэргэжлийн үйлчилгээнүүдийг хуулийн дагуу үйлчлүүлэгчид хүргэх ажлыг Залуучуудын ажил мэргэжлийн төв үзүүлдэг байна. Мөн залуучуудын ажил мэргэжлийн төвүүд өөрсдийн зүгээс ажил мэргэжлийн зөвлөгөө, зуучлал, кейс менежментийн үйлчилгээг тус тус хүргэдэг ажээ. Нийгмийн халамж, хамгааллын бодлого *халамжаас-хөдөлмөрт* чиглэж байгаа өнөө үед залуучуудад чиглэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөгөө, сургалт мэдээлэл, зуучлалын үйлчилгээг хэрэгжүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стратеги, нотолгоонд суурилсан үйлчилгээнд тулгуурлан явуулах¹¹ нь ЗХТ-ийн үндсэн бөгөөд чухал үйлчилгээний нэг байх болно.

4.5.2 Үндэсний туршлага

Зөвлөх багийн гишүүд Налайх дүүргийн ЗХТ-ийн жишиг үйлчилгээ болгож, БЗД болон Төв аймгийн ЗХТ-ийн үйлчилгээтэй харьцуулан өнөөгийн нөхцөл байдлыг судалсан болно. Төрийн байгууллага, орон нутгийн удирдлагын дэмжлэг, харъяа газрын дарга, мэргэжилтнүүдийн идэвхи санаачлагын үр дүнд зарим орон нутагт жишиг үйлчилгээ бүхий ЗХТ бий болж, хөгжих эхлэл тавигдаж байна. Нийслэл, аймгийн хэмжээнд Залуучуудын хөгжлийн төвөөс хэрэгжүүлж ирсэн үйлчилгээний чиглэлийг авч үзэхэд хувь хүний хөгжлийг дэмжих сургалтууд, биеийн тамир спортын арга хэмжээ, нөлөөллийн аян, арга хэмжээг голлон хэрэгжүүлсэн байна. Үүнийг ЗХТ-ийн ажилтнуудаас авсан¹² санал асуулгын үр дүнд тулгуурлан авч үзэхэд үйл ажиллагааны чиглэлийн хувьд хувь хүний хөгжлийг дэмжих үйлчилгээ 30%, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, холбон зуучлах үйлчилгээ 23.3%, аюулгүй амьдрах, хөгжих орчныг дэмжих үйлчилгээ 15%, эрүүл мэндийг дэмжих, холбон зуучлах үйлчилгээ 3.3%, үлдсэн 2.2% нь бусад төрлийн үйлчилгээ үзүүлсэн байна. Эндээс үзэхэд нэг удаагийн буюу мэдээлэл өгөх, аян зохион байгуулах, нөлөөллийн ажлууд голлож, үр нөлөө бүхий мэргэжлийн үйлчилгээ зарим талаар орхигдох байдал харагдаж байна.

Налайх дүүргийн ЗХТ-ийн хувьд гэхэд бүтэц, орон тоо, төсөв, ажил үүргийн хуваарь, үйлчилгээг хүргэх ажлын байр зэрэг үйлчилгээнд тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна. Тус дүүргийн ГБХЗХХ-ийн дарга, мэргэжилтнүүд ЗХТ-ийн үйлчилгээг шинэ шатанд гаргахын тулд дүүргийн хэмжээнд Дүүргийн залуучуудад тулгамдаж буй суурь

¹¹ ДЭМБ. INSPIRE. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах 7 стратеги. Женев, 2016

¹² ЗХТ-ийн үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудаас авсан санал асуулга. 2020

асуудлыг судалж, орон нутгийн онцлогт тулгуурласан үйлчилгээг төлөвлөх ажлыг эхлүүлэхээр төлөвлөжээ. Төв аймгийн ЗХТ-ийн хувьд ажлын болон үйлчилгээ үзүүлэх байр, бүтэц, орон тоог шийдвэрлэсэн болон төсөв санхүүжилт тааруу, зогсонги байдалтай, үзүүлж буй үйлчилгээ “мухардмал” байдалд орсон байна. Харин БЗД-ийн ЗХТ-ийн хувьд түрээсийн байранд, үйлчилгээ үзүүлэх тогтсон байргүй, ажилтнуудын чиг үүрэг тодорхой бус, үндсэн чиг үүргээс гадуур туслах, хавсарга маягаар ажиллаж байгаа нь төвийг “эрх мэдэлгүй, хүчгүй” харагдуулж, үйлчилгээг сул болгож байна. Багануур дүүргийн хувьд ЗХТ-ийн ажилтнуудыг гэрээт бус хэлбэрээр ажиллуулахыг зогсоож, байнгын ажлын байр буюу орон тооны ажилтны цалингийн зардлыг дүүргийн төсөвт суулгаж, тогтвортой ажиллуулах орчин нөхцлийг хангажээ. Аймаг, дүүргийн ЗХТ-ийн дээрх гурван хэв маяг, туршлагаас харахад залуучуудад чиглэсэн үйлчилгээнд үндсэн биш салбарын үйлчилгээ давамгайлах, салбар зөвлөлийг удирдаж буй эрх мэдэлтний хүсэл сонирхол, идэвх оролцоо сул байх, хэлтсийг удирдаж буй хүмүүсийн санаачилга, үйл ажиллагаа зэргээс үйлчилгээ хүртээмжтэй, чанартай, нийцтэй байх нь шууд хамаарч байна.

Өнгөрсөн 3 жилд ЗХТ-өөс үзүүлсэн үйлчилгээний нэр төрлийг авч үзэхэд сургалт сурталчилгаа, мэдээлэл зөвлөгөө зэрэг үндсэн биш салбарын үйлчилгээ голлон хийгдсэн байна. Хүснэгт 3.9-д одоогийн ЗХТ-ийн үзүүлж буй үндсэн үйлчилгээний нэр төрөл, тавигдаж буй шаардлагуудыг авч үзсэн.

Хүснэгт 3.9 ЗХТ-өөс үзүүлж буй үндсэн үйлчилгээ ба тавигдах шаардлага

| Үзүүлж буй үндсэн үйлчилгээний нэр төрөл | Үйлчилгээнд тавигдах шаардлага |
|---|---|
| Холбон зуучлах үйлчилгээ | Үр нөлөө бүхий хагас мэргэжлийн үйлчилгээ |
| Зорилтот бүлгийг чадавхижуулах | Хэрэгцээ, шаардлагатай үндсэн үйлчилгээ |
| Зөвлөгөө, дэмжлэг | Үр нөлөө бүхий хагас мэргэжлийн үйлчилгээ |
| Сайн дурын ажлыг бүртгэж, баталгаажуулах, лавлах | Хэрэгцээ, шаардлагатай үндсэн үйлчилгээ |
| Номын сангийн үйлчилгээ | Үндсэн биш салбарын үйлчилгээ |
| Хөгжлийг дэмжих үйлчилгээ | Хэрэгцээ, шаардлагатай үндсэн үйлчилгээ |
| Сургалт, мэдээлэл | Үндсэн биш салбарын үйлчилгээ |

Дээрх мэдээлэлд тулгуурлан үзэхэд жишиг үйлчилгээний зураглалын хувьд Налайх дүүрэг үндсэн голдрилдоо орж, стандарт үйлчилгээ үзүүлэхэд нэг шат ахисан гэж үзэж болохоор байна. Тус дүүргийн хувьд үйлчилгээ үзүүлэх орчин бүрдсэн бөгөөд одоогийн байдлаар орон нутгийн залуучуудын бүлэгт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох суурь судалгааг хэрэгжүүлж эхлээд байгаа юм. Харин бусад аймаг, дүүргийн хувьд

хэрэгцээтэй гэж үзсэн, эсвэл чиг үүрэгт тусгагдсан үйлчилгээг үзүүлэхээр хязгаарлагдаж байна. Эдгээр үндсэн биш салбарын үйлчилгээ нь ихэвчлэн нэг удаагийн сургалт, сурталчилгаа, мэдээлэл байгаа нь урт хугацааны тогтвортой үйлчилгээг бий болгох шаардлагатай гэдгийг харуулж байна. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулинд тусгагдсан долоон төрлийн үйлчилгээг хүргэхэд нэг хүнд үзүүлэх жишиг зардлыг тооцох нь нэн чухал. Ингэхдээ хөтөлбөр хэлбэрээр үзүүлэх болон хуулинд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын жишиг хэмжээ¹³-г тооцон гаргаж болно. Залуучуудад чиглэсэн нөлөөллийн болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний мэдээлэл бэлтгэх зардлын төрөлд сургалт, сурталчилгааны материал бэлтгэх, хэвлүүлэх, тараах болон зөвлөх, сургагч нарыг бэлтгэх зардал багтана. Залуучуудын оролцоог дэмжих үйлчилгээний нэгжийн зардлыг тухайн оролцоог дэмжсэн арга хэмжээний төлөвлөгөө, зардлын тооцоогоор тооцох боломжтой. Мөн өмнөх жилийн оролцоог дэмжсэн үйлчилгээний дундаж зардлаар төлөвлөлтийг хийж болно.

Хүснэгт 3.10 Залуучуудын хөгжлийн үйлчилгээний зардлын жишиг хэмжээ

| Д/Д | Үйлчилгээний | Жишиг зардлын хэмжээ /төгрөгөөр/ | Зардлын төрөл |
|-----|---|----------------------------------|--|
| 1 | Амьдрах ухааны чадвар эзэмшүүлэх, сургалт явуулах | 30000 ¹⁴ | Сургалтын хэрэглэгдэхүүн бичиг хэргийн зардал, сургагч багшийн хөлс гм |
| 2 | Залуучуудын оролцоог дэмжих үйлчилгээ /сараар 30 хүртэл хүнтэй байх/ | 30000 – 50000 | Сургалт, сурталчилгааны материал бэлтгэх, хэвлүүлэх, тараах |
| 3 | Сонирхолын клуб, зөвлөл, бүлгийн үйл ажиллагааг дэмжих үйлчилгээ (сараар нэг бүлэг 30 хүртэл хүнтэй байхаар тооцох) | 30000 - 50000 | Утас, харилцаа холбоо, зохион байгуулалтын зардал гм |
| 4 | Холбон зуучлах(эрүүл мэнд, хууль зүй, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, гэр бүлийн зөвлөгөө, сэтгэлзүй, ажлын байр) | 7000 ¹⁵ | Утас, харилцаа холбоо, зуучлалын зардал гм |

¹³ Б.Батхүү. Залуучуудын хөгжлийн үйлчилгээний зардлын жишиг хэмжээ. Нэгдсэн тайлан. Улаанбаатар, 2018

¹⁴ ХНХ-ын сайдын 2019 оны 3 дугаар сарын 05 ны өдрийн А/83 тушаалын хавсралт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зардлын жишиг хэмжээ, хоёрдугаар зүйл

¹⁵ ХНХ-ын сайдын 2019 оны 3 дугаар сарын 05 ны өдрийн А/83 тушаалын хавсралт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зардлын жишиг хэмжээ, зургаадугаар зүйл

| | | | |
|----|--|-----------------------------|---|
| 5 | Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ганцаарчилсан болон бүлгийн үйлчилгээ (нэг хүний 3-5 удаагийн үйлчилгээ) | 30000 - 50000 ¹⁶ | Техник хэрэгсэл, бичиг хэрэг, цай кофе гм. |
| 6 | Гарааны бизнесийг дэмжих үйл ажиллагаа (нэг хүний) | 100000 | Сургалт, санхүүгийн дэмжлэг |
| 7 | Зөвлөгөө өгөх үйлчилгээ (бүлгээр болон ганцаарчилсан) | 6000 -12000 ¹⁷ | Техник хэрэгсэл, бичиг хэрэг, цай кофены зардал, зөвлөхийн ажлын хөлс гм. |
| 8 | Залуу гэр бүлийг дэмжих хөгжлийн үйлчилгээ (нэг гэр бүлд нэг сард 100000 хүртэлх төгрөг) | 100000 | Санхүүгийн дэмжлэг туслалцаа |
| 9 | Залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ мэдээллээр хангах, ажилд зуучлах(нэг хүний) | 7000 | Утас, харилцаа холбоо |
| 10 | Шаардлагатай нөхцөлд өмгөөлөгчийн үйлчилгээний төлбөрийг хариуцах(нэг хүний) | 30000–50000 ¹⁸ | Өмгөөлөлтэй холбоотой зардлууд |

Өнөөгийн байдлаар ЗХТ улиралд 1-2 сая төгрөгийн санхүүжилт авч байна. Гэхдээ энэ хөрөнгийн зарцуулалт залуучууд хөгжлийн төв бүрийн хувьд ялгаатай байна. Ихэнхдээ хөрөнгийг залуучуудад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаанд зарцуулж байна. Өмнө дурдсан үйлчилгээний нэгжийн хамгийн их зардал, сард үйлчлүүлэх үйлчлүүлэгчийн тоог тооцоолох замаар ЗХТ-ийн үйлчилгээнд шаардлагатай нийт зардлыг гаргаж болно. Тухайн жишгээр сард 400 хүнд үйлчилгээ үзүүлнэ гэж тооцоход нэг сард ЗХТ-д 3.5 сая, улиралд 10.5 сая, жилд 41.5 сая төгрөгийн төсөв шаардлагатай байна. Гэхдээ энэхүү жишиг зардлыг жил бүрийн гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлэх ба хөтөлбөрт тулгуурлан хэрэгжүүлдэг байвал зохино. Энэ талаар Хавсралт хэсгээс үзнэ үү?

Ерөнхийдөө залуучуудтай холбоотой төрөл бүрийн асуудлаар судалгаа шинжилгээ, ялангуяа насны бүлэгт тулгуурласан нийгмийн нарийвчилсан судалгаа ихээхэн дутмаг байгаа нь харагдаж байна. Тухайлбал шилжих хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор гэр бүлийн бүтэц, харилцаанд гарч байгаа өөрчлөлт, нийгмийн мэдээллийн цахим сүлжээ өргөн дэлгэрч байгаатай холбоотой залуучуудын дунд үүсч

¹⁶ Сангийн сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны 7 дугаар сарын 27 өдрийн 264/А/293 тоот тушаалын хавсралт I

¹⁷ ХНХ-ын сайдын 2019 оны 3 дугаар сарын 05 ны өдрийн А/83 тушаалын хавсралт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний зардлын жишиг хэмжээ, тавдугаар зүйл

¹⁸ Өмгөөллийн үйлчилгээний жишиг тарифаар тооцсон.

буй шинэ харилцаа холбоо, хамтлаг бүлгүүд, өсвөр үе, залуучуудын үнэлэмж хандлага, гэр хорооллын амьдралын нөхцлөөс үүдсэн залуучуудад тулгарч буй бэрхшээл, эмзэг, эрсдэлт болон ядуурлын нөхцөл байдал зэрэг олон асуудлын мөн чанарыг тодорхойлоход бодитой мэдээлэл, үндэслэлтэй судалгаа чухал хэрэгцээтэй байна. Аймаг, дүүрэгт үзүүлж буй ЗХТ-ийн үйлчилгээний туршлагад тулгуурлан авч үзэхэд үйлчилгээг орон нутгийн нөөц, онцлогт тулгуурлан дараах байдлаар явуулах боломжтой.

Хүснэгт 3.11 Орон нутгийн онцлогт тохирсон үйлчилгээ

| Орон нутаг | Тохирох үйлчилгээ |
|--|--|
| Нийслэл, аймгийн төвүүдэд | Орон сууц, хөдөлмөр эрхлэлт, хөгжил, эрүүл мэнд |
| Шилжих хөдөлгөөн өндөртэй, уул уурхайн бүс нутаг | Эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл, хөгжилд чиглэсэн үйлчилгээ/дэмжих болон дагалдах үйлчилгээ/ |
| Аялал жуулчлалын бүс нутаг/Хөвсгөл, Хэнтий/ | Амьжиргааг дэмжих сургалт, зөвлөгөө, хөгжилд чиглэсэн үйлчилгээ |
| Газар тариалангийн бүс нутаг/Булган, Сэлэнгэ/ | Амьжиргааг дэмжих сургалт, хөгжилд чиглэсэн үйлчилгээ |
| Мал аж ахуйн бүс нутаг/Сум, хөдөө/ | Амьжиргааг дэмжих сургалт, зөвлөгөө, хөгжилд чиглэсэн үйлчилгээ |
| Сумын төв/333 сум/ | Сургалт зөвлөгөө, хөгжилд чиглэсэн үйлчилгээ |

ЗХТ-ийн үйлчилгээг стандарт болгох нь “нэг далайлтаар” шийдвэрлэх асуудал хараахан биш юм. Тухайн үйлчилгээг төрийн үйлчилгээний салшгүй хэсэг болгоход урт хугацааны төлөвлөлт, стратеги, шат дараалсан арга хэмжээ, туршилт чухал байна.

Ингэхийн тулд юуны өмнө бүс нутгийн онцлог, орон нутгийн нөөцийг тодорхойлох, үйлчилгээний онцлогийг “залуучуудын цонхоор шагайх”, өөрөөр хэлбэл залуучуудын хэрэгцээ шаардлагад тулгуурласан үйлчилгээг бий болгох шаардлагатай.

Өнгөрсөн хугацаанд залуучуудад үзүүлэх тусламж, үйлчилгээний хувьд гарааны нөхцөл баттай тавигдсан ба эдүгээ асуудлыг тодорхойлохоос шийдвэрлэх хөгжлийн хөтөлбөрт, аян арга хэмжээ зохиох үйл ажиллагаанаас нөлөөлөл интервэнц рүү, сургалтаас зөвлөгөөнд, мэдээлэл өгөхөөс мэргэжлийн үйлчилгээ рүү тус тус шилжүүлэх нь нэн чухал байна.

ТАВ. ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

5.1 Залуучуудын хэрэгцээ, шаардлагад тулгуурласан үйлчилгээг бий болгох нь

Хүн амын бодлогын нийтлэг зорилго бол нийгэм эдийн засгийн хөгжил, хүн амын төлөв байдал, хандлага, хэв маягийн өөрчлөлтийн дүнд нийт хүмүүсийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх явдал юм. “Амьдралын чанар” нь хүмүүсийн эрүүл мэнд, боловсрол, соёл, орон сууц, амьдрах орчны эрүүл, аюулгүй байдал, хүнийг татах байдал, хөдөлмөр эрхлэлт, орлого, хамгаалал, шийдвэр гаргах үйл явцад оролцох эрх чөлөө, уламжлалт зан заншил, үнэт зүйлсээ илэрхийлэх чадвар зэрэг олон хүчин зүйлсийг нэгтгэсэн ойлголт билээ. Дэлхий даяар залуу хүн амын тоо буурч байгаа энэ үед манай орон хүн ам зүйн ачаалал бага, “хүн ам зүйн цонх” тохиосон таатай нөхцөлтэй байна. Монгол Улсын хэмжээнд 2018 оны байдлаар 15-34 насны 1072071 хүн амьдарч, энэ нь нийт хүн амын 33.7%-ийг эзэлж байсан бол 2019 онд 32.8%, 2020 оны байдлаар 31.7%-тай болсон байна. Нийт залуу хүн амыг 5 жилийн интервалаар бүлэглэн, насны онцлогийг болзмол байдлаар ангилж үзэхэд 15-19 насны 233 мянга, 20-24 насны 244.9 мянга, 25-29 насны 310.7 мянга, 30-34 насны 283.4 мянган залуучууд байна. Энэхүү статистик мэдээнд хүн амын томоохон бүлэг болох залуучуудын талаар төрийн бодлогод шинжилгээ хийж, дүгнэлт тайлбар хийх, цаашид авах арга хэмжээг сайжруулах арга замыг эрэлхийлэх нь хүн ам зүйн утгаар ч, улс төрийн бодлогын дүн шинжилгээний хувиар ч чухал ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдэд нийгмийн хөдөлгөгч хүч болсон залуучуудын асуудлыг шийдвэрлэх цөөнгүй хууль тогтоомж батлагдаж, насны бүлэгт тохирсон үйлчилгээний нэр төрөл олширч, хууль эрх зүйн орчин сайжирч байна. Жишээ болгоход, Монгол Улсын Засгийн газраас Залуучуудад холбогдох хөтөлбөр, дэд хөтөлбөрийг сүүлийн 20 гаруй жилд батлан, хэрэгжүүлж байгаа нь тодорхой хүрээнд үр дүнгээ өгч байгаа нь сайшаалтай. Гэвч, нэгдүгээрт эдгээр бодлогын арга хэмжээнүүд нь тэр бүр хангалттай хэрэгжиж, залуучуудын өмнө тулгарч байгаа олон асуудлыг туйлбартай шийдвэрлэж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл хүн амын суурь бүлэг болсон залуучуудад тусгайлан баримжаалсан оновчтой, үр өгөөжтэй бие даасан бодлого, үйлчилгээ илт үгүйлэгдэж байгаа юм. Хоёрдугаарт, дурдсан бодлогын арга хэмжээнүүд нь нэг талаас хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлд ахиц авчирсан боловч, нөгөө талаас төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, залгамж чанар, үр ашигт байдал хараахан бий болоогүй байна. Иймд залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээнд тулгамдаж буй асуудлын

талаар ул үндэстэй судалж, өнөөгийн нөхцөл байдлыг танин мэдэх нь залуучуудад чиглэсэн төрийн үйлчилгээг сайжруулах, цаашилбал оновчтой бие даасан бодлого боловсруулан, хэрэгжүүлэхэд чухал алхам болно.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль 2018 оны 1 дүгээр 01-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Залуучууд хөгжлийн төв (ЗХТ)-өөр дамжуулан төрийн үйлчилгээг залуучуудад хүргэх тогтолцоог бий болгосноор өмнө олон нийт, төрийн бус байгууллагаар хүргэдэг байсан ажил үйлчилгээг төр хариуцах болсон юм.

НҮБ-ын Хүн амын сан, Монгол Улсын Засгийн газар хамтран хэрэгжүүлсэн “Залуучуудын хөгжил 2013-2017” төслийн хүрээнд 11 аймаг, 3 дүүрэг, 2 суманд нийт 16 Залуучуудын хөгжлийн төвийг байгуулсан бол Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль (УИХ, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, 2017) хэрэгжиж эхэлснээр 10 аймаг, 9 дүүрэгт нийт 19 залуучуудын хөгжлийн төвийг шинээр байгуулж, улсын хэмжээнд нийт 35 залуучуудын хөгжлийн төв үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны 4 дүгээр тогтоолын 1-р хавсралтаар “Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрэм” (МУЗГ, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны 4 дүгээр тогтоол. Хавсралт.1 “Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрэм”, 2018), 2-р хавсралтаар “Орон нутгийн салбар зөвлөлийн дүрэм”-ийг тус тус баталснаар (МУЗГ, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны 4 дүгээр тогтоол. Хавсралт.2 “Орон нутгийн салбар зөвлөлийн дүрэм”, 2018) хууль эрх зүйн орчин төгөлдөржиж, бүтэц тогтолцоо бий болох эхлэл тавигджээ.

Хууль хэрэгжиж эхэлсэн эхний жилд ЗХТ нь олон нийт, залуучуудад үйл ажиллагааны талаар таниулан ойлгуулах, танилцуулах үйл ажиллагааг голчлон явуулсан бол 2019 онд нийгмийн тодорхой бүлгийн гишүүдийг амьдрах ухааны сургалт, хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамруулах, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд холбон зуучлах болон өдөрлөг аяныг зохион байгуулсан байна.

Өнгөрсөн хоёр жилийн ажлын үр дүнгээс үзэхэд ЗХТ-ийн үйлчилгээний арга зүй, аргачлалыг боловсронгуй болгох, түүнд үндэслэн үйлчилгээний нэгж зардлыг нарийвчлах, төрийн үйлчилгээг залуучуудад хүргэхдээ ТББ, олон нийтийн оролцоог хөгжүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна.

Одоогийн үйлчилгээний нөхцөл байдалд үндэслэн дараах саналыг дэвшүүлж болох юм.

Үүнд:

- Залуучуудын хэрэгцээ, шаардлагад тулгуурлан үйлчилгээг насны онцлогт үндэслэн, хөтөлбөрт тулгуурлаж явуулах
- Үйлчилгээний тодорхойлолт, арга зүй, дарааллыг шинэчлэх
- ЗХТ-ийн үйлчилгээг анхан шатны нэгжид зохион байгуулах, сайн туршлагыг хэрэгжүүлэх

Залуучуудын хөгжлийн үйлчилгээ нь өөр өөр үүрэг бүхий төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа хамаарлаас шалтгаалж байдаг. Иймд эдгээр төрийн байгууллагуудын хувьд чиг үүргийн хүрээ, зааг, хязгаарыг нарийн тогтоох, давхардал, хийдэл үүсэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм. Учир нь залуучуудын асуудал нь салбар дундын асуудал¹⁹ бөгөөд бодлогын хэрэгжилт, ололт, амжилт нь салбар хоорондын үр дүнтэй зохицуулалтаас ихээхэн хамаарна. Тухайлбал, залуучуудын дунд архидалт буурах нь тэдний эрүүл мэндийг сайжруулаад зогсохгүй гэмт хэрэг, хүчирхийлэл, замын хөдөлгөөний осол буурахад мөн нөлөөлнө. Түүнчлэн залуучууд ажил олох, тогтвортой ажиллах боломжийг бий болгохын зэрэгцээ улмаар орлогоо нэмэгдүүлж, гэр бүлийн харилцаанд эерэг өөрчлөлт авчирна.

Нөгөө талаар залуучуудын талаарх бодлогод хүн амын энэхүү суурь бүлгийн бүх асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломжгүй. Иймд Засгийн газар, холбогдох яам, агентлагууд залуучуудад үзүүлэх бодлого, үйлчилгээг хэд хэдэн стратегид хувааж, залуучууд гэсэн томоохон суурь бүлэгт хамаарах олон талын хэрэгцээ бүхий дэд бүлгийн асуудлыг илүү үр дүнтэй шийдвэрлэх хувилбарыг дэвшүүлэх нь чухал билээ.

5.2 Залуучуудын насны бүлэгт тохирсон үйлчилгээг бий болгох нь

ЗХТ-ийн үйлчлүүлэгчийг нийтлэг үйлчилгээний болон зорилтот бүлгийн үйлчилгээ гэсэн хоёр бүлэгт хуваах нь зүйтэй. Нийтлэг үйлчилгээний хувьд насны бүлгээр дэд бүлэгт хувааж, насны онцлогийг харгалзан хэрэгцээ, шаардлагад тулгуурлан ангилах боломжтой.

5.2.1 Залуучуудын насны бүлэгт тохирсон нийтлэг үйлчилгээ

Өсвөр залуу үе буюу 14-19 насны бүлэг – Энэ дэд бүлгийн үйлчлүүлэгчийн зонхилох хувь ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангид суралцагчид байна.

¹⁹ НҮБХХ. Хүний хөгжлийн илтгэл. УБ, 2016

Иймд тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн нийтлэг үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай. Тухайн нийтлэг үйлчилгээнд өөрийгөө таних, харилцаа холбоо тогтоох, бэлгийн амьдрал, мэргэжил сонголт, нийгэмшүүлэх зэргийг агуулгын хувьд багтаасан Амьдрах ухааны боловсрол сургалтын багц-1, сайн дурын ажил, хүмүүнлэгийн ажилд оролцох оролцоог дэмжих, эрүүл мэндийн сургалт, зөвлөгөөнд хамруулах нь зүйтэй.

Орь залуучууд буюу 20-24 насны бүлэг – Энэ дэд бүлгийн үйлчлүүлэгчийн зонхилох хувь нь мэргэжлийн боловсрол болон дээд боловсролын байгууллагад суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид байна. Иймд тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн нийтлэг үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай. Тухайн нийтлэг үйлчилгээнд гэр бүл төлөвлөлт, бие даасан шийдвэр гаргах, CV танилцуулга бэлтгэх, ажлын ярилцлагад орох, санхүүгээ зохицуулах зэрэг Амьдрах ухааны сургалтын багц-2, сайн дурын болон бие даан амьдрах сургалт, зөвлөгөөнд хамруулах хэрэгтэй.

Идэр болон төгс залуучууд болох 25-35 насны бүлэг – тухайн бүлгийн зонхилох хувь нь тодорхой ажил хөдөлмөр эрхэлж буй, гэр бүл зохиох болон шинээр гэр бүлтэй болж буй залуучууд юм. Иймд тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцсэн гэр бүлийн үүрэг хариуцлага, харилцаа, санхүүгийн боловсрол олгох, бизнес эрхлэх, шийдвэр гаргах, нөлөөлөл үзүүлэх зэрэг нийтлэг үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай.

5.2.2 Зорилтот бүлэгт үзүүлэх үйлчилгээ

ЗХТ-ийн үйлчилгээ зорилтот бүлэгт илүү хүртээмжтэй, чанартай, тэдний хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээг хүргэнэ. Зорилтот бүлэг нь өөр өөр хэрэгцээтэй, ялгаатай үйлчилгээг авах шаардлагатай бүлэг, хэсэг, хувь хүн байх болно. Эдгээр дэд бүлэг аймаг, нийслэл, сум, дүүрэгт өөр хоорондоо ялгаатай байна. Дараах дэд бүлгүүд анхан шатны нэгжид нийтлэг байна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын дэд бүлэг–Тухайн харьяалах газар нутагт амьдарч 14-35 насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амыг хамруулна.
- Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, гэмт хэргийн хохирогч болон хүчирхийлэлд өртсөн, хар тамхи, мансуурах бодист автсан залуучуудын дэд бүлэг –Тухайн харьяалах газар нутгийн 14-35 насны гэмт хэрэгт холбогдож ял эдэлж буй, суллагдсан, зөрчилд холбогдсон, болзошгүй этгээдийг хамруулна.
- Ажилгүй, сургууль завсардсан, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур амьжиргаатай залуучуудын дэд бүлэг - Тухайн харьяалах газар нутгийн 14-35

насны Ажилгүй, сургууль завсардсан, амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур амьжиргаатай залуучуудыг хамруулж ойлгоно.

- Халамж, асрамжийн үйлчилгээнээс ердийн амьдралд шилжиж буй болон бие даан өрх толгойлох болсон залуучуудын дэд бүлэг - Тухайн харьяалах газар нутгийн 14-35 насны амьжиргаатай залуучуудыг хамруулж ойлгоно.
- Халамж, асрамжийн үйлчилгээнд ердийн амьдралд шилжиж буй болон бие даан өрх толгойлох болсон залуучуудыг хамруулна.

5.3 Үйлчилгээний тодорхойлолт, арга зүй, үйлчилгээний дараалал

5.3.1 ЗХТ-ийн үйлчилгээний тодорхойлолт

Баримт бичгийн судалгаанаас үзэхэд Залуучуудад чиглэсэн дараах долоон үндсэн чиглэлийн хүрээнд 21 төрлийн үйлчилгээг хүргэхээр тодорхойлсон байна. Үүнд:

1. Холбон зуучлах үйлчилгээ

- ✓ Хууль зүйн тусламж үйлчилгээнд холбон зуучлах
- ✓ Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд холбон зуучлах
- ✓ Боловсролын үйлчилгээнд холбон зуучлах
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд холбон зуучлах
- ✓ Гэр бүлийн зөвлөлгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд холбон зуучлах
- ✓ Сэтгэл зүйн болон сэтгэл заслын зөвлөгөө үйлчилгээнд холбон зуучлах
- ✓ Ажлын байранд холбон зуучлах
- ✓ Сайн дурын ажилд холбон зуучлах

2. Зорилтот бүлгийг чадавхижуулах үйлчилгээ

- ✓ Амьдрах ухааны сургалт зохион байгуулах
- ✓ Ажлын байрны чиг баримжаа олгох сургалт
- ✓ Урьдчилан сэргийлэх, нөлөөллийн үйл ажиллагаа

3. Зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ

- ✓ Нийгмийн үйлчилгээний талаар мэдээлэл, зөвлөлгөөгөөр хангах
- ✓ Залуучуудын ур чадварыг үнэлэх, хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хөгжүүлэхэд туслах, хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр зөвлөгөө өгөх
- ✓ Гарааны бизнес, компани эрхлэхийг дэмжих чиглэлээр зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах

4. Сайн дурын ажлыг бүртгэж, баталгаажуулах, лавлагаа гаргах үйлчилгээ

-
5. Номын сангийн үйлчилгээ
 6. Хөгжлийг дэмжих үйлчилгээ
 - ✓ Сонирхолын клуб, зөвлөл, бүлгийн үйл ажиллагааг дэмжих
 - ✓ Хувь хүн, бүлгийн хөгжлийн үйл ажиллагааг дэмжих
 - ✓ Залуучуудын оролцоог бүх хэлбэрээр дэмжих
 - ✓ Залуучуудын чөлөөт уулзалт, ярилцлага зохион байгуулах
 - ✓ Гэр бүлийн боловсрол олгох
 - ✓ Залуучуудад чиглэсэн нөлөөллийн болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах
 7. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр үе залуучуудад амьдрах ухааны сургалт, урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах

*Холбон зуучлах үйлчилгээ*²⁰ нь үйлчлүүлэгч зайлшгүй шаардлагатай бусад мэргэжлийн байгууллагын үйлчилгээнд хамрагдах боломжоор хангагдах, тухайн үйлчилгээнд хамрагдснаар тулгарч буй бэрхшээл, асуудал шийдвэрлэгдэх нөхцөлөөр хангах үүргийг ЗХТ хүлээнэ. Энэ үйлчилгээ нь тухайн үйлчилгээг үзүүлэх мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаатай давхцахгүй бөгөөд харилцан уялдаатай явагдах учиртай. Холбон зуучлах үйлчилгээг зорилтот бүлгийн гишүүдэд заавал хүргэнэ.

Нөгөө талаас Залуучуудын хөгжлийн төв нь төрийн байгууллагын хамтын ажиллагаа, ажлын уялдаа хамаарлаас шалтгаалж чиг үүргийн хүрээ зааг хязгаарыг тогтоож ажлын давхардал, хийдэл гаргахгүй байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор холбон зуучлах үйлчилгээний хүрээг нарийн тодорхойлох шаардлагатай.

Залуучуудын хөгжлийн төвүүд залуучуудын өмнө тулгамдаж байгаа асуудлыг салбар дундын хамтын ажиллагаа, залуучуудын өөрсдийн оролцоотой шийдвэрлэх зорилгоор дараах мэргэжлийн байгууллагад холбон зуучилж үйлчилгээнд хамруулж байна. Тухайлбал, дараах үйлчилгээнд холбон зуучилж болно.

- ✓ Ажлын байранд
- ✓ Сайн дурын ажилд
- ✓ Хууль зүйн туслалцаа
- ✓ Эрүүл мэндийн үйлчилгээ
- ✓ Боловсролын үйлчилгээ

²⁰ ХНХ-ын сайдын 2019 оны 3 дугаар сарын 05 ны өдрийн А/83 тушаалын хавсралт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж, хуудас 22 агуулгад нийцсэн байх

- ✓ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд
- ✓ Гэр бүлийн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх
- ✓ Сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл засал

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 01-р сарын 14-ний тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн дагуу Хөдөлмөрт бэлтгэх, мэргэжлийн болон давтан сургалтыг ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, сургууль завсардсан хөдөлмөрийн насанд хүрсэн хүүхэд болон ажил олоход хүндрэлтэй иргэнд богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлдэг. Мэргэжлийн болон давтан сургалтыг нийслэлийн төвийн 6 дүүрэгт Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар эрхийн бичгийн сургалтын хөтөлбөрийн дагуу үйлчилгээ үзүүлж, 21 аймаг, алслагдсан 3 дүүрэгт Хөдөлмөр халамж үйлчилгээний газар хэлтсүүд зохион байгуулдаг.

Үйлдвэрлэл дээрх сургалтыг Аймаг дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс сургалтын мэдээллийг ажил олгогч иргэдэд нээлттэй зарлан мэдээлэх ба сургалтанд хамрагдах иргэдийг бүртгэн авдаг. Мөн Ажлын байрыг дэмжих хөтөлбөр, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрүүдэд холбон зуучлах боломжтой.

Хөгжлийн бэрхшээлтэй 15-35 насны иргэдийн асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газрын харьяа салбар нэгжүүд, төрийн бус байгууллагын үйлчилгээ, хөдөлмөр халамжийн газар хэлтэст холбон зуучилна.

Залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг дэмжих чиглэлээр Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар хэлтэст холбон зуучилна.

Мөн орон нутгийн худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран ажиллаж зорилтот бүлгийн залуусын эдийн засгийн нөхцлийг сайжруулахаар бизнес эрхлэх санаа олгох сургалт, зээл, орлогын эх үүсвэрийн талаарх мэдээлэл олгоход хамран

дэмжлэг үзүүлнэ.

Эрүүл мэнд, Хууль зүйн үйлчилгээ, Боловсролын үйлчилгээнд холбон зуучлахдаа Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хамтарсан багт холбон зуучилж 15-18 насны өсвөр үеийнхнийг эрсдлээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлнэ.

Өсвөр үе залуучуудыг Нөхөн үржихүйн боловсрол, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд холбон зуучлахдаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн

дагуу орон нутгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагад дараах дэмжлэгийг хуулийн дагуу үзүүлэх боломжтой. Үүнд.

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн чиг үүргийн дагуу

6.1.3.харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

6.1.4.энэ хуулийн 6.2-т заасан жагсаалтын сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ хийх;

6.1.5.сум, тосгоны эрүүл мэндийн төв түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх. боломжтой.

Иргэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийг сонгон бүртгүүлэх, лавлагаа, шатлалын тусламж, үйлчилгээ авах

7.1.Монгол Улсын иргэн өөрийн оршин суугаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл бүхий өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийг сонгон үйлчлүүлнэ.

7.2.Орон нутгийн иргэн ойр байгаа нутаг дэвсгэрийн сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчийг сонгон үйлчлүүлж болно.

7.4.Иргэн өөрийн болон гэр бүлийн гишүүний эрүүл мэндтэй холбоотой асуудлаар өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчид хандах бөгөөд эмчийн заавар, чиглэлээр эрүүл мэндийн холбогдох бусад байгууллагад хандана.

7.5.Иргэн дараахь тохиолдолд эмнэлгийн лавлагаа, шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэг болон хөнгөвчлөх, асаргаа сувилгааны төвд шууд хандаж болно:

Энэ хуулийн дагуу үйлчилгээ авах боломжгүй өсвөр үе, эрсдэлт бүлгийн залуусын хуулийн дагуу үйлчилгээнд хамрагдах боломжоор ханган хамтарсан багт мэдээлэл өгч мэргэжлийн үйлчилгээнд холбон зуучилж болно.


Хууль зүйн тусламж үйлчилгээ. Хууль зүйн туслалцаа хүсэгч нь өмгөөлөгчид шууд хандаж хэлцэл хийх, эсхүл Хуульчдын холбоонд хүсэлт гарган тус холбоон дахь өмгөөлөгчдийн болон өмгөөллийн хуулийн этгээдийн нэр, хаягийн лавлагаанаас сонголт хийх замаар өмгөөллийн үйлчилгээ туслалцаа авах боломжтой.

Хууль зүйн туслалцаа хүсэгч нь эрүүл мэнд, төлбөрийн чадвар болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар өмгөөлөгчөө сонгон авч чадаагүй тохиолдолд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь энэ тухай Хуульчдын холбоонд мэдэгдэн өмгөөлөгч томилуулах арга хэмжээ авна. Өмгөөлөгч үйлчлүүлэгчийнхээ эд хөрөнгийн

Зан үйлд нөлөөлөх албадан сургалтаар ганцаарчилсан ба бүлгийн, хосолсон сургалт явуулдаг.

болон бусад байдлыг нь харгалзан түүнийг өмгөөллийн үйлчилгээний хөлснөөс чөлөөлж болно.

Зан үйлд нөлөөлөх албадан сургалт: Хорих ял болон захиргааны журмаар баривчлах шийтгэл хүлээсэн 15-35 насны залуусын зан үйл, сэтгэл зүйн чиг хандлагад нөлөөлөх, дахин хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлж нийгмийн хариуцлагатай ухамсарт иргэн болж төлөвшүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын харьяа нэгжүүд хариуцан захион байгуулах үүргийг Хууль зүйн дотоод хэргийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/73 дугаар тушаалаар багтлагдсан Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр батлагдсан. Үүнд дараах чиглэлийн сургалтанд хорихоос өөр төрлийн ял авсан өсвөр үе, залуусыг холбон зуучлах боломжтой тул энэ төрлийн сургалтыг давхцуулах шаардлагагүй.



Гэр бүлийн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд холбон зуучлах. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу “*Аймаг нийслэл, сум дүүргийн иргэдийн хурал*” харьяалагдах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх үүрэгтэй тул Салбар

зөвлөлийн хурлаар хэлэлцэж, хэрэгжүүлэх асуудлын хүрээнд залууст чиглэсэн соён гэгээрүүлэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг энэ хөтөлбөртэй холбон санхүүжилт авах боломжтой.

Хүний эрх, эрх чөлөө, эрх тэгш байдлыг хүндэтгэсэн, гэр бүлийн тэнцвэрт харилцааг дэмжсэн эерэг зан үйл, хандлагыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэнд хяналт тавих сурталчлах ажлыг зохион байгуулах үүрэг ГБХТТ хуулийн 16.1.1, хүчирхийллийг илэрхийлж, сурталчилсан агуулга бүхий соёл урлагийн арга хэмжээ, аливаа бүтээл, утга зохиолыг нийтэд түгээхээс урьдчилан сэргийлж хяналт тавих хязгаарлалт тогтоох үүргийн тус хуулийн 16.1.2-ийн дагуу Соёл урлагийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцдаг тул утга зохиол уран сайхны нэврүүлгийг дэмжин гэр бүлд зөвлөн туслах ажлыг соёл урлагийн газартай хамтран зохион байгуулж тэдний хөтөлбөрт хамруулах, үйлчилгээнд гэр бүлийг холбон зуучлах боломжтой.

Нийгмийн сайн сайхны төлөө залуучуудын гэр бүл төлөвлөлт, залуу гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн гишүүдийн эерэг харилцаа, уламжлал зан заншлын тухай утга зохиол уран сайхны шилдэг бүлээл шалгаруулах журмын дагуу зөвлөлийг байгуулж дэмжлэг үзүүлэх ажлыг хамтран шийдвэрлэнэ.

Зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээ²¹ нь мэргэжлийн байгууллага, хувь хүнтэй хамтран мэдээллийн сан үүсгэх, гэрээгээр болон мэргэжсэн ажилтан нар залуучуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдээлэл, арга зүй, зөвлөгөөгөөр хангах үйлчилгээ юм. Залуучуудад хувь хүний хөгжил, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй амьдрах орчин, оролцоо, хууль зүйн чиглэлээр үзүүлэх төрийн үйлчилгээ, эдгээрт хамрагдах нөхцөл, боломжийн талаар зөвлөгөө, мэдээллээр хангах зорилготой.

Өмгөөллийн үйлчилгээ шаардлагатай иргэдэд Хуульчдын эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу үйлчилгээнд холбоно.

Хөгжлийг дэмжих үйлчилгээ нь залуучуудад тулгарч болзошгүй эрсдэл, бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, тэднийг чадавхижуулах, бие бялдар, оюун санаа, сэтгэлгээг хөгжүүлэх, бүлгийн сэтгэлгээг дэмжих замаар нийгэмжсэн, төлөвшсөн хувь хүнийг бий болгоход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа юм.

²¹ХНХ-ын сайдын 2019 оны 3 дугаар сарын 05 ны өдрийн А/83 тушаалын хавсралт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг зохион байгуулах нэгдсэн удирдамж

Хөгжлийг дэмжих үйлчилгээг залуучуудын санаачилга, оролцоонд тулгуурлан хүргэнэ. Хөгжлийг дэмжих үйлчилгээ нь сонирхолын клуб, зөвлөл, бүлгийн үйл ажиллагааг дэмжих, хувь хүний хөгжлийг дэмжих, чөлөөт уулзалт, ярилцлага, гэр бүлийн боловсрол олгох зэрэг үйлчилгээний төрлөөр хэрэгжинэ.

Зорилтот бүлгийг чадваржуулах үйлчилгээ нь сургалт, нөлөөлөл, нийгэм сэтгэлзүйн дэмжлэг, сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх төрөл хэлбэртэй байна. Үүнд:

Сургалтын хувьд:

1. Амьдрах ухааны сургалт / Сургалтын модуль гарын авлагын дагуу хийнэ/
2. Залуу гэр бүлд чиглэсэн сургалт / Гэр бүл төлөвлөлт, харилцаа/
3. Өсвөр үе залууст соёл, боловсрол иргэний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр/
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр
5. Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх
6. Сайн дурын ажилтнуудыг чадваржуулах
7. Эх оронч үзэл, түүх соёл, зан заншлын сургалт
8. Мэргэжил сонголт
9. Залуучуудын хөгжлийн төвийн ажилтнуудад зориулсан цахим сургалт /Moodle.edu.mn хаягаар орж 20 төрлийн сургалтын бэлэн арга зүйг ашиглана.
10. Залуу малчдыг дэмжих сургалт

Нөлөөллийн үйл ажиллагааны хувьд:

1. Залуучуудыг бие даан амьдрах, нийгэм, эдийн засгийн эрсдэлээс хамгаалахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр зохион байгуулах
2. Залуучуудын соёл, боловсрол, иргэний үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах
3. Зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааг сайн дурынхны оролцоотойгоор зохион байгуулах
4. Олон нийтийн дэмжлэг, оролцоонд түшиглэн зохион байгуулсан ажил
5. Цахим номын сан
6. Залуучуудад чиглэсэн нөлөөллийн ажил /аян, өдөрлөг, тэмдэглэлт өдөр/

Нийгэм, сэтгэлзүйн дэмжлэгийн хувьд:

1. Эрх нь зөрчигдсөн залуусын эрх, нийгэмшил хөгжлийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа /Хорихоос суллагдсан, халамжийн төвөөс гэр бүлдээ эргэн нэгдсэн/
2. Хувь хүний болон нийгмийн ёс зүйн зөвлөгөө
3. Нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл зөвлөгөө /Хүсээгүй жирэмслэлт, халдварт өвчин, архи, мансуурлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр/

Сэтгэлзүйн тусламж, үйлчилгээний хувьд:

Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлэгч өсвөр үе, залуусын асуудлыг тодорхойлж зөвлөн туслах, дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, зан үйлийг засах бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөөний арга техникийг ашиглан үйлчилгээ үзүүлэх боломжтой. Мэргэшсэн сэтгэл зүйч хүүхэдтэй бүлгийн зөвлөгөөн хийснээр хүүхдийн зан үйл, нийгмийн харилцааны чадварыг үнэлэх, хүүхдэд өөрийн амьдралд болж байгаа үйл явдлыг ойлгоход туслах, зан байдал болон сэтгэл хөдлөлийн шинжтэй асуудлаа шийдвэрлэх, ухамсартай сонголт хийх, асуудлаа шийдвэрлэх чадварыг нэмэгдүүлэх боломжтой.

5.3.2 Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээний арга зүй, дараалал

Залуучуудын хөгжлийн үйлчилгээг үйлчлүүлэгчийн ялгаатай хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн залуучуудын хөгжлийн нийтлэг үйлчилгээ болон зорилтот бүлгийн залуучуудын хөгжлийн үйлчилгээ гэсэн ангиллаар өөр өөр арга зүй, зорилгын хүрээнд явуулж байна.

➤ Залуучуудын хөгжлийн нийтлэг үйлчилгээ

Залуучуудын хөгжлийн нийтлэг үйлчилгээний зорилго нь аль болох оновчтой зардлаар олон үйлчлүүлэгчид хүртээмжтэй, оролцоонд тулгуурласан залуучуудын хөгжлийн үйл ажиллагаа, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. Залуучуудын хөгжлийн нийтлэг үйлчилгээ нь зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээ, хөгжлийг дэмжих үйлчилгээ болон сайн дурын ажил үйлчилгээгээр дамжин хэрэгжинэ.

Залуучуудын хөгжлийн нийтлэг үйлчилгээний дараалал

- Залуучуудын нийтлэг үйлчилгээний төлөвлөлтийг өмнөх оны дөрөвдүгээр улиралд залуучуудын оролцоо, санаачилгад тулгуурлан ЗХТ боловсруулна.
- Төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохион байгуулах үүрэг бүхий нэгж, албан хаагч, гэрээний байгууллага ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулж хэрэгжүүлнэ.
- Залуучуудын санаачилгын үйл ажиллагаа, арга хэмжээг (сонирхолын клуб, зөвлөл, бүлэг, старт-ап үйл ажиллагаа, чөлөөт уулзалт, ярилцлага) зохион байгуулах арга, төлөвлөлтийг сонирхогч, оролцогч талууд хамтран боловсруулж, холбогдох албан тушаалтнаар батлуулж, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж зохион байгуулна.
- Тухайн ажил, үйлчилгээний үр дүнгийн тайланг боловсруулж, олон нийтэд нээлттэй танилцуулна.


Залуучуудын хөгжлийн нийтлэг үйлчилгээний зорилго нь аль болох оновчтой зардлаар олон үйлчлүүлэгчид хүртээмжтэй, оролцоонд тулгуурласан залуучуудын хөгжлийн үйл ажиллагаа, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. Залуучуудын хөгжлийн нийтлэг үйлчилгээ нь зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээ, хөгжлийг дэмжих үйлчилгээ болон сайн дурын ажил үйлчилгээгээр дамжин хэрэгжинэ.

➤ Зорилтот бүлгийн залуучуудын хөгжлийн үйлчилгээ

Зорилтот бүлгийн залуучуудын хөгжлийн үйлчилгээний зорилго нь зорилтот бүлгийн үйлчлүүлэгчийн залуучуудын хөгжлийн тэгш бус, хөгжлийн хоцрогдолтой байдлыг арилгах оролцоо, хөгжлийн ижил орчин нөхцөл бүрдүүлэхэд оршино. Зорилтот бүлгийн залуучуудын хөгжлийн үйлчилгээ нь холбон зуучлах болон зорилтот бүлгийг чадавхижуулах үйлчилгээгээр дамжин хэрэгжинэ.

Хөгжлийн бэрхшээлтэй залууст үзүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу чиг үүрэг бүхий байгууллага, иргэний нийгмийн байгууллагад холбон зуучилж, мэргэжил арга зүйн дэмжлэг авах хэрэгтэй.

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль дараах нэр томъёоны хүрээнд тодорхойлолт гаргаж ойлголтыг нэгтгэсэн зорилтот бүлгийг тодорхойлж өгсөн.



Зорилтот бүлгийн залуучуудын хөгжлийн үйлчилгээний ерөнхий төлөвлөлтийг хийхдээ тухайн харьяалах газар нутагт оршин суугаа зорилтот бүлгийн статистик тоог гаргаж, тэдний нэн тэргүүний тулгамдсан асуудлыг тодорхойлох замаар хийнэ.

Зорилтот бүлгийн залуучуудад үйлчилгээ үзүүлэх дараалал

- Зорилтот бүлгийн үйлчлүүлэгчид тавигдах аль нэг нөхцөл, шалгуур үзүүлэлтийг хангасан нөхцөлд ярилцлага хийх замаар нөхцөл байдлын үнэлгээг холбогдох албан хаагч хийнэ.

- Залуучуудын хөгжлийн үйлчилгээний баг хамтран тухайн үйлчлүүлэгчид кейсийн үзүүлэх төлөвлөгөө, үйлчилгээний хэлбэр, үргэлжлэх хугацаа, зардал зэргийг тодорхойлно.
- Үйлчлүүлэгчид кейсийн үйлчилгээний төлөвлөгөө, үйлчилгээ авах нөхцөлийг танилцуулж, хоёр тал хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан тохиолдолд үйлчилгээг томилогдсон кейс менежер үзүүлнэ.
- Кейсийн үйлчилгээний явц, үр дүнгийн талаар танилцуулга кейс менежер хийх бөгөөд кейсийн үйлчилгээ бүрэн дууссан нөхцөлд оролцогч талууд хүлээн зөвшөөрсөн гарын үсэг зурж, кейсийг хаана.

Кейсийн үйлчилгээг үзүүлэхдээ гэр бүл, хүүхэд, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн асуудал нэгж, байгууллага, харьяа хороо, сумын ЗДТГ-ын хамтран хамтарсан баг байгуулах замаар ажиллаж болно. Эдгээр байгууллагуудад албан бичгээр хандаж, хамтарсан тушаал гаргах замаар шийдвэрлэх боломжтой.

➤ Холбон зуучлах үйлчилгээний хүрээнд хүргэх нэмэлт үйлчилгээ

- Шаардлагатай нөхцөлд өмгөөлөгчийн болон хууль зүйн зөвлөгөөний төлбөрийг хариуцах
- Хөдөлмөр эрхлэлт болон боловсролын үйлчилгээнд хамруулах боломжгүй чадавхижуулах болон мэдлэг, ур чадвар олгох сургалтанд хамруулах
- Шаардлагатай эм, эмнэлгийн үйлчилгээний зардлыг төрөөс хариуцах
- Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй залуучуудад амьжиргааны дэмжлэг үзүүлэх


Дээрх нэмэлт үйлчилгээг зорилтот бүлгийн залуучуудад хөгжлийн цогц үйлчилгээг үр дүнтэй үзүүлэхэд шаардлагатай нөхцөлд үзүүлнэ. Нэг удаагийн үйлчилгээний зардлын хэмжээ, олгох нөхцөлийг нийгмийн халамжийн болон хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний зардлыг тоо хэмжээг судлах замаар холбогдох хууль болон дүрмэнд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ментор буюу зөвлөгч нарыг гэрээгээр ажиллуулах орчин үед чухал боловч хөдөлмөр эрхлэлтийн байгууллагатай хамтран шийдвэрлэх нь оновчтой.

ГБХЗХГ-аас Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээллээр хангах үйлчилгээг үзүүлэх хүн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай дүрэм журамд заасны дагуу мэргэшсэн зөвлөхийн эрхтэй хүн байх ёстой” гэж заасны дагуу 2020 оны 5-р сард

ЗХТ-ийн мэргэжилтнүүдээс мэргэшсэн зөвлөхийн сургалтад хамруулж, сертификаттай болгосон байна. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг Швейцарын хөгжлийн агентлагын гаргасан залуучуудын хөдөлмөрлөх ур чадварыг үнэлэх, хувийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг ашиглаж хуулийн хүрээнд энэ төрлийн үйлчилгээг хөдөлмөрийн асуудал хариуцсан байгууллагатай хамтран хэрэгжүүлэх гэдэг заалтын хүрээнд дээрх аргачлалыг ашиглаж хүмүүсээ сургасан ажээ.

Ажил мэргэжлийн зөвлөгөөг зорилтот бүлгүүдийн онцлог, нөхцөл байдлыг харгалзан дараах байдлаар үзүүлж болно. Тухайлбал, ажил мэргэжлийн нийгмийн сүлжээ, маркетинг, хөдөлмөр эрхлэлтийн кейс менежмент, зуучлал, ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөнд хамрагдах үйлчилгээнд өрөнд орсон хүмүүс, донтох эмгэг болон хамааралтай залуус, өрх толгойлсон залуус, хүчирхийлэлд өртсөн болон ажилгүй удаан хугацаанд байсан залуучуудын бүлэг тус тус хамаарна.



Зураг 4.1 Залуучуудтай холбоо тогтоох, зуучлагчаар дамжуулан үйлчилгээ үзүүлэх нь
Хөдөлмөр эрхлэх эсэх нь өнөөгийн хөдөлмөрийн насны хүн амын эрх хэмээн орхиж болохгүй бөгөөд, өнөөгийн хөдөлмөрийн насны идэвхитэй хүн амын дунд байгаа ажилгүйдэл бол хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэн болон боловсролын байгууллагаас бэлтгэж буй мэдлэг чадвар муутай боловсон хүчин хоорондын эрэлт нийлүүлэлтийн зөрчлийн үр дүн мөн. Амьжиргааны түвшин, орлого зэрэг эдийн засгийн байдлын хувьд хамгийн их гадуурхагдсан, баялгийн хуваарилалтаас хоцорсон бүлэг бол тэтгэвэрийн хөгшчүүд хийгээд амьдралд дөнгөж хөл тавьж байгаа

залуучууд болох нь олон тооны суурь судалгааны дүнгээр батлагдсан зүйл юм. Зах зээлийн нийгэмд шилжих үеийн эдийн засгийн хямрал, орлогын тэгш бус хуваарилалтад өртсөн бүлэг бол залуус, түүнчлэн ажилгүйдлийн эгнээнд олноор түрэн орогсод, шилжилтийн үеийн “архаг ядуурал”(угшмал ядуурал)-ыг өвлөн авагсад нь мөн л залуусын бүлэг билээ.

Залуучуудын хөгжил, оролцоог хангахын тулд юуны өмнө асуудалтай нөхцөл байдал хийгээд санал болгох үйлчилгээг нарийн төлөвлөх шаардлагатай.

Хүснэгт 4.1 Европ дахь залуучуудын асуудал ба үйлчилгээ

| Асуудалтай нөхцөл байдал | Санал болгох жишиг үйлчилгээ |
|--|--|
| Ажил хайгч залуус, тэдгээрийн хөдөлмөрийн чадварын байдал | Ажил зуучлах болон ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх агентууд Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн нийгэмлэг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллага, албад Цагаар ажил олгогч байгууллага Ажил олгогч |
| Орон байрны асуудал | Орон байр барих нийгэмлэг, компани Орон нутгийн орон сууцны асуудал хариуцсан алба Эмэгтэйчүүд/охидын байр Түрээсийн орон сууц-хөтөлбөр Орон сууцны бусад хөтөлбөр |
| Эрүүл мэндийн асуудал | Эрүүл мэндийн алба Мэргэжлийн эмч нар Хөдөлмөрийн эмнэлэг, магадлагааны алба Өөртөө туслах бүлэг |
| Өр зээлийн асуудал | Өрийн талаар зөвлөгөө Зээл олгох байгууллага Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага Асрамжийн газар Санхүүгийн бусад дэмжлэгүүд |
| Тусламж, дэмжлэгийн асуудал | Нийгмийн сүлжээг тодорхойлох Насанд хүрээд асрамжийн төвөөс гарч буй залуус үзүүлэх үйлчилгээ Филантропи ба сайн дурын үйлчилгээ |
| Интеграцिलाх | Шилжих хөдөлгөөн, бүртгэлийн алба Хотын дүүргийн төслүүд Чадавхийг дэмжих төвүүд Нийгэмлэгүүд |
| Нийгэм, сэтгэлзүйн асуудлууд | Эрүүл мэндийн газар Сэтгэлзүйн төвүүд Сэтгэцийн эрүүл мэндийн байгууллага Эрүүл мэндийн даатгалын газар Ажил мэргэжлийн зөвлөх үйлчилгээ Ажил мэргэжлийн уулзалтууд, бүлгүүд Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллага |
| Гэр бүлийн зөрчил | Залуучуудын тусламж Хотын залуучуудын, нийгмийн, гэр бүлийн үйлчилгээний төвүүд Орон нутгийн эцэг эхчүүдэд зориулсан хүмүүжлийн зөвлөгөө |
| Хүүхдийн асуудал | Хүүхдийн цэцэрлэг, сургууль |

| | |
|--------------------------|--|
| | Хүүхдийг асрах, өдөр өнжүүлэх төвүүд Эцэг эх, хүүхдийн өөртөө туслах бүлгүүд |
| Хамаарлын асуудал | Донтолтын үеийн зөвлөгөө Өөртөө туслах бүлгүүд |
| Ял шийтгэл | Шүүх эрх мэдлийн салбар дахь нийгмийн үйлчилгээ Хорих байгууллага болон түүнд ял эдэлж байсан хүмүүст үйлчилгээ үзүүлэх |
| Хөгжлийн бэрхшээл | Хөдөлмөрийн агентлаг Интеграцчилах болон мэргэжлийн үйлчилгээ Нийгэм, сэтгэлзүйн мэргэжлийн үйлчилгээ Мэргэжлийн байгууллага, холбоодын үйлчилгээ |

Эх сурвалж: Goeckler, R (2004) Fallmanagement und Netzwerkarbeit in der Beschaeftigungsfoerderung. Mannheim; Bundesagentur fier Arbeit

Хүснэгтэд дурдсан үйлчилгээний төлөвлөлт нь нөхцөл байдлын үнэлгээн дээр суурилан хийгддэг. Нөхцөл байдлын үнэлгээ нь бүхэлдээ үйлчлүүлэгчийн тулгамдсан асуудал болон хэрэгцээг тодорхойлоод зогсохгүй, үйлчлүүлэгчийн нөөц, боломжийг тодорхойлоход чиглэдэг.

Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн төвөөс гарсан залууст үзүүлэх үйлчилгээ. Асрамжийн газраас 18 нас хүрч гарч байгаа иргэнд нийгмийн халамжийн үйлчилгээ болон орон сууцаар хангах үйлчилгээг тэдний хүсэлтэнд суурилан үзүүлэх хэлбэр хөгжсөн улс орнуудад нийтлэг байна.

Америкийн Нэгдсэн Улс жил бүр Жон Х Чапегийн асрамжийн бие даасан хөтөлбөрөөр дамжуулан насанд хүрч асрамжаас гарч байгаа залуучуудад бие даасан амьдралд шилжүүлэхэд дэмжих үйлчилгээг үзүүлж байна. Энэ үйл ажиллагаанд жилд 140 сая ам долларын санхүүжилт олгодог байна. Тухайн санхүүжилтийн 30–аас дээш хувийг залуучуудад өрөө болон орон байраар түр хангахад зарцуулагдаж байна. Холбооны улсууд нь хөтөлбөрийн санхүүжилтийг зарцуулж байгаа бөгөөд холбооны улс залуучуудад жилд дунджаар 452 ам долларыг орон байрны тэтгэлэг үзүүлэхэд зарцуулж байна. Чапегийн сангийн хөрөнгийг холбооны улсууд ялгаатай ашиглаж байна. АНУ-д жилд ойролцоогоор 28000 залуу хүн асрамжийн газраас нийгмийн амьдралд шилжиж байна²².

Австри улсын хувьд хүүхэд, залуучуудын үйлчилгээ нь 18 насанд хүрсэн бол дуусахаар хуульчилсан байна. Гэхдээ зарим холбооны улсын хувьд 21 нас хүртэл үргэлжлэх

²²Housing Assistance for Youth Who Have Aged Out of Foster Care: The Role of the Chafee Foster Care Independence Program, Michael R. Pergamit, Marla McDaniel, Amelia Hawkins, 2012

боломжийг заасан байдаг. Гэхдээ 18 нас хүрсэн үйлчлүүлэгч төрөөс тавигдах шаардлагыг хангасан нөхцөлд 21 нас хүртэл үргэлжүүлэхээр байна. Тус улсад жилд дундажаар 200 хүүхэд асрамжийн газраас 18 насанд хүрч гарч байна²³.

ХБНГУ –д асрамжийн газраас насанд хүрч гарч байгаа иргэдийн халамжийн талаар хуулийн зүйн ямар тодорхойлолт байхгүй ч хэрэглээ нь нэмэгдэж байна. Залуу хүн 18-27 нас хүртэл залуучуудын халамжийн үйлчилгээнд үргэлжүүлэн хамрагдах боломжтой байдаг. Энэ заалт нь мөн асрамжийн газраас насанд хүрч гарч байгаа иргэд үйлчилнэ. Нийгмийн халамжийн хуулийн үйлчлэлийн хүрээ 18 нас хүртэлх өсвөр үеийнхэнд, өргөтгөсөн хөтөлбөр нь 21 нас хүртэл заасан байдаг. Онцгой тохиолдолд 27 нас хүртэл байхаар тусгажээ. Хуулийн хэрэгжилтийг орон нутгийн залуучуудын байгууллага болон бие даасан байгууллагууд хангаж байдаг. ХБНГУ-ын хувьд 18 насанд асрамжийн газраас гарсан иргэдийн орон байраар түр хангах үйлчилгээнд 18-20 насны 13247 иргэн, 21-26 насны 981 иргэн тус тус хамрагдсан байна.

Унгар улс нь 1997 онд баталсан Хүүхэд хамгааллын хуулиар асрамжийн дараах үйлчилгээ, арга, насны хязгаар, байршил, мэргэжлийн шаардлага зэргийг тодорхойлсон байдаг. Залуу хүн асрамжийн дараах үйлчилгээнд сайн дурын үндсэн дээр хамрагдах ба үүний тулд үйлчлүүлэгч болон үйлчилгээний байгууллага гэрээ байгуулна. Асрамжийн дараах үйлчилгээ нь 18-24 насныханд зөвлөгөө болон тусламж дэмжлэгийн хэлбэртэй нэг жил хүртэл хугацаатай үргэлжлэхээр байхаар хууьчилсан. Орон байрны дэмжлэг нь хүсэлт гаргасан нөхцөлд 30 нас хүртэл байж болно. Үйлчилгээнд хамрагдагч нь бие даан тогтвортой амьдрах боломжгүй залуу хүн, ажилгүй эсвэл орон сууцны байгууллагын зөвшөөрлийг хүлээж байгаа ажилтай болон суралцаж байгаа хүн байж болно. Унгар улсын хувьд 1600 залуу хүн асрамжийн дараах үйлчилгээнд жилд хамрагдаж байна. Эх сурвалжаас үзэхэд²⁴ Будапешт дахь Залуучуудын хөгжлийн төв нь 140 хүн хүлээн авах хүчин чадалтай, энгийн болон тэргэнцэртэй хүмүүст зориулсан 65 хос өрөө, дөрвөн давхар цогцолбор бөгөөд 100-200 хүнд зургаан хэл дээр нэгэн зэрэг орчуулах зориулалт бүхий дөрвөн уулзалтын өрөө, хурлын шаардлагад нийцүүлэн өрөөний зохион байгуулалтыг хийх боломжтойгоос гадна, жижиг бүлэг, интерактив боловсролын үйл ажиллагаанд зориулсан аудио, видео тоног төхөөрөмжөөр хангагдсан байдаг ажээ.

²³Leaving care and employment in five european countries:an undocumented problem? Clare Cameron, TCRU

²⁴ <https://www.coe.int/en/web/youth/eyc-budapest>

Монгол Улсын хувьд хүүхдийг асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг Гэр бүлийн тухай хуулийн 25 дугаар зүйлд, төрөлжсөн асрамжийн үйлчилгээний талаар Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд тус тус хуульчилсан байдаг. Түүнчлэн мөн хуульд төрөлжсөн асрамжийн үйлчилгээний байгууллагад асруулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан. 18 насанд хүрсэн асруулагчийг түүний харьяалах үндсэн захиргааны орон нутгийн байгууллагад шилжүүлэхээр зохицуулж байна.

Цаашид Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн зорилтот бүлгийн залуучууд тодорхойлолтыг өөрчлөх, мөн хуулийн 20.5.6 дугаар заалтанд зорилтот бүлгийн залуучуудад түр амьдрах орон байраар хангах, бие даан амьдрахад шаардлагатай зөвөлгөө, дэмжлэг хоёр талын байгуулсан гэрээний үндсэн дээр үзүүлэх тухай нэмж өөрчлөн тусгах шаардлагатай байна. Ингэснээр 18 нас хүрч асрамжийн газар, хорихоос суллагдаж гарч байгаа залуучууд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах эрх зүйн орчин бүрдэнэ.

2020 оны 07 сард ХНХЯ-наас Асрамжийн төвөөс гарсан залуучуудыг бие даан амьдрахад шаардлагатай тусламж, дэмжлэгийг үзүүлэх талаар хэрэгжүүлж буй ажлын нэг бол орон сууцыг зээл хэлбэрээр олгосон явдал юм. Залуучуудыг орон байраар түр хангах асуудал нь байнгын амьдрах орон сууцаар хангахаас ялгаатай бөгөөд 34 нас хүртэл гэрээний үндсэн дээр түр амьдрах орон байраар хангах үүргийг залуучуудын байгууллага хүлээхээр хуульчлах нь оновчтой.

5.4 ЗХТ-ийн үйлчилгээг анхан шатны нэгжид зохион байгуулах нь

Сумдад залуучуудын хөгжлийн төв байгуулахад тавигдах шаардлагыг судлан, сумын хэмжээнд ажиллах боловсон хүчин хүний нөөцийн чадамж, бусад төрийн албан хаагч хавсран гүйцэтгэх, тухайн албан хаагчийн цалин, нэмэгдэл олгох боломж, хийж хэрэгжүүлэх ажлын онцлогийг судлах

ЗХТ нь аймгийн төв болон дүүрэгт байрлаж байгаа бөгөөд үйлчлүүлэгчид засаг захиргааны анхан шатны нэгж болох сум, хороонд оршин сууж байна. Улаанбаатар хотын дүүргийн ЗХТ нь 50-60 мянган залуучууд үйлчилгээ үзүүлж байгаа бол аймгийн ЗХТ нь 50-300 км алслагдсан зайд тархсан 15-30 мянган залуучуудад үйлчилгээ үзүүлэх бодит байдалтай тулгарч байна. Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний

чанарыг сайжруулах зорилгоор сум, хороонд байгуулагдах залуучууд хөгжлийн төв нь залуучуудын хөгжлийн тодорхой үйлчилгээг хөтөлбөрт үндэслэн гэрээгээр хүргэх эрх зүйн зохицуулалт, санхүүжилтийг холбогдох хууль, дүрмэнд нэмж тусгах шаардлагатай юм. Ингэснээр салбар зөвлөл, ЗХТ нь хүүхэд хамгааллын хамтарсан багийн загвараар залуучуудад зорилтот бүлгийн үйлчилгээг хүргэх боломж бүрдэнэ.

Юуны өмнө үйлчилгээг залуучуудад ойртуулах зорилгоор залуучууд төвлөрсөн(их дээд сургууль, цэргийн анги, уул уурхай дагасан гм) томоохон суурьшлын бүсэд ЗХТ-ийг байгуулах нь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чухал алхам юм. Одоогийн байдлаар уул уурхай бүхий хүн ам ихээр төвлөрсөн Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сум, нийслэлийн Багануур дүүрэг дэх ЗХТ-үүд төсөв, зардлаа шийдвэрлэсэн, үйл ажиллагаа, үйлчилгээ тогтмолжсон, Өвөрхангай, Увс аймгуудад Хүүхэд, залуучуудын хөгжлийн нийгмийн ажилтны орон тоог батлан ажиллуулж байгаа сайн туршлага байна.

Үүний дараагаар үйлчилгээ үзүүлэх ЗХТ-ийг сумын төвд байгуулах ажлыг аймаг, дүүргийн жишиг загварт тулгуурлан хэрэгжүүлэх нь чухал юм. Одоогийн төсөв санхүүгийн нөөц, боломжоос хамаарч эхний ээлжинд аймгийн ЗХТ-ийг бэхжүүлэх, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан сумдад үйлчилгээг хавсран хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтнийг бэлтгэж болох юм. Сум, хороонд үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнийг өмнөх бүтцэд тулгуурлан бий болгох, шинээр бий болгох аль ч тохиолдолд нийгмийн ажилтан, сэтгэлзүйч, хуульчид чухал үүрэг гүйцэтгэх болно.

Солонгос Улсын залуучуудын хөгжлийн төвийн загвараас үзэхэд ихэвчлэн хотын захиргаа, аймгийн засаг захиргааны бүтцэд тулгуурлан, чиглэл хөтөлбөр боловсруулж үйл ажиллагааг төлөвлөдөг байна. Тухайлбал, Сөүл болон Дэгү хотын залуучуудын хөгжлийн төвийн хөтөлбөрөөс харахад хөгжлийн бодлогыг сайжруулах, нөхөрлөл, бүлгийг бэхжүүлэх, залуучуудын өсөлт хөгжлийг дэмжих, мэдээллийн дэмжлэг тусалцаа үзүүлэх үндсэн чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж байна. Эдгээр нь үндсэндээ хөгжилд чиглэсэн үйлчилгээний загвар ажээ.

Энэхүү загварыг жишээ болгон суманд бий болгох Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээг сумын онцлогт тулгуурлан хөтөлбөр хэлбэрээр явуулах нь зүйтэй байна.

Юуны өмнө сум, орон нутгийн захиргаа нь үйлчилгээний төсөл хөтөлбөрийг залуучуудын оролцоотойгоор төлөвлөж, олон талт хэрэгцээг тусгах хэрэгтэй бөгөөд

ингэснээр өргөн цар хүрээтэй, янз бүрийн үйл ажиллагаа явуулах боломжийг олгох болно. Ингэснээр ЗХТ-ийн жишиг загвар нь “асуудал төвт” бус “хөгжилд чиглэсэн” загвар байна.

Хүснэгт 4.2 Сум, орон нутагт залуучуудад чиглэсэн үйлчилгээг хүргэх нь

| Чиглэл | Хөтөлбөр |
|--|---|
| Залуучуудын хөгжлийн бодлогыг сайжруулах | Орон нутгийн нөөц, боломж бололцоог эрж хайх, амьдрах орон зайг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг өргөжүүлэх, залуучуудын амьдралд бодлогын хүртээмжийг нэмэгдүүлэх Тухайлбал, одоогийн нөхцөл байдлыг үнэлэх, судалгаа хийх, мэдээлэл солилцох, туршлага хуримтлуулах, хөтөлбөрийн жагсаалт гаргах гм. |
| Залуучуудын сайн дурын үйлчилгээг дэмжих | Залуучуудыг идэвхижүүлэх, нийгмийн оролцоог хангах, чөлөөт цаг өнгөрөөх, тогтвортой байдлыг хангах хөтөлбөрүүд Нийгэм, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд/ олон төрлийн бүлэгт чиглэсэн/ Байгаль орчны бохирдлыг бууруулах, гамшгаас хамгаалах хөтөлбөрүүд Журамд заасан бусад сайн дурын үйлчилгээ |
| Залуучуудын бүлэг, нөхөрлөлийн сүлжээг дэмжих | Залуучуудын үйл ажиллагааг дэмжих, төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцуулж, туршлага хуримтлуулахад туслах, албан ба албан бус сүлжээ үүсгэх Залуучуудыг идэвхижүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх гм. |
| Залуучуудын амьдрах чадварыг нэмэгдүүлэх | Залуу эцэг эхэд зориулсан хүүхэд хүмүүжүүлэх сургалт Мэргэжил сонголт, ажил мэргэжлийн зөвлөх үйлчилгээ Сум орон нутагт ажлын байр танилцуулах, ажлын байрны аян зохион байгуулах Гэр бүлийн зөвлөгөө, сургалт(гарааны бизнесийг дэмжих гм) |
| Залуучуудын өсөлт, хөгжлийг дэмжих, мэдээллээр хангах | Залуу гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл Залуусын нийгмийн оролцоо, үйл ажиллагааг дэмжих тэтгэлэг олгох Залууст чиглэсэн мэдээлэл, зар сурталчилгаа, олон нийтийн сүлжээний портал үүсгэх, үзэл бодлоо илэрхийлэх, санал бодлыг хүлээн авах |

Эх сурвалж: ЗХТ-ийн жишиг үйлчилгээний стандарт боловсруулах тайлан, УБ. 2019

Дээрх хүснэгтэд дурдсан ЗХТ нь асуудлыг цогц хэлбэрээр шийдвэрлэх, залуучуудын хөгжил, оролцоог дэмжихийн тулд орон нутгийн нөөц, хөгжлийн онцлогт тулгуурлан залуучуудыг илүү өргөн хүрээнд татан оролцуулах болно. Мөн орон нутгийн засаг захиргаа, ИНБ, хувийн хэвшил, залуучуудын байгууллагуудын хамтын түншлэлийн сүлжээ бий болгосноор, залуучуудыг дэмжих, оролцоог хангах чиглэлд ахиц дэвшил авчрах болно.

- ① Сум орон нутагт залуучуудын амьдрах орон зайг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг урамшуулах, ажлын байрыг өргөжүүлэх, залуучуудын амьдралд бодлогын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор одоогийн нөхцөл байдлыг үнэлэх, судалгаа хийх, мэдээлэл солилцох, туршлага хуримтлуулах замаар цаашид хэрэгжүүлэх хөтөлбөрийн жагсаалт гаргах зайлшгүй шаардлагатай. Үүнд тулгуурлан сум орон нутагт ЗХТ-ийн үйл ажиллагааны ерөнхий чиг, хөтөлбөр, төлөвлөгөө гарах болно. 2018 онд ГБХЗХГ-аас хариуцаж, “Залуучуудын мэдээллийн санг бүрдүүлж, хөтлөх журам”-ыг УБЕГ, ҮСХ-той хамтран баталж, хэрэгжүүлж байгаа юм²⁵. Тухайн журамд тулгуурлан ГБХЗХГ-аас залуучуудын боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт зэрэг 8 бүлгийн 129 үзүүлэлтийн арга зүйг тусгаж, 2018 оны тоон мэдээллийг 16 маягтаар бүх аймаг, дүүргээс авч нэгтгэх эхлэл тавигдсан боловч хэрэглээ хязгаарлагдмал, сум хорооны онцлог, нөхцлийг үнэлэхэд хангалттай мэдээллийн сан болж чадахгүй байна.
- ② Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх баталгаажуулах журам²⁶ батлагдсанаар ЗХТ-ийн үйлчилгээний жишиг загварыг хэрэгжүүлэхэд чухал алхам болж байна. Тус журмын 5.5-д зааснаар, Залуучуудыг сайн дурын ажилд уриалах, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах, сайн дурын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх зэрэг арга хэмжээг орон нутгийн ЗХТ хариуцан гүйцэтгэхээр заасан юм. Цаашид төрийн зүгээс зайлшгүй дэмжих сайн дурын үйл ажиллагаа, түүнийг хэн зохион байгуулах, оролцоог хэрхэн хангах, урамшуулал, зардлыг тооцох зохицуулалтыг журмаар тусгаж өгөх хэрэгтэй. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 11.1.10 болон тухайн журмыг хэрэгжүүлэхтэй уялдуулан нийтэд тусгай ажилд манлайлан оролцсон болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хамрагдсан залуучуудын хувьд төрийн албан тусгай шалгалтын удирдан зохион

²⁵ ҮСХ, ГБХЗХГ, УБЕГ. Залуучуудын мэдээллийн санг бүрдүүлж, хөтлөх журам. 2019 оны 06 сарын 18-ны өдрийн ҮСХ А/95, ГБХЗХГ А/171, УБЕГ А/681 тоот хамтарсан тушаал.

²⁶ ХНХЯ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/130-р тушаал

байгуулах, манлайлах, багаар ажиллах чадварын шалгалтын үнэлгээнд давуу байдалд тооцох зохицуулалтыг Төрийн албаны зөвлөлийн “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д тусгасан²⁷ юм.

- ③ Өмнө дурдсан чиглэлд тулгуурлан сум, орон нутгийн өсвөр үе, залуучуудыг хүсэл сонирхол, үйл ажиллагаа, сайн дурын оролцоогоор нэгдэх, хамтрах, бүлэг, нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулах, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны сүлжээг бэхжүүлэхэд ЗХТ чухал үүрэг гүйцэтгэх болно. Мөн орон нутгийн залуучуудын бүлэг сүлжээг www.mergejl.mn, www.ajil.mn, JOBNET.mn зэрэг мэдээллийн болон нийгмийн сүлжээнд холбон зуучлах, залуучуудын идэвхи оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр онлайн, ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгөх хөтөлбөрүүдийг хийж хэрэгжүүлэх шаардлагатай.
- ④ Анхан шатны нэгжид ЗХТ-өөс үзүүлэх жишиг үйлчилгээний чухал бөгөөд салшгүй хэсэг бол Залуучуудын амьдрах ур чадварыг нэмэгдүүлэх чиглэл болно. Өнөөгийн байдлаар энэ чиглэлд эрхлэн явуулж буй амьдрах ухааны сургалтыг одоогийн агуулгаас нэмэгдүүлж хүмүүжил төлөвшил, харилцаа хандлага олгохоос илүү өргөн хүрээнд, насны онцлогт тулгуурлан явуулах шаардлагатай. Амьдрах ур чадвар олгох нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн дадлага хийх, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, ажил хайх бүлэг, хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө, зуучлал зэрэг олон талын сургалт, зөвлөгөө, нөлөөллийн цогц үйл ажиллагааг хамрах болно. Өнөөгийн ажилгүйдэлд өртөж болзошгүй, ажил олоход хүндрэлтэй зорилтот бүлгийн залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, түр ажлын байраар хангах, залуучуудын гарааны бизнесийг дэмжих, мэдээлээр хангах, сонгон шалгаруулах чиглэлээр орон нутгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтарч ажиллах хэрэгтэй.
- ⑤ Залуучуудын өсөлт хөгжлийг дэмжих, мэдээллээр хангах хүрээнд залууст чиглэсэн мэдээлэл, зар сурталчилгаа, олон нийтийн сүлжээний портал үүсгэх, үзэл бодлоо илэрхийлэх, санал бодлоо солилцох зэрэг мэдээллийн урсгалыг хангах болно. Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах хүрээнд гэрлэх ёслол, гэр бүлийг эвлэрүүлэн зуучлахтай холбоотой мэдээлэл сургалт хийх, хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлвэл зохино.

²⁷ ТАЗ. Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам. 2019 оны 14 дүгээр тогтоол, 1-р хавсралт

Энд дурдсан хөтөлбөр, арга хэмжээг Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөртэй нийцүүлэхийн зэрэгцээ Төсвийн тухай хуульд тусгасан Төсвийн тухай хуулийн зүйл заалттай/6.6.5/ уялдуулах ёстой юм.

Сум, орон нутагт үйлчилгээ үзүүлж буй ЗХТ-ийн жишиг загварт тулгуурлан авч үзвэл анхан шатны нэгжид төрийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэхэд залуучуудын салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, салбар дундын үйлчилгээг уялдуулж, зохицуулах замаар үйлчилгээг тогтвортой болгох нь ихээхэн чухал байна.

ЗХТ-ийн одоогийн үйлчилгээний нэр төрөл хэт олон, төрийн бусад үйлчилгээтэй давхцсан нөхцөл байдлыг халахын тулд үйлчилгээг нөхцөл байдалд тулгуурласан, тодорхой хөтөлбөр хэлбэрээр хүргэх нь чухал юм. Сум, орон нутагт ЗХТ-д ажиллах боловсон хүчин, мэргэшсэн хүний нөөцийн чадамж сул, дутагдалтай байна. Энэ талаар зөвлөх үйлчилгээний ажлын байрны чиг үүргийн шинжилгээнд тусгагдсан болно.

Залуучуудын хөгжлийн бодлогын тогтолцоонд хөдөлмөр эрхлэлтийн бодлого үндсэн хөтөлбөр байх бөгөөд зорилтот бүлгийн залуучууд болон их сургуулийн оюутнуудад түлхүү чиглэх учиртай.

Дээр дурдсан хөтөлбөрийн хүрээнд үзүүлэх үйлчилгээний зэрэгцээ хөтөлбөр бус байдлаар зайлшгүй үзүүлэх үр нөлөө бүхий хагас мэргэжлийн үйлчилгээ болон хэрэгцээ шаардлагатай үндсэн үйлчилгээг тус бүр тодорхойлох шаардлагатай.

4.3 Хөтөлбөрийн бус хэлбэрээр үзүүлэх үйлчилгээнүүд

| | |
|------------------------|---|
| Сургалт | 12 модуль сургалтын агуулга тодорхой утгаараа шинэчлэгдэж байна, гэхдээ агуулгыг цаашид өргөжүүлэх хэрэгцээ шаардлага байна. Тухайлбал, Ажилд орох ярилцлага, CV бичих гм сэдвүүдийг нэмж оруулах, агуулгыг баяжуулах шаардлагатай. |
| Зөвлөгөө | Бүлгийн болон ганцаарчилсан зөвлөгөө үзүүлэх, бизнес хийх, асуудлыг шийдвэрлэх арга зүйн зөвлөгөө |
| Холбон зуучлал | Ажил эрхлэлт, хорихоос суллагдсан, гэмт хэрэгт холбогдсон, хамааралтай болсон залуучуудад чиглэсэн үйлчилгээ Асрамж халамжийн төвөөс би даан амьдарч буй залуучуудад зориулсан үйлчилгээ |
| Нөлөөллийн ажил | Залуучуудыг соён гэгээрүүлэх Зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх |

Сайн дурын үйлчилгээ Сайн дурын ажилтан бэлтгэх, бүртгэх, баталгаажуулах

Номын сангийн үйлчилгээ Ном, цахим номын сангийн үйлчилгээ

Хөтөлбөрийн бус хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний хувьд үндсэн биш мэргэжлийн үйлчилгээг аль болох бага, харин үр нөлөө бүхий хагас мэргэжлийн үйлчилгээг түлхүү үзүүлвэл зохино.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Захиалгат судалгааны хүрээнд явуулсан асуумж судалгаа, хөтөлбөрийн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээнд тулгуурлан үндсэн дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Манай улсын хувьд залуучуудын нийгэм, улс төрийн зохистой оролцоо анхаарал татсан асуудал болоод байна. Сүүлийн жилүүдэд явагдсан судалгаа, сонгуулийн үр дүнгээс харахад 18-25 насны залуучуудын улс төрийн оролцоо эрс буурсан үр дүн ажиглагдаж байна. Гиймээс залуучуудын улс төрийн оролцоог дээшлүүлэхэд чиглэсэн бодит үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгаа, арга зүйг бий болгох шаардлагатай байна.
- Залуучуудын нийгэм, улс төрд оролцох шалтгааны талаарх байр суурь харилцан адилгүй байна. Энэхүү судалгаанд оролцсон залуучуудын хувьд улс төрд оролцох шалтгаан бол улс орноо хөгжүүлэх, үзэл бодлоо илэрхийлэх талбар гэж үзэх нэгэн байхад ихэнх нь нийгэмд эзлэх байр сууриа ахиулах, авлига авах, ашиг хонжоо хайх, амьдрал ахуйгаа өөд татах боломж гэж үзэх нэгэн байна.
- Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт залуучуудын хөгжлийн талаар Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийг баталж, хэрэгжилтийг хангах, Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх, залуу гэр бүлийг орон сууцжуулах, орон сууцны түрээсээ урьдчилгаанд тооцуулах журам гаргах, “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг олон арга хэмжээг төлөвлөн эхлүүлсэн байна. Мөн хуулийг хэрэгжүүлэх хүрээнд залуу аавд цалинтай чөлөө олгох, үлгэр яриулах, “гэдэстэй” аав, асрамжийн газраас бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх зорилгоор залуучуудад түрээсийн орон сууцны туслалцаа үзүүлэх зэрэг залууст ээлтэй олон үйлчилгээг эхлүүлж, эдгээр үйлчилгээ нь залуусын амьдралд бодит үр дүнгээ өгч байна.
- Залуучуудын оролцоо нь онолын үүднээс залуу хүмүүст улс төр, нийгэм эдийн засгийн бүхий л хүрээний шийдвэр гаргах, төлөвлөх түвшний үйл ажиллагаанд оролцох боломжийг олгосноор тэдний нөөц боломжийг нээн илрүүлэх, тэдэнд нийгмийн бусад хэсэгт нөлөөлөх боломжийг олгох явдал ажээ.
- Монголын залуучуудад тулгамдаж буй нийгмийн асуудлууд бол ажилгүйдлээс улбаатай орлогын хомсдол, хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадварыг боомилж буй чанаргүй боловсрол, эдгээрээс үүдэлтэй нийгэм, эдийн засгийн баталгаагүй байдал мөн.

-
- Судалгааны үр дүнгээс үзэхэд өнөөгийн залуу эрэгтэйчүүдийн дундаж өндөр 177.3, биеийн жингийн дундаж 78.3кг байгаа бол залуу эмэгтэйчүүдийн дундаж өндөр 169.1, биеийн жин 67.7 кг байна.
 - Монгол Улсын хүн амын дундаж өндөр ба жингийн статистик үзүүлэлттэй харьцуулахад өнөөгийн залуучуудын дундаж өндөр ойролцоогоор 4 см-ээр өндөр, дундаж жингээс 4.6 кг-аар илүү байна.
 - Хэдийгээр биеийн өндөр ба жингийн харьцааны үзүүлэлт боломжийн түвшинд байгаа боловч Ковид-19 цар тахлын дараах нөлөөлөл болох цус өтгөрөх, даралт ихсэх гэх мэт өвчлөлийн шинж тэмдгүүд тохиолдож байгаа талаар залуучууд тэмдэглэж байна.
 - Судалгаанд оролцсон залуус ёс суртахуун, хүмүүжил төлөвшил, соёл, шашин, түүх, гэр бүлийн хүрээний үнэт зүйлсийн утга агуулгыг тайлбарлаж, үнэ цэнтэй зүйлээ эрхэмлэх нь хувь хүний болон нийгмийн хөгжил дэвшлийг хангах суурь хүчин зүйл болно гэдгийг тэмдэглэсэн байна.
 - Өнөөгийн залуус бол уламжлалт өв соёл, түүхэн өвийг эцэг эх, өвгөд дээдсээс тээн хөгжүүлж, ирээдүй хойчдоо залгамжлуулан үлдээх чухал хариуцлагатай үүргийг хүлээж, басхүү эзэмшиж байна.
 - Хэдийгээр залуучуудын түүхэн ухамсар, соёлын хөгжилд төлөвшилд нийгмийн анхдагч үүр болох гэр бүлийн хүмүүжил, оролцоо чухал боловч төрийн бодлого, шийдвэрт үнэт зүйлсийг шингээсэн үзэл баримтлалыг суулгах нь нэн чухал байна.
 - Өнөөгийн залуусын түүх соёлын хөгжлийг хангахын тулд хүүхдийн хүмүүжил, төлөвшилд багаас нь анхаарч чадвал үнэт зүйлийн чиг баримжаа баттай тогтох үндэс суурь бүрдэх болно.
 - Нийслэл, аймгийн хэмжээнд Залуучуудын хөгжлийн төвөөс хэрэгжүүлж ирсэн үйлчилгээний чиглэлийг авч үзэхэд хувь хүний хөгжлийг дэмжих сургалтууд, биеийн тамир спортын арга хэмжээ, нөлөөллийн аян, арга хэмжээг голлон хэрэгжүүлсэн байна.
 - ЗХТ-ийн үйл ажиллагаа тогтвортой биш, төсөв санхүүгийн хувьд хомсдолтой, ажиллагсадын цалин хангамж тааруу, төрөөс үзүүлж буй зарим үйлчилгээ давхардалтай, институт хоорондын уялдаагүй байдал үйлчилгээний чанарт таагүй нөлөө үзүүлж байгаа бол, нөгөө талаас төвийн байршил, үйлчлүүлэгчийн тоо, шилжих хөдөлгөөн зэрэг хүчин зүйлс үйлчилгээг хүртээмжтэй хүргэхэд сөрөг нөлөөтэй байна.

-
- Өнгөрсөн хугацаанд ЗХТ-ийн хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагааг бүхэлд нь дүгнэж үзэхэд бүгдийг нь биш ч заримыг нь шийдвэрлэх, шийдэх чиглэлээр ажиллаж тодорхой үр дүнд хүрсэн байна.
 - Гарааны бизнесийг дэмжих үйлчилгээг ЗХТ-өөс хэрэгжүүлэх боломжтой ч мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар дутмаг, нөгөө талаар хөдөлмөрийн хэлтэс энэхүү чиг үүргийг хэрэгжүүлж байгаа юм.
 - Аймгийн ЗХТ тус бүрт 2019 оны үйлчилгээний зардалд 4 сая төгрөг, улиралд 1 сая төгрөг, дүүргийн ЗХТ-д улиралд 2 сая төгрөг тус тус хуваарилсан байна. Энэ зардлаас зарим ЗХТ-ийн бичиг хэргийн зардлыг гаргаж байгаагийн зэрэгцээ хуулинд заасан үйлчилгээг үзүүлэхэд тухайн зардал огтхон ч хүрэлцэхгүй байна.
 - ЗХТ-өөс долоон чиглэлийн 20 гаруй үйлчилгээг үзүүлэхээр хуулинд заасан боловч бодит байдал дээр үндсэн ба нэмэлт хэлбэрээр, хуулинд тусгагдаагүй 50 гаруй үйлчилгээг гэрээт хэлбэрээр үзүүлж байгаа нь үйлчилгээг чанаргүй, тогтвортой биш хүргэхэд нөлөөлөхийн зэрэгцээ ажиллаж буй мэргэжилтнийг албан тушаалын хувьд “эрх мэдэлгүй” байдалд хөтөлж байна.
 - Аймаг, дүүргийн ГБХЗХГ-ын дарга, ЗХТ-ийн мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас үзэхэд Залуучуудын хөгжлийн ордон, хөдөлмөр эрхлэлт, старт-ап, АМЧБО, эрүүмэндийн нөхцөн үржихүйн сургалт, боловсрол, шинжлэх ухаан, сайн дурын үйл ажиллагаа, сонирхлын клуб, хувь хүний хөгжил амьдрах ухааны ажлуудаа дагнаж хийдэг жишиг төвүүд байхад төрийн нэг байгууллагын хажууд дайвар маягтай оршиж, зөвхөн сургалт, нөлөөллийн ажил болон бусад хуулинд тусгагдаагүй ажлыг хийдэг мэргэжилтэн, төвүүд ч байна.
 - Аймаг, дүүргийн ЗХТ-ийн үйлчилгээний туршлагаас харахад залуучуудад чиглэсэн үйлчилгээнд үндсэн биш салбарын үйлчилгээ давамгайлах, салбар зөвлөлийг удирдаж буй эрх мэдэлтний хүсэл сонирхол, идэвх оролцоо сул байх, хэлтсийг удирдаж буй хүмүүсийн санаачилга, үйл ажиллагаа зэргээс тухайн салбарын үйлчилгээ хүртээмжтэй, чанартай, нийцтэй байх нь шууд хамаарч байна.
 - Одоогийн үйлчилгээний нөхцөл байдлыг авч үзэхэд сайн дурын үйлчилгээ нь ЗХТ-ийн үйлчилгээний салшгүй хэсэг болжээ. Тухайлбал, өнгөрсөн хугацаанд гамшиг онцгой нөхцөл байдлын сайн дурын үйлчилгээ бол төрийн бусад үйлчилгээтэй давхцалгүй, олон нийтэд түшиглэсэн өвөрмөц үйлчилгээ болж чадсан байна.

Зөвлөх үйлчилгээний хүрээнд хийсэн судалгааны үр дүн, дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг санал болгож байна.

- Бодлого боловсруулагчид дангаараа үйл ажиллагаа явуулж буй залуучуудын байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, тэднийг холбогдох удирдах шатны байгууллагуудтай хамтарч ажиллахад туслах чиглэлд анхаарах нь чухал байна.
- Зөвхөн улс төрийн оролцоо гэлтгүй нийгмийн бусад бүхий л салбарыг хамарсан оролцоог дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийн тухай гадны улс туршлагаас судлах шаардлагатай.
- Залуучуудын хөгжлийн төвийн үйлчилгээний стандарт боловсруулахдаа судалгаанд тулгуурлаж, орон нутагт турших замаар үр дүнд суурилсан үйлчилгээ ба жишиг зардлын тооцооллыг тогтоох нь өнөөгийн нөхцөлд зайлшгүй чухал юм.
- Шинэ, залуу гэр бүлд сургалт, зөвлөгөө үзүүлдэг байх нь ЗХТ-ийн үндсэн үйлчилгээний нэг хэсэг байх болно. Гэр бүлд бэлтгэх, хуримын өмнөх гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн хүрээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх сургалтууд тухайн үйлчилгээний нэгээхэн хэсэг байх учиртай.
- ЗХТ-ийн үйлчилгээ ХХҮЕГ-аас үзүүлж буй сургалт, мэргэжил сонголт, хөдөлмөр зуучлалын үйлчилгээтэй олон талаар, халамжийн үйлчилгээтэй зарим талаар давхцаж байна. Иймд ЗХТ-өөс үзүүлж буй одоогийн үйлчилгээний нэр төрлийг багасгах, төрийн байгууллагын бусад үйлчилгээтэй уялдуулах шаардлагатай.
- Залуучуудын хөгжлийн бодлогын тогтолцоонд хөдөлмөр эрхлэлтийн бодлого үндсэн хөтөлбөр байх бөгөөд зорилтот бүлгийн залуучууд болон их сургуулийн оюутнуудад түлхүү чиглэх учиртай.
- Зорилтот бүлгийн залуучуудын хувьд сэжигтэн яллагдагчаар татагдсан үед хүмүүжлийн сургалт, зөвлөгөө үзүүлэх, мөн асрамжийн төвөөс гарсан залуучуудыг амьдрах орон сууц, гэрээр хангах нь ЗХТ-ийн нэгэн үндсэн үйлчилгээ байх болно.
- Ихэнх залуучуудын хувьд Хөдөлмөр халамжийн газраас ямар үйлчилгээ авах талаар сайн мэдэхгүй байна. Иймд тухайн залуучуудыг хөдөлмөр, халамжийн газраас ямар үйлчилгээ авах талаар урьдчилан мэдээлэх, сургалтад хамруулах, чадавхижуулах нь залуучуудын хөгжлийн төвөөс үзүүлэх нэгэн чухал үйлчилгээ байж болохоор байна.
- Мөн нөхцөл байдалд нийцсэн сумдын залуучуудад үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмж оруулах шаардлагатай. Гэхдээ энэхүү үйлчилгээг Солонгосын Залуучуудын

хөгжлийг дэмжих загвартай адил хэлбэрээр ерөнхий чиглэлийн хүрээнд хөтөлбөр байдлаар хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй.

|---------|-------------|---------|-------|------------|--------------------|
| Бодит | Хангалтгүй | 308 | 15.2 | 16.4 | 16.4 |
| | Дунд зэрэг | 1009 | 49.9 | 53.8 | 70.2 |
| | Хангалттай | 464 | 22.9 | 24.7 | 94.9 |
| | Үлгэр жишээ | 95 | 4.7 | 5.1 | 100.0 |
| | Нийт | 1876 | 92.7 | 100.0 | |
| Missing | Хариулаагүй | 148 | 7.3 | | |
| Нийт | | 2024 | 100.0 | | |

53.10 Мэргэжил, ур чадварын

| | | Давтамж | хувь | Бодит хувь | Хуримтлагдсан хувь |
|---------|-------------|---------|------|------------|--------------------|
| Бодит | Хангалтгүй | 208 | 10.3 | 11.0 | 11.0 |
| | Дунд зэрэг | 959 | 47.4 | 50.7 | 61.7 |
| | Хангалттай | 602 | 29.7 | 31.8 | 93.5 |
| | Үлгэр жишээ | 123 | 6.1 | 6.5 | 100.0 |
| | Нийт | 1892 | 93.5 | 100.0 | |
| Missing | Хариулаагүй | 132 | 6.5 | | |

| | | |
|------|------|-------|
| Нийт | 2024 | 100.0 |
|------|------|-------|

53.11 Зориг, тэвчээр, хатуужил

| | | Давтамж | хувь | Бодит хувь | Хуримтлагдсан хувь |
|---------|-------------|---------|-------|------------|--------------------|
| Бодит | Хангалтгүй | 298 | 14.7 | 15.7 | 15.7 |
| | Дунд зэрэг | 962 | 47.5 | 50.7 | 66.5 |
| | Хангалттай | 516 | 25.5 | 27.2 | 93.7 |
| | Үлгэр жишээ | 120 | 5.9 | 6.3 | 100.0 |
| | Нийт | 1896 | 93.7 | 100.0 | |
| Missing | Хариулаагүй | 128 | 6.3 | | |
| Нийт | | 2024 | 100.0 | | |

а54_1 Та ихэвчлэн ямар чиглэлийн мэдээлэл илүүтэй сонирхдог вэ

| | | Давтамж | хувь | Бодит хувь | Хуримтлагдсан хувь |
|---------|-------------------------------|---------|-------|------------|--------------------|
| Бодит | Ажил мэргэжилтэй холбоотой | 1156 | 57.1 | 59.0 | 59.0 |
| | Улс төр, бизнесийн | 193 | 9.5 | 9.9 | 68.9 |
| | Нийгэм, ёс суртахууны | 264 | 13.0 | 13.5 | 82.4 |
| | Шинжлэх ухаан, танин мэдэхүйн | 228 | 11.3 | 11.6 | 94.0 |
| | Урлаг уран сайхны | 117 | 5.8 | 6.0 | 100.0 |
| | Нийт | 1958 | 96.7 | 100.0 | |
| Missing | Хариулаагүй | 66 | 3.3 | | |
| Нийт | | 2024 | 100.0 | | |

а54_2 Та ихэвчлэн ямар чиглэлийн мэдээлэл илүүтэй сонирхдог вэ

| | | Давтамж | хувь | Бодит хувь | Хуримтлагдсан хувь |
|---------|-------------------------------|---------|-------|------------|--------------------|
| Бодит | Ажил мэргэжилтэй холбоотой | 6 | .3 | .4 | .4 |
| | Улс төр, бизнесийн | 165 | 8.2 | 11.7 | 12.1 |
| | Нийгэм, ёс суртахууны | 294 | 14.5 | 20.8 | 32.9 |
| | Шинжлэх ухаан, танин мэдэхүйн | 505 | 25.0 | 35.7 | 68.6 |
| | Урлаг уран сайхны | 443 | 21.9 | 31.4 | 100.0 |
| | Нийт | 1413 | 69.8 | 100.0 | |
| Missing | Хариулаагүй | 611 | 30.2 | | |
| Нийт | | 2024 | 100.0 | | |

а55 Та өөрийн сонирхсон мэдээллийг бүрэн олж авч чаддаг уу

| | | Давтамж | хувь | Бодит хувь | Хуримтлагдсан хувь |
|-------|----------------------|---------|------|------------|--------------------|
| Бодит | Бүрэн олж авч чаддаг | 380 | 18.8 | 19.6 | 19.6 |

| | | | | | |
|---------|----------------------------------|------|-------|-------|-------|
| | Ер нь олддог | 822 | 40.6 | 42.3 | 61.9 |
| | Зарим мэдээллийг олоход төвөгтэй | 593 | 29.3 | 30.5 | 92.4 |
| | Бараг олддоггүй | 77 | 3.8 | 4.0 | 96.4 |
| | Боломж байдаггүй | 70 | 3.5 | 3.6 | 100.0 |
| | Нийт | 1942 | 95.9 | 100.0 | |
| Missing | Хариулаагүй | 82 | 4.1 | | |
| Нийт | | 2024 | 100.0 | | |

а56_1 Өндөр

| | | Давтамж | хувь | Бодит хувь | Хуримтлагдсан хувь |
|-------|------|---------|-------|------------|--------------------|
| Бодит | 165 | 125 | 6.2 | 6.2 | 6.2 |
| | 166 | 148 | 7.3 | 7.3 | 13.5 |
| | 167 | 178 | 8.8 | 8.8 | 22.3 |
| | 168 | 381 | 18.8 | 18.8 | 41.1 |
| | 169 | 122 | 6.0 | 6.0 | 47.1 |
| | 170 | 270 | 13.3 | 13.3 | 60.5 |
| | 171 | 68 | 3.4 | 3.4 | 63.8 |
| | 172 | 22 | 1.1 | 1.1 | 64.9 |
| | 173 | 32 | 1.6 | 1.6 | 66.5 |
| | 174 | 30 | 1.5 | 1.5 | 68.0 |
| | 175 | 52 | 2.6 | 2.6 | 70.6 |
| | 176 | 18 | .9 | .9 | 71.4 |
| | 177 | 36 | 1.8 | 1.8 | 73.2 |
| | 178 | 154 | 7.6 | 7.6 | 80.8 |
| | 179 | 69 | 3.4 | 3.4 | 84.2 |
| | 180 | 100 | 4.9 | 4.9 | 89.2 |
| | 181 | 19 | .9 | .9 | 90.1 |
| | 182 | 8 | .4 | .4 | 90.5 |
| | 183 | 32 | 1.6 | 1.6 | 92.1 |
| | 184 | 33 | 1.6 | 1.6 | 93.7 |
| | 185 | 41 | 2.0 | 2.0 | 95.8 |
| | 186 | 23 | 1.1 | 1.1 | 96.9 |
| | 187 | 18 | .9 | .9 | 97.8 |
| | 188 | 40 | 2.0 | 2.0 | 99.8 |
| | 189 | 1 | .0 | .0 | 99.8 |
| | 190 | 1 | .0 | .0 | 99.9 |
| | 191 | 2 | .1 | .1 | 100.0 |
| | 192 | 1 | .0 | .0 | 100.0 |
| | Нийт | 2024 | 100.0 | 100.0 | |

| Дундаж өндөр | | | | |
|--------------|---------|---------|--------|----------------|
| N | Minimum | Maximum | Mean | Std. Deviation |
| 2024 | 165 | 192 | 172.20 | 6.277 |

| а56_1 Жин | | | | |
|-----------|---------|------|------------|--------------------|
| | Давтамж | хувь | Бодит хувь | Хуримтлагдсан хувь |
| Бодит 52 | 66 | 3.3 | 3.3 | 3.3 |
| 56 | 66 | 3.3 | 3.3 | 6.5 |
| 60 | 148 | 7.3 | 7.3 | 13.8 |
| 61 | 10 | .5 | .5 | 14.3 |
| 62 | 60 | 3.0 | 3.0 | 17.3 |
| 63 | 12 | .6 | .6 | 17.9 |
| 64 | 3 | .1 | .1 | 18.0 |
| 65 | 117 | 5.8 | 5.8 | 23.8 |
| 66 | 221 | 10.9 | 10.9 | 34.7 |
| 67 | 11 | .5 | .5 | 35.3 |
| 68 | 219 | 10.8 | 10.8 | 46.1 |
| 69 | 16 | .8 | .8 | 46.9 |
| 70 | 171 | 8.4 | 8.4 | 55.3 |
| 71 | 55 | 2.7 | 2.7 | 58.1 |
| 72 | 138 | 6.8 | 6.8 | 64.9 |
| 73 | 9 | .4 | .4 | 65.3 |
| 74 | 19 | .9 | .9 | 66.3 |
| 75 | 165 | 8.2 | 8.2 | 74.4 |
| 77 | 50 | 2.5 | 2.5 | 76.9 |
| 78 | 12 | .6 | .6 | 77.5 |
| 80 | 68 | 3.4 | 3.4 | 80.8 |
| 82 | 75 | 3.7 | 3.7 | 84.5 |
| 84 | 4 | .2 | .2 | 84.7 |
| 85 | 29 | 1.4 | 1.4 | 86.2 |
| 86 | 11 | .5 | .5 | 86.7 |
| 87 | 35 | 1.7 | 1.7 | 88.4 |
| 88 | 40 | 2.0 | 2.0 | 90.4 |
| 89 | 30 | 1.5 | 1.5 | 91.9 |
| 90 | 2 | .1 | .1 | 92.0 |
| 92 | 92 | 4.5 | 4.5 | 96.5 |
| 93 | 37 | 1.8 | 1.8 | 98.4 |
| 95 | 16 | .8 | .8 | 99.2 |

| | | | | |
|------|------|-------|-------|-------|
| 96 | 2 | .1 | .1 | 99.3 |
| 98 | 4 | .2 | .2 | 99.5 |
| 99 | 11 | .5 | .5 | 100.0 |
| Нийт | 2024 | 100.0 | 100.0 | |

а56_1 Жингийн дундаж

| N | Minimum | Maximum | Mean | Std. Deviation |
|------|---------|---------|-------|----------------|
| 2024 | 52 | 99 | 71.69 | 10.303 |

а58 Та ямар шашин шүтдэг вэ?

| | Давтамж | хувь | Бодит хувь | Хуримтлагдсан хувь |
|----------------------------|-------------|-------|------------|--------------------|
| Бодит | | | | |
| Будда/лам, сүм дуган/ | 1038 | 51.3 | 55.5 | 55.5 |
| Лал/мусульман/ | 28 | 1.4 | 1.5 | 57.0 |
| Бөө/сахиус, тэнгэр шүтээн/ | 68 | 3.4 | 3.6 | 60.7 |
| Христос | 148 | 7.3 | 7.9 | 68.6 |
| Шашингүй | 203 | 10.0 | 10.9 | 79.5 |
| Бусад | 384 | 19.0 | 20.5 | 100.0 |
| Нийт | 1869 | 92.3 | 100.0 | |
| Missing | Хариулаагүй | 155 | 7.7 | |
| Нийт | 2024 | 100.0 | | |

а59 Та ямар нэг улс төрийн намын гишүүн эсэх?

| | Давтамж | хувь | Бодит хувь | Хуримтлагдсан хувь |
|-------|---------|-------|------------|--------------------|
| Бодит | | | | |
| Тийм | 164 | 8.1 | 8.1 | 8.1 |
| Үгүй | 92 | 4.5 | 4.5 | 12.6 |
| АН | 1626 | 80.3 | 80.3 | 93.0 |
| ХҮН | 73 | 3.6 | 3.6 | 96.6 |
| ИЗН | 9 | .4 | .4 | 97.0 |
| МАХН | 5 | .2 | .2 | 97.3 |
| МАН | 7 | .3 | .3 | 97.6 |
| МАН | 47 | 2.3 | 2.3 | 100.0 |
| МУНН | 1 | .0 | .0 | 100.0 |
| Нийт | 2024 | 100.0 | 100.0 | |

а60 Таны яс үндэс

| | Давтамж | хувь | Бодит хувь | Хуримтлагдсан хувь |
|-------|---------|------|------------|--------------------|
| Бодит | | | | |
| Барга | 182 | 9.0 | 9.0 | 9.0 |
| Баяд | 6 | .3 | .3 | 9.3 |
| Бэсүд | 21 | 1.0 | 1.0 | 10.3 |
| | 1 | .0 | .0 | 10.4 |

| | | | | |
|-----------|------|-------|-------|-------|
| Боржигон | 6 | .3 | .3 | 10.7 |
| Буриад | 35 | 1.7 | 1.7 | 12.4 |
| Чорс | 1 | .0 | .0 | 12.5 |
| Дархад | 27 | 1.3 | 1.3 | 13.8 |
| Дарьганга | 2 | .1 | .1 | 13.9 |
| Дөрвөд | 43 | 2.1 | 2.1 | 16.0 |
| Халх | 1536 | 75.9 | 75.9 | 91.9 |
| Хатгин | 1 | .0 | .0 | 91.9 |
| Хошууд | 1 | .0 | .0 | 92.0 |
| Хотгойд | 12 | .6 | .6 | 92.6 |
| Хотон | 2 | .1 | .1 | 92.7 |
| Казак | 16 | .8 | .8 | 93.5 |
| Монгол | 1 | .0 | .0 | 93.5 |
| Мянгад | 12 | .6 | .6 | 94.1 |
| Өөлд | 3 | .1 | .1 | 94.3 |
| Шарайд | 1 | .0 | .0 | 94.3 |
| Торгууд | 12 | .6 | .6 | 94.9 |
| Тува | 1 | .0 | .0 | 95.0 |
| Урианхай | 16 | .7 | .7 | 95.8 |
| Өөлд | 23 | 1.1 | 1.1 | 96.9 |
| Үзэмчин | 1 | .0 | .0 | 96.9 |
| Захчин | 62 | 3.1 | 3.1 | 100.0 |
| Нийт | 2024 | 100.0 | 100.0 | |

МУИС-ТӨСЛИЙН
БАГ

**Баянгол дүүргийн залуучуудтай хийсэн Фокус
бүлгийн сурвалжилгын тэмдэглэл**

Ярилцлага хийсэн огноо: 2021 оны 08 сарын 10-ны өдөр.

Ярилцлага хийсэн судлаач: М.СУВДМАА

Тэмдэглэл хөтөлсөн судлаач: Э.ЭНХЖИН

Ярилцлага эхэлсэн 17.00 дууссан 19.00

Ярилцлагад оролцогчдын талаарх мэдээлэл:

/Нийгэм хүн ам зүйн үзүүлэлтүүдийг тэмдэглэл хөтөлж буй судлаач бөглөнө./

| № | Нэр | Нас | Хүйс | Мэргэжил, ажил эрхлэлт | Хаяг |
|----|--------------|-----|---------|-----------------------------------|------|
| 1 | Ц.Бат-Өлзий | 34 | Эрэгтэй | Дээд сургуульд багш | БГД |
| 2 | С.Цэвэлсүрэн | 30 | Эмэгтэй | Борлуулагч | БГД |
| 3 | Л.Чингүүн | 29 | Эрэгтэй | Хувиараа,лангуу ажиллуулдаг | БГД |
| 4 | Л.Мягмар | 32 | Эрэгтэй | Хувиараа наймаа эрхэлдэг | БГД |
| 5 | Г.Отгонбаяр | 28 | Эрэгтэй | Замын компанид, туслах | БГД |
| 6 | Б.Саруул | 25 | Эмэгтэй | Төслийн ажилтан | БГД |
| 7 | Л.Гэрэлмаа | 22 | Эмэгтэй | Ажилгүй, сурдаг | БГД |
| 8 | Ц.Халиун | 25 | Эмэгтэй | Сувилагч | БГД |
| 9 | М.Доржсүрэн | 24 | Эрэгтэй | Улирлын ажилтай, одоогоор ажилгүй | БГД |
| 10 | Ц.Батболд | 33 | Эрэгтэй | Математикийн багш | БГД |
| 11 | С.Батдэлгэр | 29 | Эрэгтэй | Зээлийн эдийн засагч | БГД |
| 12 | З.Маралгоо | 31 | Эмэгтэй | Гэртээ хүүхдээ хардаг, нябо | БГД |

Танилцах ярилцлага: Мөс хагалах буюу сэдэл төрүүлэх

Энэ шатанд судлаач өөрсдийгөө болон судалгааны зорилгын талаар танилцуулна. Мөн ярилцлага хийх тоглоомын дүрмийг санал нэгтэй батална.

Асуулгын ерөнхий чиглэлүүд

1. Оролцогч тус бүр өөрийнхөө талаар товчхон танилцуулна уу?
2. Таны амьдарч буй газар өсвөр, залуу, дунд, хөгшин хэмээн насны бүлэгт хуваавал ямар хувьтай байх вэ?/насны интервал 15 хүртэл, 16-38, 39-49, 50-с дээш/
3. Таны амьдарч буй нутаг оронд эдгээр насны хүмүүсийн, ялангуяа залуучуудын өмнө юу хамгийн их тулгамдсан байдаг вэ?. Үндсэн 1-2 асуудлыг дурдуулах.
4. Залуучуудын талаар төрөөс баримтлан, хэрэгжүүлж буй ямар бодлого, үйл ажиллагааг Та мэдэх вэ?
5. Та өнөөдрийн залуучуудын талаарх бодлого, үйл ажиллагааг хэр оновчтой гэж үздэг вэ?
6. Залуучуудын асуудлаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилт Таны бодлоор?
7. Нутгийн залуучууд чухамхүү ямар ажил хөдөлмөр голчлон эрхэлж амьдарч байна вэ?. Амьдралын гол эх үүсвэр болж байгаа 3 зүйлийг дурдана уу.
8. Залуучуудын амьжиргааны төвшин бусад насныхантай харьцуулахад ямар байна вэ?
9. Орон нутагт ажиллаж буй залуучуудын ямар нэг байгууллага/төрийн болон олон нийтийн/-тай хамтарч ажилладаг уу?, хэрэв ажилласан бол хэзээ, хэрхэн, ямар асуудлаар хамтарч ажилласан бэ?
10. Залуучуудын асуудлыг шийдвэрлэх нь орон нутагт чухам ямар өөрчлөлт, дэвшил авчрах?, өөрийн бодлоо хуваалцана уу?

Респондентын дугаар:

- P1. Б.Бат-Өлзий
- P2. С.Цэвэлсүрэн
- P3. Л.Чингүүн
- P4. Л.Мягмар
- P5. Г.Отгонбаяр
- P6. Б.Саруул
- P7. Л.Гэрэлмаа

P8. Ц.Халиун
P9. М.Доржсүрэн
P10. Ц.Батболд
P11. С.Батдэлгэр

P12. З.Маралгоо
М. /модератор/ М.Сувдмаа

М: Монголын залуусын боловсрол, соёлыг та хэрхэн үнэлж дүгнэдэг вэ?

P1: Нэг үеэ бодвол залуус боловсролтой болохыг чухалчилж байна.

P2: Зарим залуус зугаа цэнгэл хөөж, зарим нь гадаадад боловсрол эзэмшиж соёлтой боловсролтой болж л байна.

P12: Харилцаа, хүндлэл үзүүлэх, ёс заншил зэрэг олон тал дээр өөрчлөлт гарч байгаа.

М: Таны амьдарч буй орон нутагт залуучуудын өмнө ямар асуудал хамгийн их тулгамдаж байна вэ?

P3: Улс маань хөгжөөд, олон олон байшин барилгууд сүндэрлээд сайхан болж байна л даа. Гэхдээ хот төлөвлөлт, байгаль орчны асуудалд сөргөөр нөлөөлж байна.

P8: Залууст ажлын байр, орон байр, гэр бүл төлөвлөлт гээд олон асуудлууд тулгарч байна. Ажилтай, орлоготой, боловсролтой залуу гэр бүлийг дэмжиж, тоог нэмэгдүүлэх

P5: Амьдрах орчны асуудал, сүүлийн жилүүдэд утаа улам л асуудал болж байна. Хүүхдээ салхилуулах ч арга алга.

P6: Орон сууцжуулах ажил өрнөж байна л гэдэг. Бодит байдал дээр залууст орон сууц авах нөхцөл маш хүнд байна.

P10: Архидалт, садар самуун байдал, үр хөндөлт, өвчлөл зэрэг олон болохгүй хар бараан зүйлс байна.

P9: Орлогын их үүсвэр хангалттай биш байна. Өнөөдрийн олж буй таван төгрөг хоол хүнс, хувцас хунар зэрэгт л арай ядан хүрч байна. Иймд зөвхөн залуучууд биш нийт Монголчуудыг орлогын эх үүсвэртэй болгоход төр анхаарах цаг нь болжээ.

М: Залуучууд ямар өвчинд өртөмтгий байна вэ? Эрүүл мэндийн чанар хүртээмж ямар түвшинд байна вэ?

P9: Ходоод гэдсний халдвар, халдварт бус өвчин маш их байна. тэр дундаа оюутан залуус их өртөж байна.

P8: Шээс, бэлгийн замын халдварт өвчин маш их байна. Аюулын хонх дэлдэж байна гэхэд болно.

P5: Янз бүрийн харшлын гаралтай өвчин газар авч байна. Гадна дотны олон төрлийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэж байгаа нь муугаар нөлөөлж байна.

P1: Залуус биеийн тамир, спортоор хичээллэж байгаа нь ч бий, ширээний ард суугаад босохгүй байсаар өвчлөн таргалж байгаа нь бий, хоёр талтай.

P4: Нийгэм, амьдралын нөхцөл байдлаас улбаалан стресс маш их орж, сэтгэл санааны хувьд хүнд нөхцөлд амьдарч байна.

P6: Хятадын хүнсний ногоо, жимс жимсгэнүүд ямар их хортойг мэдэхгүй хэрэглэж байна. Чанар хүртээмжийн талаар яриад ч хэрэггүй.

М: Залуучуудын талаар төрөөс баримтлан, хэрэгжүүлж буй ямар бодлого, үйл ажиллагааг Та мэдэх вэ?

P1: МСҮТ, ИДС-ийн оюутанд олгож байсан 70000, 40000 төгрөгийн тэтгэлэг зэргийг хэлэх байна.

P10: Улсын мөнгөөр гадаадад дарга сайд нарын хүүхдүүд нь сурдаг гэсэн

P6: Сайн мэдэхгүй байна

P7: Орон сууцтай болгоно гээд 8%-ийн хүүтэй зээл олгох нэрийдлээр хамаг юмны үнийг хөөрөгдсөнөөс өөр юм байгаа юмуу.

P4: Тамхины хууль гарсан нь бага боловч нөлөөлсөн байх. Өсвөр насныхан архи, тамхийг маш их хэрэглэж байна.

М: Залуучууд ямар ажил хөдөлмөр эрхэлж амьдарч байна вэ?

P1: Уул уурхай гэж нэг хэсэг нь хошуураад гавиагүй, чадах чадах ажлаа л хийж амьдарч байна.

P7: Ажил ороход хэцүү болсон ш дээ. Элдвийн шаардлагатай зэрэгцээд ажлын дадлага туршлага гээд /2-3 жил/. Дөнгөж төгссөн оюутанд ямар дадлага, туршлага байх вэ дээ. Эцэг эх ах эгчийн хэдэн төгрөгөөр л амьдарч байна.

P5: Зарим нь төрийн байгууллагад ажиллаж, зарим нь хувиараа бизнес эрхэлж байна.

P9: Нэг үеэ бодвол мэргэжил сургалтын төвүүдийг ихээр нээж, хүүхэд залуучууд хамрагдан сурч ажил амьдралаа залгуулж байгаа олон залуусыг би мэднэ.

P2: Гадаад хэл мэдэхгүй бол хүссэн ажилдаа орох ч хэцүү цаг болсон үе.

P8: Төрийн байгууллагад ихэнх залуус ажиллаж байна.

М: Залуучуудын орлогын эх үүсвэр юу вэ?

P4: Хөдөлмөрлөж олсон мөнгөөрөө амьдарч байгаа залуус олон бий

P7: Оюутнууд бид эцэг эхийн явуулсан мөнгө, ах эгчийн царайг л харж амьдарч байна.

P9: Цагийн ажил хийж мөнгө олох сонирхол их байдаг ч ихэнх нь оройн цагаар, цалин урамшуулал нь бага байдаг.

P4: Хувиараа л энэ тэрхэн зүйлээр амьдралаа залгуулж байна ш дээ.

P8: Улсын хэдэн төгрөгөөр урьд хормойгоороо авч хойд хормойгоо нөхөж амьдарч байна. Над шиг залуус олон бий.

P12: Нөхрийн цалин, ээж аавын тэтгэвэр, хүүхдийн мөнгөөр болж байна

М: Залуучуудын орчин, амьдралын чанарт үнэлгээ өгөхгүй юу? /Сайн? Муу ?/

P11: Бухимдалтай асуудлууд маш их байна. Наад зах нь утаа, агаарын бохирдол

P4: Амьдрал маш хүнд байна ш дээ. Ямар сайн даа л залуучууд маань амьдрал ахуйгаа дээшлүүлэх гэж гадаад очиж жорлон угааж, хүний муу муухай болгоныг хийх вэ дээ.

P2: Сайн талаас нь харвал зам, гүүр гээд олон ажил хийж, биднийг таатай амьдрахад зүтгэж л байна.

P6: Гадуур алхаж явах ч түгшүүртэй байна ш дээ. Хэзээ дээрээс юм унаад үхчих бол гэж бодож алхах юм.

P8: Засаг төр солигдоод өмнөх үетэй харьцуулбал олон ажлуудыг хийж, сайн хуулиудыг боловсруулж байна.

P3: Шинээр олон арван сургууль, цэцэрлэг, эмнэлгийг барих, засварлах, өргөтгөх ажлууд хөдөө орон нутагт хийгдэж байна.

М: Хотын болон хөдөөгийн залуучуудын хөдөлмөрийн ялгаа

P3: Нэг хэсэг хот руу тэмүүлдэг байсан залуус эсрэгээрээ орон нутагт очиж амьдарч, ажиллах, боломжтой болсон байна.

P2: Төр дэмжээд өгвөл хөдөө орон нутагт ч гэсэн ажлын байр маш их байна.

P5: Их хотын хөдөлгөөнд зохицон ажиллаж чадах залуус байхад, чирэгдэн амиа авч явж чадахгүй байгаа залуус ч их байна.

P11: Орон нутагт өрх толгойлсон эмэгтэйчүүд маш их байна. хүүхдийн мөнгө, малаа өсгөж хөдөлмөрлөж амьдардаг.

P6: Хотод залуучууд гэртээ сууж, эхнэр нь ажиллаж өрхөө авч явах үзэгдэл нэмэгдсэн.

М: Танай дүүрэгт залуучуудын ямар байгууллага үйл ажиллагаа явуулдаг вэ, хэрэв тийм байгууллага байдаг бол эдгээр байгууллагын үйл ажиллагааны талаарх үнэлгээ?

P5: Манай дүүрэгт нам улс төрийн байгууллагууд их бий. Сонгуулийн үеэр идэвхиждэг.

P2: Тийм байгууллагууд бий л дээ. Гэхдээ сонсогдохоос тийм үйл ажиллагаа явуулаа. Ийм үйл ажиллагаа явуулаа гэж сонсогддоггүй.

P11: Залуучуудын талаар төрөөс дэмжих хэрэгтэй. Зөвхөн залуучуудын байгууллагын асуудал гээд орхих ёсгүй байх

P8: Залуус өөрсдөө санаачлаад хамтраад явахад юуг ч хийх байх л даа. Манай дүүрэгт тийм байгууллагуудын үйл ажиллагаа мэдэгддэггүй.

P3: Залуучуудад гэр бүл болох, гэр бүлээ төлөвлөх, сайн аав ээж болох талаар сургалтыг бүх сувгаар хүргэдэг байх

Ярилцлагад оролцсон залуус дүүргийн нэгдсэн үнэлгээг дараах байдлаар өгсөн болно.

| Үнэлэх зүйлс | Хувь\ойролцоогоор хувиар үнэлсэн\ | Санал өгсөн хүний тоо |
|--|-----------------------------------|-----------------------|
| ЗАЛУУЧУУДЫН ӨМНӨ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭХ БАЙДАЛ | 20 | 12 |
| ЗАЛУУЧУУДЫН АМБЖИРГААНЫ ТҮВШИН, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРҮҮД | 20 | 12 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 30 | 10 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 30 | 10 |
| ӨНӨӨГИЙН ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛААР ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ | 20 | 8 |

БАЯНГОЛ ДҮҮРЭГ
УЛААНБААТАР ХОТ

**Багануур дүүргийн залуучуудтай хийсэн Фокус
бүлгийн сурвалжилгын тэмдэглэл**

Ярилцлага хийсэн огноо: 2021 оны 08 сарын 23-ны өдөр.

Ярилцлага хийсэн судлаач: М.БАТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн судлаач: М.ЦЭВЭЛМАА

Ярилцлага эхэлсэн: 16.00 дууссан:18.30

Ярилцлагад оролцогчдын талаарх мэдээлэл:

/Нийгэм хүн ам зүйн үзүүлэлтүүдийг тэмдэглэл хөтөлж буй судлаач бөглөнө./

| № | Нэр | Нас | Хүйс | Мэргэжил, ажил эрхлэлт | Хаяг, байршил |
|----|-----------------|-----|---------|------------------------|---------------|
| 1 | Ц.Эрдэнэсайхан | 25 | Эрэгтэй | Уул уурхайд, инженер | БНД |
| 2 | С.Мөнх-эрдэнэ | 32 | Эрэгтэй | Хувиараа | БНД |
| 3 | Л.Мөнхтулга | 28 | Эрэгтэй | Хувиараа | БНД |
| 4 | Г.Нандин-Эрдэнэ | 34 | Эмэгтэй | Хянан шалгагч | БНД |
| 5 | А.Шүрэнцэцэг | 30 | Эмэгтэй | Барилгын өрлөгчин | БНД |
| 6 | Б.Оюунчимэг | 34 | Эмэгтэй | Эдийн засагч | БНД |
| 7 | Б.Амартайван | 30 | Эрэгтэй | Хувиараа | БНД |
| 8 | Ц.Ундрал | 33 | Эмэгтэй | Ажилгүй | БНД |
| 9 | С.Урангуяа | 27 | Эмэгтэй | Нарийн бичиг | БНД |
| 10 | Т.Мягмарцоож | 35 | Эрэгтэй | Багш | БНД |
| 11 | Ц.Хэрлэнчимэг | 22 | Эмэгтэй | Хувиараа | БНД |
| 12 | Д.Эрдэнэболд | 34 | Эрэгтэй | Инженер, геологич | БНД |

Танилцах ярилцлага: Мөс хагалах буюу сэдэл төрүүлэх

Энэ шатанд судлаач өөрийгөө болон судалгааны зорилгын талаар танилцуулсан. Судалгаанд Багануур дүүргийн залуучуудын төлөөлөл хүмүүсийг оролцууллаа. Судалгаанд оролцогчдыг дараах байдлаар кодлон хариулт тус бүрийн өмнө оруулсан болно.

Респондентын дугаар:

P1. Ц.Эрдэнэсайхан

P2 С.Мөнх-эрдэнэ

P3 Л.Мөнхтулга

P4. Г.Нандин-Эрдэнэ

P5. А.Шүрэнцэцэг

P6. Б.Оюунчимэг

P7. Б.Амартайван

P8. Ц.Ундрал

P9. С.Урангуяа

P10. Т.Мягмарцоож

P11 Ц.Хэрлэнчимэг

P12. Д.Эрдэнэболд

М. /модератор/ М.БАТБААТАР

Асуулгын ерөнхий чиглэлүүд

Залуучуудын талаар баримталж буй төрийн бодлого, үйл ажиллагааны талаар та бүхэнтэй ярилцлага хийж байна. Оролцогч тус бүр өөрийнхөө талаар товчхон танилцуулна уу?

Тэмдэглэл хөтлөгч: Оролцогчдын танилцуулсан нийгэм хүн ам зүйн мэдээллийг хүснэгтэд тэмдэглэв.

М: Таны амьдарч буй газар өсвөр, залуу, дунд, хөгшин хэмээн насны бүлэгт хуваавал ямар хувьтай байх вэ?/насны интервал 15 хүртэл, 16-38, 39-49, 50-с дээш/

P9: Багануур дүүрэг хамгийн алслагдмал дүүрэг. Урьд нь залуучуудын дүүрэг гэж нэрлэдэг байсан. Хөдөөнөөс шилжин ирэгсэд нэмэгдэж байгаа. Насны бүлгийн хувьд ойролцоо байх гэж бодож байна.

P4: Манай дүүргийн залуучуудын ихэнх нь оюутан болж хот руу явцгаадаг. Тэгээд эргэж ирэх нь ховор. Залуучууд ер нь багассан. Их дээд сургууль нь хотдоо төвлөрснөөс үүдсэн болов уу.

P6: Сая дурдсан ангиллаар бол 15 хүртэлх насныхан нэлээд 15-20 орчим хувийг эзлэх байх, мэдээж 16-38 насныхан их л дээ, миний бодлоор бараг 40 орчим хувийг эзлэнэ. Мөн настайчуул, тэтгэвэрийнхэн 20 орчим хувьтай байгаа болов уу.

P10: Манай дүүргийн нэг онцлог бол хотын хөдөө гэж ярьдаг. Төв аймаг гэхэд хотын төвөөс 45 км байхад, манай дүүрэг 130 гаран км. Тийм болохоор суурин залуучууд хот руу их явж байна. Мөн хөдөө төв, хэнтий, сүхбаатар аймгуудаас залуучууд их шилжин ирдэг.

P1: Залуучуудын хувьд гэр хороололд ихээр суурьших болсон. Харин дунд насныхан төвдөө орон сууцанд байдаг. Эрхэлж байгаа ажилтай нь холбоотой. Амьдарч буй орчны хувьд ялгаатай.

P3: Социалист нийгэмд уул уурхай, нүүрс олборлолт гээд залуучууд ихтэй байсан газар л даа. Гэхдээ одоо нөхцөл байдал эрс өөрчлөгдсөн. Манай дүүргээс хүмүүс ажил, сургууль хайхаар олноор явах болсон. Гэр хороолол ч нэмэгдэж байна. Их дээд сургуулиуд манай дүүрэгт ойртвол залуучууд олноор шилжин явах нь багасах байх. Ахмад настнууд нь буурь сахиад үлдэж байна. Ойролцоогоор 15-20 орчим хувийг л эзлэх болов уу?

P12: Нийт хүн амын 20 хувь нь хүүхэд, 40 гаруй хувь нь залуучууд, 40 гаруй хувь нь дунд болон ахмад настай хүмүүс байгаа байх гэж бодож байна.

Тэмдэглэл хөтлөгч: Эдгээр саналуудыг харилцан ярилцаж нэгтгэсэн. Орлоцогчид санал нэгтгэйгээр дараах байдлаар насны бүлэгт эзлэх хүн амын хувийг тооцоолон ойролцоогоор гаргасан. Үүнд:

| Насны бүлэг | Хувь |
|-------------|------|
| 15 хүртэл | 20% |
| 16-38 | 40% |
| 39-49 | 25% |
| 50-с дээш | 15% |

М: Таны амьдарч буй нутаг оронд эдгээр насны хүмүүсийн, ялангуяа залуучуудын өмнө юу хамгийн их тулгамдсан байдаг вэ?. Үндсэн 1-2 асуудлыг дурдана уу.

P1: Манай дүүргийн залуучуудын хувьд тулгамдсан асуудал их. Суралцах орчин нөхцөл алга, ажилгүйдэл ихтэй. Төвөөс алслагдмал болохоор өртөг зардал ихтэй.

P12: Мэргэжилгүй бол ажил олдохгүй. Танил байхгүй бол бас ажил олдохгүй.

P8: Мэргэжилтэй байгаад ч ажил олддоггүй. Намаар ялгаварлаж ажилд авна, ажлаас хална. Төрийн, төсвийн аль ч байгууллагад орсон удирдах хүмүүст нь мөнгө, хахуул өгч байж ордог. Гол тулгамдаж байгаа асуудал бол ажил олоход бэрхшээлтэй, авлига хээл хахуул ихтэй.

P4: Ажилд авахдаа танил тал харж авах явдал газар авсан. Мэргэжилтэй хүмүүс нь ажилгүй, мэргэжилгүй байсан ч, танилтай л бол ажил олоод хийчихдэг болж байна.

P3: Залуучуудын сурч боловсрох, мэргэжил олгох хэрэгцээ хангагдахгүй байна. Тийм болохоор олноороо шилжин явдаг.

P1: Гэр хороолол явах замд зэрлэг ноход ихтэй. Гэмт хэрэг ч их гардаг гэсэн. Залуучууд мөн архи их хэрэглэж байна.

P5: Хот тохижилтын асуудал. Хөгжихгүй улам л бохир заваан болоод байна уу гэж санагддаг. Жилдээ хотын хайс, хашааг л хаа нэг будаж, түүнийгээ бүтээн байгуулалт гэж ярьдаг нь буруу.

P8: Мэргэжилгүй, ажилгүй залуучуудын хувьд орлогогүй байх нь ихээхэн хэцүү. Манай танилын хүүхэд ажил, орлогогүйн улмаас хулгай хийгээд баригдсан гэсэн. Залуучууд ийм байдлаас болж хулгай зэлгий, гэмт хэрэгт холбогдох явдал их гарч байна.

P6: Залуучуудад ажлын байр хэрэгтэй. Ажилгүйн улмаас залуучууд ажил эрхлэхээр хот руу явж байна. Эндээ мэргэжилгүй, танил талтай хүмүүс л үлдэцгээж байна.

P7: Би хувиараа наймаа эрхэлж байна. Татвар түрээс өндөр, олсон хэдэн төгрөгөө амьдрал ахуйдаа хүргэхэд нэлээд хэцүү. Миний адил арилжаа наймаа эрхэлдэг хүмүүс нэлээдгүй бий. Бүгд л төрөөс ямар нэг дэмжлэг аваагүй ч, амьдралаа болгоод л явдаг. Ингэж явлаа гээд дэмжсэн зүйл байхгүй, татвараар дарамталдаг.

P3: Намаар ялгаварлаж ажлаас халах, ажилд авах явдал, танил тал харах авлига өгөх авах мөн ажлын байр, архидалт гээд олон л асуудал байна даа.

М: Залуучуудын талаар төрөөс баримтлан, хэрэгжүүлж буй ямар бодлого, үйл ажиллагааг Та мэдэх вэ?

P12: Сайн мэдэхгүй. Төрөөс ажил мэргэжилгүй залуучуудыг ажлын байраар хангах ёстой гэж боддог. Өөр ч санал алга даа.

P1: Залуучуудын талаар цогц бодлого хэрэгтэй. Мах боловсруулах, нүүрс олборлох гээд үйлдвэр нь байна, дээр нь сурах орчныг мөн бэлтгэх хэрэгтэй. Их дээд сургуулийг заавал хотын төвд төвлөрүүлж байхлаар заримыг нь захын дүүргүүдэд байгуулвал зүгээр санагддаг.

P4: Залуучуудын талаар ийм тийм бодлого байдаг гэж мэдэхгүй. Тийм болохоор санал алга.

P12: Багануур ХК бол томоохон ажил олгогч. Залуучуудын хувьд мэдээ мэдээлэл, сургалт дадлагаар хангах нь зүйтэй.

Бусад оролцогчдын хувьд залуучуудын талаар төрөөс баримтлан хэрэгжүүлж байгаа ямар нэгэн үйл ажиллагааг сайн мэдэхгүй байлаа.

М: Залуучуудын асуудлаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилт Таны бодлоор?

P12: Залуучуудын талаар баримталж буй бодлогыг сайн мэдэхгүй болохоор үйл ажиллагаа, хэрэгжилтийг үнэлэхэд хэцүү. Байгууллага, компаниуд залуучуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зарим нэг арга хэмжээг авдаг. Төрийн үйл ажиллагааг үнэлэхэд төвөгтэй.

Бид мэдэхгүй болохоор энэ талаар үнэлж мэдэхгүй.

Тэмдэглэл хөтлөгч: Бусад оролцогчдын хувьд энэ талаар тодорхой саналгүй байлаа.

М: Дүүргийн залуучууд чухамхүү ямар ажил хөдөлмөр голчлон эрхэлж амьдарч байна вэ?. Амьдралын гол эх үүсвэр болж байгаа 3 зүйлийг дурдана уу.

P1: Залуучуудын хувьд төрийн албанд нэг хэсэг нь ажиллаж байна, ихэнх нь хувиараа хөдөлмөр эрхэлж байна. Хувийн пүүс компанид зарим нь ажиллаж байгаа.

P2: Эцэг эхийнхээ тэтгэмжээр амьдарч байна. Ажил хөдөлмөр олдохгүй нөхцөлд ингэж амьдрахаас өөр яах билээ.

P6: Залуу, аль алин нь ажилгүй гэр бүлийн хувьд хүүхдийн мөнгөөрөө амьдарч байна. Ингэж амьдрахад ч төвөгтэй. Ийм залуучууд зарим нь хөдөө малтай байдаг. Хэд гурван мал оруулж зараад амьдраад байдаг. Цаашид мал хунар нь дуусахлаар хэрхэн амьдрах нь тодорхойгүй.

P5: Түүрүүнд хэлсэн зүйлс бол мөн л дөө. Санал нэг байна. Мөн дээр нь худалдаа арилжаа хийж хэд гурван төгрөг олоод байгаа хэсэг ч бий.

P12: Мэргэжилтэй, танил талтай залуучуудын хувьд төрийн байгууллагад ажиллаж байна. Үүнээс ажил мэргэжилгүй залуучуудын хувьд амьдрахад үнэхээр хэцүү. Эцэг эх, ах дүү нараасаа зээлж хуйлаад амьдардаг.

P11: Залуучуудын ажил эрхэлж байгаа гол салбар бол нүүрс уул уурхайд, тэгээд худалдаа арилжаа наймаа, мөн үйлчилгээний салбарт ажилладаг.

Мод:Залуучуудын амьжиргааны төвшин бусад насныхантай харьцуулахад ямар байна вэ?

P12: Ер нь хэцүү хэцүү. Залуучуудыг дэмжиж байгаа зүйл алга. Дээр нь залуучууд их хүнд нөхцөлд байгаа учраас өөр тийшээ амьдрал хайж явах нь зөв.

P10: Залуучуудын амьжиргаа тааруу. Бусад насныхан, за хүүхдүүд бол эцэг эхтэйгээ амьдарч байгаа тохиолдолд яаж ийгээд болгоно. Залуучууд бол биеэ даагаад явах, шинээр амьдрал зохиогоод явах яг тийм үедээ байгаа болохоор илүү төвөгтэй гэж бодож байна.

P9: Залуу хүмүүст дэмжлэг туслалцаа их хэрэгтэй. Амьдралд хөл алдаад, нэг л буруу гишгэвэл гэмт хэрэгтэн болно. Тийм болохоор залуучуудад зориулса ажлын байр, орлого ихээхэн чухал. Залуучуудад ажилгүйдлийн тэтгэмж гэж олгох хэрэгтэй гэж боддог. Оюутнуудад олгож болоод байна шүү дээ.

P7: Одоогийн залуучууд аав ээжээсээ их хараат болсон. Өөрсдөө цалин мөнгөгүй, олж байгаа орлогогүй учраас тэр л дээ. Аав ээжийнх нь олж буй орлого тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа гэж хэлэхэд буруудахгүй байх.

P5: Залуучуудын хувьд юмыг их хурдан сурдаг. Надтай хамт ажилладаг залуучууд хийе бүтээе гэсэн сэтгэлтэй хүмүүс их байдаг. Ажил байвал хийх бүтээх урам зориг их шүү дээ.

М: Орон нутагт ажиллаж буй залуучуудын ямар нэг байгууллага/төрийн болон олон нийтийн/-тай хамтарч ажилладаг уу?, хэрэв ажилласан бол хэзээ, хэрхэн, ямар асуудлаар хамтарч ажилласан бэ?

P12: Залуучуудын асуудлаар дагнан үйл ажиллагаа явуулдаг байгууллага гэж сонсоогүй. УИХ-сонгуулийн үеэр залуучуудыг олноор нь сонгуульд ашигладаг. Тэрнээс байнга хамтарч ажиллаж байна гэж би лав сонсоогүй.

P10: Нам дагасан улс төрийн шинжтэй залуучуудын байгууллагууд байдаг. Тэдгээр залуучууд сонгуулийн үеэр их идэвхижээд тэгээд алга болдог.

P6: Залуучуудын байгууллага байхгүй, харин зарим нэг компани, үйлдвэрүүд залуучуудаа дэмжих өөрсдийн дотоод бодлого үйл ажиллагаатай байдаг.

Тэмдэглэл хөтлөгч: Бусад оролцогчид хамтарч ажиллаж байгаагүй болно.

М: Залуучуудын асуудлыг шийдвэрлэх нь орон нутагт чухам ямар өөрчлөлт, дэвшил авчрах?, өөрийн бодлоо хуваалцана уу?

P8: Залуучуудад тулгамдаж буй хамгийн хэцүү асуудал бол намаар ялгаварлах явдал. Энэ асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй. Халагдана гэж айгаад ажлаа хийж чадахгүй, ийм байдал удаан үргэлжлэх ёсгүй. Мэргэжилтэй, чадвартай ч ажилгүй залуучууд их байна. Тэр хүмүүсийг одоо л ашиглаж, улс орондоо бүтээлгэх ёстой шүү дээ.

P12: Залуучуудын ажилгүйдлийг шийдвэрлэх шаардлагатай. Ажилтай, хамт олонтой бол хүн элдэв сөрөг зүйл архи, тамхи, гэмт хэрэгт татагдаж орохгүй. Залуу гэр бүлд өнөөдөр ажлын байр л их чухал байна.

P7: Залуучуудыг зөвхөн эцэг эхээсээ хараат байдлаар байлгаж болохгүй гэж боддог. Залуу хүмүүсийг чадваржуулж, ажил мэргэжил олгох хэрэгтэй.

P4: Дүүргийн удирдлагууд залуучуудад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар үйл ажиллагаа явуулахгүй байна. Залуучуудыг түр зуур тохижилтын ажилд дайчлах нь ажлын байр гаргасан хэрэг биш байх.

P10: Аль болох удаан хугацаанд, найдвартай ажиллах, болж өгвөл цалин хөлс өндөр ийм л ажлын байрнууд чухал даа.

P6: Залуучуудыг соёлтой болгоход анхаарах нь чухал. Өнөөгийн залуучууд биеэ хэрхэн соёлтой авч явахад хүртэл суралцах хэрэгтэй байна.

М: Өөр саналууд байна уу.

P10: Залуучуудын сурч боловсрох орчны асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байх. Тэгэхгүй бол манай дүүргээс сурч байгаа оюутнууд ихээхэн төвөгтэй нөхцөлд сурдаг. Гэр нь хол гэхэд хол биш, бас ойр биш. Тийм болохоор энэ асуудал оюутны хотхон байгуулах үед шийдэгдэх байх л даа.

Нэгдсэн үнэлгээ

Уг судалгаанд оролцогчид бүлгийн ярилцлагаар хэлэлцсэн дараах асуудлуудад үнэлгээ өгсөн болно.

| Үнэлэх зүйлс | Хувь\ойролцоогоор үнэлсэн\ | Санал өгсөн хүний тоо |
|--|----------------------------|-----------------------|
| ЗАЛУУЧУУДЫН ӨМНӨ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭХ БАЙДАЛ | 35 | 12 |
| ЗАЛУУЧУУДЫН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРҮҮД | 55 | 12 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 30 | 8 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 25 | 8 |
| ӨНӨӨГИЙН ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛААР ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ | 40 | 10 |

М: Ярилцлагад идэвхитэй оролцсон та бүхэнд баярлалаа.

Багануур дүүрэг

Улаанбаатар хот

**Баянзүрх дүүргийн залуучуудтай хийсэн Фокус
бүлгийн сурвалжилгын тэмдэглэл**

Ярилцлага хийсэн огноо: 2021 оны 07 сарын 20-ны өдөр.

Ярилцлага хийсэн судлаач: Т.ЛХАГВАА

Тэмдэглэл хөтөлсөн судлаач: М.ЦЭВЭЛМАА

Ярилцлага эхэлсэн: 17.30 дууссан:19.20

Ярилцлагад оролцогчдын талаарх мэдээлэл:

/Нийгэм хүн ам зүйн үзүүлэлтүүдийг тэмдэглэл хөтөлж буй судлаач бөглөнө./

| № | Нэрс | Нас | Хүйс | Мэргэжил, ажил эрхлэлт | Хаяг |
|----|---------------|-----|---------|-----------------------------|------|
| 1 | Б.Бямбабаатар | 37 | эрэгтэй | Хувийн байгууллагад түгээгч | БЗД |
| 2 | Г.Эрдэнэтулга | 28 | эрэгтэй | Зураач | БЗД |
| 3 | С.Галмандах | 25 | эрэгтэй | ТББ-д судлаач | БЗД |
| 4 | М.Сэрчин | 22 | эмэгтэй | Оюутан | БЗД |
| 5 | Б.Батжаргал | 34 | эрэгтэй | Ажилгүй | БЗД |
| 6 | Г.Одзаяа | 30 | эмэгтэй | Худалдагч | БЗД |
| 7 | С.Туулцэцэг | 29 | эмэгтэй | Хувиараа | БЗД |
| 8 | М.Ганжаргал | 32 | эмэгтэй | Соёл судлаач | БЗД |
| 9 | Ц.Эрдэмт | 36 | эрэгтэй | Бизнесмэн | БЗД |
| 10 | Б.Бат-эрдэнэ | 35 | эрэгтэй | Хувиараа | БЗД |
| 11 | М.Эрдэнэбаяр | 27 | эрэгтэй | Эдийн засагч | БЗД |
| 12 | Б.Гэрэлтуяа | 26 | эмэгтэй | Хуульч, өмгөөлөгч | БЗД |

Танилцах ярилцлага: Мөс хагалах буюу сэдэл төрүүлэх

Энэ шатанд судлаач өөрсдийгөө болон судалгааны зорилгын талаар танилцуулна. Мөн ярилцлага хийх тоглоомын дүрмийг санал нэгтэй батална.

Асуултын ерөнхий чиглэлүүд

1. Оролцогч тус бүр өөрийнхөө талаар товчхон танилцуулна уу?

2. Таны амьдарч буй нутаг оронд эдгээр насны хүмүүсийн, ялангуяа залуучуудын өмнө юу хамгийн их тулгамдсан байдаг вэ?. Үндсэн 1-2 асуудлыг дурдуулах.
3. Залуучуудын талаар төрөөс баримтлан, хэрэгжүүлж буй ямар бодлого, үйл ажиллагааг Та мэдэх вэ?
4. Та өнөөдрийн залуучуудын талаарх бодлого, үйл ажиллагааг хэр оновчтой гэж үздэг вэ?
5. Залуучуудын асуудлаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилт Таны бодлоор?
6. Нутгийн залуучууд чухамхүү ямар ажил хөдөлмөр голчлон эрхэлж амьдарч байна вэ?. Амьдралын гол эх үүсвэр болж байгаа 3 зүйлийг дурдана уу.
7. Залуучуудын амьжиргааны төвшин бусад насныхантай харьцуулахад ямар байна вэ?
8. Залуучуудын асуудлыг шийдвэрлэх нь орон нутагт чухам ямар өөрчлөлт, дэвшил авчрах?, өөрийн бодлоо хуваалцана уу?

Респондентын дугаар:

P1. Б.Бямбабаатар

P2 Г.Эрдэнэтулга

P3. С.Галмандах

P4. М.Сэрчин

P5. Б.Батжаргал

P6. Г.Одзаяа

P7. С.Туулцэцэг

P8. М.Ганжаргал

P9. Ц.Эрдэмт

P10. Б.Бат-эрдэнэ

P11. М.Эрдэнэбаяр

P12. Б.Гэрэлтуяа

М. /модератор/ Т.ЛХАГВАА

М: Та бүхнийг хүрэлцэн ирсэн явдалд баярлалаа. Бид залуучуудын өмнө ямар асуудлууд тулгарч байна, хэрхэн шийдвэрлэх вэ зэрэг асуудлуудаар ярилцах болно. Та бүхнийг илэн далангүй нээлттэй оролцоно гэдэгт итгэж байна.

Таны хувьд өнөөдөр залуус ямар асуудлууд тулгамдсан байна вэ?

P3: Залуучуудын гэрлэлт, гэр бүл төлөвлөлтийн тал дээр хуймгай хандаж байна. Үүнээс болж олон гэр бүл салж, хүүхдүүд хохирч байна.

P10: Залуучуудын ажилгүйдэл, Хятад, Вьетнам, Өвөр монгол залуусыг ихээр оруулан ирж ажиллуулж ажлын байрыг нь гадаадаханд алдаж байна.

P1: Орон сууцны асуудал үнэхээр тулгамдсан асуудал болж байна. Ихэнх залуус аав ээж, хажуу өрөө, байр түрээслэх зэргээр амьдарч байна

P4: Архидалт, хүчин зэрэг бусармаг явдал маш их гарч байна.

P5: Миний бодлоор ажлын байр хангалттай байгаа хэдий ч цалин, урамшуулал хангалтгүй байна. Ар гэртээ санаа зоволгүй ажиллах таатай боломжийг бий болгох, цалин хангамжийг нэмэгдүүлэх

P8: Төрөөс дэмжих дэмжлэг хэрэгтэй байна. ажил хийгээд байгаа гээд цаадуул чинь яриад байгаа боловч залууст хүрч байгаа нь нүдэнд харагдахгүй байна.

P12: Олон арван баар цэнгээний газруудыг цэгцлэх хэрэгтэй байна. Олон залуус энэ байдлаас болж амьдралаа алдаж, гэр бүлд зөрчил их үүсч байна.

М: Эдгээр асуудлыг шийдвэрлэх талаар чухам ямар санал санаачлагууд гардаг вэ? хэрхэн шийдвэрлэж байна вэ?

P11: Эдгээр асуудлыг бие дааж шийдвэрлэх боломжгүй л дээ. Хэсэг бүлэг хүмүүсийн асуудал. Жижиг дунд үйлдвэрүүдийг төрөөс дэмжиж байна л гэдэг үнэндээ хэсэг бүлэг танил хүмүүст нь хүртэж, иргэд бидэнд хүртдэггүй.

P4: Нийслэл, дүүрэгт суулгасан төсвийн хөрөнгө байдаг хэдий ч эмнэлэг, цэцэрлэг, сургууль зэрэгт зарцуулаад илүү гардаггүй. Залуус бидэнд бодитой хүрэх төрийн бодлого үнэхээр чухал байна.

P2: Төр гэлтгүй хувийн хэвшлийнхэнтэй бид хамтарч ажиллаж болох ч тэр бүр итгэж ажилладаг бизнесийн байгууллагууд байдаггүй.

P6: Олон улсын байгууллагууд олон хүмүүнлэгийн ажлуудыг явуулдаг, эдгээрт байгууллагуудтай дүүрэг нийслэлийн залуучуудын байгууллагууд холбож ажлын байраар хангаж хамтарч ажиллах хэрэгтэй.

P8: Санал санаачлага гээд байх юм байдаггүй.

M: Нийслэл, дүүрэгт ийм байдаг юм байна. Залуучуудад чиглэсэн төрөөс баримтлан хэрэгжүүлж буй ямар бодлого үйл ажиллагааг та мэдэх вэ? хамрагдаж чадаж байна уу?

P12: Эрүүл мэндийн салбарт тодорхой ажил хийгдэж байгаа.

P4: Спортоор амжилт гаргаж байгаа залуу тамирчдыг дэмжиж эхэлж байгаа.

P7: Одоогоор аль хөтөлбөр үйл ажиллагаанд хамрагдаж чадаагүй байна.

M: Өнөөдрийн хэрэгжиж байгаа “Өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт, үйл ажиллагааг хэр оновчтой гэж үздэг вэ?

P1: Энэ талаар сайн мэдэхгүй байна.

P6: Би мэдэхгүй байна, гэхдээ тодорхой ажлууд хийгдэж байгаа байлгүй дээ.

P3: Иргэд, ард түмэн тэр бүр мэдэхгүй байхыг бодвол хөтөлбөр нь хөрсөн дээрээ буугаагүй юм байлгүй дээ.

P11: Боловсрол, эрүүл мэндийн салбарт хэд хэдэн ажлууд хийгдэж байгаа

M: Залуучуудын асуудлыг шийдвэрлэснээр, залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулснаар хөдөө орон нутагт ямар өөрчлөлт, хөгжил дэвшлийг авчирна гэж бодож байна вэ?

P1: Мэдээж улс орны хөгжлийн гарц болох залуус зөвхөн хот суурин газарт биш, хөдөө орон нутагт ажиллавал зүгээр байх.

P6: Ажил, орон сууцыг нь шийдвэрлээд өгвөл өрх гэрээс гарч улс орны хөгжилд гар бие оролцон хөгжих гарц нээгдэнэ.

M: Залуучуудын дунд эрүүл мэндийн ямар асуудал тулгамдсан шинжтэй байдаг вэ?

P7: Өвчлөл маш их байна. Жишээ нь: амьсгалын замын өвчин

P6: Залуучууд нуруу бөөр, шээсний замын өвчлөлд өртөмтгий байна.

P9: Зөвхөн залуус гэлтгүй нийт иргэд түгшүүртэй амьдарч байна. Идэж байгаа хүнс, ууж байгаа ус, амьсгалж байгаа агаар гээд айдас дагуулсан байдалд л амьдарч л байна шүү дээ.

P11: Тэр бүр эмнэлэгт үзүүлээд, шинжилгээ өгөөд явж чаддаггүй, эрүүл мэндийн төвүүд нь ачааллаа дийлэхгүй, өвчин тусч туйлдаа хүрэхгүй л бол эмнэлэгт хүрээд байдаггүй.

P6: Уушиг, зүрх судас, ходоодны өвчлөлд өртөмтгий байна.

P2: Суудлын өвчин маш их болсон. Гараад машинд, гэртээ ороод зурагт хараад, ажил дээрээ ирээд уугаад ингээд л хөдөлгөөн дутаж хөших өвдөж байна даа. Мөн стресст залуус их өртөмтгий байна. Ажилдаа нэг түүртэнэ, амьдралаа авч явах гээд элдвийн бодол дарамт зэрэг нийгмийн шинжтэй дарамт шахалтууд их байна. Төрөөс залуусын эрүүл мэнд, өвчлөлд анхаарч эхлэх цаг болсон. Бага залуугаас нь анхаарахгүй бол ирээдүйн монголыг авч явах залуус бүгд стресст ороод өөрийгөө ч авч явах чадваргүй болох нь.

М: Соёлтой хүн гэж ямар хүнийг хэлэх вэ? Монгол залуусын соёлын түвшин?

P1: Залуус соёлтой болж эхэлж байна.

P9: Цаг үе нийгмээ дагаад соёлын түвшин дээрдсэн.

P4: Үс, интернет их хөгжсөн, Азын соёл Монголд давамгайлсаар байна.

P7: Боловсролтой, соёлтой хүнийг л соёлтой хүн гэж хэлэх байлгүй дээ. Харьцангуй дээшилж байгаа.

М: Залуучуудын орлогын эх үүсвэр юу байдаг юм бэ?

P2: Хувийн машинтай нь таксинд явж халтуур хийж байна.

P3: Нилээдгүй хувь нь төрийн болон төсвийн байгууллагад ажиллаж байна

P4: Ажилгүй залуус маш их байна.

P5: Хувийн бизнес эрхэлж яваа залуус бий.

P10: Орлогын эх үүсвэр гээд байх юм алга.

P12: Жижиг дунд бизнес эрхэлж байгаа залуус их байна шүү дээ.

P8: Танил тал байхгүй бол гайгүй ажлын байр олдохгүй. Олдсон ажил нь сарын хэрэглээний хаана нь хүрэхгүй хүнд байна.

М : Залуучуудын амжиргааны түвшин бусад насныхантай харьцуулахад ямар байна вэ?

P3: Сайн хэлж мэдэхгүй байна.

P7: Хөлөө олж чадахгүй яваа залуусыг ах насныхантай нь харьцуулшгүй ш дээ.

P12: Хангалттай сайхан амьдарч байгаа.

М: Танай дүүрэгт залуучуудын ямар байгууллага үйл ажиллагаа явуулдаг вэ, хэрэв тийм бол?

P3: Нам олон нийтийн байгууллага байхын хувьд байдаг л байх, ер нь сонгуулийн үеэр идэвхиждэг ш дээ.

P9, P12: Эмэгтэйчүүдийн байгууллага, оюутны байгууллагууд байдаг ч хийж буй тодорхой ажил тайлан үр дүнг хэлж мэдэхгүй байна.

P5: Хийх хүсэл эрмэлзэлтэй хэсэг бүлэг байдаг л байх төрөөс дэмжих дэмжлэг, хөрөнгө санхүүгийн байдлаас болж үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг байх.

Нэгдсэн үнэлгээ

Судалгаанд оролцогчид бүлгийн ярилцлагаар хэлэлцсэн дараах асуудлуудад нэгдсэн үнэлгээ өгсөн болно.

| Үнэлэх зүйлс | Хувь\ойролцоогоор\ | Санал өгсөн хүний тоо |
|--|--------------------|-----------------------|
| ЗАЛУУЧУУДЫН ӨМНӨ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭХ БАЙДАЛ | 30 | 12 |
| ЗАЛУУЧУУДЫН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРҮҮД | 45 | 12 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 30 | 12 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 35 | 8 |

| | | |
|---|----|---|
| ӨНӨӨГИЙН ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛААР ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ | 50 | 8 |
|---|----|---|

Баянзүрх дүүрэг
Улаанбаатар хот

**Чингэлтэй дүүргийн залуучуудтай хийсэн Фокус
бүлгийн сурвалжилгын тэмдэглэл**

Ярилцлага хийсэн огноо: 2021 оны 08 сарын 16-ны өдөр.

Ярилцлага хийсэн судлаач: М.БАТБААТАР

Тэмдэглэл хсөтөлсөн судлаач: Т.ЛХАГВАА

Ярилцлага эхэлсэн: 18.00 дууссан: 19.40

Ярилцлагад оролцогчдын талаарх мэдээлэл:

/Нийгэм хүн ам зүйн үзүүлэлтүүдийг тэмдэглэл хөтөлж буй судлаач бөглөнө./

| № | Нэр | Нас | Хүйс | Мэргэжил, ажил эрхлэлт | Оршин суух хаяг |
|----|----------------|-----|---------|-------------------------------|-----------------|
| 1 | Б.Жаргалмаа | 25 | Эмэгтэй | Оюутан | ЧД |
| 2 | М.Цэрэндорж | 28 | Эрэгтэй | Багш | ЧД |
| 3 | Б.Оюундарь | 25 | Эмэгтэй | Хувиараа, үсчин | ЧД |
| 4 | С.Марал | 24 | Эмэгтэй | Хувиараа | ЧД |
| 5 | А.Эрдэнэбулган | 33 | Эрэгтэй | Ажилгүй | ЧД |
| 6 | О.Мягмардорж | 29 | Эрэгтэй | Орчуулагч | ЧД |
| 7 | Б.Билгүүн | 36 | Эрэгтэй | Оюутан | ЧД |
| 8 | Р.Долгорсүрэн | 27 | Эмэгтэй | Эдийн засагч, нябо | ЧД |
| 9 | Д.Биндэръяа | 25 | Эрэгтэй | Багш | ЧД |
| 10 | Г.Шинэбаяр | 27 | Эрэгтэй | Эмч | ЧД |
| 11 | Б.Рэнцэнханд | 22 | Эмэгтэй | ТББ-д судалгааны ажилтан | ЧД |
| 12 | Н.Ундрах | 22 | Эмэгтэй | Хэл судлаач, Одоогоор ажилгүй | ЧД |

Танилцах ярилцлага: Мөс хагалах буюу сэдэл төрүүлэх

Энэ шатанд судлаач өөрсдийгөө болон судалгааны зорилгын талаар танилцуулна. Мөн ярилцлага хийх тоглоомын дүрмийг санал нэгтэй батална.

Асуулгын ерөнхий чиглэлүүд

1. Оролцогч тус бүр өөрийнхөө талаар товчхон танилцуулна уу?
2. Таны амьдарч буй газар өсвөр, залуу, дунд, хөгшин хэмээн насны бүлэгт хуваавал ямар хувьтай байх вэ?/насны интервал 15 хүртэл, 16-38, 39-49, 50-с дээш/
3. Таны амьдарч буй нутаг оронд эдгээр насны хүмүүсийн, ялангуяа залуучуудын өмнө юу хамгийн их тулгамдсан байдаг вэ?. Үндсэн 1-2 асуудлыг дурдуулах.
4. Залуучуудын талаар төрөөс баримтлан, хэрэгжүүлж буй ямар бодлого, үйл ажиллагааг Та мэдэх вэ?
5. Та өнөөдрийн залуучуудын талаарх бодлого, үйл ажиллагааг хэр оновчтой гэж үздэг вэ?
6. Залуучуудын асуудлаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилт Таны бодлоор?
7. Нутгийн залуучууд чухамхүү ямар ажил хөдөлмөр голчлон эрхэлж амьдарч байна вэ?. Амьдралын гол эх үүсвэр болж байгаа 3 зүйлийг дурдана уу.
8. Залуучуудын амьжиргааны төвшин бусад насныхантай харьцуулахад ямар байна вэ?
9. Орон нутагт ажиллаж буй залуучуудын ямар нэг байгууллага/төрийн болон олон нийтийн/-тай хамтарч ажилладаг уу?, хэрэв ажилласан бол хэзээ, хэрхэн, ямар асуудлаар хамтарч ажилласан бэ?
10. Залуучуудын асуудлыг шийдвэрлэх нь орон нутагт чухам ямар өөрчлөлт, дэвшил авчрах?, өөрийн бодлоо хуваалцана уу?

Респондентын дугаар:

P1. Б.Жаргалмаа

P2. М.Цэрэндорж

P3. Б.Оюундарь

P4. С.Марал

P5. А.Эрдэнэбулган

P6. О.Мягмардорж

P7. Б.Билгүүн

P8. Р.Долгорсүрэн

P9. Д.Биндэрьяа

P10. Г.Шинэбаяр

P11. Б.Рэнцэнханд

P12. Н.Ундрах

М. /модератор/ М.БАТБААТАР

М: Соёлтой хүн гэж ямар хүнийг хэлэх вэ? Өнөөгийн залуусын соёлыг тодорхойлбол.

P1: Нийгэм цаг үеэ дагаад залуус их соёлтой болсон байна.

P7: Зурагт, сонин сэтгүүлээр, цахим ертөнцөөр дамжуулан хүүхэд, залуучууд мэдлэг боловсрол, хүмүүжлийг олж авч байгаа гэж боддог. Тэр ч утгаараа соёлтой болж байгаа, тухайлбал: гадуур явахдаа хогоо хогийн саванд хийх, олны газар биеэ зөв авч яваа байдлаас харж болно.

P3: Нэг хэсэг нь соёлжоод л байна, нөгөө хэсэг нь эсрэгээрээ, орсонд шүлсээ хаяж архи дан зодолдож байна. Машиныхаа цонхоор хогоо хаяж байна

М: Залуучууд голчлон ямар ажил хөдөлмөр эрхэлж амьдарч байна вэ? орлогын эх үүсвэр?

P11: Ажилгүйдэл, олон залуус гудамжинд ажилгүй явж байна. зарим нь буруу, амар хялбар замаар мөнгө олох гэж бусдыг хохироож амь насанд нь хүртэл хүрж байна.

P8: Улсын, хувийн олон хөдөлмөрийн бирж ажиллаж байгаа хэдий ч хэдэн хувь нь ажлын байртай болж байгаа нь мэдэгдэхгүй байна.

P12: Барилгын компани, борлуулалтын ажлыг залуус түлхүү хийж байна. Ар гэртээ санаа зоволгүй ажиллаж таатай боломжийг бий болгох, цалин хангамжийг нэмэгдүүлэх хэрэгтэй.

P2: Худалдаа наймаа зэрэг жижиг бизнест хөл тавьсан байна.

P5: Сайхан боловсрол мэдлэгтэй нь гадаадын том том компанид ажиллаж байна, үүнийг буруу гэхгүй. Гэхдээ эдгээр залуусыг монголдоо ажиллуулж, улсаа хөгжүүлэхэд нь гар бие оролцуулмаар байна. Үүний тулд төр засаг оновчтой бодлого боловсруулах л хэрэгтэй байна даа.

P1: Монгол Улс залуусын орон энэ ч утгаараа тэд орон нутагтаа ажиллаж амьдарч байна. Залуус хэсэг бүглэг, найз нөхдөрөө нийлж үйлдвэрлэл явуулж байгаа

P10: Түлээ нүүрс зарж өдрийн амин зуулгаа залгуулж байгаа хэсэг бүлэг ч байна.

P9: Гарын ур, бүтээлч сэтгэлгээгээрээ хоолоо олж буй монгол үйлдвэрлэлийг хөгжүүлэх гэж яваа залуус олон.

М : Залуучуудын амжиргааны түвшин бусад насныхантай харьцуулахад ямар байна вэ?

P4: Бусад насныхантай харьцуулбал дунд гэж хэлэх байна.

P6: Амьдрал нь тогтсон буюу 35-аас дээш насныхан илүү сайхан амьдарч байна.

P9: Бусад насныхантай харьцуулбал энэ бүлгийнхэн идэвхитэй, илүү сайхан амьдарч, ажиллаж баймаар гэвч нөхцөл байдал эсрэгээрээ байна

P8: Өөрийн хүсэл тэмүүлэл, хөдөлмөрөөрөө ажиллаж, амжилт гаргаж яваа олон залуус байна. Тэд хангалттай сайхан амьдарч байна.

M: Залуучуудад чиглэсэн төрөөс баримтлан хэрэгжүүлж буй ямар бодлого үйл ажиллагааг та бүхэн мэдэх вэ?

P12: Аливаа сонгууль ажил болохоор л олон амлалт, мөрийн хөтөлбөр болорвсруулаад ойр зуур ажил хийдэг, бусад цагт нь байдаггүй.

P7: Залуучуудыг хамруулсан БЗХӨ сэргийлэх үзлэгийг явуулсан

P6: Мэргэжлийн сургалтанд сурч буй хүүхэд, залууст 40000

M: Залуучуудын дунд эрүүл мэндийн ямар асуудал тулгамдсан шинжтэй байдаг вэ?

P9: Халдварт өвчинд их өртөж байна. мөнгөний боломж, хайхрамжгүй байдлаасаа болж төрсөн хүүхэд нь ямар нэгэн халдварт өвчин тээн төрж байна.

P8: Архидалттай холбоотой сэтгэл санаа тайван бус, маш их стресс дунд олон гэр бүл айдастай амьдарч байна. Захын хороолол болон хөдөөд газар авч байна.

P5: Суугаа ажилтай холбоотой хөдөлгөөний дутагдалд орж байна.

P1: Шүдний өчлөл

P4: барилгын ажил болон бусад салбарт аюулгүй ажиллагаа алдагдсанаас гэмтэх бэртэх нас барах тохиолдолд ихсэж байна.

P6: Ядуурал, ажилгүйдэл, үнийн хөөрөгдөл зэргээс хамаарч сэтгэл зүйн хувьд хямарч өвлөлд нөлөөлж байна.

M: Залуусын өмнө тулгамдаж буй асуудал юу вэ таны бодлоор.

P10: Ажилгүйдэл

P9: Ажилгүйдэл, орон сууц

P2: Цалин, урамшуулал бага байна

P3: Хүүхдээ салхилуулах талбай газар алга

P8: Үнийн өсөлтийг барих

P7: Эрүүл мэндийн чанар, үйлчилгээ

M: Хот хөдөөгийн залуусын хөдөлмөрийн ялгаа

P8: хотын залуусын ихэнх нь амар хялбар аргаар мөнгө олохыг бодож байхад, хөдөөд мод түлээ бэлдэж, нийлүүлж амьдарч байна.

P12: хөдөөгийн залуус мал маллах, ногоо тарих зэргээр хөдөлмөрлөж байгаа

P7: хот хөдөө гэхгүй хувийн бизнестэй болсон.

M: Танай дүүрэгт залуучуудын ямар байгууллага үйл ажиллагаа явуулдаг вэ, хэрэв тийм байгууллага байдаг бол эдгээр байгууллагын үйл ажиллагааны талаарх үнэлгээ?

P1: энэ талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.

P4: хөгжлийн бэрхшээлтэй залуучуудыг дэмжих ажил өрнөж байсныг санаж байна

P9: P11: хэлж мэдэхгүй байна.

P3: бид сонсоогүй мэдэхгүй байгаас болохоос олон нийтийн байгууллагууд үйл ажиллагаа явуулж хамтарч ажилладаг л байх,

Нэгдсэн үнэлгээ

Уг судалгаанд оролцогчид бүлгийн ярилцлагаар хэлэлцсэн дараах асуудлуудад үнэлгээ өгсөн болно.

| Үнэлэх зүйлс | Хувь\ойролцоогоор үнэлсэн\ | Санал өгсөн хүний тоо |
|--|----------------------------|-----------------------|
| ЗАЛУУЧУУДЫН ӨМНӨ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭХ БАЙДАЛ | 45 | 10 |
| ЗАЛУУЧУУДЫН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРҮҮД | 40 | 10 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 25 | 10 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 35 | 10 |
| ӨНӨӨГИЙН ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛААР ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ | 50 | 10 |

Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар хот

Хан Уул дүүргийн залуучуудтай хийсэн Фокус бүлгийн сурвалжилгын тэмдэглэл

Ярилцлага хийсэн огноо: 2021 оны 09 сарын 20-ны өдөр.

Ярилцлага хийсэн судлаач: М.СУВДМАА

Тэмдэглэл хөтөлсөн судлаач: С.СОДГЭРЭЛ

Ярилцлага эхэлсэн 17.20 дууссан 19.00

Ярилцлагад оролцогчдын талаарх мэдээлэл:

/Нийгэм хүн ам зүйн үзүүлэлтүүдийг тэмдэглэл хөтөлж буй судлаач бөглөнө./

| № | Нэр | Нас | Хүйс | Мэргэжил, ажил эрхлэлт | Оршин суугаа хаяг |
|----|---------------|-----|---------|----------------------------|-------------------|
| 1 | З.Баярмаа | 29 | Эмэгтэй | Хувийн байгууллага, тогооч | ХУД |
| 2 | Д.Ганболд | 22 | Эрэгтэй | МУИС, оюутан | ХУД |
| 3 | Б.Дэлгэрмаа | 28 | Эмэгтэй | Ажилгүй | ХУД |
| 4 | Ц.Даваажаргал | 36 | Эмэгтэй | Төрийн байгууллагад | ХУД |
| 5 | С.Жаргал | 26 | Эрэгтэй | ШУТИС, оюутан | ХУД |
| 6 | Л.Чамин | 36 | Эрэгтэй | Хувиараа хөд эрхлэгч | ХУД |
| 7 | Т.Лхагвабат | 30 | Эрэгтэй | Ажилгүй | ХУД |
| 8 | Г.Дашбаатар | 34 | Эрэгтэй | МИАТ жолооч | ХУД |
| 9 | Г.Мөнхболд | 29 | Эрэгтэй | Шунхлай, нябо | ХУД |
| 10 | О.Сүрэн | 20 | Эмэгтэй | МУИС, оюутан | ХУД |
| 11 | Ю.Алдарсайхан | 26 | Эрэгтэй | Хувиараа, ажилгүй | ХУД |
| 12 | А.Цэцэгдэлгэр | 32 | Эмэгтэй | Хувиараа хөд эрхлэгч | ХУД |

Танилцах ярилцлага: Мөс хагалах буюу сэдэл төрүүлэх

Энэ шатанд судлаач өөрсдийгөө болон судалгааны зорилгын талаар танилцуулна. Мөн ярилцлага хийх тоглоомын дүрмийг санал нэгтэй батална.

Асуултын ерөнхий чиглэлүүд

1. Оролцогч тус бүр өөрийнхөө талаар товчхон танилцуулна уу?
2. Таны амьдарч буй газар өсвөр, залуу, дунд, хөгшин хэмээн насны бүлэгт хуваавал ямар хувьтай байх вэ?/насны интервал 15 хүртэл, 16-38, 39-49, 50-с дээш/
3. Таны амьдарч буй нутаг оронд эдгээр насны хүмүүсийн, ялангуяа залуучуудын өмнө юу хамгийн их тулгамдсан байдаг вэ?. Үндсэн 1-2 асуудлыг дурдуулах.
4. Залуучуудын талаар төрөөс баримтлан, хэрэгжүүлж буй ямар бодлого, үйл ажиллагааг Та мэдэх вэ?
5. Та өнөөдрийн залуучуудын талаарх бодлого, үйл ажиллагааг хэр оновчтой гэж үздэг вэ?
6. Залуучуудын асуудлаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилт Таны бодлоор?
7. Нутгийн залуучууд чухамхүү ямар ажил хөдөлмөр голчлон эрхэлж амьдарч байна вэ?. Амьдралын гол эх үүсвэр болж байгаа 3 зүйлийг дурдана уу.
8. Залуучуудын амьжиргааны төвшин бусад насныхантай харьцуулахад ямар байна вэ?
9. Орон нутагт ажиллаж буй залуучуудын ямар нэг байгууллага/төрийн болон олон нийтийн/-тай хамтарч ажилладаг уу?, хэрэв ажилласан бол хэзээ, хэрхэн, ямар асуудлаар хамтарч ажилласан бэ?
10. Залуучуудын асуудлыг шийдвэрлэх нь орон нутагт чухам ямар өөрчлөлт, дэвшил авчрах?, өөрийн бодлоо хуваалцана уу?

Респондентын дугаар:

- P1. З. Баярмаа
- P2. Д.Ганболд
- P3. Б.Дэлгэрмаа
- P4. Ц.Даваажаргал
- P5. С.Жаргал
- P6. Л.Чамин
- P7. Т.Лхагвабат
- P8. Г.Дашбаатар
- P9. Г.Мөнхболд
- P10. О.Сүрэн
- P11. Ю.Алдарсайхан
- P12. А.Цэцэгдэлгэр
- М. /модератор/ М.Сувдмаа

М: Та бүхэн бидний саналыг хүлээн авч цаг гарган ирсэн явдалд баярлалаа. Оролцогч тус бүр өөрийнхөө талаар товчхон танилцуулна уу?

P11: Намайг Алдарсайхан гэдэг. Одоогоор тодорхой эрхэлсэн ажилгүй.

P8: Би МИАТ-д жолооч ажилтай. Эхнэр хүүхдүүдийн хамт тус дүүрэг амьдардаг.

P10: Би МУИС-ын оюутан, энд байгаа Ганболд бид хоёр нэг ангийнхан.

P12: Сайн байцгаана уу? Би нэгэн хувийн байгууллагад тогооч хийдэг.

P6: Намайг Чамин гэдэг.

М: За баярлалаа, бидний энд цугласан зорилго нь өнөөгийн нийгэмд залуус бидэнд тулгарч буй бэрхшээл, бидэнд чиглэсэн төрийн бодлогын талаар ярилцах болно. Тиймээс бид нэгэн үе тэнгийн залуус цугларсан болоор чөлөөтэй илэн далангүй ярилцана гэдэгт итгэж байна. Тэгэхээр залуучуудын өмнө юу хамгийн их тулгамдсан асуудал юм бол. Тэдгээр асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй асуудал нь юу юу байгаа талаар ярилцъя. Үндсэн 2 хүртэлх асуудлыг дурдууна уу?

P7: Юуны түрүүнд ажлын байрны асуудал. Бид ажиллах сонихол их байдаг. Харин ТВ зар, сонин гэх мэт хэрэгслээр зарлагдсан ажлын байрны шаардлага өндөр тавьдаг. Үүнд: нас, хүйс, бие бялдар, мэргэжил, өндөр нам, гэрийн байршил зэрэг маш олон бүтэштгүй, шаардлага тавьсан хэрнээ өгөх цалин, ажлын байрны аюулгүй байдал гэх мэт олон зүйл нь сэтгэлд нийцдэггүй.

P6: Бидэн шиг хувиараа хөдөлмөр эрхлэж байгаа залуус тулгарч буй хамгийн том бэрхшээл нь татварын дарамт. Улс, дүүрэг татварын талаар тодорхой мэдээлэл сургалт өгдөггүй хэрнээ улирал, жилийн тайлан гаргуулж, татвар авахаас өөр зүйл хийхгүй байж торгоны гэж айлгах явдал үнэхээр сэтгэл зүй ихээхэн дарамт болдог.

P11: Санал нийлж байна. Бидэн шиг бор зүрхээрээ хөдөлмөрлөж өрх гэр, эцэг эхээ авч явж байгаа хэрэгтэй залуусыг дэмжих төрийн бодлого үнэхээр хэрэгтэй байна. Том том компани, байгууллагуудад зориулж хууль, дүрэм баталдаг юм уу, жижиг дунд бизнес эрхэлж амиа зогоож байгаа энэ байдлыг төр засаг анхаарч үзэх хэрэгтэй байна.

P2: Би оюутан, бидэнд мөнгөний асуудал маш их байдаг. Бид заримдаа хэрэглээний мөнгөө олох гэж хүнсний сүлжээнд түгээгч, баар, караокед зөөгч, үүрэн телефоны байгууллагад опериатор зэрэг газруудад цагийн ажил хийдэг. Тэдний санал болгож байгаа цалин нь нэг цагийн 1000-2000 төгрөг, өдөрт 4-6 цаг ажиллаад дунджаар 5000-10000 төгрөг авдаг. Ингээд үзэхээр биднийг маш их шулж байгаа нь илт харагдаж байгаа биз. Үүнийг төрөөс шийдвэрлэж өгнө гэж ярьдаг ч ажил хэрэг болохгүй байна. оюутнууд ч гэсэн хүн ш дээ, муусайн оюутнууд гээд хаа сайгүй ад болдог. Бидэнд сурахын хажуугаар ажиллах таатай нөхцөл боломж олгож өгөх төрийн бодлого бидэнд зайлшгүй хэрэгтэй байна.

P8: Би МИАТ-д ажилладаг. Биднийг хаана ажилладаг гэдгийг дуулаад бусад хүмүүс их атаархсан янзтай байдаг. Гэвч бодит байдал дээр гараад харвал ажлын нөхцөл байдал шал өөр. Ажлын байранд хэл ам ихтэйгээс гадна, бусдаас дутахгүйн тулд өмсөх хувцас, барих утас, унах унаанаас эхлээд өрсөлдөх зүйл их, дээр нь аливаа баяр ёслол болоход татах мөнгө нь хэдэн арван мянга биш хэдэн зуун мянгаар тооцогдоно. Зөвхөн шинэ жилийн баярт оролцохын тулд дунджаар 300000 төгрөгөөр нийлнэ. За энэ яахав ингээд өнгөрнө. Хамгийн том бэрхшээл нь намын харъяалал, арай гэж ажилд ороод зээл авч өрх гэр, хэрэгцээгээ залгуулаад явж байтал удирдага солигдоно, бид халагдана. Удирдлагад ямар намын хэн байна, доодчуул нь түүний харъяа, ах дүү амраг садан гэх мэт яриад байвал олон асуудал гарч ирнэ.

P4: Энэ хүний яриатай санал нийлж байна. Би төрийн байгууллагад ажилладаг. Бидэнд тулгардаг хүндрэлтэй асуудлыг нэг нь намаар ялгаварлаж ажилд авдаг, халдаг энэ тогтолцоо. Засаг төр энэ асуудлыг шийдвэрлэж, төрийн байгууллагын ажилтан нь нам бус байна гэж заасан боловч, энэ нь цаасан дээр бичсэнээс цаашгүй бодит байдал дээр эсрэгээр байна. Энэ байдлаас болж залуус бид тодорхой ажил, орлогогүй, өөрийн үзэл бодлоор намд элсэх эс элсэх зэрэг олон эрх зөрчигдөж байна.

M: Залуучуудын талаар төрөөс баримтлан, хэрэгжүүлж буй ямар бодлого, үйл ажиллагааг Та мэдэх вэ?

P1: Мэдэхгүй юм байна.

P10: Оюунуудын 70000 юм болов уу.

P6: Сайн мэдэхгүй байна

P7: Ёстой мэдэхгүй юм байна. тийм ажил, аян зохион байгуулсан талаар дуулаагүй юм байна.

P4: Боловсролын салбарт тодорхой ажлуудыг хийж байгаа гэж бодож байна.

P11: Магадгүй тодорхой ажлуудыг хийж байж болох юм. Хийж байгаа ажлаа нийтэд сурталчилах, түгээх, оролцуулах байдал нь тодорхой бус, менежмент байхгүй байгаа байдлаас болж залууст хүрэх хүртээмж нь хангалтгүй, ойлгомжгүй байж болох юм.

P3: Тодорхой хэлж мэдэхгүй байна

P9: Мэдэхгүй

P2: Оюутны төлбөр нэмэрлэх 500000 олгож байсан

P4: Залуусын өдөрт зориулж тодорхой ажлуудыг нийслэлээс зохион байгуулж байсан.

M:Өнөөдрийн залуучуудад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа нь залууст төдийлөн хүрээгүй, ойлгомжгүй, оновчгүй гэж ойлгогдож байна.

P3: Тийм

P1: Тэгж л ойлгодог

P11: Тийм. Залуучуудыг уриалан дуудсан, тэдний сурах, ажиллах, амьдрах нөхцөл байдалд нь тохирхон оновчтой сайхан ажлуудыг зохион байгуулвал бид ч гэсэн хүлээн авч гар бие оролцоно. Хамгийн гол нь өнөөдрийн хэрэгцээ шаардлага, тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд биш, оромдоод байгаа нь асуудал болж байна.

М: Аанхаа, тэгвэл энэ дүүргийн хувьд залуучуудын амьжиргааны төвшин бусад насныхантай харьцуулахад ямар байна вэ?

P3: Гайгүй сайхан ажил эрхлээд амьдралаа авч явж залуус ч байгаа нь ч бий байх, өнөө маргаашаа залгуулах гэж яваа нэг нь ч бий байх. Сайн хэлж мэдэхгүй байна.

P12: Нэг үе бодвол залуучууд боловсрол эзэмшиж, мэргэжилтэй болоход их анхаарч байна. Тиймээс амьдралдаа хандах хандлага, амьдралаа авч явах байдалд идэр насныхан илүү чадавхи нь өндөр байгаа.

P6: Амжиргааны түвшин хангалттай сайн гэж хэлж чадахгүй байна. Би гэхэд л эцэг эхээрээ тэжээлгээд тэдэнтэйгээ хамт амьдарч байна.

М: Залуучуудынхаа асуудлыг шийдвэрлэх нь чухам ямар өөрчлөлт, дэвшил авчрах бол, өөрийн бодлоо хуваалцана уу?

P9: Монгол улсын хэмжээнд залуучууд дийлэнх хувийг эзэлдэг, тиймээс бага байхаас нь л тэднийг сургаж, боловсрол эзэмших үйл явцаас нь л анхаарч бодлого, арга хэмжээнүүдийг авч үзэх нь зөв байх.

P5: Өнөө маргаашийг аргацаасан биш, залуусынд тархийг цэнэглэж, улс орноо авч явах үзэл бодол, арга барилд анхаарч бодлого боловсруулмаар байна.

P1: Залуучууд эрүүл, боловсролтой байж гэмээн л энэ дүүрэг, улс орноо авч явна шүү дээ. Тиймээс аливаа асуудал, хууль дүрэм журам гаргахдаа залуучууд биднээс асуудаг, оролцуулдаг, санал бодлын хуваалцдаг баймаар байна.

P7: Би ч юу хэлэх вэ дээ. Миний хэлэх гэсэн зүйлсийг эдгээр залуус хэлчихлээ.

М: Танай дүүрэгт залуучуудын ямар байгууллага үйл ажиллагаа явуулдаг вэ, хэрэв тийм байгууллага байдаг бол эдгээр байгууллагын үйл ажиллагааны талаарх үнэлгээ?

P2: сонгуулийн үеэр л их идэвхижиж үйл ажиллагаа явуулдаг байх.

P5: зөвхөн олон нийтийн байгууллага гэхгүй залуучуудыг дэмжсэн хувь хүн олон бий. Өөрсдийн хүсэл сонирхол чадлаараа олон арга хэмжээнд оролцоод явж буй залуусыг би й мэднэ. Ж: ямарч мөнгө авахгүй дуулж, олон сайн үйлсийн аян өрнүүлж яваа.

P10: жил бүр оюутан залуусыг дэмжсэн олон үйл ажиллагаа явагддаг.

М: За бид богино хугацаанд ч болов сонирхолтой ярилцлага өрнүүллээ. Оролцсон та бүхэндээ баярлалаа. Ингээд бүгдээрээ уулзалтаа өндөрлөе.

Нэгдсэн үнэлгээ

Уг судалгаанд оролцогчид бүлгийн ярилцлагаар хэлэлцсэн дараах асуудлуудад үнэлгээ өгсөн болно.

| Үнэлэх зүйлс | Хувь/ойролцоогоор үнэлсэн\ | Санал өгсөн хүний тоо |
|--|----------------------------|-----------------------|
| ЗАЛУУЧУУДЫН ӨМНӨ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭХ БАЙДАЛ | 35 | 12 |
| ЗАЛУУЧУУДЫН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРҮҮД | 45 | 12 |

| | | |
|--|----|----|
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 25 | 10 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 30 | 10 |
| ӨНӨӨГИЙН ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛААР ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ | 50 | 10 |

Хан Уул дүүрэг
Улаанбаатар хот

**Налайх дүүргийн залуучуудтай хийсэн Фокус
бүлгийн сурвалжилгын тэмдэглэл**

Ярилцлага хийсэн огноо: 2021 оны 08 сарын 05-ны өдөр.

Ярилцлага хийсэн судлаач: М.ЦЭВЭЛМАА

Тэмдэглэл хөтөлсөн судлаач: Э.ЭНХЖИН

Ярилцлага эхэлсэн: 15.00 дууссан: 17.30

Ярилцлагад оролцогчдын талаарх мэдээлэл:

/Нийгэм хүн ам зүйн үзүүлэлтүүдийг тэмдэглэл хөтөлж буй судлаач бөглөнө./

| № | Нэр | Нас | Хүйс | Мэргэжил, ажил эрхлэлт | Хаяг |
|----|---------------|-----|---------|----------------------------|------|
| 1 | Г.Анхзаяа | 32 | Эмэгтэй | Гэртээ, хувиараа | НД |
| 2 | Л.Лхагваа | 23 | Эрэгтэй | Багш | НД |
| 3 | Б.Амарсайхан | 29 | Эрэгтэй | Улсын бүртгэгч | НД |
| 4 | Л.Оюун-эрдэнэ | 25 | Эмэгтэй | Хувиараа | НД |
| 5 | Б.Уянга | 28 | Эмэгтэй | Багш | НД |
| 6 | Г.Тэмүүлэн | 36 | Эрэгтэй | Хувиараа | НД |
| 7 | Л.Цэрмаа | 28 | Эмэгтэй | Ажилгүй | НД |
| 8 | Х.Хатансайхан | 26 | Эрэгтэй | Хувиараа | НД |
| 9 | Н.Энхням | 30 | Эмэгтэй | Оёдолчин | НД |
| 10 | Т.Цолмонтуяа | 22 | Эмэгтэй | Оюутан | НД |
| 11 | Г.Уранчимэг | 28 | Эмэгтэй | Ажилгүй | НД |
| 12 | Ц.Болд | 33 | Эрэгтэй | Хувиараа, нүүрс борлуулдаг | НД |

Респондентын дугаар:

P1. Г.Анхзаяа

P2. Л.Лхагваа

P3. Б.Амарсайхан

P4. Л.Оюун-эрдэнэ

P5. Б.Уянга

P6. Г.Тэмүүлэн

P7. Л.Цэрмаа

P8. Х.Хатансайхан

P9. Н.Энхням

P10. Т.Цолмонтуяа

P11. Г.Уранчимэг

P12. Ц.Болд

М. /модератор/ М.ЦЭВЭЛМАА

Модератор М.Сувдмаа: Судалгааны ажлын зорилгыг танилцуулж, оролцогчидтой танилцав.

Судалгаанд оролцогчдын танилцуулганас хүйс болон, ажил эрхлэлтийн мэдээллийг хүснэгтэд тэмдэглэв.

М: Таны амьдарч буй газар өсвөр, залуу, дунд, хөгшин хэмээн насны бүлэгт хуваавал ямар хувьтай байх вэ?/насны интервал 15 хүртэл, 16-38, 39-49, 50-с дээш/

P1: Манай дүүргийн хувьд хотын төвөөс алслагдмал дүүргийн нэг. Хөл хөдөлгөөн ихтэй. Сүүлийн үед залуучууд олноор суурьшиж байна.

P2: Мөн залуучууд хот руу шилжин явах нь ч их, ирэх нь ч их. Өртөг зардал харьцангуй гайгүй байдаг тул эндээс хот руу ажилдаа явах, ирэх нь бий. Залуучууд ихтэй.

P5: Насны хувьд залуучууд болон өсвөр насныхан нэлээдгүй бий. Мөн тэтгэвэрт гарсан хүмүүс ч эндээ суурьшин амьдрах сонирхолтой байдаг. Утаа хотыг бодвол харьцангуй гайгүй.

P8, P5: Яг энэ талаар тооцоолж байгаагүй юм байна. Ойролцоогоор бол 15 хүртэлх насныхан 20 гаруй хувийг эзлэх байх. Мөн 16-38 насныхан 30-40 хувийг, за тэгээд үлдсэн нь хижээл болон хөгшин настай хүмүүс байгаа гэж бодож байна.

P3: Ер нь тиймэрхүү байгаа байх.

P12: Ер нь 60 гаруй хувь нь залуучууд байгаа байх. Үлдсэн хувь нь хижээл болон хөгшчүүл байгаа болов уу.

М: За тэгвэл бүгдээрээ эдгээр саналуудаа нэгтгэе. Орлоцогчид санал нэгтгэйгээр дараах байдлаар хүн амын насны хувийг гаргалаа.

| Насны бүлэг | Хувь |
|-------------|------|
| 15 хүртэл | 25% |
| 16-38 | 35% |
| 39-49 | 20% |
| 50-с дээш | 20% |

М: Таны амьдарч буй нутаг оронд эдгээр насны хүмүүсийн, ялангуяа залуучуудын өмнө юу хамгийн их тулгамдсан байдаг вэ?. Үндсэн 1-2 асуудлыг дурдана уу.

P12: Залуучуудын хувьд тулгамдсан асуудал гэвэл ажилгүйдэл их, орлого бага байна. Дүүрэгт залуучууд ажиллахаар ажлын байр байхгүй.

P7: Боловсролын чанарт төрөөс онцгой анхаарах, зөвхөн боловсрол олгоод зогсохгүй хүмүүжил, төлөвшил, хөгжилд онцгой анхаарах

P11: Ажил олддоггүй. Залуучуудын ажиллаж байгаа газар нь нүүрс болохоор үүнтэй холбоотой гэмт хэрэг гарах нь цөөнгүй. Дүүргийн удирдлагууд ажлын байр нэмэгдүүлж байгаа гэж ярьдагч бидний амьдралд мэдэгдэх зүйл байхгүй л байна.

P2: Мэргэжилгүй битгий хэл, мэргэжилтэй хүмүүс ажил эрхлэхэд төвөгтэй байдаг. Бас нэг асуудал бол архидалт. Ажилгүй залуучууд ихэвчлэн архи уудаг. Түүнээсээ болоод зодоон цохион, агсан согтуу тавьдаг.

P6: Одоогийн нийгэмд ажилтай, орлоготой байх нь санааных гэж боддог. Гэхдээ залуучуудын хувьд орлого багатай, амьдралын ачааг нуруундаа үүрч байгаа. Манай дүүргийн хувьд залуучуудын дийлэнх нь ажилгүй, хийж байгаа ажил нь нүүрс олборлох, худалдаа наймаа хийх зэргээр хувиараа хөдөлмөр эрхэлж байна.

P4: Харин тийм. Залуучуудын хувьд ажил олж амьдрахад нэлээд хэцүү. Эрэгтэй хүмүүсийн хувьд нүүрс энээ тэрээ гээд ажил олоод хийчихдэг. Харин эмэгтэйчүүд бидний хувьд хувцас оёдол хийнэ. Эсвэл гэрээ харж, хүүхдүүдээ харах болдог.

P3: Ажилгүйдэл, ажлын байрны асуудал. Тэгээд архидалт, гэмт хэрэг, эрүүл мэнд, осол аваар орох болов уу?

М: Залуучуудын талаар төрөөс баримтлан, хэрэгжүүлж буй ямар бодлого, үйл ажиллагааг Та мэдэх вэ?

P5: Залуу багш нарыг дахин сургах тал дээр нэлээдгүй анхаарч ажиллаж байгаа гэж боддог. Манай сургуулиас хэд хэдэн залуу багш нар мэргэжил дээшлүүлэх курст хамрагдсан.

P2: санал нэг байна.

P1: Залуучуудын талаар тийм бодлого байдгийг сайн мэдэхгүй байна.

P7: Хүүхдэд өгч байгаа мөнгөн тэтгэмж үүнд хамаарах уу?. Бүх өрхийн хүүхдэд өгч байгаа юм чинь залуу хүмүүс ч мөн хамрагдаж байгаа байх.

P8, P10, P11: Энэ талаар сонсож байгаагүй. Өдий болтол бидэнд төрөөс дэмжлэг гээд байх зүйл байсан гэж хэлэхэд бэрх.

P3: Яг төрийн салбарт ажиллаж байгаа хүмүүс л энэ талаар хэлж мэдэх байх, тэрнээс шууд тийм, ийм бодлого байгаа гэж хэлэхэд хэцүү.

М: Та өнөөдрийн залуучуудын талаарх бодлого, үйл ажиллагааг хэр оновчтой гэж үздэг вэ?

P4: Сайн мэдэхгүй байгаа болохоор энэ талаар үнэлж мэдэхгүй л байна.

Тэмдэглэл хөтлөгч: P6, P8, P11, P12 Бид мэдэхгүй болохоор энэ талаар үнэлж мэдэхгүй байв.

М: Залуучуудын асуудлаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилт Таны бодлоор?

P3: Ер нь залуучуудын асуудлаар хэрэгжүүлж байгаа бодлого үйл ажиллагаа хангалтгүй гэж боддог. Хэрэв сайн байсан бол залуучууд ийм хүнд нөхцөлд ажиллаж амьдрахгүй байх байсан. Манай дүүргийн ихэнх дунд эргэм насны залуус нүүрс олборлож зардаг. Тэр нь ердөө улирлын шинжтэй. Зунд нь хийх ажилгүй ачаа бараа зөөх ажил хийнэ.

Тэмдэглэл хөтлөгч: Бусад хүмүүсийн хувьд залуучуудын асуудлаар төрөөс ямар үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа талаар санал хэлж мэдэхгүй байв.

М: Нутгийн залуучууд чухамхүү ямар ажил хөдөлмөр голчлон эрхэлж амьдарч байна вэ?. Амьдралын гол эх үүсвэр болж байгаа 3 зүйлийг дурдана уу.

P12: Залуучуудын хувьд нүүрс олборлож хувиараа хөдөлмөр эрхэлж байна. Хувийн пүүс компани зарим нь ажиллаж байгаа. Эцэг эхийнхээ тэтгэмж, эсвэл хүүхдийн мөнгөөрөө амьдарч байгаа хэсэг ч бий.

P7: Ер нь хэлчихлээ дээ. Эдгээр зүйлс, бас дээр нь худалдаа арилжаа хийж нэг хэсэг нь амьдарч байгаа.

P2: Мэргэжилтэй залуучуудын хувьд төрийн болон төсвийн газарт ажиллаж амьдарч болоод байна. Гэхдээ орлого бага ч, тогтвортой, зардал их болохоор амьдрахад боломжийн байдаг.

М: Залуучуудын амьжиргааны төвшин бусад насныхантай харьцуулахад ямар байна вэ?

P9: Залуучуудын амьжиргааны төвшин бусад насныхантай харьцуулахад гайгүй. Нэг үеэ бодвол арилжаа наймаа хийгээд зарим нь хөлжсөн байдаг.

P4: Гэхдээ хэцүү ш дээ. Ихэнх залуучуудын хувьд ахмад, хижээл насны хүмүүсийг бодвол эмзэг байдаг. Тэдэнд найдвартай орлогын эх үүсвэр байхгүй. Хөгшчүүд бол тэтгэврээ авчихна. Хажуугаар нь сахиул энээ тэрээ хийчихнэ.

P10: Одоогийн залуучууд ажлыг их голж шилдэг. Цалингийн хэмжээг нь харна. Үнэхээр амьдралд шаагдаад ирэхлээр олдсон ажлыг голж шилэлгүй хийх л байх л даа. Ер нь залуучууд хөгшчүүдийн тэтгэврээ тэтгэмжээр амьдарч байгаа нь нууц биш шүү дээ.

М: Орон нутагт ажиллаж буй залуучуудын ямар нэг байгууллага/төрийн болон олон нийтийн/-тай хамтарч ажилладаг уу?, хэрэв ажилласан бол хэзээ, хэрхэн, ямар асуудлаар хамтарч ажилласан бэ?

P7: Орон нутагт гэхлээр гадны байгууллагууд бий. Манай дүүрэгт Казахууд нэлээдгүй бий. Казах залуучуудад туслалцаа үзүүлэх аян нэлээдгүй зохион байгуулагддаг.

P6: Дэлхийн зон ОУБ гэж бий. Залуучуудын талаар нэлээдгүй ажлууд хийсэн.

Тэмдэглэл хөтлөгч: Эдгээрээс бусад хүмүүсийн хувьд санал нэгтэй ажиллаж байгаагүй гэнэ.

М: Залуучуудын асуудлыг шийдвэрлэх нь орон нутагт чухам ямар өөрчлөлт, дэвшил авчрах?, өөрийн бодлоо хуваалцана уу?

P3: Маш их өөрчлөлт авчирна. Ажилгүй залуучуудын асуудлыг шийдвэрлэхийн тулд давхар давхар асуудлыг шийдвэрлэнэ гэж боддог. Өнөөдөр хэн ажилгүй байна, тэр хүмүүс архидаж байна, мөн гэмт хэрэгт холбогдож байна. Тэгэхлээр ажилгүйдлийг л нэн түрүүнд шийдвэрлэх хэрэгтэй.

P12: Хувиараа нүүрс олборлож байгаа хүмүүсийн эрүүл мэндэд анхаарах хэрэгтэй гэж боддог. Маш хүнд нөхцөлд, агааржуулагч байхгүй нүхэнд ажилладаг. Ихэнх газрыг хятадууд авчихсан. Залуучууд хөлсөөр өдрийн 15-20 мянган төгрөгөөр ажиллаж байгаа нь ч цөөнгүй. Үнэхээр хэцүү.

P2: Гэртээ ажилгүй, юм хийхгүй байгаа хүмүүс их бий. Тэдгээр хүмүүсийг л ажилтай болгох хэрэгтэй байна. Манай дүүргийн асуудал бол ажлын байр хомс байгаа явдал гэж боддог.

Нэгдсэн үнэлгээ

Уг судалгаанд оролцогчид бүлгийн ярилцлагаар хэлэлцсэн дараах асуудлуудад үнэлгээ өгсөн болно.

| Үнэлэх зүйлс | Хувь\ойролцоогоор үнэлсэн\ | Санал өгсөн хүний тоо |
|--|----------------------------|-----------------------|
| ЗАЛУУЧУУДЫН ӨМНӨ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭХ БАЙДАЛ | 40 | 12 |
| ЗАЛУУЧУУДЫН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРҮҮД | 50 | 12 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 40 | 10 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 35 | 10 |
| ӨНӨӨГИЙН ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛААР ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ | 45 | 8 |

Налайх дүүрэг
Улаанбаатар хот

**Сүхбаатар дүүргийн залуучуудтай хийсэн Фокус
бүлгийн сурвалжилгын тэмдэглэл**

Ярилцлага хийсэн огноо: 2021 оны 09 сарын 15-ны өдөр.

Ярилцлага хийсэн судлаач: Т.ЛХАГВАА

Тэмдэглэл хөтөлсөн судлаач: Ж.ШИНЭХҮҮ

Ярилцлага эхэлсэн: 16.30 дууссан: 18.30

Ярилцлагад оролцогчдын талаарх мэдээлэл:

/Нийгэм хүн ам зүйн үзүүлэлтүүдийг тэмдэглэл хөтөлж буй судлаач бөглөнө./

| № | Нэр | Нас | Хүйс | Мэргэжил, ажил эрхлэлт | Оршин суугаа хаяг |
|----|---------------|-----|---------|----------------------------------|-------------------|
| 1 | Г.Бямбажаргал | 19 | Эмэгтэй | Оюутан | СБД |
| 2 | Ц.Дашдорж | 27 | Эрэгтэй | Лаборант, ХТА | СБД |
| 3 | О.Одгэрэлхам | 29 | Эмэгтэй | Цагдаагийн газарт | СБД |
| 4 | Б.Сайнбилэг | 32 | Эмэгтэй | Эдийн засагч, Хаан банкны теллэр | СБД |
| 5 | М.Хатанбаатар | 28 | Эрэгтэй | Цэцэрлэгийн багш | СБД |
| 6 | С.Дөлгөөн | 18 | Эмэгтэй | МУБИС, оюутан | СБД |
| 7 | Т.Бадамханд | 22 | Эмэгтэй | Ажилгүй | СБД |
| 8 | Б.Батчимэг | 19 | Эмэгтэй | МУИС, оюутан | СБД |
| 9 | Ц.Батболд | 25 | Эрэгтэй | Хувиараа | СБД |
| 10 | Г.Эрдэнэсүрэн | 22 | Эрэгтэй | ШУТИС, оюутан | СБД |
| 11 | Ц.Болормаа | 29 | Эмэгтэй | Хуульч | СБД |
| 12 | О.Мөнхбат | 24 | Эрэгтэй | Ажилгүй | СБД |

Танилцах ярилцлага: Мөс хагалах буюу сэдэл төрүүлэх

Энэ шатанд судлаач өөрсдийгөө болон судалгааны зорилгын талаар танилцуулна. Мөн ярилцлага хийх тоглоомын дүрмийг санал нэгтэй батална.

Асуулгын ерөнхий чиглэлүүд

1. Оролцогч тус бүр өөрийнхөө талаар товчхон танилцуулна уу?
2. Таны амьдарч буй газар өсвөр, залуу, дунд, хөгшин хэмээн насны бүлэгт хуваавал ямар хувьтай байх вэ?/насны интервал 15 хүртэл, 16-38, 39-49, 50-с дээш/
3. Таны амьдарч буй нутаг оронд эдгээр насны хүмүүсийн, ялангуяа залуучуудын өмнө юу хамгийн их тулгамдсан байдаг вэ?. Үндсэн 1-2 асуудлыг дурдуулах.
4. Залуучуудын талаар төрөөс баримтлан, хэрэгжүүлж буй ямар бодлого, үйл ажиллагааг Та мэдэх вэ?
5. Та өнөөдрийн залуучуудын талаарх бодлого, үйл ажиллагааг хэр оновчтой гэж үздэг вэ?
6. Залуучуудын асуудлаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилт Таны бодлоор?
7. Нутгийн залуучууд чухамхүү ямар ажил хөдөлмөр голчлон эрхэлж амьдарч байна вэ?. Амьдралын гол эх үүсвэр болж байгаа 3 зүйлийг дурдана уу.
8. Залуучуудын амьжиргааны төвшин бусад насныхантай харьцуулахад ямар байна вэ?
9. Орон нутагт ажиллаж буй залуучуудын ямар нэг байгууллага/төрийн болон олон нийтийн/-тай хамтарч ажилладаг уу?, хэрэв ажилласан бол хэзээ, хэрхэн, ямар асуудлаар хамтарч ажилласан бэ?
10. Залуучуудын асуудлыг шийдвэрлэх нь орон нутагт чухам ямар өөрчлөлт, дэвшил авчрах?, өөрийн бодлоо хуваалцана уу?

Респондентын дугаар:

- P1. Г.Бямбажаргал
- P2. Ц.Дашдорж
- P3. О.Одгэрэлхам
- P4. Б.Сайнбилэг
- P5.М.Хатанбаатар
- P6. С.Дөлгөөн
- P7. Т.Бадамханд
- P8. Б.Батчимэг

P9. Ц.Батболд
P10. Г.Эрдэнэсүрэн
P11. Ц.Болормаа
P12. О.Мөнхбат
М. /модератор/ Т.ЛХАГВАА

М: Та нарын хувьд соёлтой хүн гэж ямар хүнийг хэлэх вэ?

P3: Миний бодлоор биеэ зөв авч явдаг, бусадтай зөв боловсон харьцдаг хүнийг хэлнэ, түүнээс биш маш олон дээд сургууль төгссөн дипломтой хүнийг хэлэхгүй орчин үед яг ийм хандлага их байна. Их дээд сургууль төгссөн дипломтой хүн л бол соёлтой мундаг хүн гэж боддог болж.

P10: За зарим нь тийм л байдаг юм байгаа биз гэхдээ бүгд тийм биш ш дээ.

P1: Би бодохдоо нэг үеэ бодоход монголчууд их соёлтой болж байна гэж боддог, хуучин бидний бага байхад хогоо ил задгай хаа хамаагүй хаядаг байсан харин одоо энэ үзэгдэл багассан. Хаа сайгүй хогийн цэг байдаг болсон би ер нь гадуур явахдаа хог ил хаяж байга хүнийг хардаггүй.

P4: Монголчууд соёлгүй байна, энэ нийгэмд харилцааны соёлтой хүн бараг алга эр эмгүй байнга хараалийн үг этгээд гаж үг хэлж, архи ууж, тамхи маш их татаж байна. Магадгүй энэ нь эцэг эхийн хүмүүжилээс, өсч буй орчиноос нь болдог байх.

P:2 0-18 хүртэлх насны бүх хүүдүүдэд эрүүл мэнд, ёс суртахууны боловсрол маш цэгцтэй дэс дараалалтай системтэйгээр сургалтын хөтөлбөрт суулгаж өгөх, эрдэм мэдлэг хэрэгтэй хэдий ч, хүн байх, хүнлэг байх чанар илүү хэрэгтэй байна.

P8: Хотын хүүхдүүдийг бодвол хөдөөний хүүхэдүүд илүү иймэрхүү тал дээр соёлтой байх, хөдөө газар жаахан охидууд тамхи татаад явах нь ховор шүү дээ. Хүн харвал гайхна, энд бол хамаагүй ш дээ хаа сайгүй ичиж зовохоо мэдэхгүй жаахан охидууд тамхи татаад л явдаг.

М: Залуучуудын орчин, амьдралын чанарын сэтгэл ханамжид үнэлгээ өгөхгүй юу? Сайн зүйл нь юу байна? Муу зүйл нь юу байна?

P11: Энэ тал дээр бол сэтгэл маш дундуур явдаг, байнга уур бухимдалтай давчуу жижигхэн ямар ч зохион байгуулалт байхгүй гадагшаагаа биш дотогшоогоо барилга байгууламж нь баригддаг

P5: Өглөө босоо л хар бараан сэтгэлтэй босдог, бөөн утаа тэгээ л автобусанд суудаг чихэлдээд л нил түгжрээ, явна гэж байхгүй 1 буудлын хооронд 20,30-аад минут явж байгаа юм чинь улсын нийслэл гэхэд арай л бишээ ёстой хэцүү ш дээ.

P2: Хэтэрхий амиа бодсон хүмүүс, гудамжинд хоёр хүн зодолдож байвал салгах хүн олдохгүй дэргэд нь зогсож байгаад л бичлэг хийж аваад л орой нь Facebook-т хийнэ дээ. Бие биедээ туслана гэсэн ойлголт байхгүй зундаа тоосжилт, хуурайшилтай өвөлдөө утаатай хавардаа өмхийтэй ийм л нийгэмд амьдарч байна даа

P6: Сайн тал гэж бараг л байхгүй байшин барилга нь чанаргүй, хүмүүс нь ашгийн төлөө л явдаг. Зан чанар хүний мөс гэж хөгшин залуугүй байхаа больсон, зам хөндлөн том тортой зүйл барин гарч байгаа эмээд туслахаар очдог тэгэхээр хулгайч гээд л янзан бүрээр дуудаа л бараг л зайл гэж байгаа юм чинь хөгшчүүд нь ийм байхлаар одоо яах вэ

P8: Сайн зүйл гэвэл одоо сайжрах гээд тэмцээд байгаа нь авууштай юм даа

P3: Сайн гэвэл одоо чинь сургууль цэцэрлэг их баригдаж байна. Үзвэр үйлчилгээ нэмэгдэж байна.

М: Залуучуудад чиглэсэн төрөөс баримтлан хэрэгжүүлж буй ямар бодлого үйл ажиллагааг та бүхэн мэдэх вэ?

P1: Оюутны 70,000, Виза, гэр бүлд зориулсан бага хүүтэй зээл гэх мэт байна

P4: Шинээр гэр бүл болж байгаа хүмүүст мөнгө өгөөд байдаг. Мөн алдарт эхийн одонтой хүмүүс жирэмсэн хүмүүст тэтгэвэр тэтгэмж гээд л зөндөө байдаг ш дээ

М: Тэгвэл эдгээр үйл ажиллагаа нь та бүхний бодлоор хэр оновчтой байна вэ?

P9: Хүмүүс хэрхэн зарцуулж байгаагаас л шалтгаална.

P6: Бидэнд мөнгө өгөхийн оронд харин бидэнд хэрэгцээтэй зүйлээр хангах нь дээр байх үйлдвэр, номын сан гэх мэтчилэн байгуулах

P3: Энэ нь 2 талтай сайн ч тал бий муу ч тал бий сайн зүйл нь эдгээрийг амьдралдаа зөв хэрэглэж зарцуулж байгаа нь, муу тал нь зөв зүйтэй хэрэглэхгүй байгаа явдал юм. Төрөөс ер нь хүүхдүүдийн 70-ыг сайн судалж байгаад өгөх нь зүйтэй байх /эдийн засгийн байдлыг нь харж өгвөл/

P11: Гарах ажлын байр нь дээр нь нэмэрлэвэл зүгээр байх аа.

М: Залуучуудын дунд эрүүл мэндийн ямар асуудал тулгамдсан шинжтэй байдаг вэ?

P7: Багтраа өвчин энэ нь тамхинаас болдог, залуучууд их тамхи татдагаас л болж байгаа бас биеийн тамир, спортоор хичээлэхгүй болохоор биеийн эсэргүүцэл муу байдаг.

P6: Бэлгийн замын халдварт өвчин их тусдаг үүнийгээ нуугаад даамжруулдаг ер нь 10 жилээс нь “Эрүүл мэнд”-ийн хичээлийг сайн оруулах хэрэгтэй.

P3: Толгой, хоолой өвчин их байдаг.

P11: Хоол хүнснээс болж ходоодны өвчин их тусдаг.

P6: Мөн нимгэн нойтон хувцасласнаас болоод бөөрний өвчин тусдаг

P1: компьютер болон РС их тоглодог энэ нь нүдэнд их муу нөлөөтэй юм.

М: Залуучуудын орлогын эх үүсвэр юу байдаг юм бэ?

P12: Мэргэжлээрээ ажилах гэхээр мөст нь дүүрсэн авдаггүй гэсэн, тиймээс хэдий их дээд сургууль төгссөн ч гэсэн гадаад руу явж халтуур хийж амьдардаг хүмүүс их болсон

P3: Ер нь хүүхдүүд амралтаараа барилгын ажил, зөөгч, судалгааны ажил их хийдэг

P4: Уул уурхай, барилга хувийн бизнес их эрхэлдэг

P7: Орон нутагт газар тариалан, мал аж ахуй эрхэлж байна.

P11: Цалингаараа л орлогын их үүсвэрээ хангаж байна. Үндсэн ажлын хажуугаар ажиллах боломж нөхцөл, зохицуулалт гээд байх юм байдаггүй болохоор нэмэлт ажил эрхлэхэд хүндрэлтэй байдаг.

М: Хот хөдөөгийн залуучуудын хөдөлмөрийн ялгаа

P3: Хөдөөгийн залуус мэдээлэл технологиор дутмаг байдаг. Хотод бол олон хүнтэй газар өрсөлдөөн ихтэй байдаг учраас хотынх нь илүү байдаг.

P2: Төр дэд бүтцийн асуудлаа ижил шийдэж чадахгүй байна.

P3: Хотын хүүхдүүдийг бодвол хөдөөний хүүхдүүд гэрээсээ хол болохоор арай илүү биеэ дааж сурсан байдаг байх

P12: Хөдөөгийн залуус амьдралаа авч явахын тулд гадаад тэр дундаа Солонгост очиж ажиллах тохиолдол их болсон.

М: Залуучуудын асуудлыг шийдвэрлэснээр, залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулснаар хөдөө орон нутагт ямар өөрчлөлт, хөгжил дэвшлийг авчирна гэж бодож байна вэ?

P2: Орон нутагт шинэчлэлт явагдах нь ер нь сонгуультай холбоотой байдаг сонгууль эхлэхээр л барилга байгууламж баригдаад л замууд засварт ороо л байдаг.

P10: Нэгдүгээрт ажлын байр, хоёрдугаарт орон сууц, гуравдугаарт эрүүл мэндийн тогтолцоо зэрэг ажлуудыг сууриар нь төлөвлөж, хэрэгжүүлэх юм бол олон өөрчлөлт, хөгжлийг авчиргах болно.

М: Танай дүүрэгт залуучуудын ямар байгууллага үйл ажиллагаа явуулдаг вэ, хэрэв тийм байгууллага байдаг бол эдгээр байгууллагын үйл ажиллагааны талаарх үнэлгээ?

P5: Манай дүүрэгт олон байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Тэдний үйл ажиллагааг үнэлнэ гэдэг хэцүү л дээ.

P2: Эмэгтэйчүүдийн байгууллагууд их идэвхи санаачлагатай ажилладаг. Эмэгтэйчүүдийн баяр хүүхдийн баяр зэрэгт идэвхитэй ажилладаг

P11: Залуучуудыг дэмжих бодлого маш их хэрэгтэй байна. Залуучуудын нийгмийн идэвх оролцоог сайжруулах, мэдлэг мэдээллээ солилцдог болгох хэрэгтэй.

P8: Манай дүүрэгт олон байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг ч тодорхой мэдээлэл алга

Нэгдсэн үнэлгээ

Уг судалгаанд оролцогчид бүлгийн ярилцлагаар хэлэлцсэн дараах асуудлуудад үнэлгээ өгсөн болно.

| Үнэлэх зүйлс | Хувь\ойролцоогоор үнэлсэн\ | Санал өгсөн хүний тоо |
|--|----------------------------|-----------------------|
| ЗАЛУУЧУУДЫН ӨМНӨ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭХ БАЙДАЛ | 55 | 12 |
| ЗАЛУУЧУУДЫН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРҮҮД | 60 | 10 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 50 | 10 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 40 | 10 |
| ӨНӨӨГИЙН ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛААР ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ | 60 | 10 |

Сүхбаатар дүүрэг

Улаанбаатар хот

**Сонгинохайрхан дүүргийн залуучуудтай хийсэн Фокус
бүлгийн сурвалжилгын тэмдэглэл**

Ярилцлага хийсэн огноо: 2021 оны 09 сарын 10-ны өдөр.

Ярилцлага хийсэн судлаач: М.СУВДМАА

Тэмдэглэл хөтөлсөн судлаач: Ж.ШИНЭХҮҮ

Ярилцлага эхэлсэн: 15.30 дууссан 17.50

Ярилцлагад оролцогчдын талаарх мэдээлэл:

/Нийгэм хүн ам зүйн үзүүлэлтүүдийг тэмдэглэл хөтөлж буй судлаач бөглөнө./

| № | Нэр | Нас | Хүйс | Мэргэжил, ажил эрхлэлт | Хаяг, байршил |
|----|----------------|-----|------|------------------------|---------------|
| 1 | Ц.Сангажав | 26 | Эр | Цайны газарт зөөгч | СХД |
| 2 | Г.Бадамханд | 33 | Эм | Хувиараа | СХД |
| 3 | Б.Дамдинбазар | 30 | Эр | ЕБС-д багш | СХД |
| 4 | Г.Алтангэрэл | 37 | Эм | Талх чихэр ажилтан | СХД |
| 5 | Л.Баянзул | 29 | Эм | Мандах ДС, оюутан | СХД |
| 6 | Ц.Мягмар | 20 | Эр | Мандах ДС, оюутан | СХД |
| 7 | Ш.Жаргалсайхан | 28 | Эр | Хувиараа | СХД |
| 8 | Т.Цэрэннадмид | 36 | Эм | Ажилгүй | СХД |
| 9 | С.Хандмаа | 26 | Эм | Ажилгүй | СХД |
| 10 | М.Банзрагч | 37 | Эр | УБТЗ, үзэгч | СХД |
| 11 | А.Амаржаргал | 28 | Эр | Жолооч | СХД |
| 12 | С.Ганбаяр | 36 | Эр | Багш | СХД |

Танилцах ярилцлага: Мөс хагалах буюу сэдэл төрүүлэх

Энэ шатанд судлаач өөрсдийгөө болон судалгааны зорилгын талаар танилцуулна. Мөн ярилцлага хийх тоглоомын дүрмийг санал нэгтэй батална.

Асуулгын ерөнхий чиглэлүүд

- Оролцогч тус бүр өөрийнхөө талаар товчхон танилцуулна уу?
- Таны амьдарч буй газар өсвөр, залуу, дунд, хөгшин хэмээн насны бүлэгт хуваавал ямар хувьтай байх вэ?/насны интервал 15 хүртэл, 16-38, 39-49, 50-с дээш/
- Таны амьдарч буй нутаг оронд эдгээр насны хүмүүсийн, ялангуяа залуучуудын өмнө юу хамгийн их тулгамдсан байдаг вэ?. Үндсэн 1-2 асуудлыг дурдуулах.
- Залуучуудын талаар төрөөс баримтлан, хэрэгжүүлж буй ямар бодлого, үйл ажиллагааг Та мэдэх вэ?
- Та өнөөдрийн залуучуудын талаарх бодлого, үйл ажиллагааг хэр оновчтой гэж үздэг вэ?
- Залуучуудын асуудлаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилт Таны бодлоор?
- Нутгийн залуучууд чухамхүү ямар ажил хөдөлмөр голчлон эрхэлж амьдарч байна вэ?. Амьдралын гол эх үүсвэр болж байгаа 3 зүйлийг дурдана уу.
- Залуучуудын амьжиргааны төвшин бусад насныхантай харьцуулахад ямар байна вэ?
- Орон нутагт ажиллаж буй залуучуудын ямар нэг байгууллага/төрийн болон олон нийтийн/-тай хамтарч ажилладаг уу?, хэрэв ажилласан бол хэзээ, хэрхэн, ямар асуудлаар хамтарч ажилласан бэ?
- Залуучуудын асуудлыг шийдвэрлэх нь орон нутагт чухам ямар өөрчлөлт, дэвшил авчрах?, өөрийн бодлоо хуваалцана уу?

Респондентын дугаар:

- P1. Ц.Сангажав
- P2. Г.Бадамханд
- P3. Б.Дамдинбазар
- P4. Г.Алтангэрэл
- P5. Л.Баянзул
- P6. Ц.Мягмар
- P7. Ш.Жаргалсайхан
- P8. Т.Цэрэннадмид
- P9. С.Хандмаа
- P10. М.Банзрагч

P11. А.Амаржаргал

P12. С.Ганбаяр

М. /модератор/ М.СУВДМАА

М: Соёлтой хүн гэж ямар хүнийг хэлэх вэ? Өнөөгийн залуус хэр соёлтой байна вэ?

P1: Одоогийн залуус өндөр боловсролтой, соёлтой болсон.

P9: Харилцаа нь бидний үеийг бодвол өөр болсон. Залуучууд болохгүй зан араншин гаргаж байгаа нь нийгмээсээ болж байгаа гэж боддог. Одоо нийгэм хөгжиж сайхан болж байгаа гэж ярьдаг ч эсрэгээрээ дэндүү муухай болж байгаа.

P4: Бүх залуусыг муу гэж хэлж болохгүй. Сайн залуус зөндөө бий.

P7: Их соёлтой болсон. Наад зах нь л гэхэд автобусанд настай хүн орж ирхэд суудал тавьж өгдөг.

М: Та бүхний амьдарч буй нутаг оронд өсвөр, залуу, дунд, хөгшин насныхан гэж бүлэглэвэл эдгээр насны хүмүүсийн өмнө ялангуяа залуучуудын өмнө ямар асуудал хамгийн их тулгамдаж байна вэ?

P2: Бидний үе одоо үеийнхээс илүү сайхан байсан. Хүн амын нягтаршил хэтэрхий их болсноос болоод хот жаахан замбаараагүй болсон.

P3: Монголчууд дээр үед ахмад үеэ хүндэтгэн тэднээс суралцаж бие биенээ хайрлах гэх мэт сайхан зүйл их байдаг байсан. Гэвч одоо үед бүх юмыг зоосны нүхээр харж байгаа нь биднийг доош татаж байна.

P8: Утаа хог хаягдал, замбараагүй архидалт зэргээр хот ерөнхийдөө сагаж байна.

P6: Юмны үнийн хөөрөгдөл газар авч байна. Энэ бол хүмүүсийн хувьд маш том асуудал болдог. Мэдээж цалин нэмэхгүй байж өргөн хэрэглээний бараны үнэ нэмэгдэх нь юу нь сайхан байх вэ дээ.

P5: Одоо үед хүнээсээ илүү машинтай болсон байна. Үүнээс болж түгжрэл их байна.

М: Залуучууд голчлон ямар ажил хөдөлмөр эрхэлж амьдарч байна вэ?

/орлогын эх үүсвэр /

P4: Өөрөө хөдөлмөрлөж мөнгө олж байгаа хэсэг залуус байхад эцэг эхээсээ авдаг хэсэг залуус бас байдаг.

P7: Сургуулиа төгсчихөх юм бол өөрөө мөнгөө олдог. Харин оюутан байхдаа эцэг эхээсээ л авдаг байх.

P9: Хичээлийнхээ хажуугаар цагийн ажил хийж мөнгө олдог оюутнууд байдаг юм билээ.

P10: Ажилгүйдэл нилээд байр эзэлж байна. Ихэнх хүүхдүүд их дээд боловсролыг сонирхдог. Их дээд сургууль төгссөн диплом барьсан ажилгүй залуучууд их байна.

P7: Ажилд авахдаа насны хязгаар өндөр нам гадаад төрхийг нь их хардаг болж, энэ бол маш буруу. Үүнээс болж ажилгүйдэл нэмэгдэж байгааг үгүйсгэх аргагүй.

P12: Хувийн компанид их ажиллаж байна. Ажилтай, орлоготой, боловсролтой залуу гэр бүлийг дэмжиж, тоог нэмэгдүүлэх

P9: Хөдөөгүүр ажил их байдаг. Залуус өөрсдөө хөдөө ажиллах дургүй байдаг.

P2: Бүгд л дээд боловсрол гээд байдаг. Ажилчин анги бас байх ёстой. Ер нь ажилгүй байгаа нь залуусын өөрсдийнх нь буруу ч бас бий. Одоо үеийн залуус дэндүү бэлэнчлэх сэтгэлгээтэй болсон.

P11: Одоо үед хэлний мэдлэгийг шалгуур болгож ажилд их авдаг болсон байна.

М: Залуучуудын амжиргааны түвшин бусад насныхантай харьцуулахад ямар байна вэ?

P7: Сайн гэж хэлж чадахгүй. Яагаад гэвэл эх орондоо ажиллаж байгаа залуучуудын цалин гаднаас орж ирэн ажиллаж байгаа хятдуудынхаас бага байна. Үүнээс болж залуучуудын урам зориг нь хугарч ажил хийх сонирхолгүй болж байна.

P6: Сайнгүй л байгаа байх. Ихэнх залуу гэр бүл банкинд зээл тавин амьдарч байна. Уг нь гадны хүмүүсийг ажлаар хангахын оронд эх орны залуучуудыг ажлын байраар хангавал амжиргаа нь дээшлэх байх даа.

P1: Дундаас доогуур байна. Нэг хэсэг залуучууд бараг тэтгэврийн эцэг эхээрээ гэжээлгэж байна.

P8: Үнэхээр чадвар мэдлэг сайтай амжиргааны түвшин нь дээгүүр байгаа залуус нийгэмд байгаа гэж бодож байна.

M: Залуучуудад чиглэсэн төрөөс баримтлан хэрэгжүүлж буй ямар бодлого үйл ажиллагааг та бүхэн мэдэх вэ?

P2: Сонгуульд илүү оноо авах гэсэн хүмүүсийн явуулга болох 70000

P1: Сайн мэдэхгүй юм. Одоо бол чадах нэг нь амьдар чадахгүй нэг нь үх гэдэг л болсон цаг үе.

P6: Гадаад дотоодод үнэгүй сургаж өгдөг тэтгэлэг.

M: Залуучуудын дунд эрүүл мэндийн ямар асуудал тулгамдсан шинжтэй байдаг вэ?

P9: Бүх зүйл хүнсний бүтээгдэхүүнээс л болж байгаа. Цэвэр бүтээгдэхүүн гэж байхгүй. Баталгаагүй муу хүнс хэрэглэснээс болж эрүүл мэнд мууддаг.

P8: Цай чанахдаа хуурай сүү их хэрэглэж байна.

P5: Одоогийн хүнсэнд химийн найрлага маш их байдаг.

P1: Одоогийн залуучууд гадны бүтээгдэхүүнд хэт автсан байна. Гадны юм болгоныг сайн чанартай гэж бодон хэрэглэж эрүүл мэндээрээ хохирох тохиолдол их байна.

P4: Хоолой ам нь өвдөж ханиад маш амархан тусдаг.

P6: Уушгины өвчин.Энэ нь эдгэрдэг өвчин гэж ярьдаг ч манайх шиг утаа бохирдол ихтэй газар бүрэн эдгэрнэ гэдэг хэцүү.

P7: Байгалийн цэвэр бүтээгдэхүүн хэрэглээгүйгээс болж ходоод их өвдөж байна.

M: Төрийн бодлого үйл ажиллагаа орон нутагт нөлөөлж чадаж байна уу?

P2: Нээх нөлөөлж чададгүй. Саяхнаас ноосны урамшуулал махны урамшуулал гэж өгдөг болсон.

P3: Чадахгүй байгаа. Уул уурхайгаас болж ус нь бохирдож түүнийг нь мал ууж хорогдсоор байна.

P1:Энэ жилээс эхлэн орон нутагт хөрөнгийг нь хуваан өгдөг болсон нь сайн зүйл юм.

M: Танай дүүрэгт залуучуудын ямар байгууллага үйл ажиллагаа явуулдаг вэ, хэрэв тийм байгууллага байдаг бол эдгээр байгууллагын үйл ажиллагааны талаарх үнэлгээ?

P9: Улс орны гол хүч нь залуучууд, тэднийг дэмжих олон улсын байгууллага, төрийн байгууллагууд уялдаа холбоотой ажиллаж үйл ажиллагаагаа олон нийгэд мэдээллэж байх хэрэгтэй байна. Би гэхэд энэ талаар тодорхой мэдээлэлгүй л байна. Магадгүй олон л байгууллагад үйл ажиллагаа явуулж үр дүнд хүрсэн байх.

P3: Тийм шүү, би санал нэгтэй байна.

P7: Оюутны байгууллагууд л идэвхитэй үйл явуулж мэдээлэл хийдэг

Нэгдсэн үнэлгээ

Уг судалгаанд оролцогчид бүлгийн ярилцлагаар хэлэлцсэн дараах асуудлуудад үнэлгээ өгсөн болно.

| | | |
|--------------|----------------------------|-----------------------|
| Үнэлэх зүйлс | Хувь\ойролцоогоор үнэлсэн\ | Санал өгсөн хүний тоо |
|--------------|----------------------------|-----------------------|

| | | |
|--|----|----|
| ЗАЛУУЧУУДЫН ӨМНӨ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭХ БАЙДАЛ | 30 | 12 |
| ЗАЛУУЧУУДЫН АМЬЖИРГААНЫ ТҮВШИН, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРҮҮД | 40 | 12 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 30 | 10 |
| ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАН, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ | 35 | 10 |
| ӨНӨӨГИЙН ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛААР ЯВУУЛЖ БУЙ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ | 50 | 8 |

Сонгинохайрхан дүүрэг
Улаанбаатар хот

Зургийн жагсаалт

| | |
|--|----|
| <u>Зураг-1.1. Судалгааг хэрэгжүүлэх аргачлал, үйл ажиллагааны тойм</u> | 9 |
| <u>Зураг-1.2. Судалгааны ажлын хамрах хүрээ</u> | 14 |
| <u>Зураг-1.3. Судалгааны ажлын зохион байгуулалт</u> | 16 |
| <u>Зураг-1.4. Багийн бүрэлдэхүүний схем</u> | 18 |
| Дүрсийн жагсаалт | |
| <u>Дүрс-2.1 Судалгаанд хамрагдсан залуучуудын насны бүлэг</u> | 19 |
| <u>Дүрс-2.2 Залуучуудын хүйсийн байдал</u> | 20 |
| <u>Дүрс-2.3 Залуучуудын боловсролын байдал</u> | 20 |
| <u>Дүрс-2.4 Залуучуудын ажил эрхлэлтийн байдал</u> | 21 |
| <u>Дүрс-2.5 Өрхийн орлогын хүрэлцээний байдал</u> | 24 |
| <u>Дүрс-2.6 Өнөөгийн залуусын амьдралд бэлтгэгдсэн байдал</u> | 25 |
| <u>Дүрс-2.7 Судалгаанд хамрагдсан аймаг, нийслэлээр</u> | 27 |
| <u>Дүрс-2.8 Залуучуудын улс төр сонирхох байдал</u> | 28 |
| <u>Дүрс-2.9 Улс төрийг сонирхох байдал(хүйсээр)</u> | 29 |
| <u>Дүрс-2.10 Улс төрийг сонирхдоггүй шалтгаан</u> | 30 |
| <u>Дүрс-2.11 Залуучуудын улс төрд оролцох шалтгаан</u> | 31 |
| <u>Дүрс-2.12 Залуу гэр бүл дэх харилцаа</u> | 39 |
| <u>Дүрс-2.13 Сэтгэл ханамжийн түвшин/хүйсээр</u> | 41 |
| <u>Дүрс-2.14 Ирээдүйн амьдралын талаарх залуучуудын төсөөлөл</u> | 41 |
| <u>Дүрс-2.15 Залуучуудын өндөр, биеийн жин</u> | 42 |
| <u>Дүрс-2.16 Залуучуудын үнэт зүйлст нөлөөлөх хүчин зүйлс</u> | 45 |
| <u>Дүрс-2.17 Хөрөнгө чинээний хувьд өөрсдийгөө нийгмийн аль хэсэгт хамруулах вэ?</u> | 47 |
| <u>Дүрс-2.18 Залуучуудын амьдралын чанарт нөлөөлж буй хүчин зүйлс</u> | 52 |
| <u>Дүрс-2.19 Залуучуудын үнэт зүйлсэд эзлэх түүх, соёлын хүчин зүйлс</u> | 55 |
| Хүснэгтийн жагсаалт | |
| <u>Хүснэгт-1.1. Зорилт, арга, судлах зүйл</u> | 10 |
| <u>Хүснэгт-1.2. Тоон судалгааны түүврийн тоо хэмжээ</u> | 13 |
| <u>Хүснэгт-2.1 Залуу өрхийн сарын дундаж орлого, ба нэг хүнд ноогдох орлого</u> | 22 |
| <u>Хүснэгт-2.2 Залуу өрхийн орлогын эх үүсвэрийн байдал</u> | 23 |
| <u>Хүснэгт-2.3 Залуучуудын гэрлэлтийн байдал</u> | 25 |
| <u>Хүснэгт-2.4 Залуусын гэр бүл, амьдралын талаарх бодомж</u> | 26 |
| <u>Хүснэгт-2.5 Залуучуудын улс төрийн сонирхол(насны бүлгээр)</u> | 28 |
| <u>Хүснэгт-2.6 Улс төрийг сонирхох байдал(орон нутгаар)</u> | 30 |
| <u>Хүснэгт-2.7 Төр засгийн ба оюутан залуучуудын байгууллагын үнэлгээ</u> | 32 |
| <u>Хүснэгт-2.8 Оролцооны хэлбэрүүд</u> | 32 |

| | |
|--|----|
| <u>Хүснэгт-2.9 Төр засгийн шийдвэрт нөлөө үзүүлэх бүлгийн талаарх байр суурь</u> | 33 |
| <u>Хүснэгт-2.10 Орон нутагт тулгамдаж буй асуудлуудын эрэмбэ</u> | 36 |
| <u>Хүснэгт-2.11 Нийгмийн байдлаас хамааран ялгаварлан гадуурхах байдал</u> | 37 |
| <u>Хүснэгт-2.12 Гэр бүл дэх шийдвэр гаргалтын байдал</u> | 38 |
| <u>Хүснэгт-2.13 Залуу гэр бүлийн зөрчилдөөн</u> | 38 |
| <u>Хүснэгт-2.14 Гэр бүл салалтын талаарх санал бодол</u> | 40 |
| <u>Хүснэгт-2.15 Залуучуудын сэтгэл ханамжийн байдал</u> | 40 |
| <u>Хүснэгт-2.16 Биеийн өндөр ба жингийн дундаж үзүүлэлт</u> | 43 |
| <u>Хүснэгт-2.17 Биеийн өндөр ба жин(хот, аймгаар)</u> | 43 |
| <u>Хүснэгт-2.18 Залуучуудын үнэт зүйлсийн эрэмбэ</u> | 46 |
| <u>Хүснэгт-2.19 Европын залуучуудын амьдралын хэв маяг, мөчлөг</u> | 49 |